

Монгол Улс  
Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)

# **МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ**

**Төслийн төгсгөлийн тайлангийн хавсралт  
Техникийн хамтын ажиллагааны төслийн  
хүрээнд боловсруулсан бүтээгдэхүүн /  
баримт бичиг**

**I**

**2020 оны 1-р сар**

**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
БАЙГУУЛЛАГА (ЖАЙКА)**

**ОРИЕНТАЛ КОНСАЛТАНЦ ГЛОБАЛ ХК  
КОКУСАЙ КОГЁО ХК**

**ОЁО ИНТЕРНАШНЛ КОРПОРАЦИ  
ХОТЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮРЭЭЛЭН**

**Хавсралт хэсэг: Техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд  
боловсруулсан бүтээгдэхүүн/баримт бичиг**

**Хавсралт I**

**1: Гамшгаас хамгаалах засаглал, барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлт, гамшгаас хамгаалах боловсролтой холбоотой заавар, журам, санамж бичгийн төсөл**

**【Үр дүн 1】**

- 1-1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх заавар ..... 1-1-1
- 1-2 Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа
  - 1-2-1 Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа ..... 1-2-1-1
  - 1-2-2 Газар хөдлөлтийн хохирлын үнэлгээнд Эксел программ ашиглах гарын авлага ..... 1-2-2-1
  - 1-2-3 Хохирлын тооцоолол хийх Эксел программ ..... 1-2-3-1
- 1-3 Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар ..... 1-3-1
- 1-4 Улсын албаны газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар ..... 1-4-1
- 1-5 Орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар ..... 1-5-1
- 1-6 Санамж бичгийн төслүүд
  - 1-6-1 Санамж бичиг боловсруулах гарын авлага ..... 1-6-1-1
  - 1-6-2 Санамж бичиг: Хүнс, эм хангамж, барилгын материал, усны хангамж, шуурхай тээвэр, түлш шатахуун, холбоо харилцаа, түр хоргодох байр, бохир зайлуулах тухай ..... 1-6-2-1
- 1-7 ГОЗМС-ийн журам, холбогдох санамж бичгүүд
  - 1-7-1 ГОЗМС-ийн журам ..... 1-7-1-1
  - 1-7-2 Гамшгийн мэдээлэл хамтран ашиглах гэрээ ..... 1-7-2-1

**【Үр дүн 2】**

- 1-8 Газар хөдлөлтийн тэсвэрлэлийн үнэлгээ, хүчитгэлийн заавар – ЦТБ .... 1-8-1
- 1-9 Газар хөдлөлтийн тэсвэрлэлийн үнэлгээ, хүчитгэлийн заавар – угсармал ..... 1-9-1

1-10 Газар хөдлөлтийн тэсвэрлэлийн үнэлгээ, хүчитгэлийн заавар – өрөгт.....	1-10-1
1-11 Газар хөдлөлтийн тэсвэрлэлийн үнэлгээ, хүчитгэлийн заавар – дэд бүтэц, ИШС.....	1-11-1

**【Үр дүн 3】**

1-12 Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр.....	1-12-1
--	--------

**Хавсралт II**

**2: Гамшгаас хамгаалах засаглал, барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлт, гамшгаас хамгаалах боловсролтой холбоотой сургалтын хэрэглэгдэхүүн болон сургалт явуулах гарын авлага**

**【Үр дүн 2】**

2-1 Газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтын гарын авлага	
2-1-1 Барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэлийн сургалтын гарын авлага.....	2-1-1-1
2-1-2 Дэд бүтэц, ИШС-ний газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтын гарын авлага.....	2-1-2-1

**3: Шинэчлэн боловсруулсан улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний төсөл болон гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах гарын авлага**

3-1 Дархан-Уул аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	3-1-1
3-2 Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	3-2-1
3-3 Нийслэлийн Баянгол дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	3-3-1
3-4 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	3-4-1
3-5 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах гарын авлага (Аймаг, Нийслэлийн).....	3-5-1

**4: Гамшгаас хамгаалах Цагаан ном, Цагаан ном боловсруулах гарын авлага**

4-1 Цагаан ном боловсруулах гарын авлага.....	4-1-1
---	-------

# **Хавсралт I**



**1: Гамшгаас хамгаалах засаглал,  
барилгын газар хөдлөлтийн  
тэсвэрлэлт, гамшгаас хамгаалах  
боловсролтой холбоотой заавар,  
журам, санамж бичгийн төсөл**

1-1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх заавар

Монгол Улсын Шадар Сайдын 2019 оны  
... дугаар тушаалын хавсралт

**ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ТҮВШИНД ГАЗАР  
ХӨДЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН ТОЙМ СУДАЛГАА ХИЙХ ЗААВАР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа (цаашид газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа)-г газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэнэ. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгааг газар хөдлөлтийн ерөнхий үнэлгээ гэж ойлгоно.

1.2. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх зааврын зорилго нь орон нутгийн түвшинд онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах албадын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үндэслэлийг бүрдүүлэх газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх аргазүйн удирдамжаар хангахад оршино.

1.3. Энэхүү зааврыг засаг захиргаа, нутгийн дэвсгэрийн түвшинд газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах албад, төрийн бус байгууллага, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болзошгүй газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийхэд ашиглана.

1.4. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийхэд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч болно.

1.5. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаагаар газар хөдлөх үед хүний амь нас, эрүүл мэнд, барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, бусад дэд бүтцэд учрах болзошгүй хохирлын хэмжээг чанарын аргаар үнэлж гаргана. Болзошгүй хохирлын хэмжээг чанарын аргаар үнэлэхдээ “Эксел програмд суурилсан газар хөдлөлтийн болзошгүй хохирлыг тооцоолох аргачлалын гарын авлага”-ыг ашиглана.

## Хоёр. Нэр томъёо

### 2.1. Магнитуд

Магнитуд нь газар хөдлөлтийн цар хүрээг илэрхийлэх газар хөдлөлтийн чичирхийллийн голомтын энергийн хэмжээг заах тоон хэмжигдэхүүн юм. Магнитуд нэгээр нэмэгдэхэд ялгаа нь 30 дахин, магнитуд хоёроор нэмэгдэхэд ялгаа нь 1000 дахин их байна. Газар хөдлөлтийн улмаас үүсэх хохирлын хэмжээ, түүний тархах цар хүрээ нь монгол орны хувьд “магнитуд 7”-ийн үед нэг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд, “магнитуд 8”-ын үед хэд хэдэн аймгийн газар нутгийг хамарч хохирол үүсгэх магадлалтай гэж тооцогддог.

### 2.2. Газар хөдлөлтийн эрсдэл

Газар хөдлөлтийн аюулын улмаас тодорхой газар, цаг хугацаанд таамаглаж буй үр дагавар (хүний амь нас, барилга байгууламж, дэд бүтэц (биет эвдрэл))-д үүсэх магадлалын шинж чанар, эсвэл эдгээр эвдрэл хохирлын улмаас үүсэх нийгэм, эдийн засагт учирсан хор уршгийг хэлнэ.

### 2.3. Газар хөдлөлтийн аюул

Газар хөдлөлтийн улмаас хөрсөн дээр үүсэх чичирхийллийг хэлнэ. Түүнчлэн, газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас үүсэх хөрсний шингэрэлт, хөрсний гулсалт, хадны нуранги үүсэх, хөрс хагарах зэрэг тектоник үзэгдэл, газар хөдлөлтийн улмаас үүсэх гал түймэр болон бусад дагалдах аюул хамаарна.

### 2.4. Эмзэг байдал

Газар хөдлөлтийн аюул, ялангуяа чичирхийлэлд тэсвэрлэх чадвар сул, муу байдлаар илэрхийлэгдэнэ. Уг зааварт барилга байгууламж, дэд бүтцэд газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас үүсэх хохирлын хэр хэмжээг тодорхойлсон ойлголт юм.

### 2.5. Чадавх

Газар хөдлөлтийн аюул, түүнээс учрах ялангуяа чичирхийллийг тэсвэрлэх чадвар сайн байдлаар илэрхийлэгдэнэ. Чадавх нь агуулгаараа эмзэг байдлын эсрэг ойлголт.

### 2.6. Газар хөдлөлтийн балл

Газар хөдлөлтийн чичирхийллийн нөлөөллийн хэмжээг илэрхийлэх тоон үзүүлэлт бөгөөд дэлхийн улс орнуудад хэд хэдэн төрлийн хэмжигдэхүүн хэрэглэгдэж байна. Монгол Улсад хэрэглэгдэж байгаа МСК-64 газар хөдлөлтийн баллын шаталбарыг доорх хүснэгтэд харуулав. МСК шаталбар нь чичирхийллийн биет хэмжээ (хөрсний гадаргууны хурдатгал)-тэй адил байдаг.

## Хүснэгт 2.1. МСК-64 газар хөдлөлтийн баллын шаталбар

MSK-64 шаталбар	Чичирхийллийн шинж чанар	Хөрсний гадаргууны хурдатгал (gal)
I	Хүнд үл мэдрэгдэх газар хөдлөлт	<1.6
II	Ховор мэдрэгдэх газар хөдлөлт	1.6 - 3.2
III	Зөөлөн газар хөдлөлт	3.2 - 7.0
IV	Тод мэдрэгдэх газар хөдлөлт	7.0 - 13
V	(зөөлөн чичирхийлэл) барилгын хананд жижиг ан цав үүсэх	13 - 25
VI	(хүчтэй чичирхийлэл) хүмүүс айж сандрах, өрөгт бүтээцтэй барилга байгууламжид ялимгүй ан цав үүсэх	25 - 50
VII	(нэн хүчтэй чичирхийлэл) өрөгт бүтээцтэй барилга байгууламжид эвдрэл гарах	50 - 100
VIII	(хөнөөл бүхий газар хөдлөлт) барилга байгууламж ихээр эвдэрч, хүмүүс айж үймэлдэх	100 - 200
IX	(сүйрэл бүхий газар хөдлөлт) бүхий л барилга байгууламжид эвдрэл гарч, өрөгт бүтээцтэй барилга бүрэн нурах, том хавтгаалжин угсармал барилгын хананд хөндлөн ан цав үүсч, газрын хөрсөнд хагарал үүсэх	200 - 400
X	(сүйдэл бүхий газар хөдлөлт) бүхий л барилга байгууламж нурах, галт тэрэг замаасаа гарах, далангийн байгууламжид аюултай эвдрэл гарах	400 - 800
XI	Сөнөл, хөрсний гадаргууд их хэмжээний хэлбэрийн өөрчлөлт үүсэх	800 - 1600
XII	Дэлхийн хэмжээний гамшиг, газрын хэлбэр их хэмжээгээр өөрчлөгдөх	>1600

### 2.7. Хөрсний шингэрэлт

Газар хөдлөлтийн улмаас усанд ханасан хайрга, элс мөн шаварлаг хөрсний барьцалдах чадвар алдагдаж, урсамхай төлөв байдалд шилжих үзэгдлийг хөрсний шингэрэлт гэнэ.

### 2.8. Барилгын эвдэрч, нурах магадлал

Уг зааварт газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас барилга, байгууламжийн эвдэрч нурах магадлалыг тоон утгаар илэрхийлсэн хувь, хэмжээг хэлнэ. Эвдэрч нурах магадлал 10% гэдэг нь үнэлгээ хийж барилгатай адил бүтээцтэй 10 барилга байвал 1 нь эвдэрч, нурна гэсэн утгатай юм. Барилгын эвдэрч, нурах магадлал нь үнэлгээ хийж барилгатай адил бүтээцтэй нийт барилгын хэдэн хувь нь эвдэрч нурах эсэхийг заах бөгөөд барилга тус бүрийн эвдрэлийн түвшинг заахгүй.

### 2.9. Зам, инженерийн шугам сүлжээний эвдрэх магадлал

Газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас зам, инженерийн шугам сүлжээний эвдрэх магадлалыг илэрхийлэх бөгөөд уг зааварт замын нэвтрэх боломжгүй болох цэгийн тоо/км, цэвэр бохир усны шугам хоолой, дулааны шугам хоолой, цахилгаан дамжуулах шугамын хувьд эвдрэл үүсэх цэгийн тоо/км, цахилгааны шонгийн хувьд нурах шонгийн хувь хэмжээг заана.

## 2.10. Газар хөдлөлтийн бүсчлэлийн зураг

Аюулын үнэлгээнд үндэслэн хөрсний хэлбэлзлийн зонхилох давтамж, хөрсний хурдатгал, хөрс болон барилга байгууламжид үзүүлэх нөлөөллийг урьдчилан таамаглаж гаргасан бүсчилсэн зургийг газар хөдлөлтийн бүсчлэлийн зураг гэнэ. Бүсчлэлийн зургийг ерөнхий мужлал, бичил мужлалын зураг гэж ангилна.

Газар хөдлөлтийн түүхчилсэн болон идэвхжилийн судалгаанд үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн аюулын түвшин, магадлалыг таамаглан гаргасан бүсчилсэн зураглалыг газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураг, газар хөдлөлтөөс хөрсний гадаргад үүсэх хэлбэлзлийн хурдас, газар хөдлөлтийн үеийн шинж чанараас хамаарах хамаарлыг харгалзан аюулын түвшинг нарийвчлан тодорхойлж гаргасан зураглалыг газар хөдлөлтийн бичил мужлалын зураг гэнэ.

## 2.11. Барилгын эвдрэл, гэмтлийн зэрэг

Газар хөдлөлтийн улмаас барилга байгууламжид үүсэх эвдрэл гэмтлийг дараах байдлаар ангилна.

Барилга байгууламжийн эвдрэл, гэмтлийн зэрэг				
1. Хөнгөн гэмтэл	2. Хүндэвтэр гэмтэл	3. Хүнд гэмтэл	4. Эвдрэл	5. Нуралт
Шавардлагад нарийн ан цав гарах, шавардлагаас жижиг хэмжээний хэсэг ховхорч унах.	Хананд бага хэмжээний ан цав гарах, шавардлагаас томоохон хэсэг ховхорч унах, утааны янданд ан цав гарах, яндангийн зарим хэсэг нурах	Хананд том хэмжээний бөгөөд гүнзгий ан цавууд гарах, утааны яндан нурж унах	Хананд нэвт ан цав гарч, эвдрэх, барилгад хэсэгчилсэн нуралт үүсэх, барилгын элементүүдийн уулзвар холбоосны хэсэг эвдрэх, дотор хана ба араг бүтээцийн дүүргэгч хана нурах	Барилга бүхэлдээ эвдрэх

## 2.12. Барилгын эвдэрч нурах магадлалын функц

Газар хөдлөлтийн балл (эрчим) ба барилга байгууламжийн эвдэрч, нурах (Барилгын эвдрэл, гэмтлийн зэрэг (2.11)-ийн 4, 5 дугаар түвшинд хүрэх хэмжээ) магадлалын хамаарлыг харуулсан функц.

## 2.13. Хүний хохирлын тооцоолол

Тохиолдож байсан газар хөдлөлтийн статистик мэдээлэлд тулгуурлаж гаргасан эвдэрч, нурсан (Барилгын эвдрэл, гэмтлийн зэрэг (2.11)-ийн 4, 5 дугаар түвшинд хүрэх хэмжээ) барилга дахь өрхийн тоо болон нас барсан хүний тоо хоорондын хамаарлаас гаргаж авсан томъёогоор тооцоолох тооцоолол.

### **Гурав. Шаардагдах мэдээлэл**

#### 3.1. Үндсэн мэдээлэл

3.1.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газрын зураг

3.1.2. Хүн ам, барилга байгууламжийн тооллогын бүртгэл

#### 3.2. Газар хөдлөлийн түүхэн мэдээлэл

3.2.1. Газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалд үндэслэн гаргасан газар хөдлөлтийн балл, тохиолдох давтамжийн тоо

3.2.2. Суурь хөрсний мэдээлэл

3.3. Барилга, байгууламж (онц чухал объект, орон сууц, эмнэлэг, сургууль, захиргааны барилга) мэдээлэл

3.3.1. барилга байгууламжийн хийц

3.3.2. барилга байгууламжийн тархалт

3.3.3. Паспортжуулалт хийгдсэн барилгын хувьд түүний хуулбар

#### 3.4. Дэд бүтцийн мэдээлэл

3.4.1. цэвэр усны шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн мэдээлэл

3.4.2. цахилгаан эрчим хүчний сүлжээ, тоног төхөөрөмжийн мэдээлэл

3.4.3. дулааны шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн мэдээлэл

3.4.4. гүүрийн хийц

3.4.5. автозам, бусад мэдээлэл


### **Дөрөв. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх аргачлал**

4.1. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа нь эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг шинжлэх, эрсдэлийг дүгнэх гэсэн 3 үндсэн үе шаттай байна.

4.2. Эрсдэлийг тодорхойлох үе шатанд газар хөдлөлтийн шинж чанар, нийгэм, хотжилт зэрэг эрсдэлийг үүсгэгч хүчин зүйлүүдийг авч үзнэ.

4.3. Эрсдэлийг шинжлэх үе шатанд аюулын болон эмзэг байдлын шинжилгээг хийнэ. Аюулын шинжилгээг газар хөдлөлтийн шинж чанар буюу газар хөдлөлтийн бичил мужлалд үндэслэн хийнэ. Эмзэг байдлын шинжилгээ нь нийгэм, хотжилтын хүчин зүйл дээр үндэслэгдэн хийгдэх ба хүн ам, оршин суугч, барилга, орон сууц, дэд бүтэц, газар хөдлөлтөөс үүсэлтэй гал түймэрт өртөх объектын мэдээлэлд суурилж тодорхойлогдоно.

4.4. Эрсдэлийг дүгнэх үе шатанд барилга, орон сууцны эвдрэл, хүн ам, оршин суугчид, дэд бүтцэд учрах хохирлын төсөөллийг ашиглан эрсдэлийн түвшинг тооцно. 4.1 дүгээр зурагт эрсдэлийн үнэлгээний бүдүүвч схемээр үзүүлэв.



Зураг 4.1. Газар хөдлөлтийн тойм судалгааны бүдүүвч

4.5. Газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлох үе шатанд орон нутгийн газар хөдлөлтийн эрчимшил, нийгэм, хотжилтын талаарх мэдээллийг ашиглан газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлно.

4.6. Газар хөдлөлтийн эрсдэлийн шинжилгээг хийхэд хялбаршуулсан болон нарийвчилсан аргачлал байна. Газар хөдлөлтийн эрсдэлийн шинжилгээг хялбаршуулсан аргаар хийхдээ эрсдэлийг тодорхойлох хүрээнд цуглуулсан мэдээллийг ашиглан аюулын болон эмзэг байдлын шинжилгээг хийж, хохирлын таамаглалыг гаргана.

4.6.1. Аюулын шинжилгээг хийхдээ монгол орны хэмжээнд хот суурин газруудад хийгдсэн газар хөдлөлтийн бичил мужлалын мэдээллийг тусгасан Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНБД

22.01.01\*/2006-г ашиглан тухайн газар оронд тохиолдож болох газар хөдлөлтийн балл болон давтамжийг тодорхойлно. Одон орон, геофизикийн хүрээлэнгийн боловсруулсан газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалд заасан газар хөдлөлтийн баллыг мөн ашиглах боломжтой. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дотор газар хөдлөлтийн балл өөр өөр байх тохиолдолд газар хөдлөлтийн хүчийг тус бүрээр нь тодорхойлно.

4.6.2. Эмзэг байдлын шинжилгээг хийхдээ тухайн орон нутагт тохиолдох хамгийн их эрчимшлийн газар хөдөлнө гэж тооцоолж, газар хөдлөлтийн цагийн байдлыг боловсруулан хүн ам, барилга, байгууламж, дэд бүтцийн мэдээллийг ашиглан эдгээрт учирч болох хохирлын төсөөллийг боловсруулна.

#### 4.6.2.1. Барилгад учрах хохирол

Барилгын хохирлын төсөөллийг аюулын шинжилгээгээр тогтоосон тухайн газарт тохиолдох газар хөдлөлтийн баллд барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтээр ангилсан ангилал тус бүрээр эвдэрч, нурах магадлалыг тооцож, тухайн барилгатай адил ангилалд хамаарах нийт барилгын тоонд үржүүлэн гаргана.

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтээр ангилсан ангиллыг “Газар хөдлөлтийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар /БД31-103-00/” норм, дүрмийг ашиглан барилгуудыг газар хөдлөлтийн тэсвэрлэлтээр нь 1-13 төрөлд ангилна. Барилгын хийц тус бүрийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн ангилалыг хийцийн материал, барилга баригдсан болон зураг төсөл хийгдсэн он, барилгын хэлбэр, барилгын давхар, барилгын зориулалтад үндэслэн тогтооно. Эдгээрийг барилга тус бүрийн паспортоос гаргаж авахаас гадна шаардлагатай тохиолдолд тусгайлан судалгаа хийж бүрдүүлнэ.


Барилгын эвдэрч нурах магадлалыг 2013 онд хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхыг бэхжүүлэх төсөл”-д барилгын эвдэрч нурах магадлалыг тооцоход ашигласан аргачлалыг нягтлахад ашигласан Казахстан Улсын Алматы хотын барилгын эвдэрч нурах магадлалын функцийг ашиглан тооцсон болно. Уг магадлалын функцийг зураг 4.2-т үзүүлэв. Газар хөдлөлтийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан зааварт заасан барилга байгууламжийн ангиллын дугаар болон зурагт 4.2-т үзүүлсэн барилгын ангиллын дугаартай дүйцүүлснийг хүснэгт 4.1-т үзүүлэв.



Хүснэгт 4.1. Газар хөдлөлтийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар /БДЗ1-103-00/-т заасан ангилал ба барилгын эвдэрч нурах магадлалын функц дэх барилгын ангиллын хамаарлыг харуулсан хүснэгт

Паспортжуулалтын аргачилсан заавар дахь барилгын ангилал А	1.1	1.2	1.3	1.4	1.5	1.6	1.7	2.1	2.2	3	4.1	4.2	5	6
Эвдэрч нурах магадлалын функц дэх барилгын ангилал Б	9	8	8	8	9	8	8	9	8	9	9	9	6	4

Паспортжуулалтын аргачилсан заавар дахь барилгын ангилал А	7.1	7.2	7.3	8.1	8.2	9	10.1	10.2	10.3	11	12.1	12.2	13
Эвдэрч нурах магадлалын функц дэх барилгын ангилал Б	7	7	7	6	6	5	5	5	5	5	2	3	1



Зураг 4.2 Барилгын эвдэрч, нурах магадлалын функц

4.2 зурагт заасан тоон үзүүлэлтийг хүснэгтээр илэрхийлж Хүснэгт 4.1-т үзүүлэв. Барилгын паспортжуулалтын аргачилсан зааврын дагуух барилгын ангиллыг энэхүү Барилгын эвдэрч, нурах магадлал функцийн дагуух барилгын ангилалтай дүйцүүлж, Хүснэгт 4.2-т үзүүлсэнчлэн тухайн барилгын байрлах бүс

нутгийн газар хөдлөлтийн балл /эрчим/-д харгалзуулж барилгын эвдэрч, нурах магадлалыг тооцож гаргана.

Хүснэгт 4.2. Барилгын эвдэрч нурах магадлалыг тодорхойлоход ашиглах өгөгдөл

Дугаар	1	2	3	4	5	6	7	8	9
Барилгын төрөл	Түүхий тоосгон барилга	1 давхар блок/тоосгон	2 ба түүнээс дээш давхар, Модон хучилттай блок/тоосгон	1-р давхар нь уян барилга	2 ба түүнээс дээш давхар, бетон хучилттай блок/тоосгон	1998 оноос өмнөх төмөр бетон барилга	Модон барилга	1998 оноос өмнөх төмөр бетон барилга	Том хавтгаалжин угсармал барилга
Газар хөдлөлтийн балл /Эрчим/	Барилгын эвдэрч, нурах магадлал								
6	0.02925	0.00094	0.00089	0.00037	0.00037	0.00015	0.00003	0.00000	0.00000
7	0.24962	0.02925	0.02275	0.01222	0.01002	0.00391	0.00102	0.00002	0.00000
8	0.75038	0.29441	0.22663	0.15866	0.12246	0.05527	0.02163	0.00202	0.00006
9	0.97867	0.79126	0.69146	0.59871	0.50000	0.29739	0.16917	0.05208	0.01513
9.5	0.99656	0.93142	0.86971	0.80921	0.71951	0.50000	0.33522	0.15866	0.09121
10.0	0.99964	0.98470	0.95994	0.93319	0.87754	0.70261	0.54236	0.35383	0.30854
10.5	0.99997	0.99773	0.99123	0.98321	0.95944	0.85630	0.73836	0.59871	0.63056

Ангилал тус бүрд хамаарах нийт барилгын мэдээллийг улсын хэмжээнд 10 жил тутам зохион байгуулдаг хүн ам, орон сууцны тооллогын мэдээнд үндэслэн гаргана.

4.6.2.2. Хүн амд учрах хохирол 1 (эвдэрсэн болон нурсан орон сууц дахь оршин суугчдын тоо)

Барилгыг зориулалтаар нь орон сууц, олон нийтийн болон захиргааны, бизнесийн (үйлдвэрийн гэх мэт) гэж 3 ангилан тойм судалгаанд оруулав.

Хүн амд учрах хохирлыг тооцохдоо оршин суугчдын тоо, барилгын эвдэрч, нурах магадлалд үндэслэн, оршин суугчдын нэрвэгдэх магадлалаар тодорхойлно. Хүснэгт 4.4-д Газар хөдлөлтийн үед оршин суугчдын нэрвэгдэх магадлалыг Дархан-Уул аймгийн Дархан хотын жишээн дээр гаргасан тооцоог харуулав. Тус хүснэгтэд "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм" БНБД 22.01.01\*(2006)-ын 1 дүгээр хавсралтын "Газар хөдлөлтийн хүчийг баллаар авах заалттай газар хөдлөлтийн бүс нутагт байрласан Монгол Улсын хотуудын жагсаалт"-аас тухайн хот хэдэн баллын нутаг дэвсгэр дээр оршиж байгааг тогтооно. Тухайлбал, Дархан хот 8<sub>2</sub> гэсэн баллд харгалзаж байгаа бөгөөд доод буланд бичигдсэн давтамжийн тоо 2 гэсэн байгаа нь 50-аас доошгүй жилд 1 удаа газар хөдлөлт тохиолдоно гэсэн үг юм. Тус барилгын норм ба дүрмийн 3 дугаар

хавсралтад хуучин барилгыг газар хөдлөлтийн тэсвэрлэлтээр нь ангилах хүснэгтэд барилгын зэрэглэл, хийцийн товч тодорхойлолтыг тусгаж өгсөн байна. Иймд эдгээр норм дүрмийг ашиглан барилгын зэрэглэл, хийцийн тодорхойлолтын дагуу барилгын төрөл, тоо, өрхийн тоо, харгалзах эвдрэлийн зэрэгт үндэслэн барилгын хохирол, өрхийн болон хүний хохирлыг харгалзах өгөгдөл, хүн амын бүртгэл, статистик мэдээ ашиглан тооцож гаргаж болно. Хүснэгт 4.3-ыг үзнэ үү.


Хүснэгт 4.3. Газар хөдлөлтийн үед оршин суугчдын нэрвэгдэх магадлал (Дархан-Уул аймгийн жишээ)

8 баллын газар хөдлөлтийн чичирхийллийн үед гарах хохирлын төсөөлөл - хүний болон барилга байгууламж хохирол							
Ангилал	Барилгын төрөл	Барилгын тоо	Өрхийн тоо	эвдэрч нурах магадлал	Хохирол (хүн)	Хохирол (өрх)	Хохирол (барилга)
1	Орон сууцны барилга	30	1119	0.202	5	2	0
	Хувийн орон сууц (хаус)						
	Нийтийн орон сууц						
	Гэр	5752	5752		35	12	12
	Сууцны тусдаа барилга						
	Бусад сууц						
4.2	Олон нийтийн барилга	7					0
12.2	Орон сууцны барилга	5	95	0.22663	46	15	1
	Хувийн орон сууц						
	Нийтийн орон сууц						
	Гэр						
	Сууцны тусдаа барилга						
	Бусад сууц						
	Олон нийтийн барилга	6					1
		Нийт барилга	Нийт өрх	Хохирол	Нийт хүн	Нийт өрх	Нийт барилга хүн
		1439	8365		689	232	171
					Дархан хотын хүн ам:		24863
	Өрхийн тоо (албан ёсны тоо):	8365					
					Орон сууцны барилга:	3	
					Хувийн орон сууц (хаус):	13	
					Нийтийн орон сууц:	2	
				Гэр:	12		

	Сууцын тусдаа барилга:	149
	Бусад сууц:	1
	Олон нийтийн барилга:	3
		182

#### 4.6.2.3. Хүн амд учрах хохирол (нас барсан болон гэмтэж бэртсэн хүний тоо)

Нас барсан болон гэмтсэн хүний хохирлыг тооцохдоо Монголд баригдсан орон сууц нь ихэвчлэн олон орц бүхий хүн ам ихээр оршин суух орон сууц байдагтай уялдуулан барилга тус бүрд оршин сууж байгаа өрхийн тоо нь өөр өөр байдгаас хамааруулж хүний хохирлын тооцооллыг “өрхийн тоо”-гоор тооцож гаргах нь зүйтэй гэж үзэв. Үүнд 1988 оны Армяны Улсын Спитакийн газар хөдлөлтийн хохирол дээр үндэслэн олон давхар орон сууцны барилга ба амины орон сууц эвдэрч нурах тохиолдолд гарах хүний хохирлыг тооцоолон боловсруулав. Гэмтэж бэртсэн хүний тоо нь Спитакийн газар хөдлөлтийн улмаас нас барсан болон гэмтэж бэртсэн хүний харьцаанаас тооцож гаргав.



Зураг 4.3. Хүний хохирлын тооцоолол

### Хүний хохирлын тооцоолол

Газар хөдлөлтийн үед амь насаа алдаж болзошгүй хүний тоог тооцоолоход дээрх хүний хохирлын тооцооллоос гаргасан дараах томъёог ашиглана.

<Нийтийн орон сууц>

Нас барсан хүний тоо= $10^{\{1.2 \times \log(\text{өрхийн тоо}) - 1.1\}}$

<Нэг айлын амины орон сууц>

Нас барсан хүний тоо= $10^{\{1.2 \times \log(\text{өрхийн тоо}) - 1.4\}}$

Гэмтэж бэртсэн хүний тоог дараах байдлаар тооцоолов.

Гэмтэж бэртсэн хүний тоо=(нас барсан хүний нийт тоо)÷25×31

#### 4.6.2.4. Дэд бүтэц, шугам сүлжээнд учрах хохирол

Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний эрсдэлийн үнэлгээг 2018 онд батлагдсан “Авто зам, гүүр, инженерийн хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал” /БД 22-104-18/ барилгын дүрэмд заасан аргачлалыг ашиглана. Уг аргачлалыг ашиглахад шаардлагатай мэдээллийг доор тайлбарлав.

#### Гүүр

Газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас гүүр нурах магадлалыг тогтоох ажлыг доор дурдсан аргачлал, шат дарааллын дагуу явуулна.

- 1) Тухайн гүүрийн бүтэц болон ойр орчмын хөрсний онцлогийг судлах.
- 2) Гүүрийн байршлын газар хөдлөлтийн чичирхийллийн балл болон хөрсний шингэрэлт болох магадлалыг тодорхойлох.
- 3) Дээрхийн үр дүнд үндэслэн 10 төрлийн хүчин зүйл бүрээр заасан категори /ангилал/ сонгож, тохирох хувийн жингийн коэффициентээр үржүүлнэ.
- 4) Үржүүлж гарсан дүн нь үнэлгээний оноо болох ба гүүр нурах аюулыг тодорхойлно.

10 төрлийн хүчин зүйл болон хувийн жингийн коэффициентийг Хүснэгт 4.4-т, гүүрийн хохирлын хэмжээг тооцох хүснэгтийг Хүснэгт 4.5-д тус тус үзүүлэв.

#### Хүснэгт 4.4. Гүүрийн хохирлыг тогтоох хүчин зүйл ба хувийн жингийн коэффициент

№	Хүчин зүйл	Ангилал	Хувийн жингийн коэффициент
1	Хөрс (БНБД 22.01.01*/2006/-ын 1 дүгээр хавсралтын дагуу)	Ангилал 1	0.5
		Ангилал 2	1.0
		Ангилал 3	1.5
		Тодорхойгүй	1.5

№	Хүчин зүйл	Ангилал	Хувийн жингийн коэффициент
2	Хөрсний шингэрэлт явагдах магадлал	Байхгүй	1.0
		Байж болзошгүй	1.5
		Бий	2.0
		Тодорхойгүй	2.0
3	Дам нурууны хийц	Нуман, рамэн хэлбэрийн	1.0
		Үргэлжилсэн дам нуруу	2.0
		Энгийн, консолон дам нуруу	3.0
4	Тулах хэсэг	Хамгаалалтын тоноглолтой	0.6
		Энгийн	1.0
		Завсрын нэг тулгуур дээр 2 хөдөлгөөнт тулах хэсэг	1.15
5	Захын ба завсрын тулгуурын өндөр	$\leq 5$ m	1.0
		5~10 m	1.35
		$\geq 10$ m	1.7
6	Алхмын тоо	= 1	1.0
		$\geq 2$	1.75
7	Явах анги	Өргөн	0.8
		Нарийн	1.2
8	МСК баллын шаталбар	>8	0.7
		8	1.2
		9	2.1
		10	3.0
		10>	3.9
9	Суурийн ажил	Гадсан суурь	1.4
		Бусад	1.0
10	Захын болон завсрын тулгуурын материал	арматургүй бетон, бусад	1.4
		төмөр бетон	1.0

#### Хүснэгт 4.5 Гүүрийн хохирлын хэмжээг тооцох хүснэгт

Хохирлын хэмжээ		Үнэлгээний оноо
A	- Нурах эрсдэл ихтэй - Ихээхэн эвдрэл үүсэх - Урт хугацаанд ашиглах боломжгүй, их засвар хийх шаардлагатай	30-аас дээш
B	- Нурах эрсдэл дунд зэрэг - Эвдрэл үүсэх - Хэсэг хугацаанд ашиглах боломжгүй, засварлах шаардлагатай	26-аас дээш 30-аас бага
C	- Нурах магадлал бага - Бага эвдрэл үүсэх - Үзлэг хийсний дараа ашиглах боломжтой	26-аас бага

#### Зам

Замын эвдрэх магадлалыг Хүснэгт 4.6-д үзүүлэв. Энэхүү коэффициентийг замын нийт уртад үржүүлж эвдрэх цэгийн тоог тооцож гаргана.

#### Хүснэгт 4.6 Замын хохирлын коэффициент (цэг/км)

МСК баллын шаталбар	БНБД 22.01.01*/2006/-ын 1 дүгээр хавсралтын дагуух хөрсний ангилал		
	Ангилал 1	Ангилал 2	Ангилал 3
6	0.02	0.02	0.04
7	0.04	0.06	0.10
8	0.09	0.13	0.21
9	0.17	0.25	0.38
10	0.28	0.40	0.57

#### Цэвэр ус болон дулааны газар доорх хоолой

Цэвэр ус болон дулааны газар доорх хоолойн эвдрэх магадлалыг дараах томъёогоор тооцно.

$$R = R_s * C_g * C_{pd}$$

Үүнд:

- R : Цэвэр усны хоолойны эвдрэх магадлал (эвдрэл гарах цэг/км)
- R<sub>s</sub> : Дундаж утга (эвдрэл гарах цэг/км)
- C<sub>g</sub> : Хөрсний шингэрэлтийн коэффициент
- C<sub>pd</sub> : Хоолойн төрөл, голчийн коэффициент

R<sub>s</sub> –ыг дараах томъёогоор тооцож гаргана.

$$R_s = 2.24 * 10^{-3} (V - 20)^{1.51}$$

Үүнд:

V : Хөрсний дээд хурдатгал (kinе, см/сек)

$$V = 0.0029 * 10^{(0.56 * \text{МСК балл})}$$

C<sub>g</sub> ба C<sub>pd</sub> –ын утгыг Хүснэгт 4.7, Хүснэгт 4.8-д тус тус үзүүлэв.

#### Хүснэгт 4.7 Хөрсний шингэрэлт явагдах магадлалын коэффициент C<sub>g</sub>

Хөрсний шингэрэлт явагдах магадлал	C <sub>g</sub>
Байгаа эсвэл тодорхойгүй	2.4
Байж болзошгүй	2.0
Байхгүй	1.0

#### Хүснэгт 4.8 Хоолойн төрөл, голчийн коэффициент

Хоолойн төрөл	Хоолойн голч				
	< 75 мм	100-250 мм	300-450 мм	500-900 мм	1000 мм-
Уян ширмэн хоолой	0.60	0.30		0.09	0.05
Ширмэн хоолой	1.70	1.20	0.40		0.15
Ган хоолой	0.84	0.42	0.24		
Хлорт винил хоолой	1.50	1.20			
Асбест цемент хоолой	6.90	2.70	1.20		

#### Бохир ус

Бохирын хоолойн эвдрэх магадлалыг Хүснэгт 4.9-т үзүүлэв.

#### Хүснэгт 4.9 Бохирын хоолойн эвдрэх магадлал (%)

Хоолойн төрөл	Хөрсний шингэрэлт явагдах магадлал	МСК баллын шаталбар				
		6	7	8	9	10
PVC болон шаазан хоолой	бүгд	11.5	27.2	49.3	71.7	87.8
Бусад	байхгүй	5.3	10.4	18.4	29.2	42.2
	байж болзошгүй	6.0	11.9	21.2	33.6	48.3
	байгаа эсвэл тодорхойгүй	7.4	15.7	28.5	44.9	62.2

#### Цахилгааны шугам

##### 1) Цахилгааны шон

Цахилгааны шугамын шонгийн эвдрэх магадлал Хүснэгт 4.10-д үзүүлэв.

#### Хүснэгт 4.10 Цахилгааны шугамын шонгийн эвдрэх магадлал (100 шон тутмын гэмтэх шонгийн тоо)

Шонгийн төрөл	МСК баллын шаталбар				
	6	7	8	9	10
Бетон	0.0	0.0	0.0	0.46	9.6
Мод	0.0	0.0	0.0	0.19	4.1

##### 2) Агаарын шугам

Агаарын шугамын эвдрэх магадлалыг Хүснэгт 4.11-т үзүүлэв. Эвдрэх магадлалыг АНУ-ын HAZUS-ын аргачлалаар тооцсон бөгөөд дундаж утгыг Ханшин Аважигийн газар хөдлөлтийн бодит мэдээллээс тооцож гаргасан үзүүлэлт болно.



### Хүснэгт 4.11. Агаарын шугамын эвдрэх магадлал

МСК баллын шаталбар	6	7	8	9	10	11=<
Эвдрэх магадлал (%)	0.00	0.03	0.57	15.0	67.7	97.5

### 3) Газар доорх далд шугам

Газар доорх далд цахилгаан шугамын эвдрэх магадлалыг Хүснэгт 4.12-т үзүүлэв. Уг эвдрэх магадлал нь агаарын шугамтай нэгэн адил, хамгийн их утгыг АНУ-ын HAZUS-ын аргачлалаар тооцсон бөгөөд дундаж утгыг Ханшин Аважигийн газар хөдлөлтийн бодит мэдээллээс тооцож гаргасан болно.

### Хүснэгт 4.12 Газар доорх далд цахилгаан шугамын эвдрэх магадлал

МСК баллын шаталбар	6	7	8	9	10	11=<
Эвдрэх магадлал (%)	0.00	0.01	0.12	1.17	6.72	23.3

### 4.6.3. Эрсдэлийн үнэлгээний дүнг Хүснэгт 4.13-т үзүүлсний дагуу нэгтгэнэ.

#### Хүснэгт 4.13 Хохирлын мэдээллийг нэгтгэх жишээ

Хохирлын төрөл			Хохирлын хэмжээ	Нэгж
Хүний хохирол	Нас барсан хүний тоо	Нийтийн орон сууц		хүн
		Амины сууц		хүн
	Гэмтэж бэртсэн хүний тоо	Нийтийн орон сууц		хүн
		Амины сууц		хүн
	Гэр оронгүй болсон хүний тоо	Нийтийн орон сууц		хүн
		Амины сууц		хүн
Барилгын хохирол	Нурсан, их хэмжээгээр эвдэрсэн	Барилгажсан хэсэг		ширхэг
		Гэр хороолол		ширхэг
	Нурангийн хэмжээ			тонн
Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ	Зам	Нэвтрэх боломжгүй болсон		цэг
	Гүүр	А аргачлал	Гүүрийн нэр	
		В аргачлал	Гүүрийн нэр	
	Цахилгааны шон	Нурсан		ширхэг

	Цахилгааны шугам	Эвдрэх магадлал		%
	Газар доорх шугам	Эвдрэх магадлал		%
	Цэвэр ус	Эвдэрсэн		цэг
	Бохир ус	Эвдрэх магадлал		%
	Дулаан	Эвдэрсэн		цэг

4.7 Газар хөдлөлтийн эрсдэлийн шинжилгээг илүү нарийвчилсан байдлаар хийхдээ газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид бус үнэлгээний хамрагдах талбайг торлож хуваах аргачлалаар үнэлж болно. Энэ тохиолдолд, уг зааврын хавсралт дахь “Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа”-нд үндэслэн гүйцэтгэнэ. Энэхүү зааварчилгааг ашиглахад газар хөдлөлт судлал, хөрс судлал, газар хөдлөлт тэсвэрлэлт судлалын мэргэжлийн мэдлэг туршлага шаардлагатай болох тул мэргэжлийн судлаачийн хяналтан доор үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

4.8. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгааны үр дүнд дараах мэдээллийг боловсруулна.

4.8.1. Цаашид газар хөдлөлтийн үнэлгээ (нарийвчилсан үнэлгээ) хийлгэх шаардлагатай барилга, орон сууцны болон дэд бүтцийн мэдээлэл бий болно.

4.8.2. Илэрсэн эрсдэлд хяналт тавих, эрсдэлийг бууруулах чиглэлд авах арга хэмжээний зөвлөмж боловсруулна. Зөвлөмжийг дараах чиглэлээр гаргаж болно.

4.8.2.1. Газар хөдлөлтийн гамшгаас тухайн орон нутагт учруулж болзошгүй эрсдэлийг бууруулах чадавхыг бий болгох.

4.8.2.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх.

4.8.2.3. Газар хөдлөлтийн гамшгийн улмаас учрах шууд хохирлыг зохион байгуулалтын болон инженер техникийн арга хэмжээг авч хэрэгжүүлж багасгах.

4.8.2.4. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулах, газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хөрөнгө төлөвлөх.

4.8.2.5. Шаардлагатай бол газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээнд авч үзсэн үзүүлэлт, тооцоо тус бүрээр нэг бүрчлэн шаардлагатай зохих арга хэмжээг тусгах.

## **Тав. Тайлан боловсруулах**

5.1. Газар хөдлөлтийн ерөнхий үнэлгээний үр дүнг баримтжуулсан тайланг Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг зааврын 4.2, 4.3-д заасны дагуу боловсруулна.

### **Зургаа. Эрсдэлийн үнэлгээний дүнг гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгах**

6.1. Эрсдэлийн үнэлгээнээс гаргасан үр дүнд үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө боловсруулна.

6.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар хөдлөлтийн гамшгаас төлөвлөгөө боловсруулахдаа “Аймаг, сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, “Нийслэл, дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг тус тус ашиглана. Эдгээр зааварт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа, үнэлгээ ба уг үнэлгээний дүнд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай удирдлага, хариу арга хэмжээ, хохирлыг арилгах төлөвлөгөө, газар хөдлөлтийн гамшгийн үеийн хойшлуулшгүй сэргээн босгох ажил болон гамшгийн дараах сэргээн босголтын төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай үндсэн удирдлага, чиглэлийг тусгасан болно.

6.3. Зааврын 6.2-д заасан зааврыг ашиглан төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах гарын авлагыг ашиглана. Уг гарын авлага нь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад ашиглах тодорхой аргачлалыг үзүүлсэн болно.

### **Долоо. Эксел програмд суурилсан газар хөдлөлтийн болзошгүй хохирлыг тооцоолох аргачлалын гарын авлага**

7.1. Болзошгүй хохирлын хэмжээг чанарын аргаар үнэлэхдээ “Эксел програмд суурилсан газар хөдлөлтийн болзошгүй хохирлыг тооцоолох аргачлалын гарын авлага”-ыг ашиглана.

#### **7.1.1. Ерөнхий зүйл**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн болзошгүй хохирлын хэмжээг тодорхойлохын тулд газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа, үнэлгээ хийнэ.

Онцгой байдлын ерөнхий газрын ажлын хэсэг, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас Онцгой байдлын ерөнхий газарт

хэрэгжүүлж буй “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх” төслийн мэргэжилтний баг хамтран газар хөдлөлтийн болзошгүй хохирлыг эксел програмаар тооцоолох аргачлал, аргачлалыг ашиглах гарын авлагыг боловсруулсан.

ЖАЙКА-аас 2013 онд хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд ашигласан аргачлал, үр дүнд суурилав.

### **7.1.2. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа, үнэлгээнд шаардлагатай мэдээлэл**

Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа, үнэлгээнд дараах мэдээллүүд шаардлагатай.

#### **7.1.2.1. Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ**

Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээг тодорхойлно. Үүнд “*Барилга, хүн амын мэдээлэл*”-ээс хойших мэдээлэл нь хангалттай эсэхээс шалтгаална. Голчлон хот, дүүрэг, сумын хэмжээнд хийхээр хамрах хүрээг тогтооно.

#### **7.1.2.2. Газар хөдлөлтийн эрчим (балл)**

Хохирлын тооцоог хийхэд газар хөдлөлтийн чичирхийллийн хэмжээ (балл)-г мэдэх шаардлагатай. Үүнийг газар хөдлөлтийн идэвхтэй хагарлаас тооцох бөгөөд дараах дарааллын дагуу тооцно.

- Газар хөдлөлтийн голомт болж болзошгүй идэвхтэй хагарлын урт, хагарал хүртлэх зайг тооцох
- Зайнаас хамаарах чичирхийллийн замхралыг тооцох
- Хөрсний шинж чанараас хамаарах чичирхийллийн амплификацийг тооцох

Гэвч эдгээрийг зөвхөн мэргэжлийн инженерүүд тооцох боломжтой тул энэхүү гарын авлагад “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22.01.01\*/2006/-ийн 1, 2 дугаар хавсралт дахь газар хөдлөлтийн Монгол Улсын төв суурин газар, хотын газар хөдлөлтийн баллыг ашиглана. Одон орон, геофизикийн хүрээлэнгээс боловсруулсан Монгол Улсын хэмжээнд аймгийн төвүүдийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг ашиглаж болно.

#### **7.1.2.3. Барилга, хүн амын мэдээлэл**

Барилгын хохирлын үнэлгээнд 2013 онд ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-д ашигласан аргачлалыг ашиглана. Үүнд “Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар” /БД 31.103.00/-ын дагуу хуучин барилгыг газар хөдлөлт тэсвэрлэлтээр нь 27 зэрэгт ангилсан байдаг. Дээрх ангилал тус бүрээр үнэлгээ хийх гэж буй бүс нутгийн барилгын тоо, тухайн барилгуудад амьдарч буй өрх, оршин суугчийн тоог гаргана. Үүнээс өрхийн тоо нь

чухал мэдээлэл бөгөөд 1 өрхөд ногдох оршин суугчийн тоог гаргахдаа нийт хүн амыг нийт өрхийн тоонд хувааж дундаж утгыг ашиглана.

Дараах хүснэгтэд нэг хотын мэдээллийг жишээгээр үзүүлэв.

Хүснэгт 1. Барилга, хүн амын мэдээлэл

Хуучин барилгыг газар хөдлөлт тэсвэрлэлтээр ангилсан ангилал	Барилгын зориулалт	Барилгын тоо	Өрхийн тоо
1	Орон сууц	30	1119
	Гэр	5752	5752
4.2	Олон нийтийн барилга	7	
7.1	Орон сууц	3	40
	Олон нийтийн барилга	12	
8	Орон сууц	8	158
8.1	Олон нийтийн барилга	3	
9	Амины сууц	104	104
	Дотуур байр	13	76
	Гэр хороолол дахь амины сууц	1217	1217
	Бусад сууц	8	8
11	Орон сууц	8	281
	Олон нийтийн барилга	15	
12.2	Орон сууц	5	95
	Олон нийтийн барилга	6	
Нийт	Орон сууц	54	1693
	Амины сууц	104	104
	Дотуур байр	13	76
	Гэр	5752	5752
	Гэр хороолол дахь амины сууц	1217	1217
	Бусад сууц	8	8
	Олон нийтийн барилга	43	0

#### 7.1.2.4. Авто замын мэдээлэл

Авто замын байгууламжийн ул хөрсийг “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22.01.01\*/2006/-ийн хүснэгт 1-д заасан хөрсний зэрэг (I, II, III зэрэг)-ээр ангилж, хөрсний зэрэг тус бүрд ногдох авто замын уртыг гаргана. Хэрэв хөрсний зэргийг тодорхойлох боломжгүй тохиолдолд “Тодорхойгүй” гэсэн ангилалд хамруулж түүнд ногдох уртыг гаргана.

#### 7.1.2.5. Гүүрний мэдээлэл

Гүүрний хувьд гүүр тус бүр дээр дараах хүснэгтэд заасан үзүүлэлтийг ашиглаж, эвдрэлийн зэргийг тогтооно.

## Хүснэгт 2. Гүүрний эвдрэлийг тооцох үзүүлэлт

Хөрсний зэрэг	1 дүгээр зэрэг
	2 дугаар зэрэг
	3 дугаар зэрэг
	Тодорхойгүй
Хөрсний шингэрэлт болох магадлал	Болохгүй
	Бага
	Өндөр
	Тодорхойгүй
Дам нурууны төрөл	Консолон гүүр
	Үргэлж дамнуруут гүүр
	Энгийн гүүр
Тулах хэсэг	Унахаас сэргийлсэн хамгаалалттай
	Уламжлалт
	Хоёр тулгуурт /Two moving bearing/
Тулгуурын өндөр	5м-ээс нам
	5м - 10м
	10 м-ээс өндөр
Алгаслын тоо	1
	2 ба түүнээс олон
Ригелийн тулаас	Урт (тулаасны урт (см)/алгасалын урт (м) $\geq 1$ )
	Богино (тулаасны урт (см)/алгасалын урт (м) $< 1$ )
Суурийн төрөл	Pile bent-ээс бусад
	Pile bent
Үндсэн материал	Тоосго эсвэл Бетон
	Бусад

Хөрсний шингэрэлт болох магадлалын тухай мэдээлэлгүй тохиолдолд “Тодорхойгүй”, элсэн хөрстэй бол “Өндөр” гэсэн сонголтыг хийнэ.

### 7.1.2.6. Инженерийн шугам сүлжээний мэдээлэл

#### (1) Газар доорх шугам

Ус хангамж, дулааны газар доорх шугамыг түүний материал төрөл, голч, урт тус бүрээр мэдээллийг цуглуулна. Материалын хувьд төмөр, ширэм, ган, PVC, асбест цемент, керамик гэж ангилана. Голчийн хэмжээг 75 мм-ээс доош, 75-300 мм, 300-500 мм, 500-1000 мм, 1000 мм-ээс дээш, тодорхойгүй гэж ангилна.

Ус хангамжийн шугамны хувьд зөвхөн материалын төрлөөр ангилах бөгөөд голчийнх тухай мэдээлэл шаардлагагүй. Хөрсний шингэрэлт болох магадлалын тухай мэдээлэлгүй тохиолдолд “Тодорхойгүй”, элсэн хөрстэй бол “Өндөр” гэсэн сонголтыг хийнэ.

#### (2) Цахилгааны шон

Бетон болон модон шон тус бүрийн тоог гаргана. Агаарын болон газар доорх кабелийн хувьд тус бүрийн уртыг гаргана. Хөрсний шингэрэлт болох магадлалын тухай мэдээлэлгүй тохиолдолд “Тодорхойгүй”, элсэн хөрстэй бол “Өндөр” гэсэн сонголтыг хийнэ.

### 7.1.3. Эксел программ ашиглаж хохирлын хэмжээг тооцох

Тус экселийн программ нь 15 хуудсаас бүрдэнэ. “Хүний хохирол”, “Барилгын эвдрэл”, “Авто замын эвдрэл”, “Гүүрийн эвдрэл”, “Ус хангамжийн шугамын эвдрэл”, “Бохир усны шугамын эвдрэл”, “Цахилгааны шон, кабелийн эвдрэл”, “Дулааны шугамын эвдрэл” тус бүрийн өгөгдөл оруулах болон тооцоо хийх хуудсаас бүрдэнэ.

“Хүний хохирол”-ын тооцооны хуудас гэж тусдаа байхгүй. Мөн “Хүний хохирол”-ыг тооцохоос өмнө барилгын хохирлыг түрүүлж тооцох шаардлагатай. Тооцооны хуудас тус бүрийн нэрийн ард Data&Cal гэсэн нэртэй байгаа бөгөөд энэхүү хуудасны тоо, томъёог Мэргэжлийн инженер агуулгыг ойлгосны үндсэн дээр өөрчлөхөөс бусад тохиолдолд өөрчилж болохгүй.

#### 7.1.3.1. Барилгын эвдрэлийг тооцох

Газар хөдлөлтийн балл, барилгын ангиллыг өгөгдөл болгон оруулахад эвдэрч нурах магадлалыг автоматаар тооцно.

### Хүснэгт 3. Барилгын эвдрэлийг тооцох

Өгөгдөл				
①	Хуучин барилгыг газар хөдлөлтийн тэсвэрлэлтээр нь ангилсан ангилал	Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар /БД 31-103-00/ Хавсралт 3	10.1 Тоосгон өрлөгөн даацын ханатай ба цутгамал төмөр бетон хучилттай барилга	5
②	Газар хөдлөлтийн эрчим	МСК шаталбар /балл/		8
Үр дүн				
③	Эвдэрч нурах магадлал		12.25	%

① дүгээрт барилгын ангиллыг сонгож, ② дугаарт газар хөдлөлтийн баллыг гараас оруулахад ③ дугаарт барилга нь эвдэрч нурах магадлалыг тооцон гаргана.

Энэхүү магадлалыг тухайн ангиллын барилгын тоо, түүн доторх өрхийн тоогоор үржүүлж эвдэрч, нурж болзошгүй барилгын тоо, өрхийн тоог тус тус олно.

Дараах хүснэгтэд жишээгээр үзүүлэв.

Хүснэгт 4. Нурах барилгын тоо болон гамшигт нэрвэгдэх өрхийн тоо (магадлал)

Хуучин барилгыг газар хөдлөлтөд тэсвэрлэлтээр ангилсан ангилал	Барилгын зориулалт	Барилгын тоо	Өрхийн тоо	Нурах магадлал (%)	Нурах барилгын тоо	Гамшигт нэрвэгдэх өрхийн тоо
1	Орон сууц	30	1119	5.2	2	58
	Гэр	5752	5752		300	300
4.2	Олон нийтийн барилга	7		5.2	0	
7.1	Орон сууц	3	40	16.9	1	7
	Олон нийтийн барилга	12			2	
8	Орон сууц	8	158	29.7	2	47
8.1	Олон нийтийн барилга	3		29.7	1	
9	Амины сууц	104	104	50.0	52	52
	Дотуур байр	13	76		7	38
	Гэр хороолол дах амины сууц	1217	1217		609	609
	Бусад сууц	8	8		4	4
11	Орон сууц	8	281	50.0	4	141
	Олон нийтийн барилга	15			8	
12.2	Орон сууц	5	95	69.1	3	66
	Олон нийтийн барилга	6			4	
Нийт	Орон сууц	54	1693		12	318
	Амины сууц	104	104		52	52
	Дотуур байр	13	76		7	38
	Гэр	5752	5752		300	300
	Гэр хороолол дахь амины сууц	1217	1217		609	609
	Бусад сууц	8	8		4	4
	Олон нийтийн барилга	43	0		15	0



### 7.1.3.2. Хүний хохирлыг тооцох

Хүний хохирлыг тооцохдоо орон сууц, амины сууцаар тус тусад нь тооцно. Дээрх жишээгээр орон сууц, дотуур байр нийлээд 356 өрх, амины сууц, гэр нийлээд 695 өрх гамшигт нэрвэгдэхээр гарсан байна. Энэ тоог эксел программд оруулбал нас барсан хүний тоо 194 хүн, гэмтсэн хүний тоо 241 хүн байхаар гарсан байна. Мөн гамшигт нэрвэгдсэн өрхийн тоог нэг өрхийн дундаж дундаж гишүүний тоогоор үржүүлбэл гэр оронгүй болсон иргэдийн тоо (амь насаа алдсан, гэмтэж бэртэж гэмтсэн хүний тоо) гарна.

Хүснэгт 5. Хүний хохирлыг тооцсон жишээ

Өгөгдөл		Хүний тоо
Орон сууц	Эвдэрч нурсан барилга дахь өрхийн тоо	356
Амины сууц	Эвдэрч нурсан барилга дахь өрхийн тоо	695
Нас барсан хүний тоо		194
Гэмтэж бэртсэн хүний тоо		241

### 7.1.3.3. Авто замын эвдрэл

Өгөгдөл оруулах хэсэгт хөрсний зэрэг, газар хөдлөлтийн баллыг тус бүр сонгож оруулна. Ингэснээр эвдрэх магадлал (эвдрэх цэгийн тоо/км) бодогдож гарна. Энэ утгыг тухайн хөрсөн дээрх авто замын нийт уртаар үржүүлбэл нийт эвдрэх цэгийн тоо гарна.

### 7.1.3.4. Гүүрийн эвдрэл

Гүүр тус бүрийн мэдээллийг 9 үзүүлэлтээр болон газар хөдлөлтийн баллыг оруулж сонголтоор оруулна. Ингэснээр А,В,С гэсэн 3 түвшнээр үр дүн гарах бөгөөд тайлбарыг дараах хүснэгтэд үзүүлэв.

## Хүснэгт 5. Гүүрийн эвдрэл

Эвдрэлийн түвшин	
A	- Гүүр нурах магадлал маш өндөр - Их хэмжээний хэв гажилтад орно - Урт хугацаанд ашиглах боломжгүй болж их хэмжээний засвар шаардлагатай болно.
B	- Гүүр нурах магадлал дунд зэрэг - Хэв гажилт үүсэнэ. - Түр ашиглах боломжгүй болж засвар хийх шаардлагатай болно.
C	- Гүүр нурах эвдрэл бага - Бага хэмжээний хэв гажилтад орно. - Үзлэг хийсний дараа ашиглах боломжтой.

### 7.1.3.5. Инженерийн шугам сүлжээний эвдрэл

#### (1) Ус хангамж, дулааны шугамын эвдрэл

Хөрсний шингэрэлт явагдах магадлал, материалын төрөл, голч болон газар хөдлөлтийн баллыг сонголтоор оруулснаар эвдрэх магадлал (Эвдрэх цэг/км) гарч ирнэ. Үүнийг нийт уртад нь үржүүлж нийт эвдрэх цэгийн тоог гаргана.

#### (2) Бохир усны шугамын эвдрэл

Хөрсний шингэрэлт явагдах магадлал, материалын төрөл, газар хөдлөлтийн баллыг сонголтоор оруулснаар эвдрэх магадлал (%) гарч ирнэ. Үүнийг нийт уртад нь үржүүлж нийт эвдрэх шугамын уртыг гаргана.

#### (3) Цахилгааны шугам

Хөрсний шингэрэлт явагдах магадлал, газар хөдлөлтийн баллыг сонголтоор оруулснаар 100 шон дутмын эвдрэх магадлал (%), агаарын болон газар доорх кабелийн эвдрэх магадлал 100 м тутамд %-аар гарч ирнэ. Үүнээс эвдрэх шонгийн тоо болон кабелийн уртыг гаргана.

### 7.1.4. Нийт хохирлын хэмжээг тооцоолон гаргах

Эксел программаар тооцоолж хохирлын нийт хэмжээг нэгтгэн гаргана. Дараах хүснэгтийн дагуу нэгтгэх боломжтой.

Хүснэгт 6. Болзошгүй нийт хохирлын хэмжээ

Хохирлын төрөл			Хохирлын хэмжээ	Нэгж
Хүний хохирол	Нас барсан хүний тоо	Орон сууцны хороолол		хүн
		Гэр хороолол		хүн
	Гэмтсэн хүний тоо	Орон сууцны хороолол		хүн
		Гэр хороолол		хүн
	Орон гэргүй болсон хүний тоо	Орон сууцны хороолол		хүн
		Гэр хороолол		хүн
Барилгын эвдрэл	Нурсан барилга	Орон сууцны хороолол		барилга
		Гэр хороолол		барилга
	Нуранги			Тонн
Дэд бүтэц, ИШС	Авто зам	Явах боломжгүй болсон		Цэг
	Гүүр	Эвдрэлийн түвшин А	Гүүрний нэр:	
		Эвдрэлийн түвшин В	Гүүрний нэр:	
	Цахилгааны шон	Эвдэрсэн		Ширхэг
	Агаарын кабель	Эвдэрсэн хувь		%
	Газар доорх кабель	Эвдэрсэн хувь		%
	Ус хангамжийн шугам	Тасарсан		Цэг
	Бохир усны шугам	Эвдэрсэн хувь		%
Дулааны шугам	Тасарсан		Цэг	

Дээрх хүснэгтэд орон сууцны хороолол, гэр хороолол гэж ангилсан боловч орон нутгийн түвшинд тохирсон ангиллаар гаргаж болно.

Нурангийн хэмжээг нурсан барилгын нийт талбайг олж, модон барилгад 0.5 тонн/м<sup>2</sup>, Төмөр бетон барилгад 1.0 тонн/м<sup>2</sup>-аар тооцно.

---oOo---

## 1-2 Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа

### 1-2-1 Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа

#### Газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээний аргазүйн зааварчилга

##### 1.Газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээний тодорхойлолт

Газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээний тодорхойлолт нь заавал тодорхой байх шаардлагагүй.

Газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээг газар хөдлөлтийн аюултай дэлхийн улс орнуудад хийж, газар хөдлөлтийн эрсдэлийн зураглал гэж нэрлэгддэг олон тооны зураг үйлддэг боловч агуулга нь маш их ялгаатай. Жишээлбэл, ямар нэгэн судалгаагаар тухайн бүс нутгийн ойр орчмын хагарлын тархалт ба өнгөрсөн хугацааны газар хөдлөлтийн каталогаас суурь чулуулаг дээрх газар хөдлөлтийн хүлээгдэж буй утгыг тооцоолон боловсруулсан газар хөдлөлтийн хүлээгдэж буй утгын тархалтын зургийг газар хөдлөлтийн эрсдлийн зураг гэж нэрлэдэг. Тэрчлэн өөр тохиолдолд, тодорхой газар хөдлөлтийн загварыг төсөөлөхгүйгээр геологийн тархалт, хөрсний суурийн тархалтын зургийг үндэслэн геологийн нөхцөл байдлаас чичирхийллийн хүч, лагжилтын аюулын түвшин, хад, чулууны нуралтын харьцангуй аюулын түвшинг, тухайлбал А~Е зэрэглэлээр харуулсан байдаг.

Эдгээр жишээнүүд дээр зөвхөн хөрсөнд учрах гамшгийг авч үзсэн бөгөөд орон сууц, сургууль, эмнэлэг зэрэг барилга байгууламж, зам, гүүр, төмөр зам, эргийн хамгаалалтын далан зэрэг дэд бүтэц, цэвэр бохир усны шугам сүлжээ, хийн хоолой, цахилгаан шугам сүлжээ зэрэг инженерийн байгууламж зэрэг газар хөдлөхөд хохирол учрах магадлалтай барилга байгууламжийн хувьд газар хөдлөх үеийн хохиролын хэмжээг тоон үзүүлэлтээр үнэлж тархалтыг нь зурагт буулгах тохиолдол ч бий.

Өнөө хүртэл хийж ирсэн газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээг хэд хэдэн талаас нь ангилж үзлээ.

а) Юуны өмнө үнэлгээний объектоор нь дараах байдлаар ангилж болно.

а-1) Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ

- Газар хөдлөлтийн эрчимийн үнэлгээ
- Лагжилтын аюулын түвшин
- Хад чулуу нурах аюулын түвшин

а-2) Байгалийн гамшгаас гадна байгалын гамшигаас учирах барилга байгууламжийн хохирлын эрсдлийн үнэлгээ

- Барилга байгууламж (орон сууц, эмнэлэг, сургууль, захиргааны барилга)
- Дэд бүтцийн барилга байгууламж (зам, гүүр, гүүрэн зам, төмөр зам, нисэх буудал, далан зэрэг)
- Инженерийн шугам сүлжээ (цэвэр бохир ус, хий, цахилгаа ба холбооны шугам сүлжээ)

а-3) Улмаар дээрх барилга байгууламжид учирсан хохиролоос улбалан үүсэх хоёрдогч хохиролын эрсдлийн үнэлгээ.

- Хүн амд учрах хохирол (амь үрэгдэх, шархдах, орон гэрээ алдах)
- Газар хөдлөлтөөс үүсэх түймэр(түймэрийн голомтын тоо, бүрэн шатсан байшингийн тоо)

а-4) Эд материалын хохиролоос гадна эдийн засаг нийгмийн нөлөөлөлийг хүртэл авч үзсэн үнэлгээ.

- Газар хөдлөлтөөс шууд учирсан хохиролын хэмжээ
- Эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсоноос учирсан хохирлын хэмжээ. (арилжаа наймаа, үйлдвэрлэлийн үй ажиллагаа зогссоны нөлөөлөл)
- Сэтгэл зүйн тасламж шаардлагатай хүмүүс гэх мэт.

б) Дараа нь тооны ба чанарын үнэлгээний ялгаагаар нь ангилж үзэв.

б-1) Тоон үнэлгээ

Тоон үнэлгээгээр газар хөдлөлтийн эрчмийн хүч болон барилга байгууламжийн хохирол зэргийг туйлын утгаар нь үнэлдэг. Газар хөдлөлтийн эрчмийн тохиолдолд чичирхийлэл хэмжээг, хурдатгал зэрэг барилга байгууламжийг хохиролын тохиолдолд хохирол учирсан барилгын тоог гаргана. Гэхдээ эцэсийн байдлаар болосвруулах шазар хөдлөлтийн эрсдэлийн зурагт туйлын утгаар биш ойлгоход хялбар “Зэрэглэлээр” илэрхийлэх тохиолдол ч байдаг.

б-2) Чанарын үнэлгээ

Чанарын үнэлгээгээр хохирлын туйлын хэмжээ биш, хохиролын аюулын харьцангуй түвшинд үнэлгээ хийнэ. Жишээлбэл, өнгөн хөрсийг үндэс болгон авч сэвсгэр хөрсөн дээр чичирхийлэл амархан мэдрэгддэг тул А зэрэглэл, ул чулуун хөрсөн дээр С зэрэглэл гэх мэтээр үнэлгээ хийнэ. Зэрэглэлийн ерөнхий тархалт ба цэгүүдийн харилцан харьцуулалтад ач холбогдолтой үнэлгээ юм.

с) Зорилгоор нь ангилах

с-1) Газар хөдлөлт тэсвэрлэх чадварын журмын шалгуур тогтооход шаардлагатай эрсдлийн үнэлгээ

Газар хөдлөлт тэсвэрлэх чадварын журам болон газар хөдлөлтийн даатгалын бүсийн ангилалд улсын нутаг дэвсгэрийг хэд хэдэн бүсэд хувааж, бүс тус бүрийн газар хөдлөлтийн аюулын төвшин болон өгөгдөл болгон оруулсан газар хөдлөлтийн эрчимийн пропорционал өсөлтийн коэффициентийг тогтооно.

Энэхүү түвшин болон коэффициентийг тогтоохын тулд хийдэг газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээгээр хохирлын хэмжээг тооцон гаргахаас илүүтэй өргөн бүс нутгийг нэгдсэн шкалаар үнэлж газар хөдлөлтийн харьцангуй аюулын хэмжээг тодорхой болгох нь чухал юм.

Иймд тодорхой голомтыг төсөөлөл болгон авсан газар хөдлөлтийн детерминистик хувилбар тогтоох биш аливаа газар хөдлөлтийн голомтын нөлөөллийг статистикийн хувьд нэгтгэсэн магадлалын газар хөдлөлтийн загварыг тогтооно. Үндсэндээ барилга байгууламжийн хохиролын түвшинд нөлөө үзүүлэх аюулын(байгалийн гамшгийн) үнэлгээ хийгдэнэ.

с-2) Гамшгаас хамгаалах арга хэмжээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд шаардлагатай газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээ.

Үр нөлөө бүхий гамшгаас хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн гамшгийн эсрэг төлөвлөгөө боловсруулахын тулд газар хөдлөхөд тухайн бүс нутаг ямар байдалтай болох вэ гэдгийг мэдэх явдал чухал ач холбогдолтой. Ижилхэн байгалийн гамшиг болох салхи усны гамшгийн тохиолдолд жил бүр учирдаг гамшгийн нөхцөл байдал үүсэхэд ямар хохирол хаана үүсэх магадлалтай байгааг эмпирик аргаар буюу туршлагаараа төсөөлж болно. Гэтэл үүнтэй харьцуулахад их хэмжээний хохирол учруулдаг газар хөдлөлт тэгтлээ байнга тохиолдоод байдаггүй.

Монголд гэхэд л баруун бүс нутагт нь 1905 онд магнитуд 8-аас дээш цуврал газар хөдлөлт болж байснаас гадна (Булнайн газар хөдлөлт) 1957 онд баруун өмнөд хэсэгт (Говь Алтайн газар хөдлөл) магнитуд 8.1-ийн газар хөдлөлт болж их хэмжээний хохирол учруулсан байна. Гэхдээ Улаанбаатарт хотод хохирол учруулсан газар хөдлөлт болсон тухай бүргэл мэдээ байдаггүй Харьцангуй саяхан хохирол учруулсан газар хөдлөлт боллоо гэхэд 10 жил, 20 жил өнгөрөхөд хохиролын туршлага нимгэрч, хүмүүсийн ой санаанаас арилдаг байна. Газар хөдлөлтийн интервал нь хүний амьдралыг хугацаатай харьцуулахад маш урт байдаг тул хохирлын туршлагыг ашиглаад явах хэцүү байдаг. Иймд одоо хохирол учруулсан газар хөдлөлт боллоо гэхэд энэ хот ямар байдалтай болох вэ гэдгийг бодитойгоор дүрслэн гаргахын тулд газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийдэг.

Энэхүү зааварчилгаа нь с-2 )-т дурьдсан гамшгаас хамгаалах арга хэмжээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд шаардлагатай газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээ хийхийг зорилго болгож байгаа юм. Газар хөдлөлт нь өргөн уудам нутаг дэвсгэрт байх аливаа юманд нөлөө үзүүлдэг байгалийн үзэгдэл юм. Газар хөдлөлтийн эрчим болон лагжилт зэрэг аюул, барилга байгууламжийн материалаг хохиролоор зогсохгүй инженерийн шугам сүлжээ тасалдсанаас нийгмийн амьдрал хүндрэх, эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орох зэргээр нийгэмд бүхэлд нь учрах хохиролын гинжин цувааг өргөжүүлдэг онцлогтой. Тэрчлэн хохиролын байдал нь хөрс зэрэг байгалийн нөхцлийн ялгаа төдийгүй, байшин барилга, зам харгуй зэрэг хиймэл байгууламжийн байдал, тэрчлэн гамшин болох үеийн шуурхай хариу арга хэмжээ зэргээс шалтгаалан өөр болно. Ийм зорилготой газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээнд газар хөдлөлтийн эрчмийн бодит тархалт болон хохиролын хэмжээний тооцоог үндэслэн газар хөдлөснөөс хойш хэдэн минут, хэдэн цаг, хэдэн өдөр, хэдэн долоо хоног гэсэн хугацаагаар хөөсөн газар хөдлөлтийн гамшгийн хувилбар боловсруулах ажил түгээмэл хийгддэг. Ийм тохиолдолд хийгддэг газар хөдлөлтийн эрсдлийн

үнэлгээ нь газар хөдлөлтийн урьдчилсан цогц симуляцт юм.

## 2. Мэдээлэл цуглуулах

### 2-1 Үндсэн зургийн масштаб болон тооцооны торны хэмжээ

Газар хөдлөлтийн эрсдлийн зураг боловсруулах үед ашигладаг үндсэн зургийн (basemap) зохистой масштаб нь тухайн судалгааны бүс нутгийн хэмжээнээс хамааран өөр өөр байдаг. Судалгааны бүс өргөн уудам нутаг дэвсгэрийг хамрах тохиолдолд хэт бага масштабтай зураг ашиглахад их хэмжээний зардал, хүч зарцуулах боловч үр ашиг багатай байдаг.

Тэрчлэн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээнд квадрат (эсвэл тэгш өнцөгт) торыг тооцооны нэгж болгон авах нь элбэг байдаг. Торны хэмжээний зохистой хэмжээ нь судалгааны бүс нутгийн талбайгаас хамааран өөр өөр байдаг. Бага хэмжээний тор ашиглах тохиолдолд харьцангуй тодорхой мэдээлэл шаардлагатай болно. Шаардлагаас давсан бага тор ашиглах нь их хэмжээний мэдээлэл боловсруулна гэсэн үг болох тул зайлсхийх хэрэгтэй.

Хүснэгт 2-1-д судалгааны бүс нутгийн талбайгаас хамааран санал болгох үндсэн зургийн масштаб болон торны хэмжээг харуулав.

Хүснэгт 2-1 Санал болгох үндсэн зургийн масштаб ба торы хэмжээний үзүүлэлт

Нутаг дэвсгэр	Масштаб	Торны хэмжээ
100 - 400 km <sup>2</sup>	1/25,000	250m
400 - 1,600 km <sup>2</sup>	1/50,000	500m
1,600 - 6,400 km <sup>2</sup>	1/100,000	1km
6,400 - 25,600 km <sup>2</sup>	1/200,000	2km

Дижитал хэлбэрээр биш хэвлэгдсэн зургийн хэлбэрээр мэдээлэл цуглуулах тохиолдолд, зургийн масштаб нь дээрх үндсэн зургийн масштабаас илүү нарийвчлалтай байх нь зүйтэй.

### 2-2 Олж авах шаардлагатай мэдээлэл

Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээнд олон төрлийн олон тооны янз бүрийн мэдээлэл шаардагдана. Төсөөлж буй аюул (байгалийн гамшиг) болон материаллаг хохиролын төрөл, ашиглах арга зэргээс хамааран шаардлагатай мэдээллийн агуулга ба нарийвчлал ялгаатай байна. Шаардлагатай мэдээллийг ерөнхийд нь дарах байдлаар ангилж болно.

#### а) Үндсэн мэдээлэл

- Засаг захирагаа
- Газар ашиглалт
- Хүн ам, барилга байгууламжийн тооллого
- Урьд өмнө болсон газар хөдлөлтийн хохиролын бүртгэл

#### б) Газар хөдлөлийн мэдээлэл

- Хагаралын зураг
  - Газар хөдлөлтийн тектоник бүтцийн зураг
  - Түүхэн газар хөдлөлтийн каталоги, бүртгэгдсэн газар хөдлөлтийн каталоги
  - Хүчтэй газар хөдлөлтийн бүртгэл
- c) Геологийн мэдээлэл
- Байр зүйн зураг
  - Геологийн зураг
  - Суурь хөрсний тархалт
- d) Геотехникийн мэдээлэл
- Өрөмдлөгийн график зураг
  - PS шалгалтын үр дүн
  - Хөрсний шинж чанар
  - Гүний усны тархалт
- e) Барилга байгууламжийн мэдээлэл
- Барилга байгууламжийн хийц
  - Барилга байгууламжийн тархалт
  - Газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварын норм, стандарт
- f) Дэд бүтцийн мэдээлэл
- Гүүрийн хийц, тархалт
  - Замын тархалтын зураг
  - Цэвэр усны шугам сүлжээний зураг болон тоног төхөөрөмжийн бүтэц
  - Бохир усны шугам сүлжээний зураг болон тоног төхөөрөмжийн бүтэц
  - Хотын хэрэглээний хийн шугам сүлжээний зураг болон тоног төхөөрөмжийн бүтэц
  - Цахилгаан шугам сүлжээний зураг болон тоног төхөөрөмж
  - Холбооны шугам сүлжээний зураг болон тоног төхөөрөмж

### **3. Аюулын дүн шинжилгээ**

Аюулын дүн шинжилгээнд янз бүрийн зарчим ба арга байдаг. Япон болон Калифорнид аюулын дүн шинжилгээ хийгдэх болсон 1970-аад онд хязгаарлагдмал мэдээлэл ашиглан эмпирик аргаар үнэлгээ хийдэг байсан байна. Түүнээс хойш бүх төрлийн мэдээллийг хуримтлуулан, дүн шинжилгээний арга боловсруулан, тооцоолон бодох машин хөгжиж, газар зүйн мэдээллийн систем(GIS) нэвтрүүлсэнээр янз бүрийн арга боловсруулан ашиглаж иржээ.

Гэвч эдгээр бүс нутгуудад боловсронгуй болсон шинэ аргыг байнга ашиглаж байгаа гэж болохгүй. Яагаад гэвэл дүн шинжилгээний арга нарийсах тусам олон тооны мэдээлэл шаардагдах бөгөөд мэдээллийн нарийвчлалаас хамааран үр дүн эмзэг болж ирнэ. Өөрөөр хэлбэл хангалттай мэдээлэл байхгүй тохиолдолд болон мэдээллийн нарийвчлалд асуудал байх тохиолдолд дүн



шинжилгээний боловсронгуй арга ашиглах нь алдаанд хүргэх магадлалтай. Иймд ашиглах ёстой дүн шинжилгээн аргын хувьд боловсронгуй арга гэхээсээ илүү олдсон мэдээлэлд нийцүүлэн сонгож авах шаардлагатай. Ийм нөхцөл байдлаас шалтгаалан одоо дэлхийн өнцөг буланд ашиглагдаж буй аюулын дүн шинжилгээний арга нь тухайн бүс нутаг, олдсон мэдээллийн байдал, зориулалт зэргээс хамааран янз бүр байдаг. Энэхүү аргачилалд судалгаанд хамрагдсан бүс нутагт таарсан дүн шинжилгээний аргыг сонгоход нэмэр болох үүднээс эдгээр аргыг доор хэд хэдэн том бүлэгт хуваан танилцуулав.

### 3-1 Газар хөдлөлтийн хувилбарыг сонгох

Газар хөдөлөлтийн хувилбарыг боловсруулах зарчим нь тухайн бүс нутгаасаа хамааран ихээхэн ялгаатай байдаг. Шаардлагатай мэдээлэл авч чадах эсэхээс шалтгаалах боловч судалгааны бүс нутгийн тектоникийн бүтэц болон газар хөдлөлтийн идэвхжилийн түвшний нөлөө маш их. Жишээлбэл, түүхэн газар хөдлөлтийн бүрэн бүтэн каталоги олж авч чадлаа ч гэсэн урьд өмнө хүчтэй газар хөдлөлт болж байгаагүй бүс нутагт зөвхөн түүхэн газар хөдөлөлтийг үндэслэн газар хөдлөлтийн хувилбар боловсруулах нь бодит бус юм. Ихэнх тохиолдолд хэд хэдэн ойлголтыг хослуулан хэрэглэдэг.

#### “Арга-1” Урьд өмнө болсон их хохирол бүхий газар хөдлөлтөд үндэслэх арга.

Энэхүү арга нь тодорхой газар хөдлөлтийн загварт үндэслэсэн ойлголт юм. Тодорхой газар хөдлөлтийн загвар нь “Тодорхой хагаралд болдог хамгийн том хэмжээний газар хөдлөлт нь бараг ижил хүч, ижил давтамжийн интервалаар болдог” гэсэн ойлголт юм. Энэ аргаар судалгааны бүс нутагт урьд өмнө хохирол учруулж байсан газар хөдлөлт ирээдүйд болохыг тооцоолдог.

#### “Арга-2” Идэвхтэй хагаралд үндэслэсэн арга.

Идэвхтэй хагарал гэдэг нь одоо идэвхтэй байх юм уу эсвэл урьд нь 1-2 сая жилийн хугацаанд байна байна идэвхжиж ирсэн бөгөөд ирээдүйд ч газар хөдлөлт болох магадлалтай хагаралыг хэлж байгаа юм. Мэдээж хэрэг ирдэвхтэй хагарал нь газар хөдлөлтийн хувилбар боловсруулах гол шалгуур болдог. Геологийн газрын зураг дээр олон тооны хагарал харуулсан байх боловч тэдний ихэнх нь “идэвхтэй” хагарал биш юм. Тухайн хагарал нь идэвхтэй хагарал уу идэвхгүй харагал уу гэдгийн тогтоох нь энэхүй аргын үндсэн цөм нь юм.

Дээр тайлбарласан аргуудад шаадагдах мэдээлэл болон шаардлагын түвшинг хүснэгт 3-1-д харуулав.

Хүнэгт: 3-1 Шаардлагатай мэдээлэл ба тэдгээрийг олж авах боломж. Газар хөдлөлтийн хувилбарыг сонгох.


Мэдээлэл	Шаардлагын түвшин	
	Арга-1	Арга-2
	Урьд болсон хохирол бүхий газар	Идэвхтэй хагаралд үндэслэсэн арга

	хөдлөлтийг үндэсэн арга	
Газар хөдлөлтийн гамшигтай холбоотой материал	А	С
Түүхэн газар хөдлөлтийн каталоги	А	В
Бүртгэгдсэн газар хөдлөлтийн каталоги	С	С
Идэвхтэй хагаралын байрлал, урт	С	А
Хагарал дээр газар хөдлөлт дахин болох интервал, хамгийн сүүлд болсон цаг үе.	С	В
<p>А : Судалгааны бүс нутгийн мэдээлэл маш чухал</p> <p>В : Шаардлагатай мэдээллээс таамаглал хийх боломжтой, эсвэл өөр бүсийн мэдээллийг орлуулан ашиглаж болно.</p> <p>С : Мэдээл авах нь зүйтэй</p>		

#### “Улаанбаатар хотын (1-р үе шат) тохиолдол”

Монгол улсад газар хөдлөлтийн бүртгэлийг Одон орон, геофизикийн судалгааны хүрээлэн хариуцдаг. 1900 оноос хойш болсон газар хөдлөлтийн голомт, магнитуд, газар хөдлөлт болсон он сар өдрийн тэмдэглэлийг хөтөлж байгаа боловч түүнээс өмнөх газар хөдлөлтүүд болсон он сар өдөр нь тодорхой бус юм. 1905 он болон 1957 оны газар хөдлөлтөөс бусдынх нь хувьд хохирлыг тухай мэдээ байхгүй, цэгцэлсэн мэдээллийн сан байдаггүй. Урьд өмнө болсон газар хөдлөлтийн тухай мэдээллээс газар хөдлөлтийн хувилбарыг боловсруулахад шаардлагатай материал авах боломжгүй.

Төслийн 1-р үе шатны судалгаанд газар хөдлөлтийн хувилбарыг боловсруулахдаа идэвхтэй хагарлыг үндэслэн боловсруулдаг “2-р аргыг” ашигласан байна. Зураг 3-1-д Улаанбаатар хот болон түүний ойр орчмын идэвхтэй хагаралын тархалтыг харуулав. Төслийн 1-р шатанд Хустайн хагарал дээрх газар хөдлөлтийг хамгийн их хохирол учруулах газар хөдлөлтийн хувилбар байна гэж үзэн боловсруулсан байна. Хүснэгт 3-2-д түүний түүний мэдээллийг харуулав.



Зураг 3-1 Улаанбаатар хотын ойр орчны идэвхтэй хагарал

Хүснэгт- 3-2 Хустайн хагаралын мэдээлэл

Урт	Өргөн	Гүн	Налуу өнцөг	Налуун чиглэл	Хамгийн их магнитут
80 км	21.2 км	15 км	45°	SE	7.6

### 3-2 Суурь хөрсөн дэх газар хөдлөлтийн эрчим

#### “Арга” зайнаас хамаарсан сарнилтын томъёо (PGA, PGV, Sa)

Газар хөдлөлтийн эрчим нь ерөнхийдээ магнитуд өндөртэй, чичирхийллийн голомт ойрхон байх тусам өндөр байдаг. Газар хөдлөлтийн ажиглалтын бүртгэлээс үзвэл магнитуд болон зайг параметр болгож авдаг эмпирик арга буюу зайнаас хамаарсан сарнилтын томъёог ихээхэн санал болгодог байна. Оргил хурдатгал PGA, оргил хурд PGV, хариу үйлчлэлийн спекторын зайнаас хамаарсан сарнилтын томъёог санал болгосон байна. Суурь хөрсөн дээр хийсэн ажиглалтын бүртгэл, хөрсөн дээрх ажиглалтыг үндэслэн тооцоолсон суурь хөрсөн дэх газар хөдлөлтийн эрчмийн үзүүлэлтийг ашигласан зайнаас хамаарсан сарнилтын томъёо хэрэглэсэнээр суурь хөрсөн дээрх газар хөдлөлтийн эрчимийг таамаглаж болно. Газар хөдлөлтийн эрчимийн хүчинд магнитуд болон зай төдийгүй, чичирхийллэлийн голомтын шинж чанар, газар хөдлөлтийн долгион тархах суурь чулуулгийн шигж чанар хүртэл нөлөөлөх тул эмпирик арга руу хөтөлсөн анханы үзүүлэлтүүдийн шинж чанараас хамаарна. Иймд судалгааны бүс нутагт хийгдсэн ажиглалтын бүртгэлээс зайнаас хамаарсан сарнилтын томъёог боловсруулах нь зүйтэй юм. Гэвч ингэхдээ магнитудын хүрээ, чичирхийллийн голомт хүртэлх зайн дахь хөрсний онцлог шинж чанар нь тодорхой харагдах газар хөдлөлтийн станцад бүртгэж авсан мэдээлэл байх шаардлагатай. Одоо ашиглагдаж буй зайнаас хамаарсан сарнилтын томъёо ашиглахдаа түүний хэрэглэгдэх хүрээнд нь анхаарал тавих хэрэгтэй

### “Арга-2” Гриний эмпирик функцийн арга

Бүртгэгдэж буй газар хөдлөлтийн эрчимийг газар хөдлөлтийн хагарал дээрх цаг орон зайн шилжилтийн тархалт болон тархалтын зам дахь нэгж шилжилтэд хамаарах орчны хариу үйлчлэлийн(Гриний функц) convolution-ээр загварчилж болно.Гриний эмпирик функцийн арга гэдэг нь Гриний онолын функцийн оронд бүртгэгдсэн сул чичирхийллийн эрчимийг гриний функц болгон ашиглаж том газар хөдлөлтийн эрчимийн синтез хийх зарчим юм.Том газар хөдлөлт болон жижиг газар хөдлөлтийн чичирхийллийн тархалтын зам нь адил байдаг бол жижиг газар хөдлөлийн чичирхийллийн эрчимд тархалтын зам ба газар хөдлөлт бүртгэх станцын ойролцоох хөрсний шинж чанар агуулагдаж байдаг тул жижиг газар хөдлөлтийн эрчимийг гриний эмпирик функц болгон ашиглах нь ихээхэн давуу талтай. Олон судлаачид гриний эмпирик функцийн аргыг судалж байгаагийн дотор Ирикура (1986) нэрд гарсан бөгөөд практик дээр ашиглагдаж буй аргын нэг юм. Суурь хөрсөн дэх газар хөдлөлтийн эрчимийг тооцоолохын тулд чулуулаг хөрсөн дээр байрлах газар хөдлөлт бүртгэлийн станцын чичирхийллийн бүртгэл хөрсөн дээрх чичирхийллийн бүртгэлээс эсрэг тооцоолсон суурь хөрстэй адил долгионы хэлбэрийг ашиглана. Боловсруулсан газар хөдлөлтийн хувилбар дахь чичирхийллийн голомтод болсон зохистой хэмжээний жижиг газар хөдлөлтийн бүртгэл байдаг бол энэ арга нь жижиг газар хөдлөлтийн станцад том газар хөдлөлтийг тооцоолон төсөөлөхөд тохиромжтой юм.

### “ Арга-3” Гриний статистик функцийн арга

Гриний эмпирик функцийн аргын томоохон дутагдал бол төсөөлж буй газар хөдлөлтийн хувилбарын чичирхийллийн голомтод болсон жижиг газар хөдлөлтийн бүртгэл шаардлагатай байдаг явдал юм. Үүнтэй харьцуулахад Гриний статистик функцийн аргаар бол жижиг газар хөдлөлтийн бүртгэлийн оронд газар хөдлөлтийн бүртгэлээс гаргаж ирсэн чичирхийллийн голомтын хагарлын динамик загвараас боловсруулах нөхцөлт газар хөдлөлтийн эрчимийн спекторыг ашиглан симуляци хийдэг.Энэ аргыг Ирикура санал болгосон бөгөөд (Камаэ нар 1991) ЗГХЭГ-аас улсын хэмжээнд хэрэгжүүлж буй төсөлд ашиглагдаж байгаа.

Дээр товч тайлбарласан арга тус бүрийн шаардлагатай мэдээлэл болон шаардлагын түвшинг хүснэгт 3-3-д харуулав.

Хүснэгт 3-3 Шаардлагатай мэдээлэл: суурь хөрсөн дэх газар хөдлөлтийн эрчим

Мэдээлэл	Шаардлагын түвшин		
	Арга-1	Арга-2	Арга-3
Зайнаас хамааран сарних томъёо		Гриний эмпирик функцийн арга	Гриний статистик функцийн арга
Газар хөдлөлтийн гамшигтай холбоотой материал	С	С	С
Түүхэн газар хөдлөлийн каталоги	А	А	А
Түүхэн газар хөдлөлтийн чичирхийллийн тархалт	С	С	С

Бүртгэгдсэн газар хөдлөлтийн тархалт	С	С	С
Бичил газар хөдлөлтийн каталоги	С	С	С
Хүчтэй газар хөдлөлтийн бүртгэл(бүртгэл, долгионы хэлбэр)		А	
Хүчтэй газар хөдлөлтийн бүртгэлийн станцын хөрсний байдлын талаарх материал		В	
Идэвхтэй хагарлын байршил ба урт	А	А	А
Идэвхтэй хагаралд газар хөдлөлт болох давтамж, хамгийн сүүлж идэвхжисэн цаг үе	С	С	С
GPS-аар хийсэн цардасын өөрчлөлтийн ажиглалтын бүртгэл	С	С	С
Монгол дахь зайнаас хамаарсан сарнилтын томьёо	В		
Монголын хагарлын урт ба магнитудын уялдаа холбоо	В		
Статик хагарлын загвар (Урт, өргөн, налуу, хагаралын хурд)	В	А	
Динамик хагарлын загвар(тэгш бус байдал, стресс уналт)			А
<p>А : Судалгааны бүс нутгийн мэдээлэл маш чухал  В : Шаардлагатай мэдээллээс таамаглал хийх боломжтой, эсвэл өөр бүсийн мэдээллийг орлуулан ашиглаж болно.  С : Мэдээл авах нь зүйтэй</p>			

### “1-р үе шатанд”

**Төслийн 1-р үе шатанд мэдээлэл олж авах боломжийг үндэслэн “Арга-1”-ийг ашигласан.**

Зайнаас хамаарсан сарнилтын томьёоны хувьд монголын газар хөдлөлтийн бүртгэлийг авч үзсэн үндсэн дээр Канногийн (2006) сарнилтын томьёог сонгож авсан болно. Канногийн томьёо нь ямар нэгэн цэг дээрх хагарал хүртэлх зай, магнитуд, газар хөдлөлтийн эрчимийн харилцан уялдаа холбооны томьёо юм. Зарчимын хувьд газар хөдлөлтийн хувилбарын магнитудыг бодохдоо хагарлын уртын функц гэж авдаг. 1-р үе шатанд Мацудагийн (1975) томьёог ашиглан магнитудыг бодож гаргасан

### 3-3 Өнгөн хөрсний амплитудын өсөлт

**“Арга” Урьд өмнө болсон газар хөдлөлтийн гамшигт үндэслэн арга**

Өнгөн хөрсний амплитудын өсөлтийн(Amplification) шинж чанарыг үнэлэх хамгийн шууд арга бол тухайн нутагт урьд өмнө болсон хохирол бүхий газар хөдлөлтөөс таамаглан тооцоолох арга юм. Шинэ өнгөн хөрс зузаан хуримтлагдсан нутагт ойр хавийн суурь чулуун хөрстэй нутагтай харьцуулахад их хэмжээний шазар хөдлөлтийн эрчим үүсэж, түүний тархалт нь хязгаарлагдамал хүрээн дотор ч ялгаатай байдаг байсныг урьд өмнө болсон газар хөдлөлт хэлээд өгнө. Том хэмжээний орон сууцны хороолол байгуулснаас хөрсний байдал ихээхэн

өөрчлөгдөөгүй байвал дараачийн том газар хөдлөлт болох үед ч хөрсний нөлөөлөл нэг их өөр биш байна. Урьд өмнө болсон газар хөдлөлтийн бүртгэл эсвэл хохиролоос таамаглан тооцоолсон чичирхийлэлийн хэмжээ, хурдатгал, суурь чулуун хөрсөн дээрх газар хөдлөлтийн бүртгэл, зайнаас хамаарсан сарнилтын томъёогоор таамаглан тооцоолсон үзүүлэлтийг харьцуулах замаар өнгөн хөрсний амплитудын өсөлтийн(Amplification) онцлог шинж чанарыг таамаглаж болно. Гэвч энэ аргыг ашиглахад тухайн судалгааны бүс нутгийг нэлэнхийд нь хамарсан их хохиролтой газар хөдлөлт урьд өмнө нь болж байсан байх шаардлагатай.

#### **“Арга-2” Геологи, геотехнологийн ангилалын арга**

Өнгөн хөрсөний геологи буюу бичил топографийн ангилал нь өнгөн хөрсөн дэх газар хөдлөлтийн эрчимийг тайлбарлахад өргөн ашиглагддаг. Геологи ба амплитудын өсөлтийн түвшний(Amplification) харилцан хамаарлын талаар Бушерд ба Гиббс(1976) болон Мидорикава (1987) зэрэг нэрд гарсан судлаачид байдаг. Тэрчлэн бичил топографийн ангилал ба өсөлтийн түвшний (Amplification) хамаарлын тал дээр японд Мацуока ба Мидорикава(1994) , (2003)Фужиото ба Мидорикава нарыг сайтар ашигладаг. Эдгээрийн хамаарлыг шалгуур болдог ул чулуун хөрсөн дээрх газар хөдлөлтийн бүртгэл болон бүх төрлийн өнгөн хөрсний нөхцөлийн цэг дээрх ажиглалт эсвэл хохиролоос таамаглан тооцоолсон газар хөдлөлтийн эрчимийн харьцуулалт, хөрсний тодорхой нөхцөлүүд нь өөрчлөгдөж буй цэг дээрх тооцоолсон газар хөдлөлтийн эрчимийн өсөлттэй харьцуулан тогтоодог. Гэвч эдгээр хамаарал нь дэлхий дахинд нийтлэг биш бөгөөд бүс нутгаасаа хамааран өөр байх магадлалтай.

#### **“Арга-3” S долгионы хурдыг ашигласан арга**

Өнгөн хөрсний геологи болон бичил топографын ангилалын оронд өнгөн хөрсөний ойролцоох S долгионы хурдыг ашиглан хөрсний амплитудын өсөлтийн түвшнийг үнэлэх арга юм. Газар хөдлөлтийн эрчмийн ажиглалт ба тоон анализыг үндэслэн тодорхой гүн хүртэлх S долгионы дундаж хурд болон өсөлтийн түвшний(Amplification) харьцаанд хүчтэй хамаарал байдгийг тодорхойлсон байдаг.

S долгионы хурд ба амплитудын өсөлтийн хамаарлыг илэрхийлсэн аргын хувьд Джойнер ба Фумал (1984), Бушерд (1991), Мидорикава (1994) нарын арга байдаг. Гэвч эдгээр хамаарал нь дэлхийн хэмжээнд нийтлэг, абсолют юм биш бөгөөд бүс нутгаасаа хамааран өөр байх магадлалтай.

#### **“Арга-4” Хариу үйлчлэлийн анализийг (1 хэмжээс) ашигласан арга**

Хөрсийг хэвтээ чиглэлд үргэлжилсэн олон үетэй загвар болгон илэрхийлж 1 хэмжээст S долгионы тархалтаас үүдсэн олон давхар тусгалыг симуляци хийж, өсөлтийн(Amplification) онцлогийг давтамжийн домейн дээр үнэлэх арга юм. Шугаман тооцоо, ижил шугаман тооцоо, шугаман бус тооцоо байдаг Суурь хөрсөнөөс өнгөн хөрс хүртэлх хөрсний бүтэц, S долгионы хурд, нягтрал, динамик шинж чанар зэрэг үзүүлэлтүүд шаардагдана.

**“Арга-5” Хариу үйлчлэлийн анализийг(2/3хэмжээс) ашигласан арга**

Хөрсийг 2 ба 3 хэмжээст загвар болгон илэрхийлж, Finite element method болон finite-difference method ашиглан тоон утгаар симуляци хийх арга юм. 1 хэмжээст тооцоотой харьцуулахад их хэмжээний үзүүлэлт шаардлагатай. Дээр дурьдсан бүх төрлийн аргад шаардагдах мэдээлэл болон шаардлагын түвшнийг хүснэгт 3-4-д харуулав.


Хүснэгт 3-4.Шаардлагатай мэдээлэл: Өнгөн хөрсний амплитудын өсөлт(Amplification)

Мэдээлэл	Шаардлагын түвшин				
	Арга-1	Арга-2	Арга-3	Арга-4	Арга-5
	Өмнөх газар хөдлөлтийн хохиролд үндэслэсэн арга	Геологи, геотехнологийн ангилалд үндэслэсэн арга	Өнгөн хөрсний S долгионы хурдыг ашигласан арга	Хариу үйлчлэлийн анализыг( 1 хэмжээст) ашигласан арга	Хариу үйлчлэлийн анализыг(2/3 хэмжээст) ашигласан арга
Урьд болсон хүчтэй газар хөдлөлийн чичирхийлэл ба хурдатгалын тархалт	A	B	B	C	C
Топографын зураг	C	B	B	B	B
Геологийн зураг	C	A	B	B	B
Бичил топографын зураг	C	A	B	B	B
Өнгөн хөрсний геологийн зураг	C	A	B	B	B
Өсөлт (Amplification) , ба геологи, бичил топограф, хөрсний чанарын хамаарал		B			
Өрөмдлөгийн график			A	A	A
Хурданы шалгалтын үр дүн			A	A	A
Өсөлтийн түвшин(Amplification) ба дундаж S хурданы хамаарал			B		
Статик хөрсний шинж чанар (N утга, нягтрал зэрэг)				B	B
Динамик хөрсний шинж чанар				B	B
Агаарын зураг	C	C	C	C	C
Суурь хөрсний гүн			B	A	
Суурь хөрсний 2 ба 3 хэмжээст тархалт					A
Хүчтэй газар хөдлөлтийн бүртгэл(хариу үйлчлэлийн тооцонд оруулах утга)				B	B
A : Судалгааны бүс нутгийн мэдээлэл маш чухал B : Шаардлагатай мэдээллээс таамаглал хийх боломжтой, эсвэл өөр бүсийн мэдээллийг орлуулан ашиглаж болно. C : Мэдээл авах нь зүйтэй					

**Төслийн 1-р үе шатанд**


Суурь хөрсөн дэх газар хөдлөлтийн эрчимийн тооцоонд ашигласан Канногийн томъёонд өнгөн

хөрсний амплитудын өсөлтийг(Amplification) нэмдэг хэсэг байгаа бөгөөд тэр нь хөрсний өнгөн үе 30 м дахь S долгионы хурдны (AVS30) функц юм. Иймд төслийн 1-р үе шатанд Канногийн сарнилтын томъёог сонгох үед “Арга-3”-ыг ашиглахаар болсон. Улаанбаатар хотод зөвхөн хуучин материал ашиглаад өнгөн хөрсний амплитудын өсөлтийг(Amplification) шинж чанарт үнэлгээ хийхэд хүндрэлтэй байсан. Иймд судалгааны бүс нутагт өрмийн судалгаа болон PS шалгалт хийж түүний үр дүнг ашиглан хөрсний загвар боловсруулан анализ хийсэн. Зураг 3-2-д хөрсний 30 метрийн S долгионы дундаж хурдны тархалтыг харуулав.




Зураг 3-2 Улаанбаатар хотын барилгажсан хэсгийн AVS30-ын тархалт

Өнгөн хөрсөн дэх хурдатгалын тархалт ба түүнээс тооцон гаргасан Улаанбаатар хотын төв хэсгийн MSK эрчимийн тархалтыг зураг 3-3 ба 3-4-д тус тус харуулав.



Зураг 3-3 Өнгөн хөрсөн дэх хурдатгалын тархалт





出典：調査団作成

Зураг 3-4 MSK эрчимийн тархалтын зураг

### 3-4 Лагжилтын аюулын түвшин

#### “Арга-1” Магнитуд ба чичирхийллийн голомт хүртэлх зайнд үндэслэх арга

Лагжилт чичирхийллийн голомтоос хамгийн холдоо хир зайтай үүсэх вэ гэдэг талаар олон судалгаа хийгдсэн байдаг бөгөөд тэдгээрийн үр дүнг “Лагжилт үүсэх зайн хязгаарын зурагт” нэгтгэсэн байдаг. Энэ уялдаа холбоо нь анхдагч мэдээлэл болон бүс нутгийн ялгааг агуулах бөгөөд яг ижил биш гэхэд ерөнхийдөө лагжилтыг судалж үзвэл зохих хүрээг тогтооход хэрэг болдог. Энэ хүрээн дотор гүний усны түвшин бага байвал лагжилтын аюул бага гэж үнэлж болно.

Урьд өмнө лагжилт үүсэж байсан газарт дараачийн газар хөдлөлтөөр лагжилт үүсэх явдал маш их байдаг. Иймд лагжилт үүсэх зайн хязгаар, гүний усны тархал, урьд өмнө болсон газар хөдлөлтөөр лагжилт үүсэж байсан эсэхийг нэгтгэн авч үзсэнээр лагжилтын аюулыг тодорхойлох боломжтой болно.

#### “Арга-2” Бичил топографын ангилалд үндэслэсэн арга

Лагжилт нь тунамал бодис үүсэх процессыг тусгасан бичил топографын ангилалын зурагтай харилцан хамаарал өндөр гэж үздэг. Жишээлбэл байгалаараа үүссэн далан болон хуучин горлын хэвгйд лагжилтын аюул өндөр байдаг. Урьд өмнө болсон газар хөдлөлтөөр лагжилт үүссэн газартай ямар уялдаа холбоо байгааг нарийвчлан шалгасны үндэсэн дээр тухайн бүс нутгийн дотор бие даасан дүгнэлт хийх шалгуурыг боловсруулж чадвал лагжилтын таамаглалыг өндөр нарийвчлалтай хийх боломжтой болно. Иймд агаарын зурагийн тайлбарыг ч бас ашигладаг.

#### “Арга-3” Геотехникийн загвар ашигласан тооцооллын арга

Энэ нь лагжилт үүсэх магадал өндөр хөрсөний лагжилтын эсэргүүцлийг таамаглан, газар хөдлөх үед үүсэх shear stress –ийг харьцуулан лагжилт үүсэхийг тодорхойлох арга юм.

Хөрсний лагжилтын эсэргүүцлийг Нутга ба СРТ шалгалтын үр дүнгээс таамаглан тооцоолох нь элбэг байдаг. Seed & Idriss (1971) ба японы автозамын холбооны (1980, 1991) арга өргөн хэрэглэгддэг.

Бүх төрлийн аргад шаардагдах мэдээлэл болон шаардлагын түвшнийг хүснэгт 3-5-д харуулав.

Хүснэгт 3-5 Шаардлагатай мэдээлэл: Лагжилтын аюулын түвшин

Мэдээлэл	Шаардлагын түвшин		
	Арга-1	Арга-2	Арга-3
	Магнитуд ба голомт хүртэлх зайд үндэслэсэн арга	Бичил топорграфын ангилалд үндэслэсэн арга.	Геотехникийн загвар ашигласан тооцооллын арга
Хамгийн их лагжилтын зай-магнитудын хамаарлын зураг	В	В	
Лагжилтын түүхийн зураг	В	А	В
Топографын зураг		В	
Геологийн зураг		В	
Бичил топографын ангилалын зараг		А	
Өнгөн хөрсөний геологийн зураг		А	
Өрөмдлөгийн каротажийн зураг (N утга эсвэл конус нэвтрэх эсэргүүцэл)			А
Хөрсний чанарын шалгалтын үр дүн (нягтрал,ширхэглэгийн тархалт)			А
Агаарын зураг		В	С
Гүний усны түвшний тархалт	В	В	А
<p>А : Судалгааны бүс нутгийн мэдээлэл маш чухал</p> <p>В : Шаардлагатай мэдээллээс таамаглал хийх боломжтой, эсвэл өөр бүсийн мэдээллийг орлуулан ашиглаж болно.</p> <p>С : Мэдээл авах нь зүйтэй</p>			

### Төслийн 1-р үе шат

Өрөмдлөгийн каротажийн зураг, хөрсний чанарын шинжилгээний үр дүн, гүний усны түвшний тархалтын мэдээлэл байсан тул тооцоо хийх боломжтой байсан. Гэвч тооцоо хийхээс өмнө гүний усны түвшин ба хөрсний бат бэхийг судалж үзэхэд Улаанбаатар хотын нийт нутаг дэвсгэрт гүний усны түвшнээс доошхи хөрсний N утга нь 20 дахин өндөр байсан тул лагжилт үүсэх магадлал бага гэж дүгнэсэн болно.

### 3-5 Хөрсний гулгалтын аюулын түвшин

**“Арга-1” Магнитуд ба чичирхийллийн голомт хүртэлх зайд үндэслэх арга**

Хөрсний гулгалт нь чичирхийллийн голомтоос хамгийн ихдээ хир хэмжээний зайд үүсэх вэ гэдэг талаар олон тооны судалгаа хийгдсэн байдаг бөгөөд тэдгээрийн үр дүнг “Хөрсний гулгалт үүсэх зайн хязгаарын зурагт” нэгтгэсэн байдаг. Энэ уялдаа холбоо нь анхдагч мэдээлэл болон бүс нутгийн ялгааг агуулах бөгөөд яг ижил биш гэхэд ерөнхийдөө хөрсний гулгалтыг судалж үзвэл зохих хүрээг тогтооход хэрэг болдог.

Урьд өмнө хөрсний гулгалт үүсэж байсан газарт дараачийн газар хөдлөлтөөр хөрсний гулгалт үүсэх явдал маш их байдаг. Иймд хөрсний гулгалт үүсэх зайн хязгаар ба урьд өмнө болсон газар хөдлөлтөөр хөрсний гулгалт үүсэж байсан эсэхийг нэгтгэн авч үзсэнээр хөрсний гулгалтын аюулын тодорхойлох боломжтой болно.

**“Арга-2” Хэд хэдэн зүйлийн үнэлгээнд үндэслэсэн тогтвортой байдлын үнэлгээ**

Хөрсний гулгалтад хэвгий талын өндөр, налуугийн өнцөг, геологи, хур тундас зэрэг топограф, геологийн элементүүд нөлөө үзүүлдэг. Урьд өмнө болсон газар хөдлөлтээр хөрсний гулгалт үүссэн газар болон эдгээр элементүүдийн харилцан хамаарлыг тодорхойлж чадвал энэ харилцаа холбоог ашиглан хөрсний гулгалт үүсэх магадлал өндөр газрыг геологийн зурагаас тодорхойлох боломжтой болно.

**“Арга-3 Зуурамтгай чанар ба дотоод үрэлтийн өнцөгт үндэслэсэн тоон анализ**

Тодорхой нэг хэвгий газрын тогтвортой байдлын анализ хийх арга юм. Хэвгий талын налуугийн байдал, дотоод үрэлтийн өнцөг, хөрсний зууралдах чадвар зэрэг мэдээлэл хэрэгтэй болно. Гэвч одоо санал болгож буй хэд хэдэн аргыг өөр өөр газар туршиж, шалгаж үзсэн бөгөөд бодит байдал дээр хэрэглэхэд урьд өмнө болсон газар хөдлөлтөөс үүдэлтэй хөрсний нуралтыг ашиглан шалгаж үзэх шаардлагатай.

Дээр дурьдсан бүх төрлийн аргад шаардагдах мэдээлэл болон шаардлагын түвшнийг хүснэгт 3-6-д харуулав.


Хүснэгт 3-6 Шаардлагатай мэдээлэл: Хөрсний гулгалтын аюулын түвшин

Мэдээлэл	Шаардлагын түвшин		
	Арга-1	Арга-2	Арга-3
Магнитуд ба голомт хүртэлх зайд үндэслэсэн арга		Хэд хэдэн зүйлийн оноонд үндэслэсэн тогтвортой байдлын үнэлгээ	Зуурамтгай чанар ба дотоод үрэлтийн өнцөгт үндэслэсэн тоон анализ
Хамгийн их хөрсний гулгалтын зай ба магнитудын хамаарлын зураг	В	В	
Хөрсний гулгалтын түүхийн зураг	В	В	А
Топографын зураг		А	С

Геологийн зураг		A	C
Хур тундасны хэмжээний тархалтын зураг		B	C
Гидрогеологийн зураг		C	C
Өндөрийн дижитал мэдээлэл		C	A
Хөрсний чанарын шалгалтын үр дүн (зуурамтгай чанар ба дотоод үрэлтийн өнцөгт)			A
<p>A : Судалгааны бүс нутгийн мэдээлэл маш чухал</p> <p>B : Шаардлагатай мэдээллээс таамаглал хийх боломжтой, эсвэл өөр бүсийн мэдээллийг орлуулан ашиглаж болно.</p> <p>C : Мэдээл авах нь зүйтэй</p>			

### Төслийн 1-р үе шатанд

Улаанбаатар хотод хөрсөний гулгалт, нурангийн тухай түүхэн мэдээлэл байгаагүй тул тооцоолж буй газар хөдөлөлтийн оргил хурдатгал болон өндөршлийн мэдээллээс тооцоолон гаргах боломжтой байр зүйн хүчин зүйлүүдийг агуулсан арга тохиромжтой гэж үзэн, “Арга-2”-ыг ашиглан, Учида нарын (2004) налуугийн тогтвортой байдлын үзүүлэлтийн үнэлгээний аргыг хэрэглэв. Энэхүү аргыг ашиглан хөрсөний гулсалтын аюулын түвшинг 4 шатанд ангилан үнэлгээ хийлээ. Үр дүнг нь зураг 3-5-д харуулав.



Зураг 3-5 Хөрсний гулсалтын аюулын түвшний үнэлгээний зураг.

## 4. Хохирлын коэффициент

### 4-1 Барилгын хохирлын коэффициент


Барилгын хохирлын хэмжээг тодорхойлох зорилго нь барилгын эмзэг байдлын одоогийн хэм хэмжээг тодорхойлсоны үндсэн дээр судалгаа хийх нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт болох үеийн хохирлын хэмжээг тооцоолж, богино, дунд болон урт хугацааны гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөө тус бүрийн эхний ээлжинд авч хэрэгжүүлэх дарааллын дагуу арга хэмжээ авч, ирээдүйн газар хөдлөлтийн хохирлыг бууруулах зорилготой.

Хүн амд учрах хохирол нь өмнө болж байсан хүчтэй газар хөдлөлтийн үед барилга нурах, хэсэгчлэн эвдрэхтэй шууд хамааралтай бөгөөд барилга нурж, эвдэрсэний улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэл 80-аас дээш хувийг эзэлж байна.

Газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээ хийх үеийн барилгын хохирлыг тодорхой голомтод тулгуурлан газар хөдлөлтийн чичирхийлэл болон барилгын ангилал тус бүрээр хохирлын коэффициент, мөн барилгын тоотой харьцуулан тоон үзүүлэлтээр тооцож гаргадаг. Барилгын ангилал тус бүрийн одоогийн хохирлын коэффициентийг тогтоох, өөрөөр хэлбэл статистик аргачлалаар барилгын хийц тус бүрийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн байдлыг тодорхойлох нь хамгийн чухал юм.

Барилгын хийц тус бүрийн газар хөдлөлтийн тэсвэржилт нь ихэвчлэн хийцийн материал, барилга баригдсан болон зураг төсөл хийгдсэн он, барилгын давхар, барилгын ажлын түвшин, хөрсний төрөл, байдлаас шалтгаалан ялгаатай байдаг. Эдгээр үзүүлэлтийг судлахдаа одоо байгаа материал, тоо баримтыг цуглуулж, үр дүнтэй ашиглах, эсвэл боломжит цар хүрээ, агуулга, нарийвчлалыг тогтоож, шаардлагатай тохиолдолд бие даасан судалгаа шинээр хийх хэрэгтэй болдог. Одоо байгаа болон шинээр цуглуулах материалын цар хүрээ, агуулга, нарийвчлал зэргээс шалтгаалан газар хөдлөлтийн тэсвэржилтийн нарийвчлалд зөрүү гардаг.

Зураг 4-1-д барилгын хохирлын коэффициентыг тодорхойлох үеийн дарааллыг үзүүлэв. Дөрвөлжин доторх агууллагууд нь харилцан хамааралтай боловч дарааллын хувьд нэгэн жигд хамаарал үгүй. Дугаарын дарааллын дагуу барилгын хохирлын коэффициентийг тодорхойлох мэдээлэл, материалыг олж сонгох, мөн ашиглах аргачлалын талаар тайлбарлана..



Зураг 4-1 Барилгын хийцийн хохирлын коэффициентийг тодорхойлох дараалал

## 1) Барилгын инвенторын судалгаа

Барилгын инвенторын судалгаа нь барилгын нийтлэг ангилал, мөн түүнчлэн газар хөдлөлтийн тэсвэржилтийн талаарх хялбар судалгаа бөгөөд хохирлын зураглалд үзүүлэх цар хүрээ (тухайн газар, нутаг дэвсгэрийн зориулалт) дэх төрөл зүйлүүдийн статистик тоо хэмжээ шаардлагатай. Барилгын инвенторын судалгааны гол шалгуур үзүүлэлт болон тэдгээрийн нэн чухал шаардлагатай дарааллыг Хүснэгт 4-1-д үзүүлэв.

Газар хөдлөлтийн тэсвэржилтийг тодорхойлоход шаардлагатай тоо баримт бүрэн бүрдсэн байх нь ховор бөгөөд газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээ хийхийн тулд тусгайлан судалгаа явуулах нь цөөнгүй.

### “Төслийн 1-р үе шатанд”

Төслийн 1-р үе шатанд Улаанбаатар хотын 2010 онд боловсруулсан мэдээллийн санг ашигласан.

**Хүснэгт 4-1 Барилгын инвенторын судалгааны шалгуур үзүүлэлт**

Тоо баримтын үзүүлэлт	Нэн чухал дараалал
Барилга баригдсан газар	○○○
Барилгын зориулалт (энгийн ба холимог)	○○○
Нутаг дэвсгэрийн зориулалт (хуулиар заасан заалт, хот төлөвлөлт)	○○
Эзэмшлийн хэлбэр (олон нийтийн, хувийн)	○
Хийцийн төрөл (төмөр бетон, өрөгт бүтээц, ган, модон хийц зэрэг хийцийн нарийвчилсан ангилал)	○○○
Барилга баригдсан ба зураг төсөл хийгдсэн он (газар хөдлөлтийн гэсвэржилтийн норм дүрэм шинэчлэгдсэн үе, барилгын ажлын хяналт, барилгын ажлын чанар, түвшин зэргийн өөрчлөлт)	○○○
Барилгын давхар (газар дээр, газар доор)	○○○
Газар хөдлөлтөд гэсвэртэй төсөллөгдсөн болон гэсвэртэй төсөллөгдөөгүй барилга	○○
Газар хөдлөлтөд гэсвэртэй болгон хүчитгэл хийсэн эсэх	○○○
Хэвтээ, өндөржилтийн тэнцвэргүй байдал	○○
Өргөтгөл, өөрчлөлт хийгдсэн эсэх	○
Хөрсний төрөл, байдал	○○○
Хохирлын түүх (газар хөдлөлт, гал түймэр, үер гм)	○○
Богино багана, чичирхийлэл тусгаарлагч давхартай эсэх	○○○
Заадас холбоос (шал, дэвэр, хананаас авах зай)	○
<p>Нэн чухал дарааллыг хохирлын коэффициентийг тодорхойлох дарааллын дагуу дараах 3 түвшинд хуваасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>○○○ : Нэн чухал шаардлагатай, заавал судлах</li> <li>○○ : Чухал шаардлагатай, боломжтой бол барилга барьсан болон ашиглалт хариуцсан хүмүүсээс асуумж хэлбэрээр мэдээлэл авах</li> <li>○ : Нийтлэг үзүүлэлт, тодорхой мэдээлэл байхгүй тохиолдолд судалгаа хийж буй ажилтан шийдвэрлэх</li> </ul>	

**2) Тухайн нутаг дэвсгэрийн хийцийн төрөлд эзлэх хувь**

**“Төслийн 1-р үе шатанд”**

Төслийн 1-р үе шатанд Улаанбаатар хотын мэдээллийн санд үндэслэн барилгыг дараах 7 төрлийн хийцэд ангилж, эзлэх хувийн жинд шинжилгээ хийсэн.

**Хүснэгт 4-2 Төслийн 1-р үе шатны үеийн хийцийн ангилал**

No.	
1	Steel Төмөр карказан
2	RC Хүчитгэсэн төмөр бетон
3	Large PC panel Бетон угсармал хавтан
4	Brick masonry Тоосгон өрөгт

5	Concrete brick masonry Бетон өрөгт
6	Wood Модон
7	Others Бусад

### 3) GIS зураглал дахь барилгын мэдээлэл (байрлал)

Улаанбаатар хотын мэдээллийн сан нь GIS мэдээллийн сан бөгөөд барилгууд полигон мэдээ байдлаар орсон байдаг. Дүн шинжилгээ хийхэд шаардлагатай факторуудад хаяг, зориулалт, хийцийн төрөл, барилгын давхар зэрэг багтах ба эдгээрийг ашигласан. Барилга, байгууламжийг торон сетканд тухайн барилга байгууламжийн гол цэг байрлах газарт байрлана гэж тооцсон.

### 4) Тооллого бүртгэлийн мэдээ (барилгын тоо, хүн ам)

#### “Төслийн 1-р үе шатанд”

Төслийн 1-р үе шатанд 2011 оны Улаанбаатар хотын хүн амын статистик мэдээг ашигласан.

### 5) Инвентор статистик

Тухайн үеийн инвентор статистикт хийцийн төрөлд гол анхаарлаа хандуулсан бөгөөд барилга баригдсан болон зураг төсөл хийгдсэн он, барилгын давхар, барилгын зориулалт зэрэг аль болох нарийвчилсан ангиллаар нэгтгэх нь чухал. Тоо мэдээг зураглал дахь цар хүрээ тус бүрээр нэгтгэнэ. Ингэж нэгтгэсэн тооноос туслах факторуудыг нийлүүлж, гол 10-аад фактор (ихдээ 20 дотор)-ыг ялган авч, хохирлын коэффициентийг тооцно.

### 6) Барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн төсөллөлтийн норм

Одоо байгаа барилгын тэсвэржилтийг тодорхойлох нь барилгын хохирлыг тооцоолоход хамгийн чухал шаардлагатай ажил юм. Өөрчлөгдөж ирсэн газар хөдлөлтийн тэсвэржилтийн норм, мөн барилгын зөвшөөрөл авах барилгын тэсвэржилтийг тоон үзүүлэлтээр мэдэх боломжтой. Тэсвэржилтийн норм нь хуулиар заасан хамгийн доод хэмжээ бөгөөд аль ч үед тухайн доод хэмжээнд дөхүү барилгууд ихээр баригддаг.

Барилгын тэсвэржилтийн нормын өөрчлөлтийн судалгаа хийснээр барилга баригдах, зураг төсөл хийгдэх үеийн ангиллыг ашиглах, тухайн цаг үе бүрийн тэсвэржилтийг мэдэх боломжтой болно. Мөн тэсвэржилтийн норм, барилгын зөвшөөрөл авах шаардлагагүй барилгын тэсвэржилтийн тухайд тухайн цаг үеийн тэсвэржилтийн нормын хэм хэмжээ болон барилгын ажлын явц байдлыг асууж судлаад, нэгтгэн төсөөлөх боломжтой.

### 7) Барилгын зөвшөөрөл хүсэх, хяналтын байдлын судалгаа

Барилгын газар хөдлөлийн тэсвэржилтийн норм батлагдаж, барилгын зөвшөөрөл хүсэж, хяналт хийгдсэн байлаа ч хүсэлт гаргах болон хяналт хийгдэх цар хүрээ, агуулга, мөн тухайн барилгын хэдэн хувь нь бодитоор зөвшөөрөл авч, хяналт хийгдсэн бэ гэдэг нь тухайн цаг үеэс шалтгаалан ялгаатай байдаг тул сайтар судлах шаардлагатай. Зөвшөөрлийн хүсэлт, хяналтын цар хүрээ нь тухайн барилгын нийт хэмжээний 10 %-30 %-д явагдах нь нийтлэг бөгөөд тэр



дундаа 50 %-100 %-д нь бодитоор зөвшөөрөл хүсэж, хяналт хийгдсэн байх нь олон. Улаанбаатар хотод төрийн буюу олон нийтийн барилгын ажилд зөвшөөрөл хүсэж, хяналт хийхийг хуулиар заасан байдаг боловч хувийн хэвшлийн барилга хамрагдахгүй байсан байж магадгүй. Хэзээ, ямар норм дүрэм батлагдаж, хэр хэмжээнд мөрдөгдөж байсан талаар өнгөрсөн нөхцөл байдлыг мэдэж авах нь хийцийн төрлөөр нь ангилахад чухал мэдээлэл болж ирнэ.

#### **8) Хийцийн төрөл тус бүрээр тэсвэржилтийн үзлэг**

Газар хөдлөлтийн тэсвэржилтийн үзлэг нь маш их ажиллагаатай хэдий ч одоо байгаа барилгын тэсвэржилтийг шууд, нарийвчлан тодорхойлох боломжтой бөгөөд барилгын хохирлын коэффициентийг тооцоолох үүднээс ихээхэн үр дүнтэй ажил юм. Газар хөдлөлтийн тэсвэржилтийн үзлэгийн норм батлагдсан улс цөөн ч газар хөдлөлт ихээр болдог улс орнуудад засгийн газар, их дээд сургууль хамтран тэсвэржилтийн үзлэгийн хэд хэдэн аргачлалыг судалж, хэрэгжүүлдэг.

#### **“Төслийн 1-р үе шатанд”**

Төслийн 1-р үе шатанд барилгын зориулалт, хийцийн төрөл, барилгын давхар зэрэг нь зохих хэмжээнд ялгаатай байх 30 барилгыг сонгож, динамик шинжилгээ хийж тэсвэржилтийг үнэлсэн.

#### **9) Барилгын одоогийн байдлыг газар дээр нь судлах**

Газар дээрх судалгаа нь барилгын бүтээцийн инженер хийх үзлэг судалгаа бөгөөд судалгаанд хамрагдах нийт нутаг дэвсгэрт байрлах барилгыг үзэх нь зүйтэй бөгөөд боломжтой бол холбогдох хүмүүсээс асууж ярилцан, бусад нутаг дэвсгэрийн барилгыг харьцуулах байдлаар үзвэл зүгээр. Барилгын одоогийн байдлын тухайд тухайн нутаг дэвсгэр, дүүрэг дэх хийцийн төрөл ба хийцийн онцлог, барилгын давхар, шинэ ба хуучин хороолол (баригдсан он), хөрсний байдал, барилга ба авто зам, хоосон газар, ногоон байгууламж, мөн түүнчлэн барилгын ажил явагдаж буй байдал зэргийг нийгэд нь үзэж танилцах замаар судална. Газар дээр нь судлах ажил нь барилгын хохирлын коэффициент тодорхойлох хийцийн төрлийг сонгох, тэсвэржилтийн чадварыг тодорхойлох үед лавлагаа мэдээлэл байдлаар ашиглагдана.

#### **10) Чухал, аюултай байгууламжийн инвентор судалгаа**

Чухал байгууламж гэдэг нь хүчтэй газар хөдлөлт болсон үед аврах, шуурхай ажиллагааны стратеги удирдлагын төв, гол хүлээн авах зориулалт бүхий барилга, байгууламж юм. Төвийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын барилга, эмнэлэг, сургууль (цугларах газар, сургуулийн хашааны талбай), сүм хийд, спортын байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, талбай гэх зэрэг гамшигт өртөгсдийг аврах, шуурхай ажиллагааг удирдан зохион байгуулах төв, гамшигт өртөгсөд болон орон гэргүй болсон хүмүүсийг байрлуулах боломжтой тоноглол, орон зай талбайтай байх ёстой. Аюултай байгууламж гэдэг нь хүчтэй газар хөдлөлт болсон үед тухайн байгууламж дахь аюултай бодисын улмаас үүсэж болзошгүй гал түймэр, дэлбэрэлт, хий, химийн бодис алдагдах зэрэг хүн амд хохирол учруулах магадлалтай байгууламжийг хэлнэ.

Чухал болон аюултай байгууламжийн байршил нь тун чухал бөгөөд гамшигт өртөгсдийг яаралтай хүлээж авах, шуурхай арга хэмжээ, түр байрлах болон нүүлгэн шилжүүлэх газрын байршил нь хүн амын тоотой харьцуулахад тохирох байрлалд байгаа эсэхийг урьдчилан судалж тодорхойлох үед ч хэрэг болдог. Нөгөөтэйгүүр аюултай байгууламжаас орон сууцны барилга зэрэг нь тодорхой зайтай байрлаж буй эсэхийг шалгах хэмжүүр болдог.

#### **11) Хийцийн төрлөөр ангилах**

Барилгыг хийцийн материал, хэлбэрээр ангилж, газар хөдлөлтийн тэсвэржилтийн хэмжээ, өөрөөр хэлбэл газар хөдлөлтийн үед хохирол учрах магадлалаар нь зохих байдлаар ангилах нь барилгын хохирлыг тооцоолоход чухал шаардлагатай ажил юм.

#### **“Төслийн 1-р үе шатанд”**

Төслийн 1-р үе шатанд Улаанбаатар хотын мэдээллийн санд 2)-ын Хүснэгт 4-2-д үзүүлсэн хийцийн ангиллаас өөр ангиллын мэдээ байгаагүй тул тэр чигээр нь ашигласан.

#### **12) Хийцийн төрөл тус бүрээр тэсвэржилтийг тодорхойлох**

Дээрх 11)-д ангилсан хийцийн төрлүүдийн тэсвэржилтийг тодорхойлох нь барилгын хохирлыг тооцоолоход тун чухал үүрэгтэй. Хийцийн төрөл тус бүрийн тэсвэржилтийг тодорхойлох аргачлал нь Америк, Европ, мөн Японд хэрэглэгддэг үнэлгээний аргачлалаас гадна хэд хэдэн дээд сургууль, төрийн байгууллагаас бие даан хэрэгжүүлдэг аргачлал бий. Судалгаанд хамрагдах нутаг дэвсгэрийн барилгад тохирч, тэсвэржилтийг зөв үнэлэх боломжтой аргачлалыг ашиглах нь зүйтэй.

Барилгын тэсвэржилтийг тодорхойлох гол аргуудын талаар дор тайлбарлав.

##### **А) Америкт**

- АТС нь MMI балл эсвэл PGA-д барилгын элэгдлийг тохируулж, хийцийн төрлөөр стандарт үзүүлэлтийг гаргаж, тэсвэржилтийн үнэлгээний материалаар хангадаг : АТС-13, 14 & 21
- FEMA нь хэвтээ деформацаас тэсвэржилтийг төсөөлөх аргачлал болон хэвтээ чиглэлийн ачааллыг тооцож газар хөдлөлтийн тэсвэржилтийг шууд тооцоолох аргачлалыг гаргасан : HAZUS-99, FEMA-154, 155, 178, 237 & 310

В) Японд 1970-аад оны сүүл хагаст “хүчитгэсэн төмөр бетон” болон “төмөр карказан” хийц бүхий барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийн үзлэг, хүчитгэлийн нормыг баталж, 2001 онд Японд хамгийн их байдаг “модон хийц”-ийн тэсвэржилтийн үзлэгийн норм батлагдсан.

- Хүчитгэсэн төмөр бетон хийцийн барилгад дээрх 8)-д заасан “Is утга”-аар тэсвэржилтийг үнэлнэ.

- Төмөр карказан хийцтэй барилгад хэвтээ чиглэлийн ачааллыг тооцож тэсвэржилтийг үнэлнэ.
- Модон хийцийн барилгад “хананы хэмжээнд тулгуурласан нарийвчилсан үзлэгийн аргачлал” нийтлэг хэрэглэгддэг ба үүнээс гадна “тэсвэрлэлтийн хязгаарыг тооцоолох аргачлал”, “энергийн тэнцвэрт байдалд суурилсан тэсвэрлэлтийн аргачлал (energy balance-based seismic resistant design)”, мөн “цаг хугацаанд суурилсан анализын аргачлал (time history response analysis method)”-ыг ашиглаж тэсвэрлэлтийг үнэлнэ.

С) Европод EMS нь EMS баллд барилгын хохирлын байдлыг тохируулан хийцийн төрөл тус бүрээр статистик стандарт хохирлын коэффициентийг гаргаж, VULNUS ба FAMIVE-д барилгын аюулгүй байдлын стандартад үндэслэн хохирлын үржвэрийг тооцох аргачлалаар тэсвэржилтийг үнэлдэг.

Японд 1977 онд хүчитгэсэн төмөр бетон хийцийн барилгын тэсвэржилтийн үзлэгийн нормыг баталж, бат бэхийн индекс (C), налархай чанарын индекс (F), хэлбэрийн индекс (SD), мөн насжилтын индекс (T)-ээс хийцийн тэсвэржилтийн индекс (Is)-ыг тооцож, тэсвэржилтийг үнэлдэг. 1978 онд төмөр карказан барилгын тэсвэржилтийн үзлэгийн нормыг баталж, баригдсан хийцийн карказын хэвтээ чиглэлийн ачаалалд үндэслэн тэсвэржилтийг үнэлдэг.

### **13) Монголын газар хөдлөлтийн балл ба барилгын хохирлын тэмдэглэл**

Монголд өмнө болсон газар хөдлөлтийн хохирлын тухайд газар хөдлөлтийн балл болон барилгад учирсан хохирлын талаар тэмдэглэл байвал дээрх 12)-д заасан хохирлын коэффициент болон түүнд тохирсон барилгын тоо ба газар хөдлөлтийн чичирхийллийн хэмжээнээс хохирлын хувийг тооцож, эдгээртэй харьцуулан зөв эсэхийг нь тодорхойлох боломжтой.


### **14) Барилгын бүтээцийн хохирлын коэффициент**

Барилгын хохирлын коэффициентийг тогтоох нь хохирлыг тооцоолох технологи болон статистикийн шийдвэр гаргах ажил юм. Хамрагдах нутаг дэвсгэр дэх барилгын тэсвэржилтийг зохих байдлаар үнэлж, статистикийн үүднээс зохих хэмжээний хохирлын коэффициентийг тодорхойлох ажилд өргөн хүрээний өндөр мэдлэг чадвар шаардагдана. Ингэж сайтар судалсаны үндсэн дээр тогтоосон хохирлын төсөөлөл нь ойрын ирээдүйд бодитоор хүчтэй газар хөдлөлт болох тохиолдлын хохирлын бодит тоотой харьцуулахад өмнө болсон жишээ, туршлагаас үзэхэд  $\pm 50\%$  -  $\pm 100\%$  орчмын зөрүүтэй байх тохиолдол гардаг. Үүнийг мэдэж, ойлгосны үндсэн дээр гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай.

### **[Нэгдүгээр үе шатны судалгаа]**

Нэгдүгээр үе шатны судалгааны үед хохирлын функцийг бус, газар хөдлөлтийг тэсвэрлэх даацын хязгаарыг тооцоолох аргачлалыг ашигласан. Газар хөдлөлтийг тэсвэрлэх даацын хязгаарыг тооцоолох аргачлал гэдэг нь барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэх

чадварыг 1 чөлөөний зэргийн муруйгаар, барилгад үйлчлэх газар хөдлөлтийн чичирхийллийн шинж чанарыг нэгдмэл спектрээр илэрхийлж, энэ хоёрын огтлолцоолоор ганхалтын хурдатгал ба ганхалтаар үүсэх шилжилтийг тооцож гаргана. Энэхүү аргачлалын үнэн зөвийг нягтлахын тулд ЖАЙКА нь Алматы хот (Казахстан)-ын газар хөдлөлтийн хохирлын төсөөлөл боловсруулахад ашигласан хохирлын функцээр тооцоолж үзэхэд аль алиных нь үр дүн харилцан уялдаж байсныг тогтоосон. Монголын хувьд ч, барилга байгууламжийн хохирлын функцийг шинээр тооцоолж гаргахад хүндрэлтэй тохиолдолд, дээрх Алматы хотын хохирлын функцийг ашиглах нь зүйтэй.



Зураг 4-2 Алматы хотын барилгын хохирлын функци

#### 4-2 Дэд бүтэц

Дэд бүтцийн байгууламжид учрах газар хөдлөлтийн хохирлын төсөөллийн тухайд Япон ба Америк (HAZUS гэх мэт)-т урьдчилан тооцоолох аргачлалыг сайн судалсан байдаг. Энд Японд ашиглагдаж буй тооцооллын аргачлалын талаар танилцуулна.

Тээврийн хэрэгслийг хуурай газрын, усан болон агаарын тээвэр гэж ангилж болно. Энэ хэсэгт тээврийн хэрэгсэл тус бүрийн хохирлын тооцооллын аргачлалыг танилцуулна. Гэхдээ Монголд усан тээврийн шаардлага бага учраас дурдахгүй.

##### 4-2-1 Хуурай газрын тээвэр


Хуурай газрын тээврийн тухайд авто замын хохирлын тооцооллоос гадна өнгөрч гарах

боломжтой эсэхийг шийдвэрлэх цэг болох гүүрийн хохирлын тооцоолол хийнэ.

а) Авто зам

Авто замын хохирол нь голчлон хөрсний хэв гажилтаас болж хучилтад цууралт үүсэх, овойлт, эвдэрч нурах зэрэг гэмтэл гарах ба замын хучилтын үндсэн бүтцээс илүү замын суурь (далан, ухмал), хөрсний төрлөөс шалтгаалсан нөлөөлөл их гэж үзэж байна.

Японд, Зүүн Японы хүчтэй газар хөдлөлтийн хохирлын тоо баримтыг нэгтгэж, балл тус бүрээр замын хохирлын хувийг тооцоолсон. Улсын онцгой комисс нь энэхүү хохирлын хувь (Хүснэгт 4-3)-ийг ашиглан хохирол үүсэх газрын тоог тооцоолсон.



Зураг 4-2 Чичиргээний улмаас үүсэх замын хохирлын тооцоолол

Хүснэгт 4-3 Замын хохирлын хувь (Улсын онцгой комисс)

JMA балл	Хохирлын хувь (газар/км)
4-с доош	-
-5	0.016
+5	0.049
-6	0.071
+6	0.076
7	0.21

JMA балл: Японы Ус цаг уурын хүрээлэнгийн балл

**“Төслийн 1-р үе шатанд”**

Төслийн 1-р үе шат нь Зүүн Японы хүчтэй газар хөдлөлт болохоос өмнө байсан тул Сайтама хотод 2010 онд хэрэгжүүлсэн хохирлын төсөөлөлд ашиглагдсан хохирлын хувийг ашигласан. Хүснэгт 4-4-т хохирлын хувийг үзүүлэв. Үүнийг ашиглан тооцоход хувилбар газар хөдлөлтөөр Улаанбаатар хотод 66 газарт хохирол учирна гэсэн дүн гарсан.

Хүснэгт 4-4 Төслийн 1-р үе шатанд ашигласан замын хохирлын хувь (Сайтама хотын хохирлын тооцооллын ажил)

Хөрсний төрөл		1-2 төрөл	3 төрөл	4 төрөл
Чичирхийллийн хүч				
ЖМА балл	Дээд хурдатгал Х Дээд хурд $V_{max}$ (cm/s)	$T_g < 0.4s$	$0.4s \leq T_g < 0.6s$	$0.6s \leq T_g$
7	$116 \leq V_{max}$	0.11	0.16	0.25
+6	$64 \leq V_{max} < 116$	0.09	0.13	0.20
-6	$35 \leq V_{max} < 64$	0.07	0.10	0.16
+5	$20 \leq V_{max} < 35$	0.05	0.07	0.12
-5	$11 \leq V_{max} < 20$	0.03	0.04	0.06


$T_g$  : Хөрсний доминант хэлбэлзэл

б) Гүүр

Гүүрийн хохирлыг тооцохдоо гүүр тус бүрээр тооцоолох нь цөөнгүй бөгөөд дор дурдсан 2 аргачлал нийтлэг хэрэглэгддэг.

(1) Катаямагийн томъёо

Энэхүү аргачлал нь дараах дараалал (Зураг 4-2-ыг үз)-аар гүүр унах магадлалын тооцоолдог.



Зураг 4-2 Гүүрийн хохирлын хэмжээг таамаглах дараалал (Катаямагийн томъёо)

- 1) Тухайн гүүрийн хийц ба орчны хөрсний онцлогийг судлах.
- 2) Гүүр байрлах газрын чичирхийлэл (хүчний шаталбар), мөн лагжилтыг тодорхойлох.
- 3) Дээрх хариунд үндэслэн шалгуур үзүүлэлт бүрээр заасан категорийг сонгож, тохирох

хувийн жингийн коэффициентээр үржүүлнэ.

4) Үржүүлж гарсан дүн нь үнэлгээний оноо болох ба гүүр нурах аюулыг тодорхойлно.

Катаямагийн томъёо нь гүүр нурахад нөлөөлөх 10 хүчин зүйлийн талаар авч үздэг. Хүчин зүйл тус бүр нь Хүснэгт 4-3-д үзүүлсэнчлэн тооцоолоход хялбар параметртэй. Хүснэгт 4-5-д үзүүлэлтийн тохирох хувийн жингийн коэффициентийг үзүүлэв.

Хүснэгт 4-5 Гүүрийн хохирлыг тодорхойлох норм

Зүйл	Ангилал	Хувийн жингийн коэффициент
Хөрс	хатуу	0.5
	дунд зэрэг	1.0
	Зөөлөн	1.5
	Тун зөөлөн	1.8
Лагжилт	Байхгүй	1.0
	Магадлалтай	1.5
	Бий	2.0
Дам нурууны хийц	Нуман, рамэн хэлбэрийн	1.0
	Үргэлжилсэн дам нуруу	2.0
	Энгийн, консолон дам нуруу	3.0
Тулах хэсэг	Хамгаалалтын тоноглолтой	0.6
	Энгийн	1.0
	Завсрын нэг тулгуур дээр 2 хөдөлгөөнт тулах хэсэг	1.15
Захын ба завсрын тулгуурын өндөр	$\leq 5$ m	1.0
	5~10 m	1.35
	$\geq 10$ m	1.7
Алхмын тоо	= 1	1.0
	$\geq 2$	1.75
Явах анги	Өргөн	0.8
	Нарийн	1.2
JMA хүчний шаталбар	-5	1.0
	+5	1.7
	-6	2.4

Зүйл	Ангилал	Хувийн жингийн коэффициент
	+6	3.0
	7	3.5
Суурийн ажил	Гадсан суурь	1.4
	Бусад	1.0
Захын болон завсрын тулгуурын материал	арматургүй бетон, бусад	1.4
	төмөр бетон	1.0

Гүүр нурах эсэхийг тодорхойлохдоо дараах томъёогоор үзүүлсэнчлэн дээрх хүснэгтийн хувийн жингийн коэффициентээр үржүүлж олно.

$$y_i = \prod_{j=1}^N \prod_{k=1}^{M_j} X_{jk}^{\delta_i(jk)}$$

Энд,

$y_i$  :  $i$ -гүүрийн хохирлын хэмжээг тодорхойлох индекс

$N$  : нийт зүйл

$M_j$  :  $j$ -зүйлийн ангилал

$\delta_i(jk)$  : хиймэл коэффициент ( $\delta_i(jk) = 1$ ;  $i$ -гүүрийн онцлог нь  $k$ -ангилалд тохирох тохиолдолд  $\delta_i(jk) = 0$ ; тэрнээс бусад)

$X_{jk}$  :  $j$ -зүйлийн  $k$ -ангилалд тохирох хувийн жингийн коэффициент

$\prod_{j=1}^N$  :  $1 \sim N$  дугаар хүртэлх нийлбэр

Гүүрийн хохирлыг тодорхойлох нормд Японд болсон 3 газар хөдлөлт (1923 оны Кантогийн газар хөдлөлт, 1948 оны Фүкүигийн газар хөдлөлт, 1964 оны Нийгатагийн газар хөдлөлт)-н үеийн 30 гүүрийн хохиролд үндэслэн Хүснэгт 4-6-д үзүүлсэн байдлаар заадаг.

Хүснэгт 4-6 Гүүрийн хохирлын хэмжээг тооцох стандарт

Хохирлын хэмжээ		Катаямагийн томъёонд үндэслэсэн үнэлгээний оноо
A	- Нурах эрсдэл ихтэй - Ихээхэн эвдрэл үүсэх - Урт хугацаанд ашиглах боломжгүй, их засвар хийх шаардлагатай	30-с дээш
B	- Нурах эрсдэл дунд зэрэг - Эвдрэл үүсэх - Хэсэг хугацаанд ашиглах боломжгүй, засварлах шаардлагатай	26-с дээш 30-с бага
C	- Нурах магадлал бага - Бага эвдрэл үүсэх - Үзлэг хийсний дараа ашиглах боломжтой	26-с бага



## “Тайлбар”

Энэхүү аргачлал нь Японд болсон өргөн цар хүрээ бүхий газар хөдлөлтийн улмаас гүүрэн байгууламжид учирсан төрөл бүрийн хохирлыг нарийвчлан судалж, судалсан үр дүнгээ тоон байдлаар илэрхийлэх аргачлал ашиглан санал болгосон аргачлал юм. 1978 оны аргачлал учраас сүүлийн үеийн хохирлын жишээ багтаагүй боловч ашиглах боломж өндөртэй учраас орчин үед ч их хэрэглэгддэг.

Энэхүү аргачлал нь цаг хугацааны хувьд шинэ биш ч гүүрийн бүтээц болон хөрсний онцлогийг харгалзан үзсэн, уг томъёогоор хувийн жингийн коэффициент болон үнэлгээний оноог тооцож гаргах боломжтой зэрэг давуу талтай.

## “Төслийн 1-р үе шатанд”

Төслийн 1-р үе шатанд 70 гүүрийг энэхүү аргачлалаар үнэлсэн ба бүх гүүрийн нурах магадлал C гэсэн үнэлгээтэй гарсан.

### (2) Японы авто замын нийгэмлэгийн аргачлал

Энэхүү аргачлал нь гүүрийн үзлэгийн бүртгэл (Хүснэгт 4-7-г үз)-ийг ашиглан, уг бүтээцийн онцлог болон гүүрийн техникийн үзүүлэлтийн батлагдсан он, хөрсний нөхцөлд үндэслэн үнэлгээний оноог тооцож, гүүрийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг үнэлдэг.

Гүүрийн үзлэгийн бүртгэлийн тухайд, Японд гүүрийг хариуцагч байгууллага тодорхой хугацаанд гүүрийн үзлэг хийж, мэдээллийн сан үүсгэдэг.

Хүснэгт 4-7 Гүүрийн үзлэгийн шалгуурын агуулга

Гол зүйл	Агуулга
Зорчих хэсэг	(1) Ашигласан техникийн үзүүлэлт (2) Зорчих хэсэг (3) Зорчих хэсгийн материал (4) Гүүр нурахаас сэргийлсэн хийц
Тулгуур хэсгийн деформац	(5) Тулгуур хэсгийн хийцийн төрөл (6) Гүүрийн нүүр хэсгийн өндөр (7) Хөрс (8) Лагжилтын нөлөө
Гол арматурын шаталсан тулгуурын бат бэх	(9) Шүргэх алгаслын харьцаа (10) Шаталсан тулгуурын мурийх таталтын хагарал (11) Суурь ба шаталсан тулгуурийн аюулгүйн түвшин (12) Гол арматурын шаталсан тулгуурын суултын бат бэхийн аюулгүйн түвшин (13) Шүргэх хүчдэл

Гол зүйл	Агуулга
Тулгуур хэсгийн деформац	(14) Тулах хэсгийн деформац (15) Их биеийн деформац (16) Суурийн деформац (17) Дам нуруу зэргийн деформац (18) Тулгуур хэсгийн хийцийн төрөл

### “Тайлбар”

Гүүр нь норм дүрмийн дагуу баригддаг ба хэрвээ уг норм дүрэмд нь газар хөдлөлтийн тэсвэржилт заагдсан бол гүүрийн тэсвэржилтийг төсөөлөх боломжтой. Мөн түүнчлэн гүүр нь ихэвчлэн олон нийтийн байгууламж байдаг тул барилгын ажил явуулах хэлбэр, төрөл нь тогтсон хэв шинжтэй байдаг. Тиймээс Японы нэгэн адил удаан хугацаанд зураг төсөл боловсруулах норм дүрэм мөрдөгдөж байгаа оронд тухайн норм дүрмийн агуулга ба нэмэлт өөрчлөлт нь хохирлыг тооцоолоход чухал фактор болж өгдөг.

Мөн HAZUS-н хохирлын тооцооллоор баригдсан он нь маш чухал гэж үздэг. Баригдсан он нь сүүлийн үеийнх байх тусмаа гүүрийн тэсвэржилт сайн байна гэсэн үг юм.

Японд бүх гүүрийг үзлэг судалгаанд хамруулж, гүүрийн бүртгэлийн мэдээллийн санд оруулдаг. Энэ мэтчилэн гүүрийн үзлэгийн мэдээллийн сантай байвал гүүрийн тэсвэржилтийг харьцангуй хялбар үнэлэх боломжтой. Гэвч тийм бүртгэлийн мэдээллийн сангүй бол бүртгэлийн мэдээлэл үүсгэх ажлаас эхлэх тул цаг хугацаа хөрөнгө мөнгө шаардагдана.

Гүүрийн мэдээллийн сан гэдэг нь тодорхой хугацаанд шинэчилж, засвар арчлалт хийхэд ашиглах зорилготой зүйл юм. Тиймээс мэдээллийн санг шинээр хийхдээ өргөн хүрээний ойлголт (төрийн байгууллага – сургалт судалгааны байгууллага – аж үйлдвэрийн салбар) шаардлагатай.

#### 4-2-2 Агаарын тээвэр

Агаарын тээврийн тухайд онгоцны буудлын хохирлын тооцоолол хийх хэрэгтэй болох боловч өмнө хохирол гарч байсан түүх бага, хохирлын хэмжээ бага байсны улмаас тоон үзүүлэлтээр хохирлыг тооцоолох нь бага.

Энд өмнө болж байсан хохирлын түүхэд үндэслэн хөрсний хурдатгал болон хохирлын хэмжээний хамаарал (Хүснэгт 4-8-г үз)-г олж, хохирлын тооцооллын үнэлгээний хүснэгт (Хүснэгт 4-9)-ыг санал болгоно.

Хүснэгт 4-8 Өмнө болж байсан газар хөдлөлтийн улмаас онгоцны буудлын байгууламжид учирсан хохирол

Газар хөдлөлт	Онгоцны буудал	Хохирлын түвшин	Хохирлын байдал	Хэмжсэн / Тооцоолсон хөрсний хурдатгал

1989 он Лома Приетагийн газар хөдлөлт (Америк)	Санфранцискогийн онгоцны буудал (Олон улсын нислэг)	1	- Нисэх буух зурваст хялгасан хагарал - Терминалд хийцийн хохирол гараагүй - Удирдлагын цамхгийн тааз нурж унасан - Удирдлагын цамхгийн цонхны тавцан эвдэрсэн - Онгоцны буудал 13 цаг хаагдсан	323 gal
1993 он Күширо тэнгисийн газар хөдлөлт (Япон)	Күширогийн онгоцны буудал (Дотоодын нислэг)	1	- Жижиг хагарал	520 gal
1993 он Хоккайдогойн Нансэй тэнгисийн газар хөдлөлт (Япон)	Окүширигийн онгоцны буудал (Орон нутгийн нислэг)	2	- Нисэх буух зурваст 20 м хагарал - Онгоцны буудал 4 хоног хаагдсан - Залагч дохионы гэрэл эвдэрсэн	392 gal
1995 он Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлт (Япон)	Кансай онгоцны буудал (Олон улсын нислэг)	0	- Хохирол гараагүй	169 gal
2000 он Тоттори мужийн баруун хэсгийн газар хөдлөлт (Япон)	Ёнаго онгоцны буудал (Дотоодын нислэг)	2	- Нисэх буух зурваст хагарал - Онгоцны буудал 5 өдөр хаагдсан	546 gal
2001 он Гэйёогийн газар хөдлөлт (Япон)	Хирошима онгоцны буудал (Дотоодын нислэг)	0	- Хохирол гараагүй	298 gal
	Баруун Хирошимагийн онгоцны буудал (Орон нутгийн нислэг)	1	- Бага зэргийн хохирол	298 gal
	Мацүяма онгоцны буудал (Дотоодын нислэг)	1	- Бага зэргийн хохирол	298 gal
2001 он Сиатлын газар хөдлөлт (Америк)	Сиатл Такомагийн онгоцны буудал (Олон улсын нислэг)	1	- Удирдах цамхагт хохирол	194 gal
	King County онгоцны буудал (Боингийн үйлдвэр)	2	- Бууж суух зурваст томоохон хагарал	267 gal

Тайлбар

Хохирлын хэмжээ 0: хохирол гараагүй

Хохирлын хэмжээ 1: бага хэмжээний хохирол, онгоцны буудал 1 хоног хаагдсан

Хохирлын хэмжээ 2: дунд зэргийн хохирол, онгоцны буудал хэдэн өдөр хаагдсан

#### Хүснэгт 4-9 Хохирлын хэмжээ болон хөрсний хурдатгалын хамаарал

Хөрсний дээд хурдатгал (gal)	0 ~ 200	200 ~ 300	300 ~
Хохирлын хэмжээ	0	1	2

Хохирлын хэмжээ 0: хохирол гараагүй

Хохирлын хэмжээ 1: бага хэмжээний хохирол, онгоцны буудал 1 хоног хаагдсан

Хохирлын хэмжээ 2: дунд зэргийн хохирол, онгоцны буудал хэдэн өдөр хаагдсан

#### 4-3 Шугам сүлжээ


Шугам сүлжээний байгууламжийн тухайд дэд бүтцийн байгууламжийн нэгэн адил газар хөдлөлтийн хохирлын талаар Япон ба Америк (HAZUS ГМ) -т тооцоолох аргачлал сайн судлагдсан байдаг. Энд Японд ашигладаг аргачлалын талаар танилцуулна.

Шугам сүлжээний байгууламжийг цэвэр ба бохир ус, цахилгаан, байгалийн хий, цахилгаан холбооны сүлжээ гэж ангилж болно. Энэ хэсэгт шугам сүлжээ тус бүрийн хохирлыг үнэлэх аргачлалын талаар тайлбарлана.

#### 4-3-1 Цэвэр усны шугам

Цэвэр усны шугам сүлжээ нь төрөл бүрийн бүтээц болон төхөөрөмжөөс бүрдэнэ.

- (1) Ус нөөцлөх байгууламж : Усыг нөөцөлж хадгалах далан гэх зэрэг байгууламж
- (2) Усны эх үүсвэрийн байгууламж : Ус олборлох цөөрөм, цамхаг, худаг зэрэг байгууламж
- (3) Ус зөөвөрлөх хоолой : Эх үүсвэрийн байгууламжаас цэвэр усны байгууламжид усыг зөөвөрлөх хоолой гэх зэрэг
- (4) Цэвэр усны байгууламж : Усыг ундны ус болгон цэвэршүүлэх байгууламж
- (5) Цэвэршүүлсэн ус зөөвөрлөх байгууламж : Цэвэршүүлсэн усыг ус түгээх байгууламжид хүргэх хоолой гэх зэрэг
- (6) Ус нийлүүлэх байгууламж : Эрэлтэд нийцүүлэн шаардлагатай усыг нийлүүлэх ус түгээх цөөрөм, хоолой гэх зэрэг
- (7) Ус түгээх байгууламж : Ус нийлүүлэх хоолойноос салбарлан айл өрх зэрэгт хүрэх хоолой мөн эдгээртэй холбогдох ус түгээх төхөөрөмж гэх мэт



Зураг 4-3 Цэвэр усны системийн зураг

“Хотын гамшгаас хамгаалах болон хүрээлэн буй орчны талаар судлах баг (1998) : Газар хөдлөлт ба

Байгууламжуудын газар хөдлөлтөд тэсвэржилтийн асуудлыг дараах байдлаар хялбархан тайлбарлаж болно.

- Ус нөөцлөх, ус олборлох, цэвэршүүлэх, нийлүүлэх цөөрөм болон насос зэрэг байгууламж Газар хөдлөлтийн норм дүрмийн дагуу зураг төсөл нь хийгдсэн тохиолдолд өмнө болж байсан газар хөдлөлтийн улмаас учрах хохирлын жишээнээс харахад ч үйл ажиллагаа нь их хэмжээгээр алдагдах хохирол гарахгүй гэж үзнэ. Гэвч хуучин норм дүрмээр баригдсан төхөөрөмж ч цөөнгүй учраас эдгээрийн тухайд нэг бүрчлэн тэсвэржилтийг үнэлэх шаардлагатай.
- Ус цэвэршүүлэх байгууламж Цахилгаанаар ажиллах нь их байдаг тул цахилгаан тасарсан үед байгууламж хэрхэн ажиллах талаар мэдэж авах шаардлагатай.
- Ус нийлүүлэх, түгээх хоолой Газар хөдлөлтөөр хохирол их гардаг байгууламж

Дээр дурдсанчлан газар доорх хоолой нь хохирол ихээр гардаг ба тэр дундаа уг хохирол нь хэвийн ашиглалтанд ихээхэн сөрөг нөлөөтэй тул цэвэр усны эдгээр байгууламжийн хохирлын үнэлгээ хийх хэрэгтэй.

Хохирлын хэмжээний тухайд хоолойн урттай харьцуулахад хэдэн газар хохирол гарахыг тооцно. Ингэхдээ өмнө болсон хохирлын тэмдэглэлд үндэслэн дундаж хохирлын хувийг гаргаж, түүн дээр хөрс, хоолойны төрөл, голч зэргийн улмаас тэсвэржилтийн онцлогийг тусгасан коэффициентийг ашиглана. Энд 3 төрлийн томъёог үзүүлэх ба илэрхийлэл нь өөр боловч тооцооллын зорилго нь ижил юм.

#### “Орон нутгийн засаг захиргаа”

$$R_{fm} = R_f * C_g * C_p * C_d$$

Энд

$R_{fm}$  : Цэвэр усны хоолойны хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$R_f$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$C_g$  : Хөрс, лагжилтын коэффициент

$C_p$  : Хоолойн төрлийн коэффициент

$C_d$  : Хоолойн голчийн коэффициент

#### “Японы цэвэр усны нийгэмлэг (1998)”

$$R_w = C_g * C_1 * C_p * C_d * R_{sw}$$

Энд

$R_{fm}$  : Цэвэр усны хоолойны хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$R_f$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$C_g$  : Хөрсний коэффициент

$C_l$  : Лагжилтын коэффициент

$C_p$  : Хоолойн төрлийн коэффициент

$C_d$  : Хоолойн голчийн коэффициент

### “Цэвэр усны хоолойн технологи судалгааны төв (2000)”

$$(\text{Хохирол гарах газрын тоо}) = C_p * C_d * C_l * S_d * L$$

Энд

$S_d$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$C_p$  : Хоолойн төрлийн коэффициент

$C_d$  : Хоолойн голчийн коэффициент

$C_l$  : Лагжилтын коэффициент

$L$  : Хоолойны төрөл, голчид ногдох тооцоолол хийгдэх нүд тус бүрийн хоолойн урт (км)


Дундаж хохирлын хувь болон коэффициентуудын тухайд дор үзүүлсэнчлэн төрөл бүрийн аргачлал байдаг. Тэр дундаас алийг нь ашиглах вэ гэдэгт хохирлын үнэлгээ хийх газрын нөхцөл байдал, өмнө болж байсан газар хөдлөлтийн хохирлын симуляц хийх зэргээр цогц байдлаар судалж шийдвэрлэх шаардлагатай.

#### (1) Дундаж хохирлын хувь

Дундаж хохирлын хувийн тухайд 3 янзын ойлголт бий.

##### (1-1) Хөрсний дээд хурдатгалд үндэслэх

- 1) Кубо, Катаяма (1975) нар нь Сан фернандын газар хөдлөлтөөр газар доорх шугам сүлжээний хохиролд үндэслэн тооцсон



Зураг 4-4 Сан фернандын газар хөдлөлт (1971) -ийн хохирлын байдалд

үндэслэсэн газар доорх шугам сүлжээнд үзүүлэх хөрсний дээд хурдатгал ба дундаж хохирлын хувийн хамаарал

Дундаж хохирлын хувийг дараах томъёо ашиглан тооцно.

$$R_f = 1.7 * A^{6.1} * 10^{-16} \text{ ----- (Хамгийн дээд } R_f = 2.0)$$

$R_f$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$A$  : Хөрсний дээд хурдатгал (gal)

- 2) Японы цэвэр усны нийгэмлэг (1998) -ийн Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтийн хохирлын тоо баримтад үндэслэн тооцсон

$$R_{sw} = \begin{cases} 0 \text{ -----} & (A_{max} < 100 \text{ gal}) \\ 2.88 * 10^{-6} (A_{max} - 100)^{1.97} \text{ -----} & (A_{max} \geq 100 \text{ gal}) \end{cases}$$

$R_{sw}$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$A_{max}$  : Хөрсний дээд хурдатгал (gal)

(1-2) Хөрсний дээд хурдатгалд үндэслэсэн аргачлал

- 1) Хёого мужийн өмнөд газар хөдлөлтөөр болсон цэвэр ус нийлүүлэх хоолойны хохирлын жишээнд үндэслэн тооцсон

$$R_f = 2.24 * 10^{-3} (V - 20)^{1.51}$$

$R_f$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$V$  : Хөрсний дээд хурдатгал (kine)

- 2) Хёого мужийн өмнөд газар хөдлөлтөөр босон Нишимия хотын цэвэр ус нийлүүлэх хоолойн хохиролд үндэслэн тооцсон

$$R_f = \begin{cases} (V - 20) * 0.0125 * 0.8 & (\text{DIP} - \text{A, K, T}) \\ (V - 70) * 0.0125 * 0.8 & (\text{DIP} - \text{S, P}) \\ (V - 20) * 0.0125 * 3.0 * (2 / 3) & (\text{CIP} - \text{A}) \\ (V - 20) * 0.0125 * 0.8 & (\text{SP}) \end{cases}$$

$R_f$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$V$  : Хөрсний дээд хурдатгал (cm/sec)

DIP : Ductile cast iron pipe

CIP : Cast iron pipe

SP : Ган хоолой Steel pipe

A, K, T, S, P : Холбоос хэсгийн хэлбэр

- 3) Японы цэвэр усны нийгэмлэг (1998) -ийн Хёого мужийн өмнөд газар хөдлөлтийн

үеийн хохирлын тоо баримтад үндэслэн тооцсон

$$R_{sw} = \begin{cases} 0 & (V_{max} < 15 \text{ cm/sec}) \\ 3.11 * 10^{-3} (V_{max} - 15)^{1.30} & (V_{max} \geq 15 \text{ cm/sec}) \end{cases}$$

$R_{sw}$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$V_{max}$  : Хөрсний дээд хурдатгал (cm/sec)

- 4) Цэвэр усны технологи судалгааны төв (2000) -ийн Хёого мужийн өмнөд газар хөдлөлтийн үеийн хохирлын тоо баримтад үндэслэн тооцсон

$$S_d = 6.33 * 10^{-5} V^{2.10} \quad (V \leq 110 \text{ kine})$$

$S_d$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

$V$  : Хөрсний дээд хурдатгал (kine)

(1-3) SI үзүүлэлтэд үндэслэсэн

SI утгад үндэслэсэн дундаж хохирлын хувийг Хёого мужийн өмнөд газар хөдлөлтөөр цэвэр усны газар доорх хоолой хохирлын жишээнд үндэслэн тооцдог.

$$R_f = 0.025 * SI - 0.51 \quad (\text{хамгийн ихдээ } R_f = 1.5)$$

$R_f$  : Дундаж хохирлын хувь (эвдрэл гарах газар/км)

SI : SI индекс (cm/sec)

(2) Хөрс, лагжилтын коэффициент

Хөрс, лагжилтын коэффициентийг тухайн нутаг дэвсгэрийн онцлогт тохируулах тогтооно.

Хүснэгт 4-10-д Японы орон нутгийн удирдлагад хэрэглэдэг коэффициентийн жишээг Хүснэгт 4-11 ба 4-12-д Японы цэвэр усны нийгэмлэг ба Цэвэр усны технологийн судалгааны төвийн санал болгож буй коэффициентийг үзүүлэв.

Хүснэгт 4-10 Японы нутаг дэвсгэрүүдийн хөрс, лагжилтын коэффициент

Хөрсний төрөл	Акита, Нийгата, Хирошима, Миязаки муж	Хөрсний төрөл	Сэндай хот
Уулархаг газар	0.5	Уулархаг газар	0.4
Тэгш тал	0.5	Тэгш тал	0.5
Хурдсан тэгш тал	1.0	Хурдсан тэгш тал	1.0
Сул зөөлөн хөрстэй газар	2.0	Сул зөөлөн хөрстэй газар	2.0
Хөрсний төрөл	Мияги муж	Хөрсний төрөл	Фүкүи муж
Аллювийн өмнөх	0.5	Диллювийн үеийн хөрс	0.5
Аллювийн үеийн хөрс	1.0	Аллювийн үеийн хөрс	1.0
Өтөгт хөрс	2.0	Диллювийн үеийн (ялзмагт хөрс)	2.0
Хиймэл газар	2.0	Хөрсний төрөл	Аомори муж
Хөрсний төрөл	Сайтама муж	Диллювийн хөрснөөс илүү	0.5



		сайн хөрс		
Dc, Ds, Dg	0.5	Аллювийн хөрс	Шавар	0.9
Lm	0.9		Шавар, элс гэх мэт	1.0
Ac, As	1.0		Ялзмагт хөрс	2.0
Ap	2.0	Хөрсний төрөл		Ямагучи, Хирошима хот
Хөрсний төрөл	Нагано муж	1-р төрөл		0.6
1-р төрөл	0.6	2-р төрөл		1.3
2-р төрөл	1.3	3-р төрөл		1.3
3-р төрөл	1.3	4-р төрөл		1.9
4-р төрөл	1.9	Хөрсний төрлийн хязгаар		2.5

Лагжилтын коэффициент (P <sub>L</sub> )	0	5	10	15	20
Токио 97, Кавасаки хот	1.0	1.2	1.5		3.0
Саппоро хот	1.0	1.1	1.3		2.1
Шизүока муж	1.0	1.0	2.9		4.7
Мияги, Миязаки муж, Сэндай хот	-	-	2.9		4.7
Аомори, Акита, Сайтама, Хирошима муж	-	-	2.9		4.7
Фүкүи муж	-	-	2.5		3.5
Нийгата муж	-		-		3.0

Хөрсний төрлийн коэффициент болон лагжилтын коэффициентийн аль алийг заадаг орон нутагт аль их үзүүлэлттэйг нь ашигладаг.

#### Хүснэгт 4-11 Японы цэвэр усны нийгэмлэгийн хөрс, лагжилтийн коэффициент

Хөрсний төрөл	C <sub>g</sub>	Лагжилтын коэффициент		C <sub>l</sub>
Уул, уулархаг газрын хиймэл газар	1.1	Лагжилтын магадлал	Өндөр (P <sub>L</sub> >15)	2.4
Толгод бүхий тэгш газар, толгод	1.5		Дунд зэрэг (5<P <sub>L</sub> ≤15)	2.0
Хуучин хоолой, намаг газар, тэгш талын хиймэл газар, далайн эрэг	3.2		Бага (0≤P <sub>L</sub> ≤5)	1.0
Хөндий тал, аллювын сэнс, цохио, байгалийн далан ( хөгжүүлсэн болон хөгжүүлээгүй газар)	1.0			

#### Хүснэгт 4-12 Цэвэр усны технологи судалгааны төвийн лагжилтын коэффициент

Лагжилтын тооцоо	C <sub>l</sub>
Байхгүй (0≤P <sub>L</sub> ≤5)	0.9
Хэсэг газар (5<P <sub>L</sub> ≤15)	1.0
Нийт (P <sub>L</sub> >15)	1.6

(3) Хоолойн төрлийн болон голчийн коэффициент

Хоолойн төрлийн болон голчийн коэффициентийг өмнө болсон хохирлыг дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тогтоодог. Орон нутгийн засаг захиргаадад хэрэглэдэг коэффициент нь хоолойн төрлийн болон голчийн коэффициентийн нийлбэрээр тооцоолдог жишээ (Хүснэгт 4-13-с Хүснэгт 4-14-г үз) болон хоолойн төрлийн болон голчийн коэффициентийг тус тусад нь тодорхойлдог жишээ (Хүснэгт 4-15-с Хүснэгт 4-18) бий. Мөн Японы цэвэр усны нийгэмлэг болон Цэвэр усны судалгааны төвд тус тусад нь тодорхойлох аргыг санал болгодог (Хүснэгт 4-19-с Хүснэгт 4-20).

Хүснэгт 4-13 Фүкүока мужид мөрдөгдөх хоолойн төрөл ба голчийн коэффициент

Хоолойн төрөл \ Хоолойн голч (мм)	≤ 75	100 - 125	150 - 350	400 -
Асбест цемент хоолой	10.2	5.3	3.9	3.3
Хлорт винил хоолой	2.6	1.9	1.9	-
Энгийн ширмэн хоолой	1.4	1.0	0.8	0.3
Ductile iron ширмэн хоолой	1.1	0.5	0.5	0.1
Эрэгддэг ган хоолой	10.5	5.5	4.0	3.4
Гагнаастай ган хоолой	0.5	0.3	0.2	0.1

Хүснэгт 4-14 Миэ мужид мөрдөгдөх хоолойн төрөл ба голчийн коэффициент

Хоолойн төрөл \ Хоолойн голч (мм)	≤ 75	100 - 150	200 - 250	300 - 450	500 -
Ductile iron ширмэн хоолой	2.1	1.0	1.0	1.0	0.1 (0.2)
Ширмэн хоолой	1.7	1.2	1.1	0.6	0.2
Ган хоолой	2.8	1.5	1.3	0.9	0.8

Хүснэгт 4-15 Нийслэл Токио 97, Саппоро хот, Кавасаки хотод мөрдөгдөх хоолойн төрөл ба голчийн коэффициент

Хоолойн төрөл	Хоолойн голч φ (mm)	Коэффициент
Ductile iron ширмэн хоолой	φ ≤ 75	0.6
	100 < φ ≤ 450	0.3
	500 < φ ≤ 900	0.09
	1,000 < φ	0.045
Ширмэн хоолой	φ ≤ 75	1.7

	$100 < \varphi \leq 250$	1.2
	$300 < \varphi \leq 900$	0.4
	$1,000 < \varphi$	0.15
Ган хоолой	$\varphi \leq 75$	0.84
	$100 < \varphi \leq 250$	0.42
	$300 < \varphi$	0.24
Хлорт винил хоолой	$\varphi \leq 75$	1.5
	$100 < \varphi$	1.2
Асбест цемент хоолой	$\varphi \leq 75$	6.9
	$100 < \varphi \leq 250$	2.7
	$300 < \varphi$	1.2

Хүснэгт 4-16 Шизуока мужид мөрдөгдөх хоолойн төрөл ба голчийн коэффициент

Хоолойн төрөл	Хоолойн төрлийн коэффициент	Хоолойн голчийн коэффициент	
Эрэгддэг ган хоолой	10.0	$< 100 \text{ mm}$	1.3
		$100 \text{ mm} \leq$	0.75
Гагнадаг ган хоолой	0.1	$< 1,000 \text{ mm}$	1.0
		$1,000 \text{ mm} \leq$	0.5
Ширмэн хоолой	1.0	$< 400 \text{ mm}$	1.5
		$400 - 1,000 \text{ mm}$	0.3
		$1,000 \text{ mm} \leq$	0.15
Ductile iron ширмэн хоолой	0.25	$< 500 \text{ mm}$	1.3
		$500 - 1,000 \text{ mm}$	0.3
		$1,000 \text{ mm} \leq$	0.15
Асбест цемент хоолой	3.0	$< 100 \text{ mm}$	2.3
		$125 - 250 \text{ mm}$	0.9
		$300 \text{ mm} \leq$	0.4
Хлорт винил хоолой	1.5	$< 100 \text{ mm}$	1.1
		$100 \text{ mm} \leq$	0.9

Хүснэгт 4-17 Муж, хотуудад мөрдөгдөх хоолойн төрлийн коэффициент

Хоолойн төрөл	Мияги муж	Аомори, Сайгама муж	Канагава муж	Акига, Нагано муж	Хирошима муж	Нийгага, Миязаки муж	Сэндай хот	Ямагүчи муж	Фукуи муж
	1.0								
Энгийн ширмэн хоолой	0.2								0.3
Ган хоолой	-	2.0			-				

Гагнадаг ган хоолой	0.1						0.2	
Эрэгддэг ган хоолой	2.0	-	2.0	-			2.8	
Зэвэрдэггүй ган хоолой	0.1	-						
Углуургатай ган хоолой	-		0.8	-			0.8	
Тугалган хоолой	0.8	-			1.0*	-		
Хлорт винил хоолой	1.5				1.0	0.8	1.2	
Асбест цемент хоолой	4.0			2.0	1.0	4.0	1.3	2.8
Полиэтилен хоолой	-		0.1			-		0.2
Бетон хоолой	-				1.0	-		
Магистрал шугам	0.1	-						

\*Нийгата муж: тугалган хоолойн заалт байхгүй

#### Хүснэгт 4-18 Муж, хотуудын хоолойн голчийн коэффициент

Хоолойн голч (mm)	100	200	300	400	500	600	700	800	900	1,000	1,100	
Мяги муж	1.3	0.9	0.6	0.5	0.3							
Нагано муж	1.33	-	0.67	-	0.50						0.33	
Канагава муж	1.3	0.8			0.4						0.2	
Акита, Хирошима муж, Сэндай хот	1.2	0.6		-	0.4						0.2	
Аомори муж	1.2	0.6			0.4							0.2
Сайтама муж	1.2	0.6		-	0.4						-	0.2
Нийгата муж	2.0	*	0.6	-	0.4						-	0.2
Фүкүи муж	1.0	0.6		-	0.4						-	0.2
Миязаки муж	1.0			0.5		0.4					0.2	
Ямагучи муж	1.0	0.8	0.6	-	0.4	-	0.3		-	0.1		
Хирошима хот	1.0	-	0.6	-	0.4	-	0.3		-	0.1		

\* Нийгата муж : 100-125 мм-н хоолойн голчийн коэффициент нь 1.5

Мөн “-” нь тухайн хоолойн голчоор заалт байхгүй гэсэн утга агуулна.

Хүснэгт 4-19 Японы Цэвэр усны нийгэмлэгийн хоолойн төрөл ба голчийн коэффициент

Хоолойн төрөл	C <sub>p</sub>
Гагнадаг ган хоолой	0.3
Ductile iron ширмэн хоолой	0.3
Ширмэн хоолой	1.0
Хлорт винил хоолой	1.0
Асбест цемент хоолой	1.2
Эрэгддэг ган хоолой	2.0
Полиэтилен хоолой	0.1
Бусад төрлийн хоолой	1.0
Тодорхойгүй	1.0

Хоолойн голч	C <sub>d</sub>
500 мм-с дээш	0.5
200 – 450 мм	0.8
100 – 150 мм	1.0
75 мм-с бага	1.6

Хүснэгт 4-20 Цэвэр усны технологийн судалгааны төвийн хоолойн төрөл ба голчийн коэффициент

Хоолойн төрөл	C <sub>p</sub>
Ductile iron ширмэн хоолой (A, K, T)*	0.3
Ductile iron ширмэн хоолой (S, SII)*	0.0
Ширмэн хоолой	1.0
Гагнадаг ган хоолой	0.3**
Хлорт винил хоолой	1.0
Эрэгддэг ган хоолой	4.0**
Асбест цемент хоолой	2.5**

\*: A, K, T, S, SII: холбоосын хэлбэр  
 \*\*: Цуглуулсан тоо баримт цөөн байсан тул лавлагаа байдлаар үзүүлж буй

Хоолойн голч	C <sub>d</sub>
75 mm	1.6
100~150 mm	1.0
200~250 mm	0.9
300~450 mm	0.7
500~600 mm	0.5***

\*\*\*: Цуглуулсан тоо баримт цөөн байсан тул лавлагаа байдлаар үзүүлж буй

“Тайлбар”

(1) Дундаж хохирлын хувь

Дундаж хохирлын хувийг тооцохдоо дээр дурдсан 3 төрлийн аргачлал бий.

Сүүлийн үеийн ололт туршлагаас шугам сүлжээ зэрэг шугаман бүтээцийн тухайд хөрсний хурд нь хөрсний хурдатгалтай харьцуулахад газар хөдлөлийн хохиролтой хамаарал өндөртэй гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Мөн SI утга нь газар хөдлөлтийн хохирлыг сайтар илэрхийлэх боломжтой гэсэн судалгаа ч цөөнгүй хийгдсэн. Энэ мэтчилэн ирээдүйд хөрсний хурд болон SI утгад үндэслэсэн дундаж хохирлын хувийг тодорхойлох жишээ ихээр гарч ирнэ гэж үзэж байна.

Гэвч хөрсний хурдатгалыг ашигласан жишээ илүү олон байгаа тул одоогийн нөхцөлд харьцангуй тооцоход хялбар гэсэн давуу талтай.

**“Төслийн 1-р үе шатанд”**

Төслийн 1-р үе шатанд “орон нутгийн засаг захиргаа”-ны тооцооллын томъёог ашиглаж, дундаж хохирлын хувь нь (1-2) “хөрсний дээд хурдатгалд үндэслэсэн” 1) “Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтийн улмаас цэвэр усны түгээх шугам сүлжээнд учирсан хохирлын жишээнд үндэслэсэн заалт”-ыг ашигласан.

(2) Хөрс, лагжилтын коэффициент

Хөрс, лагжилтын коэффициентийн тухайд төрөл бүрийн коэффициент ашиглагддаг.

**“Төслийн 1-р үе шатанд”**

Төслийн 1-р үе шатанд Улаанбаатар хотын лагжилтын аюул маш бага байдаг тул “орон нутгийн засаг захиргаа”-ны томъёон дахь  $C_g$  нь 1.0 гэж заадаг.

(3) Хоолойн төрөл ба голчийн коэффициент

Хоолойн төрөл ба голчийн коэффициентийн тухайд хөрс, лагжилтын коэффициентийн нэгэн адил төрөл бүрийн коэффициент ашиглагддаг.

**“Төслийн 1-р үе шатанд”**


Төслийн 1-р үе шатанд Хүснэгт 4-15 “Нийслэл Токио 97, Саппоро хот, Кавасаки хотын хоолойн төрөл ба голчийн коэффициентийг ашигласан.

**4-3-2 Бохир усны шугам сүлжээ**

Бохир усны шугам сүлжээ нь дор дурдсан байгууламжуудаас бүрдэнэ (Зураг 4-5-г үз) .

(1) Байгууламж : Айл өрх болон албан байгууллагаас гарах бохирус болон борооны усыг хаях бохир усны газар доорх хоолой болон суваг шуудуу зэрэг байгууламж

- (2) Ус цуглуулах байгууламж : Ус зайлуулах хоолойноос бохир усыг цуглуулах ус цуглуулах хоолой, худаг, шуудуу зэрэг байгууламж
- (3) Насосны өрөө : Цуглуулж авчирсан бохир ус, борооны усыг насосоор шахаж илгээх насосны байгууламж
- (4) Бохир ус цэвэрлэх байгууламж : Бохир ус, борооны усыг цэвэрлэж, гол мөрөн ба далайд хаях байгууламж



Зураг 4-5 Бохир усны системийн бүтцийн зураг

(Материал : Токио хотын бохир усны газар, <http://www.gesui.metro.tokyo.jp/>)

Энэ дундаа газар хөдлөлтийн хохиролд их өртөх магадлалтай нь газар доорх хоолой, худаг зэрэг юм. Нөгөөтэйгүүр насосны өрөө болон ус цэвэрлэх байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэртэй байхаар зураг төсөл нь хийгдсэн учир газар хөдлөлтөөр хохирол учирсан жишээ цөөн. Тиймээс бохир усны байгууламжийн хохирлын тооцооллыг газар доорх хоолой зэрэгт хийдэг.

Бохир усны хоолойн ажил харьцангуй сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдсэн учраас газар хөдлөлтөд өртсөн тохиолдол цөөн, цэвэр усны хоолойн нэгэн адил хохирлын аргачлал ашиглах нь олонтаа.

Гэвч 2012 онд Токио хотод хэрэгжүүлсэн Нийслэлийн босоо чичирхийлэлт газар хөдлөлтийн хохирлын таамаглалд Хүснэгт 4-21-д үзүүлсэн хохирлын хэмжээг ашигласан.

Хүснэгт 4-21 Бохир усны шугам хоолойн хохирлын хувь (Нийслэлийн босоо чичирхийлэлт газар хөдлөлтийн улмаас Токио хотод учрах хохирлын төсөөлөл 2012)

Хоолойн төрөл	Лагжилтын коэффициент	JMA балл				
		-5	+5	-6	+6	7
Хлорт винил, шаазан хоолой	Бүгд	19.0	30.8	39.3	48.6	57.0
Бусад хоолой	15<PL	11.4	17.4	23.1	28.0	33.4
	5<PL≤15	8.7	13.6	17.0	20.8	24.6
	0<PL≤5	8.0	12.6	15.6	19.1	22.5

	PL=0	7.6	12.1	14.6	18.1	21.2
--	------	-----	------	------	------	------

### “Тайлбар”

Дээр дурдсанчлан одоогоор бохир усны байгууламжийн хохирлын тооцоог цэвэр усныхтай ижил байдлаар хийж байна. Гагцхүү ирээдүйд бохир усны хоолойд учрах хохирлын тооцооллын аргачлал хийгдэнэ гэж үзэж байна.

### “Төслийн 1-р үе шатанд”

Харин төслийн 1-р үе шатанд цэвэр усны хоолойн хохирлын хувийг ашиглалгүй Хүснэгт 4-21-д үзүүлсэн хохирлын хувийг ашигласан.

#### 4-3-3 Дулааны шугам сүлжээ

Дулааны шугам сүлжээний тухайд Японд дулааны шугам сүлжээ байхгүй тул өмнө болсон газар хөдлөлтийн хохиролд үндэслэн тооцсон хохирлын коэффициент байхгүй.

### “Төслийн 1-р үе шатанд”

Нийслэлийн дулааны шугам сүлжээний нийт уртын 82% нь газар доогуур далд, 18% нь ил хоолой юм. Далд хоолойны тухайд цэвэр усны хоолойтой бараг ижил хоолойн төрөл ба голчтой байх тул цэвэр усны хоолойтой ижил аргачлал, коэффициент ашиглана.


Ил хоолой нь тулгууртай байх бөгөөд ихэвчлэн бэхэлгээгүй байдаг. Тиймээс хохирлын хэв маягийн тухайд хоолой нь өөрөө гэмтэх, тулгуур нь гэмтэх, тулгуур баганаас газарт унах зэрэг хохирол гарах магадлалтай боловч өмнө учирсан хохирлын тоо баримт байхгүй тул тооцоолоход хүндрэлтэй.

#### 4-3-4 Цахилгаан шугам сүлжээ

Цахилгаан эрчим хүчний шугам сүлжээ нь (Зураг 4-6-г үз) дараах байгууламжуудаас бүрдэнэ.

- (1) Цахилгаан станц : Цахилгаан эрчим хүч гаргах байгууламж (атомын ЦС, дулааны ЦС, усан ЦС гм)
- (2) Цахилгаан дамжуулах байгууламж : Цахилгаан станцаас цахилгааныг дамжуулах өндөр хүчдлийн шугам, цамхаг, хонгилын систем, трансформатор гэх мэт
- (3) Цахилгаан түгээх байгууламж : Хэрэглэгч (айл өрх, үйлдвэр гэх мэт) -д цахилгаан хүргэхийн тулд дунд ба нам хүчдлийн шугам, цахилгааны шон, түгээх трансформатор гэх мэт





Зураг 4-6 Цахилгаан эрчим хүч нийлүүлэх системийн бүтцийн зураг

(Материал : Чюубү цахилгаан эрчим хүч (ХК) , <https://link.chuden.jp/>)

Энэ дундаа газар хөдлөлтийн хохирол хамгийн их байх магадлалтай нь дунд ба нам хүчдлийн шугам болон цахилгаан шон юм. Нөгөөтэйгүүр цахилгаан станц болон цахилгаан дамжуулах байгууламж, цахилгаан түгээх трансформатор зэрэг нь газар хөдлөлтөд тэсвэртэй байхаар зураг төсөл нь хийгдсэн байдаг тул хохирол учирсан жишээ ч цөөн байдаг. Тиймээс цахилгаан эрчим хүчний хохирлын тооцоолол хийхдээ цахилгааны шон ба дунд, нам хүчдлийн шугамын тухайд авч үзнэ.

Хохирлыг тооцохдоо ихэвчлэн агаарын болон газар доорх далд шугамд хуваан авч үзнэ. Хохирлын хэмжээг тооцооны секта тус бүрээр агаарын болон далд шугамын хохирол учрах уртыг тооцож, тэдгээрийн нийлбэрийг олж гаргана.

Энд цахилгааны шон, агаарын шугам, газар доорх далд шугам гэсэн дарааллаар хохирлын тооцооллын аргачлалыг тайлбарлая.

(1) Цахилгааны шон

Цахилгааны шонгийн хохирлыг тооцох 2 төрлийн томоохон аргачлал хэрэглэгддэг.

(1-1) Дундаж хохирлын хувьд үндэслэсэн томъёо ашиглах аргачлал

Энэхүү аргачлал нь Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтийн хохирлын жишээн дээр үндэслэсэн болон үндэслээгүй гэсэн 2 арга бий.

1) Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтөөс өмнөх аргачлал (1991)

$$N_h = C_{gl} * R(A) * N$$

$$R(A) = \begin{cases} 0 & (A < 150 \text{ gal}) \\ 0.0053A - 0.795 & (150 \leq A < 300 \text{ gal}) \\ 0.8 & (300 \text{ gal} \leq A) \end{cases}$$

$N_h$  : хохирол учирсан цахилгаан шонгийн тоо (ш)

$C_{gl}$  : хөрс, лагжилтын засварлах коэффициент (цэвэр усны хоолойтой ижил)

$R(A)$  : дундаж хохирлын хувь (%)

$A$  : хөрсний дээд хурдатгал (gal)

$N$  : цахилгаан шонгийн тоо (ш)

2) Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтийн хохирлын жишээг харгалзан үзсэн аргачлал (1997)

$$N_d^P = C_1 * R / 100 * N + N_f * N$$

$N_d^P$  : Цахилгаан шонгийн хохирлын хэмжээ (ш)

$C_1$  : Лагжилтын нөхцөл байдалд үндэслэсэн засварлах коэффициент (цэвэр усны хоолойтой ижил)

$R$  : дундаж хохирлын хэмжээ (%)

ЖМА балл	5 + с бага	6 -	6 +	7
Муж, хот				
Аомори муж	0.00	0.47		6.68
Нийслэл Токио 97	0.00	0.55		Заагаагүй
Саппоро хот	0.00	0.47	2.86	6.68
Кавасаки хот	0.00	0.47		заагаагүй

$N$  : цахилгаан шонгийн хэмжээ (ш)

$N_f$  : шагах хувь (%)

(1-2) Чичирхийлэл болон хохирлын хувийн матриксыг ашигласан аргачлал

Энэхүү аргачлал нь газар хөдлөлтийн чичирхийллээр хөрсний дээд хурдатгалыг ашигласан болон балл ашигласан гэсэн төрлүүдтэй.

1) Хөрсний дээд хурдатгал ашигласан аргачлал

Энэхүү аргачлалт нь Нийгатагийн газар хөдлөлт ба Мияги мужийн тэнгисийн газар хөдлөлтийн хохирлын жишээнд тулгуурласан болон тэдгээрт Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтийн хохирлын жишээг нэмж оруулсан гэсэн төрөлтэй.

1-1) Нийгатагийн газар хөдлөлт, Мияги мужийн тэнгисийн газар хөдлөлтөд үндэслэсэн аргачлал (1986)

Хүснэгт 4-22 Нийгатагийн газар хөдлөлт, Мияги мужийн тэнгисийн газар хөдлөлтөд үндэслэн цахилгааны 100 шон тутамд учрах хохирлын тоог тооцсон байдал

Цахилгаан шон		PGA (gal)	Канагава, Акита, Тояама, Фүкүи, Миязаки муж				
			≤150gal	151 – 300gal	301 – 400gal	401gal≤	Лагжилт үүсэх нутаг дэвсгэр $P_I \geq 15$
Хугарах	Бетон шон		0.00	0.00	0.01	0.03	0.9
	Модон шон		0.00	0.00	0.01	0.02	0.2
Унах	Бетон шон		0.00	0.00	0.03	0.10	3.4
	Модон шон		0.00	0.00	0.01	0.03	0.9

1-2) Нийгата, Мияги мужийн газар хөдлөлт болон Хёого мужийн өмнөд газар хөдлөлтөд үндэслэсэн аргачлал (1998)

Хүснэгт 4-23 Нийгата, Мияги мужийн газар хөдлөлт болон Хёого мужийн өмнөд газар хөдлөлтөд үндэслэн цахилгааны 100 шон тутамд учрах хохирлын тоог тооцсон байдал

Цахилгаан шон		PGA (gal)	Сайтама муж					Лагжилт үүсэх нутаг дэвсгэр: $P_I \geq 15$	
			≤150gal	151 – 300gal	301 – 400gal	401 – 600gal	601 – 800gal		801 gal≤
Цахилгаан шон хугарах, унах	Бетон шон		0.0	0.0	0.04	0.13	1.0	3.2	4.3
	Модон шон		0.0	0.0	0.02	0.05	0.4	1.3	1.1

2) Балл ашигласан аргачлал

Энэхүү аргачлал нь Япон тэнгисийн Чюүбү газар хөдлөлт болон Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтөөс жишээ авсан болон Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтөөс жишээ авсан гэсэн 2 төрөл бий. Мөн түүнээс гадна цахилгаан шон шатах талаар авч үзсэн аргачлал ашиглагддаг ба энэ нь Японы орон сууцны барилга (модон барилга ихтэй) -тэй ихээхэн хамааралтай учраас энд дурдахгүй.

2-1) Япон тэнгисийн Чюүбү газар хөдлөлт болон Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтөөс жишээ авсан аргачлал

Хүснэгт 4-24 Япон тэнгисийн Чюүбү газар хөдлөлт болон Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтөөс жишээ авсан цахилгаан шонгийн хохирлын хувь

JMA балл	Дундаж хохирлын	Фүкүока муж
----------	-----------------	-------------

	хувь	Лагжилтын коэффициент	Хохирлын хувь
5 + с бага	Хохирол байхгүй	-	Хохирол байхгүй
6 -	0.13 %	$0.98 + 0.014 P_L$	$0.13 + 0.0018 P_L$
6 + с дээш	0.49 %	$0.99 + 0.006 P_L$	$0.49 + 0.0029 P_L$

2-2) Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтөөс жишээ авсан аргачлал

Хүснэгт 4-25 Хёого мужийн өмнөд хэсгийн газар хөдлөлтөөс жишээ авсан цахилгаан шонгийн хохирлын хувь

JMA балл	Точиги муж	
	Трансформатор зэрэг төхөөрөмж	
	-тэй тулгуур	-гүй тулгуур
7	1.8 %	1.3 %

(2) Агаарын шугам

Агаарын шугамын хохирлыг тооцоолох 2 томоохон төрлийн аргачлал ашиглагддаг.

(2-1) Цахилгаан шонгийн хохирлыг тооцоолох аргыг ашигласан аргачлал

Муж, хотуудад ашиглагдаж буй 4 жишээг дор үзүүлнэ. Тус бүрийн томъёо нь өөр хоорондоо ялгаатай ч цахилгааны шонгийн хохирлын хэмжээгээр цахилгааны шон ба цахилгааны шугамын хохирлын хамаарлыг үржүүлж хохирлын хэмжээг тодорхойлдог.

1) Токио хот 91, Мияги, Канагава, Яманаши болон Шизүока муж

$$N_d^C = 0.5 \text{ “шон хоорондын зай/ш} \text{”} * l \text{ [м/шон хоорондын зай]} * N_d^P$$

$N_d^C$  : агаарын шугамын хохирлын урт (km)

$l$  : 1 шон хоорондын зайн дундаж урт (коэффициент)

$N_d^P$  : цахилгаан шонгийн хохирлын тоо (ш)

2) Токио хот 97

$$n_d^C = a * N_d^P / L$$

$n_d^C$  : агаарын шугамын дундаж хохирлын хувь (хохирол болсон газар/km)

$a$  : 1 тулгуурт ногдох агаарын шугамын хохирлын алхам хоорондын зай,  $a = 0.396$  (Хёого мужийн өмнөд газар хөдлөлтийн хохирлоос жишээ авсан)

$N_d^P$  : Damage number of pole (poles)

$L$  : Cable length (km)

3) Саппоро хот

$$N_d^C = L * N_d^P / N + N_f * L$$

$N_d^C$  : Агаарын шугамын хохирлын урт (km)

$L$  : Агаарын шугамын урт (km)

$N_d^P$  : Цахилгаан шонгийн хохирлын тоо (ш)

$N$  : Цахилгаан шонгийн тоо (ш)

$N_f$  : Барилгын нурах хувь (%)

4) Кавасаки хот

$$N_d^C = a * N_d^P * l$$

$N_d^C$  : Агаарын шугамын хохирлын урт (km)

$a$  : 1 тулгуур тутмын агаарын шугамын хохирлын алхам хоорондын зай,  $a = 0.5$  (өмнө болсон газар хөдлөлтийн хохирлоос жишээ авсан)

$N_d^P$  : Тулгуурын хохирлын хэмжээ (ш)

$l$  : 1 шон хоорондын зайд ногдох урт (km)

(2-2) Чичирхийлэл ба хохирлын хувийн матриксыг ашигласан аргачлал

Энэхүү аргачлал нь Хёого мужийн өмнөд газар хөдлөлтийн хохирлоос жишээ авсан болон уг хохирлоос жишээ аваагүй гэсэн 2 төрөлтэй.

1) Хёого мужийн өмнөд газар хөдлөлтөөс өмнөх аргачлал (1986)

Хүснэгт 4-26 Агаарын шугамын хохирлын хувь (шон хоорондын зай/цахилгаан шон 100 ш тутамд)

PGA (gal) / Цахилгаан шон	Канагава, Акита, Фүкүи болон Миязаки муж				Лагжилт үүсэх нутаг дэвсгэр $P_L \geq 15$
	$\leq 150 \text{gal}$	151 – 300gal	301 – 400gal	401gal $\leq$	
Бетон шон	0	0.01	0.32	1.2	11.0
Модон шон	0	0.002	0.05	0.18	2.6

2) Хёого мужийн өмнөд газар хөдлөлтийн хохирлоос жишээ авсан аргачлал (1997)

Хүснэгт 4-27 Хёого мужийн өмнөд газар хөдлөлтийн хохирлоос жишээ авсан агаарын

шугамын хохирлын хувь  
(шон хоорондын зай /цахилгаан шон 100 ш тутамд)

Цахилгаан шон		PGA (gal)						
		Сайтама муж						
Цахилгаан шон		≤150gal	151 – 300gal	301 – 400gal	401 – 600gal	601 – 800gal	801 gal≤	Лагжилт үүсэх нутаг дэвсгэр $P_t \geq 15$
Цахилгаан шон хугарах, унах	Бетон шон	0.0	0.01	0.32	1.20	8.5	27.0	11.0
	Модон шон	0.0	0.002	0.05	0.18	1.3	4.1	2.6

(3) Газар доорх далд шугам

Энэхүү аргачлал нь Хёого мужийн өмнөд газар хөдлөлтийн хохирлоос жишээ авсан ба жишээ аваагүй гэсэн 2 төрөл байна.

(3-1) Хёого мужийн өмнөд газар хөдлөлтөөс өмнөх аргачлал (1991)

$$L_c = C_{gl} * R(A) * L$$

$$R(A) = \begin{cases} 0 & (A < 200 \text{ gal}) \\ 0.002A - 0.4 & (200 \leq A < 300 \text{ gal}) \\ 0.2 & (300 \text{ gal} \leq A) \end{cases}$$

$L_c$  : Газар доорх кабелийн хохирлын нийт урт (km)

$C_{gl}$  : Хөрс, лагжилтын засварлах коэффициент (цэвэр усны хоолойтой ижил)

$R(A)$  : Дундаж хохирлын хувь (%)

$A$  : Хөрсний дээд хурдатгал (gal)

$L$  : Газар доорх кабелийн урт (km)

(3-2) Хёого мужийн өмнөд газар хөдлөлтийн хохирлоос жишээ авсан аргачлал (1997)

Энэхүү аргачлал нь тооцоолох томъёолол нь ижил ч өөр өөр дундаж хохирлын хувь ашигладаг.

Мөн дор дурдах цахилгаан утас, холбооны байгууламжийн газар доорх далд шугам нь цахилгааны байгууламжийн нэгэн ижил тооцоолох аргачлал ашиглах нь олонтаа. Энд эдгээр дундаж хохирлын хувийг мөн дурдана.

$$N_d = C_1 * R / 100 * L$$

$N_d$  : Хохирлын хэмжээ (km)

$C_1$  : Лагжилтын нөхцөл байдлаас хамаарах засварлах коэффициент (цэвэр усны хоолойтой ижил)

$L$  : Тооцоот хүчин чадал (km)

R : Дундаж хохирлын хувь (%)

JMA балл	Дундаж хохирлын хувь (%)		
	Токио 97	Аомори муж*	Саппоро хот*
5с бага	0.00	0.00	0.00
-6	0.30	0.30	0.30
+6			2.00
7	- **	4.70	4.70

\*: Утасны байгууламжийн үзүүлэлт

\*\* : Заалт байхгүй

### “Төслийн 1-р үе шатанд”

Төслийн 1-р үе шатанд цахилгаан эрчим хүчний шугам, нам хүчдлийн шугам, цахилгаан шон, газар доорх далд шугам зэрэг тоо баримт олдоогүй тул хохирлын хэмжээг тооцоогүй.

#### 4-3-5 Телефон утас

Телефон утасны байгууламж нь дараах байгууламжаас бүрдэнэ.

- (1) Дамжуулах газар : телефон утасны холболт хийх байгууламж (телефон утасны алба, дамжуулах алба, утасгүй холбооны станц, шилэн кабель гм)
- (2) Утасны шугам, тулгуур : утасны алба ба хэрэглэгч (айл өрх, байгууллага гм) -г холбох байгууламж (шон, агаарын шугам, газар доорх далд шугам гм)

Эдгээрээс газар хөдлөлтөөр хохирол гарах магадлал өндөртэй нь утасны шугам ба шон юм. Харин дамжуулах байгууламж нь анхнаасаа газар хөдлөлтөд тэсвэртэй байхаар тооцсон байдаг бөгөөд хохирол гарсан тухай түүх ч бага. Тиймээс утасны байгууламжийн хохирлын тооцоог хийхдээ цахилгааны байгууламжийн нэгэн адил шон ба шугам (агаарын ба далд шугам) -д хийнэ.

Хохирлын тооцооны аргачлал нь ч цахилгааны байгууламжийн нэгэн адил аргачлал (4-3-3-г үз) ашиглан явуулах нь нийтлэг.

#### “Тайлбар”

Сүүлийн жилүүдэд гар утас болон интернет хурдтай тархаж байгаатай холбогдуулан өмнөхөөс ялгаатай хохирол (гар утасны антенн унах гм) гарч буй. Мөн цахилгааны холбооны салбарын хөгжил нь газар хөдлөлтийн үеийн яаралтай тусламж зэрэгт ихээр хувь нэмрээ үзүүлэхийн нөгөөтэйгүүр хэт ачаалал зэргийн улмаас илүү эмх замбараагүй байдал үүсэх шалтгаан ч болдог. Иймээс газар хөдлөлтийн тэсвэржилтийг сайжруулах талаар бодохоос гадна хохирлыг тооцоолох аргачлалыг сайжруулах, шинээр бий болгох шаардлага гарч буй.

### “Төслийн 1-р үе шатанд”

Төслийн 1-р үе шатанд телефон утасны байгууламжийн хохирлын тооцоолол хийгдээгүй.

#### 4-4 Бусад хохирол

Энэхүү бүлэгт барилга, дэд бүтэц, шугам сүлжээний байгууламжийн хохирлын коэффициент болон хохирлын үнэлгээний аргачлалын талаар тайлбарлав. Гэвч газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээний үүндээс барилга нурснаас гал түймэр гарах болон газар авах, барилга нурах болон гал түймэр гарснаас хүний амьсгүйдэх, гэмтэж бэртэх талаар мөн үнэлгээ хийх нь олонтаа. Түүнчлэн хөрөнгө мөнгөний хохирлыг тооцоолох нь ч бий.

Эдгээр асуудлын тухайд Япон улсын Засгийн газрын веб хуудас, Америкийн HAZUS-н гарын авлага ба веб хуудас, RADIUS Tool-н гарын авлага зэрэгт нарийвчлан дурдсан байдаг. Ямар ч тохиолдолд газар хөдлөлтийн эрсдлийг үнэлэх зорилгоос шалтгаалан ямар агуулгаар хэр хэмжээнд үнэлэх, нутаг дэвсгэр болон тоо баримт ашиглах магадлал болон түүний нарийвчлалын талаар бодолцох шаардлагатай.

### 5. Хохирлын тооцоолол

Эрсдлийн үнэлгээний үндсэн ойлголт нь

Эрсдэл (хохирол) = аюул × эмзэг байдал × эрсдлийн хүчин зүйл (одоогийн байдал)

байх бөгөөд аюулын тухайд 3-р бүлэг, эмзэг байдлын талаар 4-р бүлэг, эрсдлийн хүчин зүйлийн тухайд (2-р бүлэг) -т авч үзсэн. 4-р бүлэгт тайлбарласан хохирлын коэффициентийг ашиглан хохирлыг тооцохдоо хохирлын коэффициентэд тохирсон чичирхийллэл (балл, хурдатгал гм) -н тархалт болон барилга, шугам сүлжээ (цэвэр ба бохир ус, цахилгаан гэх мэт) -ний тархалт шаардлагатай болно. Жишээлбэл төслийн 1-р үе танад барилгыг хийцийн төрөл ба норм дүрмээс шалтгаалан 7 төрөлд ангилсан ба энэ тохиолдолд төслийн 1-р үе шатанд тооцсон 250 м сетка тус бүрт 7 төрлийн ангилал тус бүрээр барилгын тоо хэрэг болно.

Одоо байгаа тархалтын хэмжээг хохирлын коэффициентээр үржүүлэх аргаар сетка тус бүрийн хохирлын хэмжээг тооцон гаргана. Сетка тус бүрээр тооцсон хохирлын тоог засаг захиргааны нэгж тус бүрээр тооцох нь олонтаа.

Хөрсний мэдээлэл, барилгын инвенторын судалгааны үр дүн, түүнээс гадна хотын үйл ажиллагааны одоогийн байдлын талаар цуглуулж, цэгцэлсэн материал чухал. Эдгээр тоо баримт нь зөвхөн эрсдлийн үнэлгээгээр тогтохгүй гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах шатанд ч хэрэг болно. Мөн GIS мэдээллийн сан бий болгох замаар байршлын мэдээлийг нэмэлт байдлаар оруулах нь маш үр дүнтэй. GIS мэдээллийн санг шаардлагатай бол ашиглаж, сэдэв тус бүрийн зураглал хийх боломжтой.

GIS дангаараа газар хөдлөлтийн эрсдлийг үнэлэх боломжгүй ч мэдээллийн сан нь гамшгаас хамгаалах төлөвлөгөө, ВСР төлөвлөлт зэрэгт чухал материал болж чадна.



1-2-2 Газар хөдлөлтийн хохирлын үнэлгээнд Эксел программ ашиглах гарын авлага

## ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ХОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНД ЭКСЕЛ ПРОГРАММ АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА

### 1. Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээнд шаардлагатай мэдээлэл

Газар хөдлөлтийн хохирлын хэмжээг тодорхой гаргахын тулд газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг хийдэг. Үүнд ОБЕГ-ын ажлын хэсэг болон ЖАЙКА-ийн мэргэжилтний багтай хамтран боловсруулсан эксел программыг ашиглана.

УБ хотын хувьд 2013 онд ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн үр дүнг ашиглаж болно.

Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээнд дараах мэдээллүүд шаардлагатай.

1) Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ

Юуны түрүүнд эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээг тодорхойлоно. Үүнд 3)-аас хойших мэдээлэл нь хангалттай эсэхээс шалтгаалана. Голчлон хот, дүүрэг, сумын хэмжээнд хийхээр хамрах хүрээг тогтооно.

2) Газар хөдлөлтийн эрчим (балл)

Хохирлын тооцоог хийхэд газар хөдлөлтийн чичирхийллийн хэмжээ (балл)-г мэдэх шаардлагатай. Үүнийг газар хөдлөлтийн идвэхитэй хагарлаас тооцох бөгөөд дараах дарааллийн дагуу тооцно.

- ✓ Газар хөдлөлтийн голомт болж болзошгүй идвэхитэй хагарлын урт, хагарал хүртлэх зайг тооцох
- ✓ Зайнаас хамаарах чичирхийллийн замхралыг тооцох
- ✓ Хөрсний шинж чанараас хамаарах чичирхийллийн амплификацийг тооцох

Гэвч эдгээрийг зөвхөн мэргэжлийн инженерүүд тооцох боломжтой тул энэхүү гарын авлагад “Газар хөдөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22.01.01\*/2006/-ийн 1, 2-р хавсралт дах газар хөдлөлтийн Монгол Улсын хот, төв суурин газруудын газар хөдлөлтийн баллыг ашиглана. Мөн ООГФХ-ээс Монгол Улсын хэмжээн дэх аймгийн төвүүдийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг боловсруулж байгаа бөгөөд эдгээр зураглалууд батлагдсаны дараа ашглаж болно.

### 3) Барилга, хүн амын мэдээлэл

Барилгын хохирлын үнэлгээнд 2013 онд ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-д ашигласан аргачлалыг ашиглана. Үүнд “Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар” /БД 31.103.00/-ын дагуу хуучин барилгыг газар хөдлөлт тэсвэрлэлтээр нь 27 зэрэгт ангилсан байдаг. Дээрх ангилал тус бүрээр үнэлгээ хийх гэж буй бүс нутгийн барилгын тоо, тухайн барилгуудад амьдарч буй өрх, оршин суугчийн тоог гаргана. Үнээс өрхийн тоо нь чухал мэдээлэл бөгөөд 1 өрхөд ногдох оршин суугчийн тоог гаргахдаа нийт хүн амыг нийт өрхийн тоонд хувааж дундаж утгыг ашиглана. Дараах хүснэгтэд Монголын Улсын нэг хотын мэдээллийг жишээгээр үзүүлэв.

**Барилга, хүн амын мэдээлэл**

Хуучин барилгыг газар хөдлөлт тэсвэрлэлтээр ангилсан ангилал	Барилгын зориулалт	Барилгын тоо	Өрхийн тоо
1	Орон сууц	30	1119
	Гэр	5752	5752
4.2	Олон нийтийн барилга	7	
7.1	Орон сууц	3	40
	Олон нийтийн барилга	12	
8	Орон сууц	8	158
8.1	Олон нийтийн барилга	3	
9	Амины сууц	104	104
	Дотуур байр	13	76
	Гэр хороолол дах амины сууц	1217	1217
	Бусад сууц	8	8
11	Орон сууц	8	281
	Олон нийтийн барилга	15	
12.2	Орон сууц	5	95
	Олон нийтийн барилга	6	
Нийт	Орон сууц	54	1693
	Амины сууц	104	104
	Дотуур байр	13	76
	Гэр	5752	5752
	Гэр хороолол дах амины сууц	1217	1217
	Бусад сууц	8	8
	Олон нийтийн барилга	43	0

4) Авто замын мэдээлэл

Авто замын байгууламжийн ул хөрсийг “Газар хөдөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22.01.01\*/2006/-ийн хүснэгт 1-д заасан хөрсний зэрэг (I, II, III зэрэг)-ээр ангилж хөрсний зэрэг тус бүрд ногдох авто замын уртуудыг гаргана. Хэрэв хөрсний зэргийг тодорхойлох боломжгүй тохиолдолд “Тодорхойгүй” гэсэн ангилалд

хамруулж түүнд ногдох уртыг гаргана.

5) Гүүрний мэдээлэл

Гүүрний хувьд гүүр тус бүр дээр дараах хүснэгтэд заасан үзүүлэлтийг ашиглаж эвдрэлийн зэргийг тогтооно.

Хөрсний зэрэг	1-р зэрэг
	2-р зэрэг
	3-р зэрэг
	Тодорхойгүй
Хөрсний шингэрэлт болох магадлал	Болохгүй
	Бага
	Өндөр
	Тодорхойгүй
Дам нурууны төрөл	Консолон гүүр
	Үргэлж дамнуруут гүүр
	Энгийн гүүр
Тулах хэсэг	Унахаас сэргийлсэн хамгаалалттай
	Уламжлалт
	Two moving bearing
Тулгуурын өндөр	5м-ээс нам
	5м - 10м
	10 м-ээс өндөр
Алгаслын тоо	1
	2 ба түүнээс олон
Ригелийн тулаас	Урт (тулаасны урт (см)/алгасалын урт (м) $\geq$ 1)
	Богино (тулаасны урт (см)/алгасалын урт (м) $<$ 1)
Суурийн төрөл	Pile bent-ээс бусад
	Pile bent
Үндсэн материал	Тоосго эсвэл Бетон
	Бусад

Хөрсний шингэрэлт болох магадлалын тухай мэдээлэлгүй тохиолдолд “Тодорхойгүй”, элсэн хөрстэй бол “Өндөр” гэсэн сонголтуудыг хийнэ.

## б) Инженерийн шугам сүлжээний мэдээлэл

### (1) Газар доорх шугам

Ус хангамж, дулааны газар доорх шугамыг түүний материал төрөл, голч, урт тус бүрээр мэдээллийг цуглуулана. Материалын хувьд төмөр, ширэм, ган, PVC, асбест цемент, керамик гэж ангилана. Голчын хэмжээг 75 мм-ээс доош, 75-300 мм, 300-500 мм, 500-1000 мм, 1000 мм-ээс дээш, тодорхойгүй гэж ангилана.

Харин ус хангамжийн шугамны хувьд зөвхөн материалын төрлөөр ангилах бөгөөд голчийнх тухай мэдээлэл шаардлагагүй. Хөрсний шингэрэлт болох магадлалын тухай мэдээлэлгүй тохиолдолд “Тодорхойгүй”, элсэн хөрстэй бол “Өндөр” гэсэн сонголтуудыг хийнэ.

### (2) Цахилгааны шон

Бетон болон модон шон тус бүрийн тоог гаргана. Агаарын болон газар доорх кабелийн хувьд тус бүрийнх уртыг гаргана. Хөрсний шингэрэлт болох магадлалын тухай мэдээлэлгүй тохиолдолд “Тодорхойгүй”, элсэн хөрстэй бол “Өндөр” гэсэн сонголтуудыг хийнэ.

## 2. Экселийн программ ашиглаж хохирлын хэмжээг тооцох

Тус экселийн программ нь 15 sheet-ээс бүрдэнэ. “Хүний хохирол”, “Барилгын эвдрэл”, “Авто замын эвдрэл”, “Гүүрийн эвдрэл”, “Ус хангамжийн шугамын эвдрэл”, “Бохир усны шугамын эвдрэл”, “Цахилгааны шон, кабелийн эвдрэл”, “Дулааны шугамын эвдрэл” тус бүрийн өгөгдөл оруулах болон тооцоо хийх sheet-үүдээс бүрдэнэ. Харин “Хүний хохирол”-ийн тооцооны sheet гэж тусдаа байхгүй. Мөн “Хүний хохирол”-ыг тооцохоос өмнө барилгын хохирлыг түрүүлж тооцох шаардлагатай. Тооцооны sheet-үүд тус бүрийн нэрийн ард Data&Cal гэсэн нэртэй байгаа бөгөөд энэхүү sheet-ний тоо, томъёог Мэргэжлийн инженер агуулгыг ойлгосны үндсэн дээр өөрчлөхөөс бусад тохиолдолд өөрчлө болохгүй.

### 1) Барилгын эвдрэлийг тооцох

Газар хөдлөлтийн балл, тухай барилгын ангилалыг өгөгдөл болгон оруулахад эвдрэх магадлалыг автоматаар тооцно.

Өгөгдөл			
Хуучин барилгыг газар хөдлөлтийн тэсвэрлэлтээр нь ангилсан ангилал	Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар /БД 31-103-00/ Хавсралт 3	10.1 Тоосгон өрлөгөн даацын ханатай ба цутгамал төмөр бетон хучилттай барилга ①	5
Газар хөдлөлтийн эрчим	МСК шаталбар /балл/	8 ②	
Үр дүн			
нурах магадлал		12.25 ③	%

①-д барилгын ангилалыг сонгож, ②-т газар хөдлөлтийн баллыг гараас оруулахад барилга нь нурах, эсвэл их хэмжээний эвдрэлд орох магадлалыг ③-т тооцон гаргана. Энэхүү магадлалыг тухайн ангилалын барилгын тоо, түүн дотрох өрхийн тоогоор үржүүлж барилгын эвдрэх тоо, өрхийн тоог тус тус олно. Доорх хүснэгтэд жишээгээр үзүүлэв.

Нурах барилгын тоо болон гамшигт нэрвэгдэх өрхийн тоо

Хуучин барилгыг газар хөдлөлт тэсвэрлэлтээр ангилсан ангилал	Барилгын зориулалт	Барилгын тоо	Өрхийн тоо	нурах магадлал (%)	Нурах барилгын тоо	Гамшигт нэрвэгдэх өрхийн тоо
1	Орон сууц	30	1119	5.2	2	58
	Гэр	5752	5752		300	300
4.2	Олон нийтийн барилга	7		5.2	0	
7.1	Орон сууц	3	40	16.9	1	7
	Олон нийтийн барилга	12			2	
8	Орон сууц	8	158	29.7	2	47
8.1	Олон нийтийн барилга	3		29.7	1	
9	Амины сууц	104	104	50.0	52	52
	Дотуур байр	13	76		7	38
	Гэр хороолол дах амины сууц	1217	1217		609	609
	Бусад сууц	8	8		4	4

11	Орон сууц	8	281	50.0	4	141
	Олон нийтийн барилга	15			8	
12.2	Орон сууц	5	95	69.1	3	66
	Олон нийтийн барилга	6			4	
Нийт	Орон сууц	54	1693		12	318
	Амины сууц	104	104		52	52
	Дотуур байр	13	76		7	38
	Гэр	5752	5752		300	300
	Гэр хороолол дах амины сууц	1217	1217		609	609
	Бусад сууц	8	8		4	4
	Олон нийтийн барилга	43	0		15	0

## 2) Хүний хохирлыг тооцох

Хүний хохирлыг тооцохдоо орон сууц, амины сууцаар тус тусад нь тооцно. Дээрх жишээгээр орон сууц, дотуур байр нийлээд 356 өрх, амины сууц, гэр нийлээд 695 өрх гамшигт нэрвэгдэхээр гарсан байна. Энэ тоог эксел программд оруулбал нас барсан хүний тоо 194 хүн, гэмтсэн хүний тоо 241 хүн байхаар гарсан байна. Мөн гамшигт нэрвэгдсэн өрхийн тоог нэг өрхийн дундаж дундаж гишүүний тоогоор үржүүлбэл гэр оронгүй болсон иргэдийн тоо (амь насаа алдсан болон бэртэж гэмтсэн хүн ороод) гарна.

### Хүний хохирлыг тооцсон жишээ

Өгөгдөл		
		Хүний тоо
Орон сууц	Нурсан барилга дах өрхийн тоо	356
Амины сууц	Нурсан барилга дах өрхийн тоо	695
Нас барсан хүний тоо		194
Гэмтсэн хүний тоо		241

3) Авто замын эвдрэл

Өгөгдөл оруулах хэсэгт хөрсний зэрэг, газар хөдлөлтийн баллыг тус бүр сонгож оруулна. Ингэснээр эвдрэх магадлал (эвдрэх цэгийн тоо/км) бодогдож гарна. Энэ утгыг тухайн хөрсөн дээрх авто замын нийт уртаар үржүүлбэл нийт эвдрэх цэгийн тоо гарна.

4) Гүүрийн эвдрэл

Гүүр тус бүрийн мэдээллийг 9 үзүүлэлтээр болон газар хөдлөлтийн баллыг оруулж сонголтоор оруулна. Ингэснээр А,В,С гэсэн 3 түвшнээр үр дүн гарах бөгөөд тайлбарыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Эвдэрлийн түвшин	
А	- Гүүр нурах магадлал маш өндөр - Их хэмжээний хэв гажилтад орно - Урт хугацаанд ашиглах боломжгүй болж их хэмжээний засвар шаардлагатай болно.
В	- Гүүр нурах магадлал дунд зэрэг - Хэв гажилт үүсэнэ. - Түр ашиглах боломжгүй болж засвар хийх шаардлагатай болно.
С	- Гүүр нурах эвдрэл бага - Бага хэмжээний хэв гажилтад орно. - Үзлэг хийсний дараа ашиглах боломжтой.

5) Инженерийн шугам сүлжээний эвдрэл

(1) Ус хангамж, дулааны шугамын эвдрэл

Хөрсний шингэрэлт явагдах магадлал, материалын төрөл, голч болон газар хөдлөлтийн баллыг сонголтоор оруулсанаар эвдрэх магадлал (Эвдрэх цэг/км) гарч ирнэ. Үнийг нийт уртад нь үржүүлж нийт эвдрэх цэгийн тоог гаргана.

(2) Бохир усны шугамын эвдрэл

Хөрсний шингэрэлт явагдах магадлал, материалын төрөл, газар хөдлөлтийн баллыг сонголтоор оруулсанаар эвдрэх магадлал (%) гарч ирнэ. Үнийг нийт уртад нь үржүүлж нийт эвдрэх шугамын уртыг гаргана.

(3) Цахилгааны шугам

Хөрсний шингэрэлт явагдах магадлал, газар хөдлөлтийн баллыг сонголтоор оруулсанаар 100 шон дутмын эвдрэх магадлал (%), агаарын болон газар доорх кабелийн эвдрэх магадлал 100 м дутам дах %-аар гарч ирнэ. Үүнээс эвдрэх шонгийн тоо болон кабелийн уртыг гаргана.



### 3. Нийт хохирлын хэмжээг гаргах

Эксел программаар тооцоолж хохирлын нийт хэмжээг нэгтгэн гаргана.

Дараах хүснэгтийн дагуу нэгтгэх боломжтой.

Хохирлын төрөл			Хохирлын хэмжээ	Нэгж
Хүний хохирол	Нас барсан хүний тоо	Орон сууцны хороолол		хүн
		Гэр хороолол		хүн
	Гэмтсэн хүний тоо	Орон сууцны хороолол		хүн
		Гэр хороолол		хүн
	Орон гэргүй болсон хүний тоо	Орон сууцны хороолол		хүн
		Гэр хороолол		хүн
Барилгын эвдрэл	Нурсан барилга	Орон сууцны хороолол		барилга
		Гэр хороолол		барилга
	Нуранги			Тонн
Дэд бүтэц, ИШС	Авто зам	Явах боломжгүй болсон		Цэг
	Гүүр	Эвдрэлийн түвшин А	Гүүрний нэр:	
		Эвдрэлийн түвшин В	Гүүрний нэр:	
	Цахиилгааны шон	Эвдэрсэн		Ширхэг
	Агаарын кабель	Эвдэрсэн хувь		%
	Газар доорх кабель	Эвдэрсэн хувь		%
	Ус хангамжийн шугам	Тасарсан		Цэг
	Бохир усны шугам	Эвдэрсэн хувь		%
	Дулааны шугам	Тасарсан		Цэг

Дээрх хүснэгтэд Орон сууцны хороолол, гэр хороолол гэж ангилсан боловч орон нутгийн түвшинд тохирсон ангилалаар гаргаж болно.

Нурангины хэмжээг нурсан барилгын нийт талбайг олж, модон барилгад 0.5 тонн/м<sup>2</sup>, Төмөр бетон барилгад 1.0 тонн/м<sup>2</sup>-аар тооцно.

### 1-2-3 Газар хөдлөлтийн хохирлын тооцооны хуудас

#### 1. Хүний хохирол

Input		Number
Нийтийн орон сууц	нурсан барилга доторх өрхийн тоо	5
Хувийн сууц	нурсан барилга доторх өрхийн тоо	1
Нас барсан		1
Гэмтэж бэртсэн		1


#### 2. Барилга

Өгөгдөл		Сонгох хэсэг	Дугаар
Барилгын бүтээц	Хучин барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлт оор ангилсан ангилал /БД 31 103-00/	12.1 Тоосгон өрлөгийн даацын ханатай ба модон дам нуруун хучилттай нэг давхар барилга	2
Газар хөдлөлтийн балл	МСК шаталбар		8 31
Эвдрэлийн хувь	29.441 %		

### 3. Барилга-мэдээлэл

	Түүхий тоосгон	Тоосго /Блок/	Модон хүчилтгэй тоосгон	Уян давхартай барилга	Төмөр бетон хүчилтгэй тоосгон	1998 он хүртлэх цутгамал төмөр бетон	Модон	1999 оноос хойших цутгамал төмөр бетон	Угсармал том хавтгаалжин
Дундаж	7.5	8.4	8.6	8.8	9.0	9.5	9.9	10.3	10.3
Хазайлт	0.74	0.74	0.80	0.80	0.86	0.94	0.94	0.80	0.60

МСК шаталбар	Д/д	Түүхий тоосгон	Тоосго /Блок/	Модон хүчилтгэй тоосгон	Уян давхартай барилга	Төмөр бетон хүчилтгэй тоосгон	1998 он хүртлэх цутгамал төмөр бетон	Модон	1999 оноос хойших цутгамал төмөр бетон	Угсармал том хавтгаалжин
5.0	1	0.00036	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000
5.1	2	0.00059	0.00000	0.00001	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000
5.2	3	0.00094	0.00001	0.00001	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000
5.3	4	0.00147	0.00001	0.00002	0.00001	0.00001	0.00000	0.00000	0.00000	0.00000
5.4	5	0.00227	0.00003	0.00003	0.00001	0.00001	0.00001	0.00000	0.00000	0.00000
5.5	6	0.00344	0.00004	0.00005	0.00002	0.00002	0.00001	0.00000	0.00000	0.00000
5.6	7	0.00512	0.00008	0.00009	0.00003	0.00004	0.00002	0.00000	0.00000	0.00000
5.7	8	0.00750	0.00013	0.00014	0.00005	0.00005	0.00003	0.00000	0.00000	0.00000
5.8	9	0.01080	0.00022	0.00023	0.00009	0.00010	0.00004	0.00001	0.00000	0.00000
5.9	10	0.01530	0.00036	0.00037	0.00014	0.00016	0.00006	0.00001	0.00000	0.00000
6.0	11	0.02133	0.00059	0.00058	0.00023	0.00024	0.00010	0.00002	0.00000	0.00000
6.1	12	0.02925	0.00094	0.00089	0.00037	0.00037	0.00015	0.00003	0.00000	0.00000
6.2	13	0.03948	0.00147	0.00135	0.00058	0.00057	0.00022	0.00004	0.00000	0.00000
6.3	14	0.05244	0.00227	0.00202	0.00089	0.00085	0.00033	0.00006	0.00000	0.00000
6.4	15	0.06858	0.00344	0.00298	0.00135	0.00125	0.00049	0.00010	0.00000	0.00000
6.5	16	0.08829	0.00512	0.00433	0.00202	0.00182	0.00071	0.00015	0.00000	0.00000
6.6	17	0.11195	0.00750	0.00621	0.00298	0.00263	0.00102	0.00022	0.00000	0.00000
6.7	18	0.13983	0.01080	0.00877	0.00433	0.00374	0.00145	0.00033	0.00000	0.00000
6.8	19	0.17209	0.01530	0.01222	0.00621	0.00526	0.00204	0.00049	0.00001	0.00000
6.9	20	0.20874	0.02133	0.01679	0.00877	0.00731	0.00284	0.00071	0.00001	0.00000
7.0	21	0.24962	0.02925	0.02275	0.01222	0.01002	0.00391	0.00102	0.00002	0.00000
7.1	22	0.29441	0.03948	0.03040	0.01679	0.01358	0.00534	0.00145	0.00003	0.00000
7.2	23	0.34259	0.05244	0.04006	0.02275	0.01817	0.00721	0.00204	0.00005	0.00000
7.3	24	0.39348	0.06858	0.05208	0.03040	0.02404	0.00963	0.00284	0.00009	0.00000
7.4	25	0.44625	0.08829	0.06681	0.04006	0.03141	0.01274	0.00391	0.00014	0.00000
7.5	26	0.50000	0.11195	0.08457	0.05208	0.04056	0.01668	0.00534	0.00023	0.00000
7.6	27	0.55375	0.13983	0.10565	0.06681	0.05177	0.02163	0.00721	0.00037	0.00000
7.7	28	0.60652	0.17209	0.13029	0.08457	0.06531	0.02775	0.00963	0.00058	0.00001
7.8	29	0.65741	0.20874	0.15866	0.10565	0.08146	0.03526	0.01274	0.00089	0.00002
7.9	30	0.70559	0.24962	0.19079	0.13029	0.10044	0.04437	0.01668	0.00135	0.00003
8.0	31	0.75038	0.29441	0.22663	0.15866	0.12246	0.05527	0.02163	0.00202	0.00006
8.1	32	0.79126	0.34259	0.26599	0.19079	0.14766	0.06820	0.02775	0.00298	0.00012
8.2	33	0.82791	0.39348	0.30854	0.22663	0.17613	0.08334	0.03526	0.00433	0.00023
8.3	34	0.86017	0.44625	0.35383	0.26599	0.20784	0.10087	0.04437	0.00621	0.00043
8.4	35	0.88805	0.50000	0.40129	0.30854	0.24269	0.12096	0.05527	0.00877	0.00077
8.5	36	0.91171	0.55375	0.45026	0.35383	0.28049	0.14370	0.06820	0.01222	0.00135
8.6	37	0.93142	0.60652	0.50000	0.40129	0.32092	0.16917	0.08334	0.01679	0.00230
8.7	38	0.94756	0.65741	0.54974	0.45026	0.36361	0.19737	0.10087	0.02275	0.00383
8.8	39	0.96052	0.70559	0.59871	0.50000	0.40805	0.22823	0.12096	0.03040	0.00621
8.9	40	0.97075	0.75038	0.64617	0.54974	0.45372	0.26164	0.14370	0.04006	0.00982
9.0	41	0.97867	0.79126	0.69146	0.59871	0.50000	0.29739	0.16917	0.05208	0.01513
9.1	42	0.98470	0.82791	0.73401	0.64617	0.54628	0.33522	0.19737	0.06681	0.02275
9.2	43	0.98920	0.86017	0.77337	0.69146	0.59195	0.37481	0.22823	0.08457	0.03338
9.3	44	0.99250	0.88805	0.80921	0.73401	0.63639	0.41575	0.26164	0.10565	0.04779
9.4	45	0.99488	0.91171	0.84134	0.77337	0.67908	0.45764	0.29739	0.13029	0.06681
9.5	46	0.99656	0.93142	0.86971	0.80921	0.71951	0.50000	0.33522	0.15866	0.09121
9.6	47	0.99773	0.94756	0.89435	0.84134	0.75731	0.54236	0.37481	0.19079	0.12167
9.7	48	0.99853	0.96052	0.91543	0.86971	0.79216	0.58425	0.41575	0.22663	0.15866
9.8	49	0.99906	0.97075	0.93319	0.89435	0.82387	0.62519	0.45764	0.26599	0.20233
9.9	50	0.99941	0.97867	0.94792	0.91543	0.85234	0.66478	0.50000	0.30854	0.25249
10.0	51	0.99964	0.98470	0.95994	0.93319	0.87754	0.70261	0.54236	0.35383	0.30854
10.1	52	0.99978	0.98920	0.96960	0.94792	0.89956	0.73836	0.58425	0.40129	0.36944
10.2	53	0.99987	0.99250	0.97725	0.95994	0.91854	0.77177	0.62519	0.45026	0.43382
10.3	54	0.99992	0.99488	0.98321	0.96960	0.93469	0.80263	0.66478	0.50000	0.50000
10.4	55	0.99996	0.99656	0.98778	0.97725	0.94823	0.83083	0.70261	0.54974	0.56618
10.5	56	0.99997	0.99773	0.99123	0.98321	0.95944	0.85630	0.73836	0.59871	0.63056



#### 4. Барилга-төрөл

Зэрэг	Хуучин барилгыг газар хөдлөлт тэсвэрлэлтээр нь ангилсан ангилал /БД31-103-00/ Хийцийн товч тодорхойлолт	Баригуудын жишээ	Хийцийн хамрах хүрээ	Тайлбар
1.1	1.1 Том хавтгаалжин барилга, ханын хавтгаалж нь өөр хоорондоо болон хучилтын хавтантай цутгамал бетоноор холбогдсон.	Сери 92-УБ сери 92-УБД	9	
1.2	1.2 Ган араг бүтээцтэй ба өлгөмөл ханын хавтантай барилга	Үйлдвэрт бэлдсэн бэлдэц хийцтэй тухайлсан барилга	8	
1.3	1.3 Цутгамал төмөр бетон араг бүтээцтэй ба өлгөмөл ханын хавтантай барилга	Тухайлсан зургаар баригдсан	8	
1.4	1.4 Цутгамал төмөр бетон хөшүүний цөмтэй, цутгамал буюу угсармал төмөр бетон араг бүтээцтэй барилга	Тухайлсан зургаар баригдсан	8	
1.5	1.5 Угсармал төмөр бетон араг бүтээцтэй томсгосон элементээс бүрдсэн диафрагмтай баараг бүтээцийн элементүүдийн арматур нэг маягийн хэвэнд гагнаасаар холбогдсон барилга	СЖКУ-9, ИИС-04У серийн хийцүүд	9	
1.6	1.6 Төмөр бетон араг бүтээцтэй ба өлгөмөл ханын хавтантай нэг давхар барилга	Нэг маягийн хийц ашиглаж хийсэн тухайлсан зургаар	8	
1.7	1.7 Зөөврийн зээлхүүнт буюу том бамбайт хашлаганд цутгасан цутгамал төмөр бетон даацын ханатай барилга	Тухайлсан зургаар	8	
2.1	2.1 Ханын хавтгаалжууд өөр хоорондоо ба хучилтын хавтантай бэхлэгээний эд ангийг нь гагнаж холбосон том хавтгаалжин барилга	Туршилтын зургаар УБхотын 5, 12, 15, 19, 21-р хороолол	9	
2.2	2.2 Гулсагч хашлаганд цутгасан цутгамал төмөр бетон даацын ханатай барилга	Тухайлсан зургаар	8	
3	3. Шугаман элементэн угсармал төмөр бетон араг бүтээцтэй ба дагуу арматур нь нэг маягийн хэвэнд гагнаасаар холбогдсон. Хашлага хана-өлгөмөл хавтан.	ИИС-20; ИИС-4 серийн бүтээц	9	Их хэмжээний элэгдэлд орсон бол
4.1	4.1 Олон давхар төмөр бетон араг бүтээцтэй, рамын хавтгайд тоосгон өрлөгөн хашлага ханатай	Тухайлсан зургаар	8	Их хэмжээний элэгдэлд орсон бол 7
4.2	4.2 Нэг, хоёр давхар төмөр бетон араг бүтээцтэй, рамын хавтгайд тоосгон дүүргэгч ханатай	Тухайлсан зургаар	8	
5	5. Цутгамал төмөр бетон араг бүтээцтэй ба зэгсэн хавтан дүүргэгчтэй 1957 оноос өмнө зураг төслийг нь хийсэн олон давхар барилга	Тухайлсан зургаар	6	
6	6.Уян нэгдүгээр давхартай олон давхар барилга		4	
7.1	7.1 Модон араг бүтээцтэй барилга	Тухайлсан зургаар	7	
7.2	7.2 Угсармал модон бамбайт барилга	Тухайлсан зургаар	7	
7.3	7.3 Заамал модон барилга	Тухайлсан зургаар	7	
8.1	8.1 Өөрийгөө даах тоосгон өрлөгөн ханатай, төмөр бетон араг бүтээцтэй барилга, 1957 оноос хойш зураг төслийг нь хийсэн	Тухайлсан зургаар	6	
8.2	8.2 Өөрийгөө даах ханатай, төмөр бетон араг бүтээцтэй барилга, 1957 оноос өмнө зураг төслийг нь хийсэн	Тухайлсан зургаар	6	
9	9. Гадна даацын ханатай болон дотор араг бүтээцтэй барилга	Тухайлсан зургаар	5	
10.1	10.1 Тоосгон өрлөгөн даацын ханатай ба цутгамал төмөр бетон хучилттай барилга	Тухайлсан зургаар	5	
10.2	10.2 Тоосгон өрлөгөн даацын ханатай ба угсармал төмөр бетон хучилттай, 1957 оноос хойш хийгдсэн зургаар баригдсан барилга	Тухайлсан зургаар	5	
10.3	10.3 Тоосгон өрлөгөн даацын ханатай ба угсармал төмөр бетон хучилттай, 1957 оноос өмнө хийгдсэн зургаар баригдсан барилга	Тухайлсан зургаар	5	
11	11. Төмөр бетон оролцоотой /холомог/ тоосгон өрөгт даацын ханатай ба төмөр бетон хучилттай барилга	Нэг маягийн төсөл	5	
12.1	12.1 Тоосгон өрлөгийн даацын ханатай ба модон дам нуруун хучилттай нэг давхар барилга	Тухайлсан зургаар	2	
12.2	12.2 Тоосгон өрлөгийн даацын ханатай ба модон дам нуруун хучилттай 2 ба түүнээс дээш давхар барилга	Тухайлсан зургаар	3	
13	13. Түүхий тоосгон даацын ханатай барилга	Тухайлсан зургаар	1	

#### 5. Зам

Өгөгдөл			
		Сонгох хэсэг	
Хөрсний төрөл	БНБД 22-01-01	II зэргийн хөрс	2
Газар хөдлөлтийн багл	МСК шаталбар	< 9	4
Үр дүн			
Хөрсний оргил хурд, $V_{max}$		35.0	
		0.069	
Эвдрэлд орох цэгийн тоо		0.069 Цэг/км	
Damage spots is		0.069	Points per km
Damage of embankment and earth cut			

## 6. Зам-мэдээлэл

Ангилал

**Хөрсний төрөл**

I зэргийн хөрс

II зэргийн хөрс

III зэргийн хөрс

Тодорхойгүй

$V_{max}$  /Хөрсний оргил

хурд/

$$MCK=1.5I_{DMA}+1.5, MCK < 5$$

$$MCK=1.5I_{DMA}+0.75, MCK \geq 5$$

$$I_{DMA} = 1.1931 * \log(V_{max}) + 2.519$$

MCK шаталбар

< 6

< 7

< 8

< 9

< 9.5

< 10

10>

$I_{DMA}$  см/сек

3.50 3.22

4.17 7.13

4.83 15.79


5.50 34.98

5.83 52.05

6.17 77.45

6.83 171.49

$V_{max}$	Type I	Type II	Type III
20	0.03	0.04	0.06
35	0.05	0.07	0.12
64	0.07	0.1	0.16
116	0.09	0.13	0.2



## 7. Гүүр

Мэдээлэл

Категори	Өгөгдлүүд	Оноо
Хөрсний төрөл	II зэргийн хөрс	1
Хөрсний усны төвшин дээшлэх магадлал	Тодорхойгүй	2
Дам нурууны төрөл	Энгийн гүүр	3
Тулах хэсэг	Уламжлалт	1
Тулгуурын өндөр	5-10 м	1.35
Алгаслын тоо	$\geq 2$	1.75
Girder support	Short (support length (cm)/ span length (m)<1)	1.2
MCK шаталбарын балл	$7 \leq MCK < 8$	1
Суурь	Pile	1.4
Substructure Member	Brick • Concrete	1.4

Нийт оноо (= Өгөгдлүүдийн нийлбэр оноо) ба эвдрэлийн түвшин 33.3

Эвдрэлийн түвшин А

Эвдрэлийн түвшин А	Нурах эсвэл их хэмжээний хэв гажилтад орно
Эвдрэлийн түвшин В	Зарим хэсэг нь хэв гажилтад орно
Эвдрэлийн түвшин С	Эвдрэлд орохгүй, эсвэл маш бага хэмжээний эвдэрэлд орно

## 8. Гүүр-мэдээлэл

Категори	Өгөгдөл	Оноо
Хөрсний төрөл	I зэргийн хөрс	0.5
	II зэргийн хөрс	1
	III зэргийн хөрс	1.5
	Тодорхойгүй	1.5

Хөрсний шингэрэлт явагдах магадлал	Болохгүй	1
	Бага	1.5
	Өндөр	2
	Тодорхойгүй	2

Дам нурууны төрөл	Консолон гүүр	1
	Үргэлж дам нуруут гүүр	2
	Энгийн гүүр	3

Тулах хэсэг	Fall prevention	0.6
	Уламжлалт	1
	Two moving bearing	1.15

Тулгуурын өндөр	$\leq 5$ м	1
	5-10 м	1.35
	$\geq 10$ м	1.7

Алгасалын тоо	= 1	1
	$\geq 2$	1.75

Girder support	Long (support length (cm)/span length(m) $\geq 1$ )	0.8
	Short (support length (cm)/ span length (m) $< 1$ )	1.2

МСК шаталбарын балл	7 баллаас бага	0.7
	$7 \leq \text{МСК} < 8$	1
	$8 \leq \text{МСК} < 9$	1.7
	$9 \leq \text{МСК} < 9.5$	2.4
	$9.5 \leq \text{МСК} < 10$	3
	10 баллаас их	3.5

МСК	$I_{\text{MA}}$	$V_{\text{max}}$
$< 6$	3.50	3.22
$< 7$	4.17	7.13
$< 8$	4.83	15.79
$< 9$	5.50	34.98
$< 9.5$	5.83	52.05
$< 10$	6.17	77.45
$10 >$	6.83	171.49

Суурь	Other than pile	1
	Pile	1.4

Substructure Member	Brick · Concrete	1.4
	Others	1

Нийт оноо (= Өгөгдлүүдийн нийлбэр оноо) ба эвдрэлийн түвшин	
Эвдрэлийн түвшин	Нийт оноо
A	30-аас дээш
B	26-аас 30-ын хооронд
C	26-аас бага

9. Усан хангамж

Өгөгдөл			
Сонгох хэсэг			
Хөрсний усны төвшин дээшлэх магадлал	Cl	Тодорхойгүй	4
Cpd factors	Яндангийн материал	PVC	4
	Яндангийн диаметр	300-500 мм	3
			21
Газар хөдлөлтийн балл	МСК	< 9	4

Үр дүн

Cl	2.0
C <sub>dp</sub>	1.2
V <sub>max</sub>	35.0
Rs	0.050
Rm	0.121 Points/ km
Damage spots is	<input type="text" value="0.121"/> Pints per km

10. Усан хангамж мэдээлэл

Cl  
**Хөрсний шингэрэлт явагдах эсэх**  
 Болохгүй  
 Бага  
 Өндөр  
 Тодорхойгүй

Cpd	Шугам хоолой	Яндангийн диаметр
	Ductile iron	<75 мм
	Cast Iron	100-300 мм
	Steel	300-500 мм
	PVC	500-1,000 мм
	Asbestos cement	1000 мм-ээс дээш
	Бусад	Тодорхойгүй



$V_{max}$	$MSK = 1.5I_{JMA} + 1.5, MSK < 5$ $MSK = 1.5I_{JMA} + 0.75, MSK \geq 5$ $I_{JMA} = 1.1931 * \log(V) + 2.519$	
MCK	$I_{JMA}$	с м/с е
< 6	3.50	3.22
< 7	4.17	7.13
< 8	4.83	15.79
< 9	5.50	34.98
< 9.5	5.83	52.05
< 10	6.17	77.45
10>	6.83	171.49

### 11. Ариутгах татуурга

Өгөгдөл			
Сонгох хэсэг			
Хөрсний усны Төвшин дээшлэх магадлал		Тодорхойгүй	3
Ариутгах татуургаас хамаарах хүчин зүйл	Яндангийн материал	Бусад	2
Газар хөдлөлтийн балл	MCK	< 9	3
Үр дүн			
$V_{max}$	35.0		
Damage length	13.60 %		

### 12. Ариутгах татуурга-мэдээлэл

CI  
**Хөрсний шингэрэлт явагдах магадлал**  
 Болохгүй  
 Бага  
 Өндөр  
 Тодорхойгүй  
  
 Cpд  
**Яндангийн материал**  
 PVC  
 Ceramic  
 Бусад

Vmax	$MSK=1.5I_{JMA}+1.5, MSK < 5$ $MSK=1.5I_{JMA}+0.75, MSK \geq 5$ $I_{JMA} = 1.1931 \cdot \log(V)+2.519$		
М С К	$I_{JMA}$	с м / с е к	
< 7	4.17	7.13	
< 8	4.83	15.79	5-
< 9	5.50	34.98	5+
< 9.5	5.83	52.05	6-
< 10	6.17	77.45	6+
10>	6.50	115.25	7

### 13. Цахилгааны шон


Өгөгдөл			
			Сонгох хэсэг
Газар хөдлөлтийн балл	МСК	< 9	4
<b>Үрдүн</b>			
$GPA_{max}$ (см/сек <sup>2</sup> )	566.0		
<b>Poles</b>			
Concrete	0.79 per 100 poles		
Wood	0.31 per 100 poles		
<b>Агаарын кабель</b>			
Хамгийн их эвдрэл (%)	17.182 %		
Дундаж эвдрэл (%)	3.519 %		
<b>Газрын кабель</b>			
Хамгийн их эвдрэл (%)	2.208 %		
Дундаж эвдрэл (%)	0.505 %		
Дээрхи эвдрэлийн түвшинг АНУ-ын HAZUS болон Японы Сайтама мужийн эвдрэлийн функцид үндэслэн тооцсон болно.			

14. Цахилгааны шон-мэдээлэл

PGA(cm/s <sup>2</sup> )	Damage ratio(%)
0	0
49	1.90E-08
98	1.20E-03
147	7.50E-02
196	0.5
245	1.5
294	3
343	5.1
392	7.5
441	9.6
490	11.1
539	12.9
588	16.1
637	21.3
686	28.2
735	35.2
784	41.3
833	46.2
882	50.1
931	53.7
980	57.3
1029	61.1
1078	64.9
1127	68.5
1176	71.6
1225	74.1
1274	76
1323	77.4
1372	78.4


PGA(cm/s <sup>2</sup> )	Average Damage ratio(%)
0	0
225	1.00E-02
350	0.3
500	1.2
700	8.5
1000	27

4.44444E-05 2.67E-03



PGA(cm/s <sup>2</sup> )	Damage ratio(%)
0	0
49	1.90E-08

Underground cable	
0	0
219.8	0
400	0
gal damage ratio (%)	
480	0.001
500	0.8
738.6	6
2481	16




Underground cable	
0	0
219.8	0
400	0
gal damage ratio (%)	
480	0.001
500	0.04
738.6	0.3
2481	4.7

MSK	Intensity of JMA		gal
< 6	3.50	3	71.0
< 7	4.17	4	141.0
< 8	4.83	5-	283.0
< 9	5.50	5+	566.0
< 9.5	5.83	6-	663.0
< 10	6.17	6+	800.0
10>	6.50	7	985.3

I <sub>JMA</sub>	Estimated acceleration
0	0~0.6gal
1	0.6~2gal
2	2~6gal
3	6~20gal
4	20~60gal
5-	60~110gal
5+	110~200gal
6-	200~350gal
6+	350~600gal
7	More Than 600gal

$$I_{jma} = (\log(A) + 0.27) / 0.54$$

(Midorikawa etc 1982)



## 15. Дулааны шугам

Өгөгдөл			
Сонгох хэсэг			
Хөрсний усны төвшин дээшлэх магадлал	Cl	Бага	2
Cpd factors	Материал	Ductile iron	1
	Диаметр	500-1,000mm	4
			4
Газар хөдөлгөөний Балл	МСК	< 9	4

Үр дүн

Cl	2.0
Cdp	0.09
V <sub>max</sub>	35.0
Rs	0.050
Rm	0.009 Цэг/км
Эвдрэл үүсэх цэгийн тоо	0.009 Цэг/км

## 16. Дулааны шугам-мэдээлэл

Cl

**Хөрсний шингэрэлт болон  
х магадлал**

Болохгүй

Бага

Өндөр

Тодорхойгүй

Cpd

**materials**

**Diameter**

Ductile iron

<75mm

Cast Iron

100-300mm

Steel

300-500mm

PVC

500-1,000mm

Asbestos cement

1000- mm

Others

unknown

V<sub>max</sub>

**MSK = 1.5I<sub>JMA</sub>+1.5, MSK < 5**

**MKS = 1.5I<sub>JMA</sub>+0.75, MSK >=5**

**I<sub>JMA</sub> = 1.1931\*log(V)+2.519**

MSK

I<sub>JMA</sub> cm/s

< 6

3.50 3.22

< 7

4.17 7.13

< 8

4.83 15.79

< 9

5.50 34.98

< 9.5

5.83 52.05

< 10

6.17 77.45

10>

6.83 171.49

## **МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР**

### **Зааврын бүтэц**

**Нэг. Оршил**

**Хоёр. Төлөвлөгөөний ерөнхий бүтэц**

**Гурав. Төлөвлөгөөний агуулга**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1.Танилцуулгын хэсэг.**

1.1.1. Монгол Улсын газар зүй, байгаль цаг уур, нийгэм эдийн засаг, хүн ам, засаг захиргааны нэгжийн товч танилцуулга

1.1.2. Тохиолдсон газар хөдлөлтийн гамшгийн сургамж, дүгнэлт

#### **1.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, баримтлах зарчим**

1.2.1. Төлөвлөгөөний зорилго

1.2.2. Төлөвлөгөө боловсруулахад баримтлах зарчим

#### **1.3. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах удирдлага, бүтэц зохион байгуулалт**

1.3.1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тогтолцоо

1.3.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, гүйцэтгэх чиг үүрэг

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

#### **2.1. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ ба хохирлын төсөөлөл**

2.1.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй хохирлын төсөөлөл

#### **2.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

2.2.1. Газар хөдлөлтийн гамшгийн аюул, мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэмжээ

2.2.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага, сурталчилгаа

2.2.3. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох талуудын оролцоо

#### **2.3. Барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн гамшигт тэсвэртэй байдлыг дээшлүүлэх**

2.3.1. Газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ, барилга байгууламжийн хийц бүтээц, норм, дүрэм, журам, стандарт

2.3.2. Газар хөдлөлтөд тэсвэртэй хөдөлгөөнт болон суурин удирдлагын байрыг бэлтгэх

2.3.3. Хувийн болон олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

- 2.3.4. Шуурхай тээвэрлэлт хийх автозамыг тогтоох, зам болон замын байгууламжийг сэргээн засварлах, бэлтгэх арга хэмжээ
- 2.3.5. Цэвэр, бохир усны шугам хоолойн байгууламж, эрчим хүчний байгууламж, ахуйн хэрэглээний хийн байгууламж, телефон утасны байгууламж, хөдөлгөөнт холбооны байгууламж, нийтийн тээвэр, төмөр замын газар хөдлөлтийн тэсвэржилт болон аюулгүй байдлыг хангах арга хэмжээ

#### **2.4. Газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ**

- 2.4.1. Холбоо, зарлан мэдээллийн сүлжээ, мэдээллийн санг бүрдүүлэх
- 2.4.2. Гал түймэртэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэх
- 2.4.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх
- 2.4.4. Эм тариа, эмнэлгийн материал, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний хангамжийн тогтолцоог бий болгох
- 2.4.5. Гоц халдварт өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн халдвар эсэргүүцэх арга хэмжээний зохион байгуулалт
- 2.4.6. Хог хаягдал, ялгадас цэвэрлэх арга хэмжээний зохион байгуулалт
- 2.4.7. Цэвэр ус, хоол хүнс, эм, эмийн хэрэгсэл, шатахуун, нэн шаардлагатай эд материалын нөөц бүрдүүлэлт, нөхөн хангалт
- 2.4.8. Усан хангамжийн тогтолцоог бүрдүүлэх
- 2.4.9. Нүүлгэн шилжүүлэх, түр хорогдох байрыг бэлтгэх, байршлыг тогтоох

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ХОР УРШГИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

#### **3.1. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай удирдлага зохицуулалт**

- 3.1.1. Гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалт
- 3.1.2. Холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагаа
- 3.1.3. Төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах албадын гүйцэтгэх чиг үүрэг
- 3.1.4. Гамшгаас хамгаалах дайчилгааг зохион байгуулах
- 3.1.5. Мэдээ, мэдээллийг дамжуулах, хүлээн авах .
- 3.1.6. Хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт

#### **3.2. Гамшгийн голомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

- 3.2.1. Гамшгийн голомтод ажиллах хүч хэрэгслийн зохион байгуулалт
- 3.2.2. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа
- 3.2.3. Эрэн хайх, аврах, яаралтай тусламж үзүүлэх ажиллагаа
- 3.2.4. Хэв журам сахиулах арга хэмжээ
- 3.2.5. Нөхөн хангалт зохион байгуулах

#### **3.3. Эмнэлгийн хангалтыг зохион байгуулах ба нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ**

- 3.3.1. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ
- 3.3.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн, ороох, боох материалын хангалт
- 3.3.3. Нүүлгэн шилжүүлэх болон түр хорогдох байрны эмнэлгийн тусламж үйлчилгээ

#### **3.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах**

- 3.4.1. Нүүлгэн шилжүүлэх бүсийн төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт
- 3.4.2. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах
- 3.4.3. Нүүлгэн шилжүүлэх бүсэд хүнс, материалын хангалтыг зохион байгуулах

### **3.5. Ариун цэвэр, халдвар судлал, хог хаягдал, хүрээлэн буй орчны талаар авах арга хэмжээ**

3.5.1. Эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх арга хэмжээ

3.5.2. Ахуйн болон барилгын хог хаягдал, ялгадас цэвэрлэх, зайлуулах арга хэмжээ

3.5.3. Хүнсний эрүүл ахуй, хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ

3.5.4. Шарилыг таниулах, байршуулах, оршуулах арга хэмжээ

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ДАРАА ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **4.1. Хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэх**

**4.2. Гамшгийн хохирлыг үнэлэх, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах**

**4.3. Хойшлуулшгүй сэргээн босгох, сэргээн босголтын ажлын ерөнхий шат дараалал**

4.3.1. Хойшлуулшгүй сэргээн босгох, сэргээн босголтын ажлыг эхлүүлэх тогтолцоог бүрдүүлэх (Газар хөдлөлт болсноос 14 хоногийн хугацаанд)

4.3.2. Сэргээн босгох ажлын үндсэн чиглэлийг тогтоох (14 дэх хоногоос 2 сарын хугацааны хооронд)

4.3.3. Сэргээн босгох ажлын үндсэн төлөвлөгөөг боловсруулж баталж хэрэгжүүлэх (2 сар~1 жил)

## **ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ**

1. Онцгой байдлын ерөнхий газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой комисс, улсын алба, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын шаардлагатай үед холбогдох албан тушаалтны гэрийн хаяг, ирэх, явах маршрут, утасны жагсаалт, зарлан мэдээлэл дамжуулах бүдүүч,

2. Онцгой байдлын ерөнхий газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой комисс, улсын алба, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын холбооны үелзлэл, нөөц холбооны техник хэрэгсэл

3. Хөдөлгөөнт болон суурин удирдлагын байр, шаардлагатай техник, хэрэгслийн судалгаа

4. Ард иргэд, олон нийтэд гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл хүргэх системийн тогтолцоо

5. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн судалгаа

6. Тээврийн хэрэгслийн дайчилгаа ба бүрдүүлэлтийн судалгаа

7. Яаралтай тусламжийн нөөцийн бараа материалын жагсаалт



# **МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР**

## **Нэг. Оршил.**

1.1. Энэхүү заавар нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж хэрэгжүүлэхэд удирдлага болгох баримт бичиг юм.

1.2. Энэ зааврыг ашиглан Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг (цаашид төлөвлөгөө гэх) боловсруулах бөгөөд төлөвлөгөө нь Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний салбар хэсэг байна.

1.3. Төлөвлөгөө боловсруулахдаа Монгол Улсын нийгэм, эдийн засаг, газарзүйн онцлог, газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл, үүсч болзошгүй цагийн байдал, хохирлын үнэлгээ, удирдлага зохион байгуулалт, нөөц, хүч хэрэгслийг үндэслэл болгоно.

1.4. Төлөвлөгөөг гамшгаас хамгаалах улсын алба, онцгой байдлын байгууллагаас бүрдсэн ажлын хэсэг боловсруулж, Монгол Улсын Засгийн газар батална.

1.5. Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын даргын саналыг үндэслэн дадлага, сургуулиар Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар 4 жилд нэг удаа тодотгоно.

1.6. Төлөвлөгөө нь 2 буюу түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед идэвхжинэ.

## **Хоёр. Төлөвлөгөөний ерөнхий бүтэц**

2.1. Төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл
- Хоёрдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө
- Гуравдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах төлөвлөгөө
- Дөрөвдүгээр бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн үед хойшлуулшгүй сэргээн босгох төлөвлөгөө
- Хавсралтууд

## **Гурав. Төлөвлөгөөний агуулга**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1.Танилцуулгын хэсэг.**

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн үзүүлэлт, засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн байршил, хүн амын судалгаа, тохиолдож байсан газар хөдлөлтийн гамшгийн сургамж, дүгнэлт, эрсдэлийн үнэлгээ байна.

Тоо баримтыг статистикийн албан ёсны мэдээллийг үндэслэн гаргах бөгөөд тоо баримт үзүүлэлтийг хүснэгтэн мэдээллээс гадна график болон бусад аргаар үзүүлж болно.

Тохиолдсон газар хөдлөлтийн гамшгийн сургамж, дүгнэлтийг сүүлийн 10 жилийн байдлаар гаргаж /хүснэгт болон бусад хэлбэрээр/, түүнээс учирсан хохирол, хор уршгийг арилгах ажлыг зохион байгуулахад гарч байсан сургамжийн талаар товч дурдана.

## **1.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, баримтлах зарчим**

### **1.2.1. Төлөвлөгөөний зорилго**

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, учирч болзошгүй хохирлыг багасгах, бэлэн байдлыг хангах, гамшигт тэсвэртэй хот, суурин газар, хүрээлэн буй орчныг цогцлоох асуудлыг гол зорилгоо болгоно.

### **1.2.2. Төлөвлөгөө боловсруулахад баримтлах зарчим**

Төлөвлөгөө боловсруулахад газар хөдлөлтийн гамшгийн болзошгүй цагийн байдал, хохирлын төсөөлөлд үндэслэсэн, амьдралд илүү нийцсэн, хэрэгжих үндэслэлтэй, газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох талуудын харилцан ажиллагаа, уялдааг хангасан, орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдсан байх зэрэг зарчмыг баримтлана.

## **1.3. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах удирдлага, бүтэц зохион байгуулалт**

### **1.3.1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо**

Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц зохион байгуулалтыг харуулж, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Улсын онцгой комисс газар хөдлөлтийн гамшгийн үед гүйцэтгэх үндсэн чиг үүргийг дурдана.

### **1.3.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, гүйцэтгэх чиг үүрэг**

Онцгой байдлын байгууллага, Зэвсэгт хүчин, гамшгаас хамгаалах алба, МУЗН-ийн гүйцэтгэх үндсэн чиг үүргийг дурдана.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **2.1. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ ба хохирлын төсөөлөл**

#### **2.1.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй хохирлын төсөөлөл**

Энэ хэсэгт 21 аймаг, нийслэл, дүүргийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүн, хохирлын төсөөллийг улсын хэмжээнд нэгтгэж оруулна.

### **2.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

2.2.1. Газар хөдлөлтийн гамшгийн аюул, мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэмжээ

Газар хөдлөлтийн гамшгийн аюулын мэдээ, мэдээллийг төр, засгийн удирдлага, олон нийтэд тасралтгүй хүргэх тогтолцоог хэрхэн бий болгох талаар дурдана.

#### 2.2.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага, сурталчилгаа

Орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, мэргэжлийн анги, иргэд, олон нийтэд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг ямар хэдий хугацаанд ямар хэлбэрээр хэрхэн зохион байгуулах талаар дурдана.

#### 2.2.3. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох талуудын оролцоо

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл, гамшгаас хамгаалах алба, орон нутгийн удирдлага, төрийн захиргааны байгууллага, МУЗН аж ахуйн нэгж зэрэг байгууллагууд ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар дурдана.

### **2.3. Барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн гамшигт тэсвэртэй байдлыг дээшлүүлэх**

#### 2.3.1. Газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ, барилга байгууламжийн хийц бүтээц, норм, дүрэм, журам, стандарт

Газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ, барилга байгууламжийн хийц бүтээц, норм, дүрэм, журам, стандартыг хэрхэн мөрдөх, сайжруулах асуудлыг ямар байгууллага хариуцаж, хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгана.

#### 2.3.2. Газар хөдлөлтөд тэсвэртэй хөдөлгөөнт болон суурин удирдлагын байрыг бэлтгэх

Газар хөдлөлтийн гамшигт тэсвэртэй хөдөлгөөнт болон суурин удирдлагын байрыг ямар байгууллага хариуцаж, хэрхэн хэрэгжүүлэх талаар дурдана.

2.3.3. Хувийн болон олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах талаар дурдана. /юуг хэн хариуцаж, хэрхэн хийх талаар дурдах, шаардлагатай бол хугацааг оруулах/ тухайн шатны Засаг дарга эсхүл тухайн асуудал хариуцсан яам, холбогдох салбар нэгж/

#### 2.3.4. Шуурхай тээвэрлэлт хийх автозамыг тогтоох, зам болон замын байгууламжийг сэргээн засварлах, бэлтгэх арга хэмжээ

Газар хөдлөлтийн гамшгийн үед шуурхай тээвэрлэлт хийх автозамыг тогтоох, зам болон замын байгууламжийг сэргээн засварлах ажлыг аль байгууллага хариуцаж зохион байгуулах талаар дурдана.

2.3.5. Цэвэр, бохир усны шугам хоолойн байгууламж, эрчим хүчний байгууламж, ахуйн хэрэглээний хийн байгууламж, телефон утасны байгууламж, хөдөлгөөнт холбооны байгууламж, нийтийн тээвэр, төмөр замын газар хөдлөлтийн тэсвэржилт болон аюулгүй байдлыг хангах арга хэмжээ

Дээрх асуудлыг аль байгууллага хариуцаж, газар хөдлөлтийн тэсвэржилт болон аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар байгууллага бүрээр нь дурдана.

### **2.4. Газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ**

#### 2.4.1. Холбоо, зарлан мэдээллийн сүлжээ, мэдээллийн санг бүрдүүлэх

- 2.4.2. Гал түймэртэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэх
  - 2.4.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх
  - 2.4.4. Эм тариа, эмнэлгийн материал, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний хангамжийн тогтолцоог бий болгох
  - 2.4.5. Гоц халдварт өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн халдвар эсэргүүцэх арга хэмжээний зохион байгуулалт
  - 2.4.6. Хог хаягдал, ялгадас цэвэрлэх арга хэмжээний зохион байгуулалт
  - 2.4.7. Цэвэр ус, хоол хүнс, эм, эмийн хэрэгсэл, шатахуун, нэн шаардлагатай эд материалын нөөц бүрдүүлэлт, нөхөн хангалт
  - 2.4.8. Усан хангамжийн тогтолцоог бүрдүүлэх
  - 2.4.9. Нүүлгэн шилжүүлэх, түр хорогдох байрыг бэлтгэх, байршлыг тогтоох
- 2.4.1-2.4.9 дэх арга хэмжээнүүдийг улс, орон нутгийн хэмжээнд ямар байгууллага, алба хариуцаж, бэлэн байдлыг хангах ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар байгууллага, алба тус бүрээр тодорхой тусгана.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ХОР УРШГИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **3.1. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай удирдлага зохицуулалт, холбогдох талуудын чиг үүрэг**

#### 3.1.1. Гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалт

Газар хөдлөлтийн гамшгийн үед учирсан хор уршгийг арилгах шуурхай удирдлага зохицуулалтыг улсын онцгой комисс хариуцаж, Онцгой байдлын асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

#### 3.1.2. Холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагаа

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу зохион байгуулах асуудлыг тусгана.

Мөн гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дарааллыг дусгана.

#### 3.1.3. Төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах албадын гүйцэтгэх чиг үүрэг

Энэ хэсэгт газар хөдлөлтийн гамшгийн үед төр, захиргааны байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой заана. Тухайлбал:

#### Онцгой байдлын ерөнхий газар:

- Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдлыг үнэлж, харилцан ажиллагааг зохицуулах;
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, цуцлах тухай санал, дүгнэлтийг гаргах;
- Газар хөдлөлтийн гамшгийн үед эрэн хайх, аврах, гал унтраах ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгахтай холбогдсон асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;
- Улсын онцгой комиссыг хуралдуулж асуудал шийдвэрлүүлэх;

- Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын нөөцөөс бараа материал гаргах, хуваарилах, тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулах;
- олон улсын байгууллагад хандах хүсэлтийг Засгийн газарт тавих;
- олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах;
- нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл цуглуулах, үндэсний аюулгүй байдлын зөвлөл, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг бодит мэдээллээр хангах.

#### Эрүүл мэндийн яам: (Эрүүл мэндийн улсын алба)

- Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдалтай холбоотой асуудлыг дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх;
- Газар хөдлөлтийн гамшгийн үед нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам: (Хүнс, хөдөө аж ахуйн улсын алба)

- гамшгийн нөхцөл байдалтай холбоотой асуудлыг дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Байгаль орчин, ногоон хөгжлийн яам: (Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх улсын алба)

- Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдалтай холбоотой асуудлыг дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- хими, биологийн холбогдолтой ослын мэдээг орон нутгаас болон олон улсын байгууллагуудаас хүлээн авч мэдээ, мэдээлэл солилцох;
- усны нөөц, уст цэгийн ашиглалт, хангалт хийх, хяналт тавих;
- байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээ мэдээлэл, сансарын хиймэл дагуулын зургаар хангах.

#### Эрчим хүчний яам: (Түлш эрчим хүчний улсын алба)

- эрчим хүчний зохицуулалт, цахилгаан эрчим хүчний хангалтанд хяналт тавих, хязгаарлах, түдгэлзүүлэх;
- нэмэлт болон нөөц эрчим хүчээр хангах;
- Газар хөдлөлтийн гамшгийн үед ашиглагдах шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Барилга хот байгуулалтын яам: (Барилга, хот байгуулалтын улсын алба)

- гамшгийн үед шаардлагатай мэдээлэл, хот байгуулалт, барилга байгууламжийн зураг, төслөөр хангах;
- бүх төрлийн байр зүйн зургаар хангах;
- инженерийн шугам сүлжээ, ундны усны эх үүсвэрийг хамгаалж, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- гамшгийн үеийн геодезийн хэмжилтийн ажил гүйцэтгэх багаж, тоног төхөөрөмжөөр хангах;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Зам тээврийн яам: (Зам тээврийн улсын алба)

- нүүлгэн шилжүүлэлтийн үед шаардлагатай техник, тээврийн хэрэгслээр хангах;
- авто зам, төмөр замын саад бэрхшээлийг арилгах;
- иргэний агаар, төмөр зам, усан зам болон нийтийн тээврийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах;
- улс, хот хоорондын авто замын чиглэлийг өөрчлөх, хаах арга хэмжээг тухайн нөхцөл байдалд нийцүүлж авах;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Мэргэжлийн хяналтын ерөнхий газар: (Мэргэжлийн хяналтын улсын алба)

- Газар хөдлөлтийн гамшгийн голомтод зохион байгуулж буй үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Цагдаагийн ерөнхий газар: (Хэв журам сахиулах улсын алба)

- Газар хөдлөлтийн гамшгийн үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, төр, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг гэмт халдлагаас хамгаалах;
- гамшгийн голомт болон хорио цээрийн бүсэд хамгаалалт зохион байгуулах;
- гамшгийн голомтод гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах зорилгоор хууль сахиулах ажиллагаа явуулах, шалтгаан нөхцлийг тогтоох;
- хохирогч, нэрвэгдэгсдийн талаарх мэдээллийг цуглуулах, шалган тогтоох, цогцсыг таниулах ажиллагаа, нэрвэгдэгсдийн талаарх мэдээллийг өгөх;
- гамшгийн голомт, хорио цээрийн бүсэд зорчих хөдөлгөөн, тусгай зориулалтын техник хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, дайчлах, шалган нэвтрүүлэх;
- гамшгийн үед гарч болзошгүй үймээн самууны үед дэг журам сахиулах, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, удирдлагын штабыг мэдээллээр хангах;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо технологийн газар: (Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба)

- гамшгийн үед харилцаа холбоо, мэдээллийн сүлжээг хууль тогтоомжийн дагуу дайчлах, найдвартай ажиллагаагаар хангах;
- мэдээллийг саадгүй дамжуулах
- гамшгийн голомтод холбоо зохион байгуулах, бэлэн байлгах;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба: (Сурталчилгааны улсын алба)

- засгийн газрын шийдвэрийг нийтэд мэдээлэх;
- гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээний талаарх нөхцөл байдлыг мэдээлэх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах.

#### Батлан хамгаалах яам:

- гамшгийн аюулаас хүн ам, эд юмсыг авран хамгаалах, хорио, цээрийн дэглэм сахиулах;
- аврах, сэргээн босгох ажиллагааны үед хүч, хэрэгслээр дэмжлэг үзүүлэх;
- цэрэг дайны зориулалттай тэсэрч дэлбэрэх хэрэглэлийг аюулгүй болгох;

- цацраг идэвхт болон химийн хордолтыг хоргүйжүүлэх, саармагжуулах
- гамшгийн үед хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах.
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Гадаад хэргийн яам:

- олон улстай гамшгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцох;
- Засгийн газрын шийдвэрийн дагуу гадаад орон, олон улсын байгууллагад хандах;
- олон улсын аврах багийг Монголд ажиллах нөхцөл бүрдүүлэх;
- гадаадын иргэд гамшигт өртсөн үед тухайн улсын элчин сайдын яам, холбогдох байгууллагад мэдээлэх;
- шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх;
- гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах.

#### Сангийн яам:

- Засгийн газар, улсын онцгой комиссын шийдвэрээр гамшгаас хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- улс орны санхүү, эдийн засгийн байдал хүндэрсэн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх;
- олон улсын аврах баг, хүмүүнлэгийн тусламж, аврах багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг улсын хилээр орох, гарах асуудлыг шуурхай шийдвэрлэх;
- олон улсын байгууллага, хандивлагч орны аврах баг болон тусламжийн бараа материал, техник, тоног төхөөрөмж, аврах багаж хэрэгслийн татвар, хураамжтай холбоотой асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх.

#### Хууль зүйн яам:

- үүссэн нөхцөл байдалтай уялдуулан ажиллах эрх зүйн орчинд шаардлагатай зохицуулалтыг шуурхай авч хэрэгжүүлэх;
- нийтийг хамарсан үймээн, самууныг гаргахгүй байх талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

#### Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам: (Хүн ам, нийгмийн хамгааллын улсын алба)

- хүүхдийн эсрэг жендэрээс үүдэлтэй хүчирхийллээс хамгаалах ажлыг зохион байгуулах;
- хүүхдийн аюулгүй байдал, язгуур эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах;
- эмзэг бүлгийн хүүхэд, хараа хяналтгүй эцэг эх, гэр бүлээс тусгаарлагдсан хүүхдүүдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, тэднийг таньж тогтоох, бүртгэж тооцоо гаргах ажлыг зохион байгуулах;
- түр байрны нөхцөлд эхний ээлжинд хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ундны ус, хоол тэжээлээр хангахад анхаарал тавьж ажиллах;
- онцгой байдлын үед олон нийтэд үзүүлэх нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;
- нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд (иргэний бүртгэл, мэдээллийн бүлэгт) дэмжлэг үзүүлэх;

#### Иргэний нисэхийн ерөнхий газар:

- Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед гадаад орнуудаас ирэх тусламжийн бараа материалыг түр хадгалах байр савыг бэлтгэх, тэдгээрийг норгох, хөлдөөх зэргээр чанар байдлыг алдагдуулахгүй байх;
- “Чингис хаан” олон улсын нисэх буудал, нисэх зурвас, талбай газар хөдлөлтийн гамшигт өртөж удаан хугацаанд сэргээн босгох шаардлага гарсан тохиолдолд

нөөц буудал (аэродромууд)-ыг урьдчилан төлөвлөж, дээрх шаардлагуудыг хангуулах;

- гамшгийн дараах үед гадаад, дотоодын сурвалжлагч нарт мэдээлэл хийх, өрөө тасалгааг тоноглон байх, бусад шаардлагатай зүйлсийг бүрдүүлж, бэлтгэсэн байх;

- тохиолдсон гамшгийг арилгахад туслахаар хүрэлцэн ирсэн гадаад орнуудын аврах багийг түргэн хугацаанд саадгүй нэвтрүүлэх (хил, гаалиар аврах багаж хэрэгсэл, аврагч ноход, түр байр, хүнсний зүйлс);

- тусламжийн бараа материалыг татаж авах үүргийг гүйцэтгэх онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч, аврагч нарыг аэродромын бүсэд шуурхай нэвтрүүлэх арга хэмжээг урьдчилан төлөвлөсөн байх;

- олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, шаардлагатай тохиолдолд агаарын тээврийн хөдөлгөөнд зарим зохицуулалтыг хийх;

- осолдсон агаарын хөлгийг эрэн хайх, нислэг техникийн осол зөрчлийг шинжлэх, шалгах үйл ажиллагааг зохион байгуулах, осол сүйрлийн шалтгааныг шуурхай тогтоох;

- нэрвэгдэгсдийг шаардлагатай газар руу агаараар тээвэрлэх;

- Иргэний нисэхийн ерөнхий газар нь өөрийн аюулгүй байдал, хамгаалалтын алба, нисэхийн цагдаагийн хэлтэстэй хамтран гамшгийн үед нисэх буудлын орчимд хамгаалалтын бүс, хорио цээрийн дэглэм тогтоож, сахилга, дэг журмыг чангатгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлэх.

#### Хил хамгаалах ерөнхий газар:

- хилийн бүс, зурваст гарч болох гамшгийн үед хор уршгийг арилгахад шаардлагатай арга хэмжээг авах;

- шаардлагатай тохиолдолд хил хамгаалах байгууллагын анги, салбараас хүн хүч, техникийн туслалцаа үзүүлэх;

- гадаад орнуудын аврах баг, тэдгээрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зохих дүрэм, журмын дагуу улсын хилээр саадгүй нэвтрүүлэх.

#### Тагнуулын ерөнхий газар:

- Газар хөдлөлтийн гамшгийн аюул Монгол улсын Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох;

- техникийн холбогдолтой осол, химийн хорт бодисын нөлөөлөл үүссэн үед нөхцөл, шалтгааныг тодорхойлох;

- ҮАБЗ, Засгийн газрыг мэдээллээр хангах;

- үүссэн нөхцөл байдалтай холбогдсон санал боловсруулах, шийдвэр гаргах;

- террорист ажиллагааны үед сөрөг тусгай ажиллагаа зохион байгуулах;

#### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар:

- гамшгийн улмаас эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах ажиллагааг зохион байгуулах;

- гамшгийн үед хоригдогсдын аюулгүй байдлыг хангах, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

- гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд хоригдогсдыг дайчлах;

#### Төмөр замын хэрэг эрхлэх газар:

- төмөр замд үүссэн нөхцөл байдлыг үнэлэх, арга хэмжээний санал боловсруулах;

- олон улсын төмөр замын байгууллагатай хамтран ажиллаж мэдээлэл солилцох;

- осол сүйрлийн шалтгааныг шуурхай тогтоох, сэргээн босгох;

- нэрвэгдэгсэд, хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг тээвэрлэх.



### Нутгийн захиргааны байгууллага:

- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- орон нутгийн гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг үүрэг гүйцэтгүүлэх;
- байгууллага хоорондын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;
- дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;
- шаардагдах хүн, хүч хэрэгслийг орон нутгаас дайчлан гаргах, хангалт зохион байгуулах;
- гамшгийн голомтоос хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах.

#### 3.1.4. Гамшгаас хамгаалах дайчилгааг зохион байгуулах

Гамшгаас хамгаалах дайчилгааг Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын дагуу зохион байгуулах асуудлыг тусгана.

#### 3.1.5. Мэдээ, мэдээллийг дамжуулах, хүлээн авах

Гамшгийн үед мэдээ, мэдээллийг ямар дарааллаар хэрхэн иргэдэд хүргэх, гамшгийн шуурхай удирдлага зохицуулалтыг мэдээ, мэдээллээр хэрхэн хангах, ямар байгууллага хариуцан гүйцэтгэх талаар дурдана.

#### 3.1.6. Хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт

Гамшгийн үеийн олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийг аль байгууллага хариуцаж, хэрхэн зохион байгуулах талаар Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох журамд нийцүүлэн тусгана.

### **3.2. Гамшгийн голомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

#### 3.2.1. Гамшгийн голомтод ажиллах хүч хэрэгслийн зохион байгуулалт

Гамшгийн голомтод ажиллах мэргэжлийн байгууллага, иргэд, сайн дурынхан, дайчлагдан ажиллах хүч хэрэгслийн зохион байгуулалт, удирдлага зохицуулалтаар хэрхэн хангах талаар тусгана.

#### 3.2.2. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа

Гамшгийн үед хавсран тохиолдох гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар дурдана.

#### 3.2.3. Эрэн хайх, аврах, яаралтай тусламж үзүүлэх ажиллагаа

Гамшигт нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах ажиллагаа, эмнэлгийн яаралтай утсламж үзүүлэх арга хэмжээг аль аль байгууллага удирдаж болон хамтран зохион байгуулах талаар тусгана.

#### 3.2.4. Хэв журам сахиулах арга хэмжээ

Гамшгийн үед үүсэх эмх замбараагүй байдал, олон нийтийн хэв журмыг аль байгууллага хэрхэн сахиулах талаар дурдана.

#### 3.2.5. Нөхөн хангалт зохион байгуулах

Гамшгийн голомтод ажиллаж байгаа хүч хэрэгсэлд шаардлагатай хоол хүнс, шатахуун, техник тоног төхөөрөмж, эд материал, бусад шаардлагатай зүйлсийг аль байгууллага хариуцан зохион байгуулах асуудлыг тусгана.

### **3.3. Эмнэлгийн хангалтыг зохион байгуулах ба нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ**

3.3.1. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ

3.3.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн, ороох, боох материалын хангалт

3.3.3. Нүүлгэн шилжүүлэх болон түр хорогдох байрны эмнэлгийн тусламж үйлчилгээ

#### **3.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах**

3.4.1. Нүүлгэн шилжүүлэх бүсийн төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт

3.4.2. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

3.4.3. Нүүлгэн шилжүүлэх бүсэд хүнс, материалын хангалтыг зохион байгуулах

#### **3.5. Ариун цэвэр, халдвар судлал, хог хаягдал, хүрээлэн буй орчны талаар авах арга хэмжээ**

3.5.1. Эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх арга хэмжээ

3.5.2. Ахуйн болон барилгын хог хаягдал, ялгадас цэвэрлэх, зайлуулах арга хэмжээ

3.5.3. Хүнсний эрүүл ахуй, хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ

3.5.4. Шарилыг таниулах, байршуулах, оршуулах арга хэмжээ

3.3-3.3 дахь хэсэгт заасан арга хэмжээг аль байгууллага хариуцан болон хамтран зохион байгуулах талаар хэсэг тус бүрээр тодорхой тусгана.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ДАРАА ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

#### **4.1. Хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэх**

Хүн амын эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, орон байр болон бусад нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар энэ хэсэгт тодорхой дурдана.

#### **4.2. Гамшгийн хохирлыг тогтоох, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах**

Энэ хэсэгт газар хөдлөлтийн гамшгийн улмаас учирсан хохирлыг үнэлэх, хэрэгцээг тодорхойлох, улс орны нийгэм, эдийн засгийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцах болон хамтран хэрэгжүүлэх байгууллагын хамт дурдана.

#### **4.3. Хойшлуулшгүй сэргээн босгох, сэргээн босголтын ажлын ерөнхий шат дараалал**

Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлж, сэргээн босгох арга хэмжээний ерөнхий шат дарааллыг тодорхойлно.

4.3.1. Хойшлуулшгүй сэргээн босгох, сэргээн босголтын ажлыг эхлүүлэх тогтолцоог бүрдүүлэх (Газар хөдлөлт болсноос 14 хоногийн 1 жил хүртлэх хугацаанд)

4.3.2. Сэргээн босгох ажлын үндсэн чиглэлийг тогтоох (14 дэх хоногоос 2 сарын хугацааны хооронд)

4.3.3. Сэргээн босгох ажлын үндсэн төлөвлөгөөг боловсруулж баталж хэрэгжүүлэх (2 сар~1 жил)

4.3.1-4.3.3 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар хэсэг тус бүрээр тодорхойлно.

#### **Дөрөв. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахад анхаарах асуудлууд**

- Төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах орон нутгийн болон улсын албадын төлөвлөгөөтэй уялдуулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч бүх талуудын төлөөллийг оролцуулах;

- Газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлгээ, хохирлын төсөөлөл дээр үндэслэн боловсруулах

- Онцгой байдлын ерөнхий газар, Онцгой комисс, Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, бусад холбогдох байгууллагуудын хэрэгжүүлэх арга хэмжээг нарийн тусгах, хүч хэрэгслийн тооцоог нарийвчлан тооцох;

- Байгууллагуудын харилцан ажиллагаа, удирдлага зохицуулалт, хүч хэрэгслийн чадавхыг сайтар тооцох;

- Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед хаанаас, ямар хүч, хэрэгсэл, хэдий хугацаанд гарч үүрэг гүйцэтгэхийг тусгайлан тодотгох;

- Бусад холбогдох, хууль, дүрэм журам, зааврыг нарийн судлах.

- 1-4 Улсын албаны газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар

## **ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЗААВАР**

### **Зааврын бүтэц**

#### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Ерөнхий зүйл;
- 1.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, баримтлах зарчим, үндсэн чиглэл
  - 1.2.1. Төлөвлөгөө боловсруулах зорилго
  - 1.2.2. Баримтлах зарчим, үндсэн чиглэл
- 1.3. Гамшгаас хамгаалах албаны удирдлага, зохион байгуулалт, ерөнхий чиг үүрэг, харилцан ажиллагаа
  - 1.3.1. Гамшгаас хамгаалах албаны тогтолцоо
  - 1.3.2. Гамшгаас хамгаалах улсын албаны ерөнхий чиг үүрэг
  - 1.3.2. Гамшгаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн гамшгийн үеийн харилцан ажиллагаа:
- 1.4. Хамтын ажиллагааны санамж бичиг

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

- 2.1. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, хохирлын төсөөлөл, үүсч болзошгүй цагийн байдлын төсөөлөл;
- 2.2. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл, болзошгүй хохирлыг бууруулах зорилго, зорилт
- 2.3. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- 2.4. Гамшгаас хамгаалах улсын албаны зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах
- 2.5. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх
- 2.6. Улсын албаны барилга байгууламж болон холбогдох барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах
- 2.7. Гамшгийн үед материал хэрэгслийг шуурай тээвэрлэлтийн тогтолцоог бүрдүүлэх
- 2.8. Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал, хүнсний бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгсэл, эрчим хүч, дулаанаар тасралтгүй хангах тогтолцоог бүрдүүлэх
- 2.9. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ҮЕИЙН ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭ**

- 3.1. Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн цагийн байдлыг үнэлж, нөхцөл байдлыг тодотгох
- 3.2. Гамшгаас хамгаалах улсын албаны штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, ажилтнуудын бэлэн байдлыг хангах
- 3.3. Гамшгийн үеийн шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэх
- 3.4. Харилцан ажиллагааг зохион байгуулах, мэдээ мэдээллийг солилцох үйл ажиллагаа
- 3.5. Гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрт тусламж үйлчилгээгээр хангах

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ДАРААХ ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ**

- 4.1. Гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ болон түүнд шаардагдах зардлыг судалж тогтоох;
- 4.2. Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн барилга байгууламжийн хойшлуулшгүй сэргээн босгох;

### **Хавсралтууд:**

1. ГХУА –ны удирдлага штабын бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журам
2. Гамшгаас хамгаалах албаны хүч хэрэгслийн судалгаа
3. Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах албадын барилга байгууламжуудын судалгаа, байршлын газрын зураг
4. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй цагийн байдлын төсөөлөл ба хохирлын үнэлгээний үр дүн
5. Гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн гаднаас бараа материал хүнсний бүтээгдэхүүн, эм бэлдмэлцус, цусан бүтээгдэхүүн, гэр орон сууц, дулаан хувцас, хэрэгслэл, барилгын материал ханган нийлүүлэх (эхний ээлжинд эм тариа, ундны ус) маршрут
6. Гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн гаднаас шатах тослох материал, эм бэлдмэл, хүнсний бусад бараа материал ханган нийлүүлэх маршрут
7. Бусад шаардлагатай мэдээлэл, тооцоо, судалгаа

## ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЗААВАР

### Нэг. Оршил

1.1. Энэхүү заавар нь газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг гамшгаас хамгаалах болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлэхэд удирдлага болгох баримт бичиг юм.

1.2. Гамшгаас хамгаалах улсын алба /цаашид “ улсын алба” гэх/ нь энэхүү зааврыг ашиглан газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө /цаашид “төлөвлөгөө” гэх/ боловсруулах бөгөөд энэхүү төлөвлөгөө нь албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг болно.

1.3. Төлөвлөгөө боловсруулах ажлыг улсын албад, бусад холбогдох яам агентлаг, байгууллагатай хамтран боловсруулна. Онцгой байдлын байгууллага албаны төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, ач холбогдол, төлөвлөгөөний агуулга, боловсруулах үе шатыг танилцуулж, шаардлагатай тохиолдолд сургалт явуулна.

1.4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах арга зүйн дагуу төлөвлөгөө боловсруулна:

1. Төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээлэл цуглуулах (албан ёсны статистик мэдээ, тоо баримт, дүрэм, журам заавар гэх мэт);

2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн салбарын гүйцэтгэх үүрэг чиглэл, тулгарч болзошгүй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хүч хэрэгсэл, ар тал, хангалтын тооцоог боловсруулах;

3. Боловсруулсан төлөвлөгөөг сургууль дадлагаар туршиж, дутагдалтай талуудыг засаж залруулж дээд шатны байгууллага, албан тушаалтнаар хянуулж батлуулах.

4. Төлөвлөгөө боловсруулахдаа орон нутгийн /нийслэлийн/ болон **тухайн салбарын** газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл, үүсч болзошгүй цагийн байдал, хохирлын үнэлгээ, нөөц, хүч хэрэгслийг үндэслэл болгоно.

5. Улсын албаны төлөвлөгөөг онцгой байдлын байгууллага хянаж, албаны даргаар батлуулна. Төлөвлөгөөг тохиолдсон гамшгийн туршлага, сургамж, албаны хэмжээнд зохион байгуулж байгаа удирдах бүрэлдэхүүний сургалт болон штабын дадлага, гамшгаас хамгаалах команд штабын сургуулиар тус тус тодотгоно.

6. Төлөвлөгөөг дараах ерөнхий дарааллын дагуу боловсруулна.

**Жич: Хийгдэх ажлыг 15 хэсэгт хуваасан нь өдөр хоногийн тоо биш бөгөөд төлөвлөгөө боловсруулах нийт хугацааг 15 хэсэгт хувааж үзүүлсэн болно.**

№	Хийгдэх ажил, үе шат	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	
1.	Ажлын хэсэг байгуулах																
2.	Мэдээлэл цуглуулах																
3.	Мэдээлэл эмхтгэх																
4.	Танилцуулга хэсэг боловсруулах																
5.	Салбарын эрсдэлийн үнэлгээ хийж хохирлын төсөөлөл гаргах																
6.	Цагийн байдал үүсгэх																
7.	Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлэх																
8.	Урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах																
9.	Гамшгийн үеийн хор уршгийг арилгах төлөвлөгөө																
10.	Гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох төлөвлөгөө																
11.	Төлөвлөгөөний хавсралт хэсгийг боловсруулах																
12.	Тухайн улсын албаны даргаар батлуулах																
13.	Улсын албаны штаб мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд танилцуулах																
<b>Хариуцах байгууллага, албан тушаалтан</b>																	
Улсын албаны дарга		+														+	+
Ажлын хэсэг			+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+			

## Хоёр. Төлөвлөгөөний ерөнхий бүтэц

2.1. Төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

-Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

-Хоёрдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ

-Гуравдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай арга хэмжээ

-Тавдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ

-Хавсралтууд

## **Гурав. Төлөвлөгөөний агуулга**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1.Ерөнхий зүйл**

Энэ хэсэгт улсын албаны товч танилцуулгын талаар бичнэ. Танилцуулгыг албан ёсны статистик тоо баримтыг үндэслэн хүснэгт, зурган болон бусад хэлбэрээр үзүүлнэ. Түүнчлэн, тухайн яамны танилцуулга, веб хуудас, үйл ажиллагааны хөтөлбөр, тайлан мэдээг ашиглаж болно.

Албаны товч танилцуулга нь дараах мэдээлэлийг оруулна:

Тухайн салбарын бүтэц зохион байгуулалт, үндсэн чиг үүрэг, хүчин чадал, харьяа байгууллага, ажилтан албан хаагчид, салбарын төсөв зардал, барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгслийн чанар байдал.

#### **1.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, зорилт, баримтлах зарчим, үндсэн чиглэл**

##### **1.2.1. Төлөвлөгөө боловсруулах зорилго**

Гамшигт тэсвэртэй хот, суурин газар, хүрээлэн буй орчныг цогцлоох, орон нутгийн болон салбарын гамшгаас хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг үр дүнтэй зохион байгуулахад улсын албаны гүйцэтгэх үүрэг, хариуцлага, бусад албадтай харилцан ажиллагааг хангах асуудлыг гол зорилгоо болгоно.

##### **1.2.2. Баримтлах зарчим, үндсэн чиглэл**

Төлөвлөгөө боловсруулахад газар хөдлөлтийн гамшгийн болзошгүй цагийн байдал, хохирлын төсөөлөлд үндэслэсэн, амьдралд илүү нийцсэн, хэрэгжих үндэслэлтэй, газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох талуудын харилцан ажиллагаа, уялдааг хангасан, албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдсан байх зарчмыг баримтлана.


Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг бүрэн таслан зогсоох боломжгүй ч гамшгийн хохирлыг аль болох хэмжээнд бууруулж, учирсан хор уршгийг шуурхай арилгах, нөхөн сэргээх замаар “гамшгийн аюулыг бууруулах” үзэл баримтлалыг мөрдлөг болгох, гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангаж гамшигт нэрвэгдсэн ч хүний амь насны эрсдэл, албаны барилга байгууламж, эд хөрөнгийн эвдрэл гэмтэл аль болох бага байхын тулд газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг авч хэрэгжүүлэн албаны хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг аль болох бага хэмжээнд хязгаарлахыг үндсэн чиглэлээ болгоно.

#### **1.3. Гамшгаас хамгаалах албаны удирдлага, зохион байгуулалт**

##### **1.3.1. Гамшгаас хамгаалах албаны тогтолцоо**

Энэ хэсэгт тухайн салбарын болон албаны удирдлага зохион байгуулалт, салбар нэгж, штаб мэргэжлийн ангийн бүтэц, зохион байгуулалт тэдгээрийн гүйцэтгэх чиг үүрэг, харилцан ажиллагааны талаар тусгана.





Зураг 1. Гамшгаас хамгаалах улсын албаны бүтэц зохион байгуулалт

### 1.3.2. Гамшгаас хамгаалах улсын албаны ерөнхий чиг үүрэг

Гамшгаас хамгаалах улсын алба нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, хор уршиг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх ерөнхий чиг үүрэг, бэлтгэл бэлэн байдлыг хангах, бусад холбогдох талуудтай харилцан ажиллагааг хангах чиг үүргийг тодорхойлно. Тухайлбал:

Гамшгаас хамгаалах улсын албаны ерөнхий чиг үүрэг		
Гамшгийн өмнө	Гамшгийн үед	Гамшгийн дараа
-Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй цагийн байдлын төсөөлөл ба хохирлын үнэлгээ хийх;	-Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн цагийн байдлыг үнэлж тухайн үеийн нөхцөл байдлыг тодотгох ;	-Салбарын хэмжээнд сэргээн засварлах болон сэргээн босгох арга хэмжээ салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах;
-Тухайн салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх;	-Гамшгаас хамгаалах улсын албаны штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, ажилтнуудын бэлэн байдлын удирдамжийн дагуу үүрэг гүйцэтгэх;	-Гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ болон түүнд шаардагдах зардлыг судалж тогтоох;
-Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хариуцсан салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ,	-Газар хөдлөлтийн гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ, албаны даргын	Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн барилга байгууламжийн хойшлуулшгүй сэргээн

<p>салбар зохицуулалтыг хангах асуудлыг Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>-Газар хөдлөлтийн аюул тулгарах үеийн гамшгаас хамгаалах улсын албаны бэлэн байдлыг хангах арга хэмжээ;</p> <p>-Гамшгаас хамгаалах улсын албаны зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах;</p> <p>-Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх;</p> <p>-Гамшгийн үед материал хэрэгслийг шуурай тээвэрлэлтийн тогтолцоог хангах;</p> <p>-Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал, хүнсний бүтээгдэхүүний тасралтгүй хангамжийг хангах;</p> <p>- Гамшгийн үеийн гамшгаас хамгаалах арга хэмжээний сургалт, судалгааны ажил;</p> <p>-Газар хөдлөлтийн гамшгийн үеийн сайн дурын үйл ажиллагааг дэмжих орчин нөхцлийг бүрдүүлэх;</p> <p>-Бусад арга хэмжээ</p>	<p>хоорондын хангах оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>хийдвэрт үндэслэсэн гамшгийн үеийн шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэх</p> <p>-Улсын Онцгой комисс, гамшгаас хамгаалах бусад албад, мэргэжлийн байгууллагуудтай харилцан ажиллагааг зохион байгуулж, мэдээ мэдээллийг солилцох;</p> <p>-Газар хөдлөлт болсон бүсээс хүн амыг нүүлгэн шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p> <p>-Нүүлгэн шилжүүлэх болон түр хорогдох байранд тусламж үйлчилгээг зохион байгуулах</p> <p>-Бусад албадын үйл ажиллагаатай харилцан ажиллагаа зохицуулалтыг хангаж , шаардлагатай тохиолдолд Онцгой байдлын газраас нэмэлт хүн, хүч, техник хэрэгсэл хүсэх</p>	<p>босгох;</p> <p>-Гарсан зардлын тооцоог гаргаж Улсын Онцгой комисст хүргүүлэх</p>
---	--	---

1.3.2. Гамшгаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн гамшгийн үеийн харилцан ажиллагаа:

д/д	Улсын албаны чиг үүрэг /өөрт хамаарахыг бичнэ/	Хамтран ажиллах улсын албад
1	Гамшгийн үеийн холбоо, мэдээллийг зохион байгуулах шаардагатай холбооны хэрэгслийн тооцоог судалгаа, хангалт хийх	ЗХЖШ, МТШХХГ, ОБЕГ, ХХЕГ
2	Эрүүл мэндийн үйлчилгээ, эм, тариа, боох материал болон бусад зүйлсийн хангалтыг зохион байгуулах	ЭМЯ, БХЯ, БСШУЯ, ОБЕГ, МУЗН, ОУБ (кластер), НЗБ
3	Орон байр, дулаан хувцас, бусад нэн шаардлагатай материал хэрэгслийн хангалт хийх	БХБЯ, ХХААЯ, БСШУЯ, БХЯ, ОБЕГ, МУЗН, ОУБ (кластер), НЗБ
4	Хоол, хүнсний хангалт үйлчилгээг зохион байгуулах	ХХААЯ, БХЯ, ГХЯ, ОБЕГ, МХЕГ, ГЕГ, МУЗН, ОУБ (кластер), НЗБ

5	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний хангалтыг зохион байгуулах, тусламжийн бараа материал татах, хүргэх ажилд шаардагдах тээврийн хэрэгслийг зохион байгуулах	ЗТЯ, БХЯ, ОБЕГ, ИНЕГ, УБТЗ
6	Гамшгийн хамгаалах хүч хэрэгслийг дайчлан эрэн хайх аврах хор уршгийг арилгах арга хэмжээнд татан оролцуулах	БХБЯ, УУЯ, ЭХЯ, ЗТЯ, ХХААЯ, БХЯ, ХЯ, ЗХЖШ, ОБЕГ, МУЗН, ЦЕГ
7	Түлш эрчим хүчээр хангах ажлыг зохион байгуулах	ЭХЯ, ХХААЯ, УУЯ, БХЯ,
8	Ус, дулаанаар хангах ажлыг зохион байгуулах	НЗБ, БОНХАЖЯ, БХБЯ, ХХААЯ, ЭХЯ,
9	Шатах, тослох материал, шатахууны хангалтыг зохион байгуулах	УУЯ, ГХЯ, ЗТЯ, УБТЗ, ИНЕГ, ОБЕГ
10	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах ажлыг дараах байдлаар зохион байгуулахдаа тусламжийн бараа материалыг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	ХХЕГ, СЯ, ГЕГ, МХЕГ, ИНЕГ, ИХШХЕГ
11	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг тээвэрлэх ажлыг зохион байгуулах	ШШ, БХЯ, ЗХЖШ, ОБЕГ, ЦЕГ, ХХЕГ, ЗТЯ,
12	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хадгалах, хамгаалах асуудлыг зохион байгуулах	ШШ, ХХААЯ, ЗТЯ, ГЕГ, ОБЕГ, ИНЕГ, ЦЕГ, НЗБ
13	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг бараа материалыг хуваарилах асуудлыг зохион байгуулах	ШШ, СЯ, ОБЕГ, МХЕГ, ЦЕГ, ЗХЖШ, НЗБ,
14	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг олгох, түгээх асуудлыг зохион байгуулах	ШШ, НЗБ, ОБЕГ, ОУБ (кластер), ЦЕГ, УБЕГ,
15	Бараа материал болон олголт, тараалт, хүргэлтийн асуудлуудад хяналт тавих асуудлыг зохион байгуулах	ШШ, ОБЕГ, НЗБ, ОУБ (кластер)

#### 1.4. Хамтын ажиллагааны санамж бичиг

Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл санамж бичиг байгуулах тухай, санамж бичгийн зорилгын тухай дурьдах. Санамж бичгийн зорилго нь албаны төлөвлөгөөгөөр зохицуулах боломжгүй нэмэлт үйл ажиллагааг талууд харилцан тохиролцож зөвшилцсөний үндсэн дээр хамтран хэрэгжүүлэх, гарах зардлыг гүйцэтгэлээр нөхөн төлж барагдуулахад оршино.

Санамж бичгийг тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, нийгэмлэг, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулж бо

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

#### 2.1. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй цагийн байдал, хохирлын төсөөлөл

Гамшгаас хамгаалах улсын албад нь газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахын тулд Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд болон Улаанбаатар хот орчимд М7.0-М8.0-ийн газар хөдлөлт тохиолдоход барилга байгууламж нуралтаас үүдэж хүний амь нас эрсдэх болзошгүй хохирлыг болон өвлийн хүйтний улиралд газар хөдлөлт тохиолдоход осголт хөдлөлтөөс үүдэж хүний амь нас эрсдэх болзошгүй хохирлын төсөөллийг бий болгоно.

Нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэхдээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн онцгой байдлын газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)–аас хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл<sup>1</sup> -ийн хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлын төгсгөлийн тайлангийн “Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийх үйл явц ба түүний үр дүн” гэсэн 4 дүгээр бүлгийг үндэслэл болгоно.

## 2.2. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл, болзошгүй хохирлыг бууруулах зорилго, зорилт

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд газар хөдлөлтийн гамшгийн болзошгүй эрсдэл, хохирлыг тооцож, түүнээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг хувь болон тоон үзүүлэлтээр бууруулах, чадавхыг бэхжүүлэх зорилго, зорилт дэвшүүлж, зорилтыг хангахын тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар төлөвлөгөөнд тусгана.

Тухайлбал:

1. Газар хөдлөлтийн улмаас амь насаа алдагсдын тоог 70 хүртлэх хувиар бууруулах

2. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний барилгад учрах хохирлыг 60 хувиар бууруулах

3. Орон сууц болон бусад барилга байгууламжид учрах хохирлыг 40 хувиар бууруулах

4. Инженерийн шугам сүлжээнд учрах хохирлыг 50 хувиар бууруулах.

5. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүчин чадлыг 20 хувиар нэмэгдүүлэх .... гэх мэт өөрийн салбарын хэмжээнд хамаарах асуудлаар зорилго зорилт дэвшүүлнэ.

Дэвшүүлсэн зорилгыг хангах зорилт, бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ:

№	Дэвшүүлэх зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа, хамтран хэрэгжүүлэх байгууллага
<b>1. Бүтцийн бус арга хэмжээ</b>			
1.	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулах	Гамшгаас хамгаалах удирдлага, менежментийн чадавхыг бэхжүүлэх	
		Ажилтан албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх	
		Гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, хөгжлийн бодлогод гамшгийн эрсдэлийг тооцож, уялдуулах	
		Мэдээ, мэдээллийг хүргэх тогтолцоог бүрдүүлэх	
		Гамгийн эрсдэлийн үнэлгээ хийх нөхцлийг	

<sup>1</sup>Монгол Улс Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх төсөл (хөгжлийн судалгааны хэлбэрт техникийн хамтын ажиллагаа) Төгсгөлийн тайлан 2-р бүлэг Үндсэн тайлан. УБ хот. 2013 он. х-1-1.

		бүрдүүлэх	
2.Бүтцийн арга хэмжээ			
2.	Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний барилга, байгууламж <b>эсвэл</b> харьяа байгууллагын барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг сайжруулах	<b>Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх</b>	
		<b>Тэсвэржилтийг хангах, хүчитгэх арга хэмжээнд шаардагдах санхүү, зардлын тооцоог гаргах</b>	
		<b>Шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх</b>	
		Барилга, байшинг хүчитгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	
		Шинээр барих барилгыг газар хөдлөлтөд тэсвэртэй байхаар барих	
3.	Инженерийн шугам сүлжээний тэсвэржилтийг хангах	Эрсдэлийн үнэлгээ хийх	
		Тэсвэржилтийг хангах, хүчитгэх арга хэмжээнд шаардагдах санхүү, зардлын тооцоог гаргах	
		Шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	
		Барилга, байшинг хүчитгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	
4.	Орон сууцны барилга, байшингийн тэсвэржилтийг хангах /тухайн албанд хамаарах/	Эрсдэлийн үнэлгээ хийх	
		Тэсвэржилтийг хангах, хүчитгэх арга хэмжээнд шаардагдах санхүү, зардлын тооцоог гаргах	
		Шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	
		Барилга, байшинг хүчитгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	
		Шинээр барих барилгыг газар хөдлөлтөд тэсвэртэй байхаар барих	
5.	Бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлэх	Хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах	
		Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, чадавхыг сайжруулах	
		Нүүлгэн шилжүүлэх байрны бэлэн байдлыг хангах	
		Гамшгийн нөөцийг бүрдүүлэх	
		Холбоо, зарлан мэдээллийн бэлэн байдлыг хангах, чадавхыг сайжруулах	
		Ариутгал, халдваргүйтгэлийн бэлэн байдлыг хангах, чадавхыг сайжруулах	
		Хог хаягдал зайлуулах бэлэн байдлыг хангах	
		Усан хангамжийн тогтолцоог бүрдүүлэх гэх мэт	

### 2.3. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Гамшгаас хамгаалах албаны удирдлага нь салбарын хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах бөгөөд тухайн салбарын гамшигт тэсвэрлэх, даван туулах чадавхыг бэхжүүлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах алба нь өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд газар

хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг үүргийг дурдана.

Гамшгаас хамгаалах алба нь газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ дараах үндсэн зарчим баримтална. Үүнд:

- Хүний амь насыг хамгаалах арга хэмжээг нэн тэргүүнд тавих;
- Төрийн ажил, үйлчилгээ, нийгмийн амьдралд ноцтой саатал учруулахгүйгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Иргэдийн эд хөрөнгө болон нийтийн эзэмшлийн барилга, байгууламжид гарч болзошгүй хохирлыг багасгах;
- Сэргээн засварлах, сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-т заасныг үндэслэн санхүүжилнэ.

#### **2.4. Гамшгаас хамгаалах улсын албаны зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах**

Гамшгаас хамгаалах албаны хэмжээнд зарлан мэдээллийн системийн бэлэн байдлыг хангах арга хэмжээг энэ хэсэгт дурдана.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журмыг үндэслэн улсын албаны хэмжээнд буюу түүний зарим хэсэгт үүссэн болон үүсэж болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн үед гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн байгууллагуудад зарлан мэдээллийг хэрхэн дамжуулах талаар дурьдана. Улсын хэмжээнд гамшгийн үеийн холбоо зарлан мэдээллийн системийн бэлэн байдлыг хангах арга хэмжээг ЗХЖШ, МТШХХГ, ОБЕГ, ХХЕГ газар хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр сургалт зохион байгуулж шаардлагатай холбооны хэрэгслийн тооцоог хийж хангалтыг зохион байгуулна. Түүнчлэн Гамшгаас хамгаалах улсын албаны штабын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан нь гамшгийн цагийн байдлын тухай мэдээлэл цуглуулах голомтын бүсэд холбоо тогтоож барих ажлыг гүйцэтгэх ажилтнуудыг урьдчилан төлөвлөж зохион байгуулалтын арга хэмжээ авах. Гамшгаас хамгаалах улсын алба нь албаны хэмжээнд мэдээлэл харилцааны техник тоног төхөөрөмжийн гамшигт тэсвэртэй байдлыг хангаж, цахилгаан тасрахад бэлэн байдлыг хангах, харилцаа холбооны сувгийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх, радио холбооны нөөц бий болгох, гамшгийн үеийн харилцаа холбооны технологи болон давтамжийг үр дүнтэйгээр ашиглах технологийг судалж хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

Гамшгаас хамгаалах улсын албаны штабын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан нь гамшгийн үеийн харилцаа холбооны зохион байгуулалтыг бүрдүүлэх, радио холбооны сүлжээг өргөтгөн бэхжүүлэх, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангиудын хооронд найдвартай холбоогоор хангах, үүрэн телефон, цахилгаан холбооны шугамыг гамшгийн үед ашиглах үүднээс багтаамж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, гамшгийн үед ашиглах цахилгаан үүсгэх тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангахын зэрэгцээ засвар үйлчилгээ явуулах,

ажиллуулах горимыг сайтар эзэмших, мэргэжлийн мэдлэг болон технологийн дагуу газар хөдлөлтөд тэсвэртэй бөгөөд ус нэвтрэх аюул багатай бат бөх бөгөөд найдвартай газар (газар хөдлөлтийн гамшгийн үед чичирхийллийн тэсвэржилттэй болон салхи усны гамшгийн үед усанд автах аюул багатай газар) суурилуулах. Мөн шуурхай үйлчилгээний холбооны тоног төхөөрөмж гамшигт нэрвэгдэх цагийн байдлыг тооцож үндсэн тоног төхөөрөмжийн байршлыг тараан зохион байгуулах, яаралтай засвар үйлчилгээний тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, харилцаа холбооны ачаалал нэмэгдсэн үеийн арга хэмжээг хэрэгжүүлэх зэргээр цахилгаан холбооны тоног төхөөрөмжийн аюулгүй бөгөөд найдвартай байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг тусгах.

## **2.5. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх**

Гамшгийн үед салбарын хэмжээнд хүч хэрэгслийг хэрхэн татан оролцуулах, гамшгийн нөөцийг хаана, ямар хэмжээтэй бүрдүүлэх асуудлыг тусгах.

Тухайлбал, Улсын албаны гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн дайчилгааг хоёр үе шаттай явуулах, эхний ээлжинд тухайн улсын албаны үндсэн хүч хэрэгсэл болох ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийг өргөтгөн зохион байгуулах, нөхөн хангалт хийх зорилгоор бүх штаны Засаг даргын Тамгын газар, цэргийн штаб, эрүүл мэндийн газруудтай хамтран цэргийн хоёрдугаар үүрэгтэн буюу цэргийн насны цэргийн алба хаагаагүй иргэд, гамшгаас хамгаалах дүйцүүлэн алба хаасан тусгай мэргэжилтэй иргэд, оюутнуудыг дайчлах талаар тусгана.

Хэрэв газар хөдлөлтийн гамшгийн үед эрэн хайх аврах, яаралтай тусламжийн арга хэмжээг зохион байгуулахад дээр дурьдсан үндсэн хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд дайчилгааны хоёрдугаар ээлжийг зохион байгуулж гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг өргөтгөн зохион байгуулах, нөхөн хангалт хийнэ.

## **2.6. Улсын албаны барилга байгууламж болон холбогдох барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах**

Улсын албаны болон харьяа байгууллагын барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хэрэхэн хангах талаар /холбогдох алба/ дурдана. Тухайлбал:

ОБЕГ, Аймаг, Нийслэлийн ОБГ, МХЕГ, БХБЯ, ЭХЯ, ЗТЯ хамтран газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах нь газар хөдлөлтийн эрсдэл, хүний амь нас, эдийн засгийн хохирлыг бууруулах ач холбогдолтой бөгөөд барилга байгууламжийн бүтээц хийцийг хүчитгэх замаар тэсвэржилтийг хангана. Иймд барилгын норм, дүрэмд газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээг хийх, хийц бүтээцийг хүчитгэх арга хэмжээг тусгах талаар дурьдана. Тухайлбал, Барилгын тухай хуулийн 25.2 дугаар зүйлд зааснаар газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах барилгын байгууламжийн зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт магадлалын ажлыг гүйцэтгэж бүтээц, хийцийн даацын бат бэхийг сайжруулах, хүчитгэх арга хэмжээ авах талаар тусгах.

Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний хялбарчилсан ба нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэж тэдгээрийг хүчитгэх, шинэчлэн барих ажлыг тусгах. Үнэлгээг доорхи барилгын дүрмийн дагуу гүйцэтгэх талаар тусгах.

1) Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал (БД);

2) Угсармал том хавгаалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал(БД); ;

3) Тоосгон өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал (БД);

## **2.7. Гамшгийн үед материал хэрэгслийг шуурхай тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх**

Гамшгийн үед шаардлагатай хүч хэрэгслэл, бараа материал, тоног төхөөрөмжийг шуурхай тээвэрлэх тогтолцоог хэрхэн бүрдүүлэх, тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар /холбогдох алба/ дурдана. Тухайлбал:

ОБЕГ, Аймаг, Нийслэлийн ОБГ, ЗТХЯ, ЦЕГ, ТЦГ, НЗДТГ хамтран газар хөдлөлтийн гамшгийн үеийн эд материал, хэрэгслийн шуурхай тээвэрлэлтийг сайжруулах, техник, багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, тээвэрлэлтийн нэгдсэн тогтолцоо бий болгох, аймаг, нийслэл, дүүргийн онцгой байдал, цагдаагийн байгууллагын хамтарсан мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааны харилцан ажиллагааг сайжруулах, газар хөдлөлтийн үед тээврийн алба, зам, гүүрийн засварын алба, хэв журам сахиулах алба, замын цагдаагийн албатай хамтран зам, гарц хаагдсан тохиолдолд тойрч гарах замын чиглэлийг зааж, саадыг даван гарах боломжоор хангах, тойруу замаар бараа материалыг тээвэрлэх зам маршрутыг тогтоож төлөвлөх талаар тусгах, тусламжийн бараа материал нэрвэгдэгсдэд шуурхай, цаг алдалгүй очих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор иргэдийн оршин суугаа хороолол, гудамжны гэрэлтүүлэг, хаягжилтыг шинэчлэн сайжруулж, замын саадыг арилгах, түүнчлэн шуурхай тээврийн хэрэгсэл, хүн хүч дайчлах, шатахуунаар хангах чиглэлээр бүх шатны Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллах, шаардлагатай бараа материал багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх асуудлыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх асуудлыг тусгах.

## **2.8. Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал, хүнсний бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгсэл, эрчим хүч, дулаанаар тасралтгүй хангах тогтолцоог бүрдүүлэх**

Гамшигт нэрвэгдэгсдэд нэн шаардлагатай, амьдралын суурь хэрэгцээг хангах тухайлбал тусламжийн бараа материал, хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгслээр хэрхэн хангах асуудлыг /холбогдох алба/ тусгах. Тухайлбал:

ОБЕГ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ нь тухайн нутаг дэвсгэрийн бодит нөхцөл байдалд нийцүүлэн аврах, тусламж үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материалын 24-72 цаг, 7 хоног, нэг сарын хэрэгцээг холбогдох хангамжийн байгууллагуудад захиалга өгөх; ОБЕГ, ХХААЯ, БХЯ, МХЕГ, ГЕГ, МУЗН, ОУБ (кластер), НЗБ хамтран бараа материал, хүнсний бүтээгдэхүүн дутагдах аймаг, дүүрэг, сумыг тодорхойлж тухайн хот суурин газар, орон нутаг дахь бараа материал хүнсний нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, эсвэл бусад аймаг, нийслэл, дүүргээс татаж нийлүүлэх арга хэмжээ авах, газар хөдлөлтийн гамшгийн үед хангамжийн байгууллага, бөөний болон жижиглэн худалдах үйчилгээг тодорхой хугацаагаар хязгаарлах арга хэмжээ авах талаар тусгах ;



ОБЕГ, ХХААЯ, ЭМЯ, МХЕГ, НЗДТГ хамтран түр цугларах байр, түр хорогдох байр, түр орон сууцад шилжин ирсэн иргэдэд тусламж үзүүлэх арга хэмжээнд шаардагдах хэрэгцээг тооцож гаргах;

ОБЕГ, ХХААЯ, ЭМЯ, БХЯ, БХБЯ УУЯ, ЭХЯ, ЗТЯ, ХХААЯ, ЗХЖШ, МУЗН НЗДТГ хамтран газар хөдлөлтийн гамшгийн үед эрэн хайх, аврах ажиллагааг явуулах томилгоот шуурхай бүлэг, ерөнхий болон тусгай зориулалттай мэргэжлийн анги, бусад хүч хэрэгсэл, бие бүрэлдэхүүний хангалтын нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах талаар тусгах; ЗТЯ, БХЯ, ОБЕГ, ИНЕГ, УБТЗ хамтран нүүлгэн шилжүүлэх болон хангалт зохион байгуулах, тусламжийн бараа материал татах, хүргэх ажилд шаардагдах тээврийн хэрэгслийг шаардагдах шатах тослох материал тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авах, ЭХЯ, ХХААЯ, УУЯ, БХЯ хамтран түлш эрчим хүчээр хангах ажлыг хэрхэн зохион байгуулах, НЗБ, БОНХАЖЯ, БХБЯ, ХХААЯ, ЭХЯ хамтран Ус, дулаанаар хангах ажлыг зохион байгуулах УУЯ, ГХЯ, ЗТЯ, УБТЗ, ИНЕГ, ОБЕГ хамтран шатах, тослох материал, шатахуунаар хангах асуудлыг тус тус хариуцан зохион байгуулах тогтолцоог бүрдүүлэх талаар тус тус тусгана.

## **2.9. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага**

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, хор уршгийг арилгах сургалт, дадлагыг албаны хэмжээнд хэрхэн зохион байгуулах талаар дурдана.

Тухайлбал: Улсын албаны сургалт, мэргэжлийн ангиуд, бэлтгэл бэлэн байдал хариуцсан ажилтан болон төрийн бус байгууллага, сайн дурынхны бүлэг, хэсгүүдтэй хамтран албаны болон мэргэжлийн ангиудын гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль, сурталчилан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах улсын албаны штаб, үйлдвэр, үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагын болон аймаг, дүүргийн гамшгаас хамгаалах албадын дарга, сургалт, бэлтгэл хариуцсан албан тушаалтан хариуцаж зохион байгуулах талаар төлөвлөгөөнд дурьдана.

Мөн төлөвлөгөөнд Гамшгаас хамгаалах иж бүрэн болон удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн (тусгай чиг үүргийн томилгоот бүлэг) ангийн сургалт бэлтгэлийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 5 дүгээр сарын 01/ны өдрийн А/331 дугаар тушаалын хавсралт “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлага зохион байгуулах заавар”-ын дагуу зохион байгуулах талаар дурьдах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ҮЕИЙН ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭ**

### **3.1. Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн цагийн байдлыг**

## **үнэлж, нөхцөл байдлыг тодотгох**

Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед улсын алба чиг үүргийн хүрээнд цагийн байдлыг үнэлж, нөхцөл байдлыг тодотгоно.

Тухайлбал: ОБЕГ, БХЯ, ЦЕГ, ТЕГ, МХЕГ, ХХМТ, БОАЖЯ, ООГФХ, ИНЕГ хамтран газар хөдлөлтийн гамшиг болох үед юуны өмнө эрт зарлан мэдээлэх дохиог тухайн салбарын хэмжээнд дамжуулах, гамшгаас сэргийлэх шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх бөгөөд гамшиг болсны дараахи ерөнхий мэдээлэл болон газар зүйн, орон зайн мэдээлэл, бусад холбоо мэдээллийн систем ашиглан газар хөдлөлтийн аюулын анхдагч нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах үүссэн нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээг гаргах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд болон Шадар сайдад мэдээлэл хүргэхийн хамт гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, онц байдал зарлах болон холбогдох бусад шийдвэрийг гаргуулах талаарь дурьдах. Гамшгаас хамгаалах улсын албаны штаб нь гамшиг болсны дараа салбарын хохирлын тухай мэдээлэл цуглуулж, үүссэн нөхцөл байдлыг үнэлж, цагийн байдлыг мэдэхийн тулд Онцгой байдлын ерөнхий газар, хэлтэс, цагдаагийн хэлтэс 101, 102, 103 дугаарт ирж буй дуудлагын мэдээллийг ашиглана.

ОБЕГ, БХЯ, ЗХЖШ, ЦЕГ, ХХМТГ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ хамтран эрэн хайх аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн арга хэмжээг зохион байгуулах.

Шуурхай штаб байгуулах, нэрвэгдсэн хүн амын судалгаа болон хохирол, хэрэгцээний нарийвчилсан үнэлгээ гаргах, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд шаардлагатай хүч хэрэгслийг тодотгох, гамшгийн голомтод холбоо зохион байгуулах, 24 цагийн жижүүрлэлтэд шилжүүлэх, тусгай чиг үүргийн шуурхай бүлэг томилон ажиллуулах, Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэргийн анги, салбарыг дайчлах, хүч хэрэгслийг татан төвлөрүүлэх, нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр дамжуулан хүргэх талаар тусгана.

ОБЕГ, БХЯ, ЭМЯ, ЗХЖШ, ЦЕГ, БХБЯ, ЗТЯ Аймаг, Нийслэлийн ЗДТГ хамтран Шуурхай штабаас гаргасан шийдвэрт үндэслэн эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх эхлэх бөгөөд гамшгийн хохирлын талаар цуглуулсан мэдээлэлд үндэслэн гамшгийн дараахи эхний 72 цагийг хугацаанд хүний амь нас аврах, гал унтраах, хэв журам сахиулах эмнэлгийн яаралтай тусламж бусад тусламж үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа явц байдал, бусад үйл ажиллагаанд шаардлагатай хүн, техник ба эд материалын нөөцийг нэн тэргүүнд хуваарилах талаар мэдээлнэ. Дээрхи албадын Шуурхай штаб нь хүний амь насны хохирлын байдал (сураггүй алга бологсдыг оруулаад), барилга байгууламжийн хохирол, түймэр, хөрсний нуралтын гамшгийн байдлын мэдээллийг цуглуулахын хамт сураггүй алга бологсдын тоо бүртгэлд үндэслэн эрэл хайгуул, аврах, хэв журам сахиулах зам гарцыг чөлөөлж аврах ажиллагаа явуулах нөхцөл боломж бүрдүүлэх арга хэмжээ үйл ажиллагааг явуулж байгаа талаар дээд байгуулагад мэдээлж шаардлагатай дэмжлэг тусламж авах талаар тусгана.

БХЯ, УУЯ, ЭХЯ, ХЯ, ХХААЯ, БХБЯ, ЗХЕШ, ЦЕГ, ХХЕГ, ТЕГ, ХХМТГ зэрэг

яам албадын шуурхай штаб нь улсын онц чухал болон галын аюултай объектыг хамгаалалтад авах, харьяа байгууллагуудын зам талбай, харилцаа холбоо, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны инженерийн дэд бүтцийн эвдрэл гэмтлийн байдлыг тодорхойлох, болзошгүй хоёрдогч хөнөөл үүсэхээс хамгаалах арга хэмжээг авахын хамт тэдгээрийг сэргээн завсарлах, дулаан, цахилгаанаар хангах авч нийтийн аюулгүй байдлыг хамгаалах ажиллагааг зохион байгуулна. Харилцаа холбоо тасарсан тохиолдолд мэдээлэл холбооны хэрэгслийн эвдрэл, гэмтлийг сэргээн засварлаж нэн даруй холбоо холбоо тогтоох ялангуяа, алс бөглүү сумын харилцаа холбооны хэрэгслийн сэргээх, шаардлагатай бол гар утас, сансарын холбоо, хөдөлгөөнт холбоог ашиглаж холбоо тогтооно.

Гамшгийн хөнөөлийн голомтод дахь нэрвэгдэгсдийн буцалтгүй болон эрүүл мэндийн хохирол, эмнэлгийн анхны яаралтай тусламж авах иргэдийн талаархи мэдээлэл солилцох талаар тусгана.

Монгол Улсын Засгийн газар, Гадаад хэргийн яам нь Монгол Улсад суугаа гадаадын дипломат төлөөлөгчдийн газраар дамжуулан гадаад улс орон, олон улсын байгууллагаас хүмүүнлэгийн тусламж авах хүсэлт гаргах талаар тусгах

### **3.2. Гамшгаас хамгаалах улсын албаны штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, ажилтнуудын бэлэн байдлыг хангах**

Тухайлбал, Улсын Онцгой комисс, ОБЕГ, НОБГ, БХЯ, ЦЕГ, ЗХЕШ, ТЕГ, ТТГ хамтран Гамшгаас хамгаалах улсын албадын харилцан ажиллагааг хангаж үүссэн цагийн байдалтай холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, гамшгаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангиудыг гамшгийн голомтод томилж үүрэг гүйцэтгүүлэх болон аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд шаардлагатай хүч хэрэгслийг тодотгох, эрэн хайх, аврах яаралтай тусламж үзүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулах, гамшгийн цагийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар дээд шатны байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад илтгэх, тэднээс мэргэжлийн зөвлөгөө зааварчилгаа тусламж авах, гамшгийн голомтод зам гарцыг чөлөөлж, хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын бүс тогтоож эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог хангах, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа хүч хэрэгслийн харилцан ажиллагаа болон ОБЕГ –ын шуурхай удирдлагын төв, албаны шуурхай удирдлагын төв, Нийслэлийн шуурхай удирдлагын төвөөр дамжуулан мэдээлэл солилцож, эрэн хайх, аврах, гал унтраах, эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хяналт тавих, голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний болон нэрвэгдэгсдэд үзүүлэх бүх төрлийн хангалтыг зохион байгуулах, (хоол хүнс, шатах тослох материал, байр сууц, эм тариа, хувцас тоног хэрэгсэл г.м.) Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын цэргийн хүч хэрэгслийг харилцан ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу үүрэг гүйцэтгүүлэх, шаардагдах ажилтнууд, хүч хэрэгслийг орон нутгаас дайчлан гаргах, тэдгээрийн хангалтын асуудлыг зохион байгуулах, хариу ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хүч хэрэгслийн уядаа холбоо, үйл ажиллагааг зохион байгуулах шуурхай штаб (хээрийн штаб)-ыг байгуулах, цугларах талбайд цугласан иргэдийг бүртгэх, зааварчилгаа өгөх, хэрэв шаардлагатай бол гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулахад бүх төрлийн хангалтыг зохион байгуулах талаар тусгах.

### **3.4. Гамшгийн үеийн шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэх**

3.4.1. Гамшгийн үед өөрийн салбарын хариуцсан чиг үүргийн хүрээнд гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэсэн ямар ямар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар дурдана.

Тухайлбал: ЭМЯ, БХЯ, ЦЕГ, ХХААЯ, ОБЕГ, Нийслэлийн ЗДТГ, Ус сувгийн удирдах газар, орон сууц нийтийн ахуй үйлчилгээний газартай хамтран голомтын бүсэд нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээг хэрхэн зохион байгуулах, газар хөдлөлтийн гамшгийн хөнөөлийн голомтод нэрвэгдэгсдийг олж, тэдгээрийн биеийн байдал, тоог тогтоож, аюулгүй газар зөөж тээвэрлэх, зам гарцыг сонгох, эмнэлгийн анхны болон эмнэлгийн тусламж үзүүлэх эмнэлэг дэлгэх газар, нэрвэгдэгсдийг цуглуулах газрын сонгож, ангилан ялгах ажлыг зохион байгуулах талаар тусгах, нас барагсдыг таниулах, цогцос цуглуулах, зөөвөрлөх, хадгалах, оршуулах ажлыг зохион байгуулах, гамшгийн бүс, ялангуяа түр хоргодох байранд амьдралын орчны огцом өөрчлөлтөөс гамшигт өртөгсдийн бие сэтгэлийн байдал муудахаас сэргийлэх, эрүүл ахуйн таатай нөхцөлийг хангах арга хэмжээ авахын хамт гамшигт өртөгсдийн эрүүл мэндийн байдлыг сайтар тодруулж, шаардлагатай бол асрах, тусламж үзүүлэх цэг байгуулж, сэтгэл заслын тусламжийг багтаасан арга хэмжээ авах, түр хоргодох байрны амьдралын орчныг хангах үүднээс шаардлагатай бол түр жорлон болон нүхэн жорлон зэргийг даруй байгуулахын хамт гамшгийн бүсийн эрүүл ахуйн нөхцөлийг хангахын тулд цэвэрлэгээ хийх, бохир зайлуулах, ахуйн хог цуглуулан зайлуулах талаар шаардлагатай арга хэмжээ авах,

Зам, тээврийн улсын алба, Хүнс, хөдөө аж ахуйн алба, Төмөр замын удирдах газар, Иргэний нисэхийн удирдах газар, Ашигтмалт мал газрын тосны газар, Аймаг, нийлэлийн онцгой комисстой хамтран Газар хөдлөлтийн гамшгийн үед Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг, Буянт-Ухаа боомтуудын үйл ажиллагаа зогссон хангамжийн байгууллагуудын агуулахуудын тохиолдолд тусламжийн бараа, эд материал, хэрэгслийн нөөц, нэмэлт хангалт хийх боломжтой хугацааг тодорхойлж ОБЕГ –г мэдээлэх. Газар хөдлөлтийн гамшгийн үед төмөр зам, автозам, нисэх онгоцны буудлыг сэргээн засварлаж дуустал хугацаанд тусламжийн бараа, эд материал, хэрэгслээр хомсдох аймаг, нийслэл, сум, дүүргийг тодорхойлж тухайн хот суурин газар, орон нутаг дахь нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, эсвэл бусад аймаг, орон нутгаас татаж нийлүүлэх арга хэмжээ авах. Гамшгийн нөөцийг хуваарилах, хангалтыг зохион байгуулахын зэрэгцээ хангамжийн байгууллага, бөөний болон жижиглэн худалдах үйчилгээг тодорхой хугацаагаар хязгаарлах. Үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд шатахүүн тослох материал, бусад эд материалаар хангах арга хэмжээ авах талаар дурдана.

БХЯ, ОБЕГ, УУЯ, ЭХЯ, ХЯ, ХХААЯ, БХБЯ хамтран болзошгүй хоёрдогч хөнөөл үүсэхээс хамгаалах арга хэмжээ авахын зэрэгцээ үйлдвэр, үйлчилгээний газруудыг онцгой үед ажиллах тусгай дэглэм тогтоох, мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.

3.4.2. Нүүлгэн шилжүүлэх болон түр хорогдох байранд тусламж үйлчилгээг хэрхэн зохион байгуулах талаар тусгах.

Тухайлбал: Улсын болон аймаг, нийслэлийн онцгой комисс нь ЭМЯ, БХБЯ, БХЯ, ЗТЯ, ЭХЯ, ЗХЕШ, ЦЕГ, Тээврийн цагдаагийн алба, Орон сууц, нийтийн аж

ахуйн албатай хамтран нүүлгэн шилжүүлэлтийн бүх төрлийн хангалтыг төлөвлөх, нүүлгэн шилжүүлэлтийн бүх төрлийн хангалтыг зохион байгуулахад холбогдох байгууллага, мэргэжлийн ангиудыг бэлтгэх, нүүлгэн шилжүүлэлтийн цугларах байр, зам, чиглэл, суулгах, буулгах, дундын байр байрласан газарт эмнэлгийн анхны тусламж, сэтгэл заслын болон бусад төрлийн тусламж үзүүлэх. Мөн гамшгийн голомтод болон нүүлгэн шилжүүлэх бүсэд эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тусгана. Тухайлбал, халдварт өвчин дэгдэж тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэрвэгдэгсдэд эмнэлгийн үзлэг хийх, илэрсэн өвчтөнүүдийг тусгаарлан эмчилэх, эмнэлгийн ариутгал хийх ажлыг зохион байгуулах, хоол хүнсний хангалт, усны эх үүсвэрийг хамгаалах, гамшгийн болон гамшгийн бүсийн гадна нэрвэгдэгсдийг цуглуулах, түр байрлуулахдаа эмнэлэг, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж ариутгасан зөөврийн хоол, хүнс, усны хангалтыг тоолцох, нэгд 2.5 м<sup>2</sup> байраар тооцох, байрны агаарын температур 18 хэмээс доошгүй 35-65 хувийн чийгшилтэй байх, ундны усыг хоногт нэг хүнд 10 литр байхаар тооцох, нүүлгэн шилжүүлэх бүсийн эргэн тойронд байнгын халдваргүйжүүлэлтийг хлорын шохой, хлорамины 3 хувийн уусмалаар усалгааны машин, авто цэвэрлэгээний тусгай зориулалтын машин, галын болон бусад техник ашиглаж эмнэлгийн болон нийтийн ахуйн үйлчилгээний албаны бие бүрэлдэхүүний хүчээр гүйцэтгэх талаар тусгана. Мөн түр цугларах талбай, түр хорогдох байр, түр орон сууцад шаардагдах нийтийн бие засах газар, био жорлонгийн хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулж, орон сууц нийтийн аж ахуйн болон бохирын ус тээвэрлэх компаниудыг мэдээллээр хангах; Нүүн шилжигчдийг дамжин өнгөрүүлэх болон хүлээж авах цэгүүдэд шаардагдах нийтийн бие засах газар, био жорлонгийн хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулж бохирын ус тээвэрлэх компаниудыг мэдээллээр хангах;

### **3.5. Харилцан ажиллагааг зохион байгуулах, мэдээ мэдээллийг солилцох үйл ажиллагаа**

Улсын Онцгой комисс, гамшгаас хамгаалах бусад алба, мэргэжлийн байгууллагуудтай харилцан ажиллагааг хэрхэн зохион байгуулах, мэдээ, мэдээллийг хэрхэн солилцох талаар дурдана. Тухайлбал:

Засгийн газрын дэргэдэх Харилцаа холбоо мэдээлэл технологийн газар нь Улсын онцгой комисс, аймаг, нийслэлийн онцгой комисс болон гамшгаас хамгаалах бусад албад, мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааг хангахын тулд ОБЕГ –ын шуурхай удирдлагын төв, Нийслэлийн шуурхай удирдлагын төвөөр дамжуулан харилцан ажиллагаа хангах, харилцан мэдээ, мэдээллийг солилцох ажлыг зохион байгуулна. Түүнчлэн ОБЕГ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газраар дамжуулах Зэвсэгт хүчин, хилийн цэрэг болон төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагатай харилцан ажиллагааг хангаж нэрвэгдэгсдэд тусламж үйлчилгээ үзүүлнэ.

Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон аймаг, дүүргийн онцгой комисс, гамшгаас хамгаалах алба нь УОК болон холбогдох Гамшгаас хамгаалах улсын албадад хандан гамшгийн үеийн үеийн аврах, гал унтраах, хэв журам сахиулах эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх нэмэлт шуурхай бүлгийг илгээх хүсэлт тавина.

Газар хөдлөлтийн гамшгийн голомт дахь Аймаг, нийслэлийн Онцгой байдлын албаны шуурхай штаб нь шаардлагатай бол эсвэл орон нутгийн

захиргааны байгууллагын хүсэлтийг үндэслэн гамшгийн үеийн үеийн аврах, гал унтраах, хэв журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх нэмэлт шуурхай бүлгийг илгээх төлөвлөгөө боловсруулан тусламж, үйлчилгээний ерөнхий зохицуулалт хийнэ.

Гамшгаас хамгаалах улсын албаны шуурхай штаб нь эрэн хайх, аврах, гал унтраах, эмнэлгийн тусламж үйлчилгээний явц байдлын тухай мэдээллийг ОБЕГ –ын шуурхай удирдлагын төв, Нийслэлийн шуурхай удирдлагын төв, бусад мэдээллийн системээс шуурхай тодруулж, газар хөдлөлтийн гамшгийн голомтод эрэн хайх, аврах, гал унтраах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх нэмэлт хүч хэрэгсэл илгээх тухай шийдвэрийн төсөл боловсруулж холбогдох Гамшгаас хамгаалах улсын албадад танилцуулах арга хэмжээ авна.

Аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газар, Цэргийн штаб, Онцгой байдлын газар, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран газар хөдлөлтийн гамшиг тохиолдоогүй аймаг, дүүргийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги бие бүрэлдэхүүнийг цуглуулан гамшгийн үеийн аврах, гал унтраах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх нэмэлт шуурхай бүлгийг байгуулахын хамт холбогдох Гамшгаас хамгаалах улсын албаны хүсэлтийн дагуу нэмэлт хүч хэрэгсэл илгээх арга хэмжээг зохион байгуулна.

Гамшгаас хамгаалах улсын албаны даргын шийдвэр гарсны дараа аврах, гал унтраах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх нэмэлт шуурхай бүлгийг татан оролцуулахдаа газар хөдлөлтийн гамшиг тохиолдоогүй аймаг, дүүргүүдээс автотээврийн хэрэгслээр нисдэг тэрэг зэрэг агаарын тээврийн хэрэгслээр цуглуулах арга хэмжээ авна. Мөн УОК нь Зэвсэгт хүчний анги салбаруудаас аврах, гал унтраах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шуурхай бүлгийг газар хөдлөлтийг гамшгийн голомтод илгээнэ.

Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон аймаг, дүүргийн Гамшгаас хамгаалах алба орон нутгийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, байгууллагуудын хүчээр эрэн хайх, аврах, гал унтраах, нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч энэ тухай УОК, Гамшгаас хамгаалах улсын албаны даргын илтгэнэ. Гамшиг тохиолдсон аймаг, дүүргийн онцгой комисс нь зэргэлдээ аймаг, дүүргийн Гамшгийн үеийн эрэн хайх, аврах, гал унтраах, нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шуурхай бүлгийг хүлээж авахтай холбоотой зохицуулалтыг хийнэ. Тэрчлэн тусламж үйлчилгээ үйл ажиллагаа явуулах түшиц газрыг нь гаргаж өгнө.

УОК, Гамшгаас хамгаалах улсын албаны дарга нь газар хөдлөлтийн гамшиг тохиолдоогүй аймаг дүүргийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нарт эрэн хайх, аврах, гал унтраах, нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шуурхай бүлгийг гамшгийн голомт руу илгээх тухай үүрэг даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавина.

### **3.6.Гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрт тусламж үйлчилгээгээр хангах**

Гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн хүн амд тусламж үйлчилгээг өөрийн салбарын чиг үүргийн хүрээнд хэрхэн үзүүлэх талаар дурдана.

Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон аймаг, нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах улсын албаны харьяа аймаг, дүүргийн гамшгаас хамгаалах албадаар дамжуулан цугларах талбайд цугласан иргэдийг бүртгэх, зааварчилгаа өгөх,

нэрвэгдэгсдийн талаарх мэдээлэл хүргэх, хүлээн авах ажиллагааг зохион байгуулах, нэрвэгдэгсдийг ангилах, анхны болон нарийн мэргэжлийн тусламж бусад бүх төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн хамт шаардлагатай бол тухайн аймаг, орон нутгийн хувийн хэвшлийн байгууллагуудад хандан хамтран ажиллахыг шаардана. Гамшиг тохиолдсон Аймаг, Нийслэл, дүүргийн орон нутгийн гамшгаас хамгаалах албад нь барилга, тоног төхөөрөмжийн хохирлыг арилган яаралтай сэргээн босгохын хамт шаардлагатай бол инженерийн болон холбоо харилцааны шугам сүлжээ хариуцсан байгууллагад хандан яаралтай сэргээн босгох арга хэмжээ авах шаардлага тавина. Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон аймаг орон нутгийн албад нь улам бүр өсөн нэмэгдсээр байгаа хохирогчдод бүх төрлийн яаралтай тусламжийг тасралтгүй үзүүлэхийн тулд өөр хорондоо мэдээлэл солилцон харилцан ажиллагааг сайтар ханган шаардлагатай бол бусад албад, байгууллагаас дэмжлэг тусалцаа хүсэх арга хэмжээ авна.

ОБЕГ, ЭМЯ, БХЯ, ЗХЕШ –аас газар хөдлөлтийн гамшгийн байдлаас хамааран гамшгийн үеийн эрэн хайх, аврах, гал унтраах, нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, сэтгэл заслын шуурай бүлгийг гамшгийн голомтод илгээх арга хэмжээ авна.

ОБЕГ, ЭМЯ, ХХААЯ, МУЗН –тай хамтран олон улсын байгууллага, хандивлагч орон, иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хандив тусламжийг хүлээн авах, зохицуулалт хийх арга хэмжээ авах.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ДАРААХ ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ**

### **4.1. Гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ болон шаардагдах зардлыг судалж тогтоох**

Гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ болон түүнд шаардагдах зардлыг өөрийн салбарын хүрээнд гаргах асуудлыг дурдана.

Тухайлбал: Гамшгаас хамгаалах улсын албаны штаб нь газар хөдлөлтийн тухай (чичирхийллийн хүч, голомт, магнитут) болон тухайн салбарын хохирлын талаархи мэдээллийг цуглуулах, мэдээлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ. Гамшгаас хамгаалах улсын алба нь ОБЕГ –ын шуурхай удирдлагын төв, улсын албаны шуурхай удирдлагын штабын холбооны мэдээллийн системийг ашиглан ерөнхий цагийн байдлын мэдээлэл, бусад төрлийн бүрийн мэдээллийг цуглуулж, тухайн салбарын хохирлын үнэлгээ, дүн шинжилгээнд үндэслэн хохирлын болон сэргээн босгох үйл ажиллагааны хэрэгцээ, шаардагдах зардал, хөрөнгийг яаралтай тодорхойлох талаар тусгах.

Хэрэв тухайн салбарын хохирлын хэмжээ нь аймаг, сумын дотоод нөөц боломжийн хүрээнд байна гэж үзвэл тухайн аймаг, орон нутгийн гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн хүчээр зохион байгуулах арга хэмжээг авах, харин газар хөдлөлтийн гамшгийн хохирол нь тухайн аймаг, сумын дотоод нөөц боломжоос давсан тохиолдолд тухайн бүсийн хэмжээний гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, улсын онцгой комиссын оролцоотойгоор сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулах талаар тусгана.

Засгийн газар болон яам, агентлагууд нь аймаг сумын онцгой комисст албаны хэмжээний байгууллагуудын барилга байгууламжийг шуурхай сэргээн босгоход хүн, техникийн дэмжлэг үзүүлж бараа материалаар тасралтгүй хангах арга

хэмжээ авах талаар тусгана.

#### **4.2. Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн барилга байгууламжийн хойшлуулшгүй сэргээн босгох**

Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг хойшлуулшгүй сэргээн босгох чиглэлээр ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар холбогдох улсын алба дурдана.

Тухайлбал: Гамшгаас хамгаалах улсын алба нь эхний ээлжинд тухайн аймаг, дүүргийн барилга байгууламжийн эзэмшил газарт гамшгийн улмаас бий болсон хог хаягдлын төрөл ба шинж чанарыг (шавхай, лаг, бохирдуулагч бодис гэх мэт) харгалзан хог хаягдлын нийт хэмжээг тооцож цуглуулах, тээвэрлэж, хаях арга хэмжээг зохион байгуулах талаар тусгах, түүнчлэн эвдэрч гэмтсэн барилга барилга, байгууламжийг буулгах арга хэмжээг барилгын компаниудын тусламжтайгаар гүйцэтгэх, байгаль орчны бохирчны бохирдлоос сэргийлэх, ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авна. Барилга байгууламж, дэд бүтцийг шуурхай сэргээн босгох ажлыг гүйцэтгэхдээ эхний ээлжинд хялбарчилсан арга хэмжээ авч хэвийн байдалд эргэж оруулах бөгөөд эвдрэлийн хэмжээ, зэрэглэлээр цаашид ашиглах боломж бүхий барилга байгууламжийг үе шаттайгаар сэргээн засварлах, олон нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг хүчитгэн бэхжүүлэх, сайжруулан барих арга хэмжээ авна.

Аймаг, дүүргийн захиргаатай хамтран гамшигт өртсөн барилга байгууламжуудыг сэргээн босгох ажлыг гүйцэтгэхдээ барилга байгууламжийн газар хөдлөлтэд тэсвэрлэх чадварыг бэхжүүлж, түр ажлын байр, байгууламжийг ашиглах арга хэмжээ авна.

#### **Дөрөв.Төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал**

Төлөвлөгөө боловсруулахад энэхүү зааврыг удирдлага болгон орон нутаг болон салбарын онцлогт нийцүүлэн газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үеийн цагийн байдал, хохирлын төсөөллийг бий болгож, авч хэрэгжүүлэх арга хэмжээг аль болох бүрэн дүүрэн тодорхойлж, бүтээлч сэтгэлгээгээр хандах шаардлагатай.

Мөн шаардагдах мэдээ, мэдээллийг цуглуулж, бусад орны туршлагыг судлан холбогдох байгууллагын мэргэжлийн хүмүүсийн оролцоог хангаж боловсруулах нь амьдралд илүү нийцсэн, хэрэгжих боломжтой төлөвлөгөө болоход ач холбогдолтой юм.

---oOo---



## **ОРОН НУТГИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР**

### **Зааврын бүтэц**

**Нэг. Оршил**

**Хоёр. Төлөвлөгөөний ерөнхий бүтэц**

**Гурав. Төлөвлөгөөний агуулга**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1.Танилцуулга**

1.1.1. Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ерөнхий танилцуулга:

1.1.2. Тухайн орон нутагт тохиолдсон газар хөдлөлтийн гамшгийн тухай мэдээлэл

#### **1.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, баримтлах зарчим**

1.2.1. Төлөвлөгөө боловсруулах зорилго

1.2.2. Зарчим, үндсэн чиглэл

#### **1.3. Орон нутгийн гамшгаас хамгаалах удирдлага, бүтэц зохион байгуулалт**

1.3.1. Гамшгаас хамгаалах тогтолцоо

1.3.2. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн ерөнхий чиг үүрэг

#### **1.4. Хамтын ажиллагааны санамж бичиг**

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

#### **2.1. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй цагийн байдлын төсөөлөл ба хохирлын үнэлгээ**

2.1.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ

2.1.2. Үүсч болзошгүй хохирлын төсөөлөл, гамшгийн эрсдэл болон учирч болзошгүй хохирлын хэмжээг бууруулах чиглэлээр дэвшүүлэх зорилго, зорилт

#### **2.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт**

2.2.1 Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны зорилго

2.2.2. Холбогдох талын ерөнхий чиг үүрэг

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**3.1. Барилга байгууламж, дэд бүтэц болон инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн гамшигт тэсвэртэй байдлыг дээшлүүлэх**

3.1.1. Газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

3.1.2. Удирдлагын байрны газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

3.1.3. Хувийн болон олон нийтийн барилга байгууламжийн тэсвэржилтийг хангах

3.1.4. Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

3.1.5. Шуурхай тээвэрлэлт хийх автозамыг тогтоох, зам болон замын байгууламжийг сэргээн засварлах бэлтгэл ажлыг хангах

3.1.6. Гал түймэрт нэрвэгдэх болзошгүй барилга байгууламж, хүний хохирлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

**3.2. Хүч хэрэгсэл**

3.2.1. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах

3.2.2. Орон нутгийн дотоод нөөц боломж, чадавх

**3.3. Холбоо, зарлан мэдээлэл**

3.3.1. Холбоо, зарлан мэдээллийн бэлэн байдал

3.3.2. Холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангах

3.3.3. Холбоо, зарлан мэдээллийн чадавхыг бэхжүүлэх

3.3.4. Газар хөдлөлтийн гамшгийн аюулын мэдээ, мэдээллийг хүргэх

**3.4. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ**

3.4.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоо

3.4.2. Эм тариа, эмнэлгийн материал, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний хангамж

3.4.3. Эрүүл ахуйн халдвар эсэргүүцэх арга хэмжээний зохион байгуулалт

**3.5. Гамшгаас хамгаалах арга хэмжээ**

3.5.1. Гал түймэртэй тэмцэх тогтолцоо

3.5.2. Хог хаягдалыг цэвэрлэх арга хэмжээний зохион байгуулалт

3.5.3. Нөөц бүрдүүлэлт

3.5.4. Усан хангамжийн тогтолцоо

3.5.5. Нүүлгэн шилжүүлэх, түр хорогдох байр

**3.6. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа**

3.6.1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах дадлага сургууль

3.6.2. Сурагч болон сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалт

3.6.3. ААН байгууллага, иргэдийн гамшгаас хамгаалах боловсролын арга хэмжээ

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН**

## **ХОР УРШГИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **4.1. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай удирдлага зохицуулалт**

4.1.1. Удирдлага, зохион байгуулалт

4.1.2. Онцгой комисс

4.1.3. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн чиг үүрэг

4.1.4. Гамшгаас хамгаалах дайчилгааг зохион байгуулах

4.1.5. Гамшгийн үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах ажлыг зохион байгуулах

4.1.6. Холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах

4.1.7. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах

4.1.8. Гал түймэртэй тэмцэх ажлыг зохион байгуулах

4.1.9. Эрэн хайх, аврах ажлыг зохион байгуулах

4.1.10. Ар тал, хангалтыг зохион байгуулах

### **4.2. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах**

4.2.1. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг төлөвлөх

4.2.2. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

4.2.3. Нүүлгэн шилжүүлэх байршил болон түр хоргодох байрны ар тал, хангалтыг зохион байгуулах

4.2.4. Хэв журам сахиулах арга хэмжээг зохион байгуулах

### **4.3. Гамшгийн үед нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ**

4.3.1. Нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ

4.3.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг зохион байгуулах

4.3.3. Түр хорогдох байрны эмнэлгийн тусламж үйлчилгээ

### **4.4. Ариун цэвэр, халдвар судлал, хог хаягдал, хүрээлэн буй орчны талаар авах арга хэмжээ**

4.4.1. Эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх арга хэмжээ

4.4.2. Хог хаягдал цэвэрлэх, зайлуулах арга хэмжээ

4.4.3. Хүнсний эрүүл ахуйг хангах арга хэмжээ

4.4.4. Мал амьтныг хамгаалах арга хэмжээ

4.4.5. Амь насаа алдсан иргэдийг оршуулах арга хэмжээ

## **ТАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ҮЕД ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ БОЛОН СЭРГЭЭН БОСГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **5.1 Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ.**

5.1.1. Хүн амын амьдралын зайлшгүй хэрэгцээг хангах арга хэмжээ

5.1.2. Гамшгийн хохирлыг тогтоох, хойшлуулшгүй сэргээн босгох ажлын

зохион байгуулалт

## **5.2. Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээний үндсэн чиглэл**

### **5.3. Хойшлуулшгүй сэргээн босгох ажлын ерөнхий шат дараалал**

5.3.1. Хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг эхлүүлэх тогтолцоог бий болгох (Газар хөдлөлт болсоноос хойш 14 хоногийн хугацаанд)

5.3.2. Сэргээн босгох арга хэмжээний үндсэн чиглэлийг тогтоох (газар хөдлөлт болсоноос хойш 14 дэх хоногоос 2 сарын хугацаанд)

5.3.3. Сэргээн босгох ажлын үндсэн төлөвлөгөө боловсруулах (2 сар-6 сар)

5.3.4. Сэргээн босгох арга хэмжээний үндсэн төлөвлөгөөг батлах (6 сар-1 жил)

5.3.5. Сэргээн босгох ажлыг хөгжлийн бодлоготой уялдуулж хэрэгжүүлэх (1 жилээс хойш)

## **Дөрөв.Төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал**

### **Тав.Төлөвлөгөөний хавсралтууд.**

1. Тухайн хот, суурин газрын план зураг
2. Аймаг, сумын онцгой комиссын гишүүдийн хаяг, утасны жагсаалт
3. Онцгой комисс, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг зарлан мэдээллийн дохиогоор дуудах бүдүүвч
4. Хөдөлгөөнт болон суурин холбооны судалгаа
5. Холбоо барих, мэдээ, мэдээлэл дамжуулах бүдүүвч
6. Зарлан мэдээлэх дуут дохионы байршил
7. Нутаг дэвсгэрт байгаа улсын онц чухал объектын судалгаа
8. Барилга байгууламжийн аюулын зэрэглэлийн судалгаа
9. Хүч хэрэгслийн тооцоо, судалгаа
10. Замын хөдөлгөөний зохицуулалт, тээврийн хэрэгслийн зам маршрутын төлөвлөлтийн схем зураг
11. Тээврийн хэрэгслийн дайчилгаа ба бүрдүүлэлтийн судалгаа
12. Ундны цэвэр ус, ахуйн хэрэглээний усан хангамжийн тооцоо судалгаа
13. Яаралтай тусламжийн нөөцийн бараа материалын жагсаалт
14. Цугларах талбай, хоргодох байр, түр орон сууцны байршил, судалгаа
15. Санамж бичиг
16. Аймаг, сумын эрсдэлийн үнэлгээний тайлан

---oOo---

# ОРОН НУТГИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

## Нэг. Оршил

1.1. Энэхүү заавар нь аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг гамшгаас хамгаалах болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлэхэд удирдлага болгох баримт бичиг юм.

1.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь дээрх зааврыг ашиглан орон нутагтаа газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө (цаашид төлөвлөгөө гэнэ) боловсруулж хэрэгжүүлнэ.

1.3. Төлөвлөгөө боловсруулах ажлыг орон нутгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хийнэ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах алба, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулах бөгөөд Онцгой байдлын байгууллага удирдлага зохицуулалтаар хангана. Төлөвлөгөө боловсруулахдаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, ач холбогдол, төлөвлөгөөний агуулга, боловсруулах үе шатыг танилцуулж, шаардлагатай тохиолдолд сургалт явуулна.

1.4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах арга зүйн дагуу төлөвлөгөө боловсруулна:

1. Төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээлэл цуглуулах (албан ёсны статистик мэдээ, тоо баримт, дүрэм, журам заавар гэх мэт);

2. Тухайн орон нутгийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж, цагийн байдал буюу гамшгийн хохирлын төсөөлөл гаргах;

3. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулах дараалал, тулгарч болзошгүй асуудал, удирдлагын тогтолцоо, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн чиг үүргийг тодорхойлж, хүч хэрэгсэл, ар тал, хангалтын тооцоог боловсруулах;

4. Боловсруулсан төлөвлөгөөг сургууль дадлагаар туршиж, дутагдалтай талуудыг засаж залруулж дээд шатны байгууллага, албан тушаалтнаар хянуулж батлуулах.

1.5. Төлөвлөгөө боловсруулахдаа орон нутгийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл, үүсч болзошгүй цагийн байдал, хохирлын үнэлгээ, тухайн орон нутгийн удирдлага, нөөц, хүч хэрэгслийг үндэслэл болгоно.

1.6. Нийслэл, дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тухайн орон нутгийн онцгой байдлын байгууллага хянаж, тухайн шатны Засаг дарга батална. Аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын гамшгийн асуудал хариуцсан бүтцийн нэгжийн дарга хянаж, тухайн аймгийн Засаг дарга, сумын төлөвлөгөөг тухайн аймгийн онцгой байдлын газрын дарга хянаж, тухайн сумын Засаг дарга тус тус батална.

1.7. Төлөвлөгөөг тухайн орон нутагт зохион байгуулж байгаа удирдах бүрэлдэхүүний сургалт болон гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, команд штабын дадлагаар, мөн газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад илэрсэн дутагдал, сул талыг арилгах зорилгоор эсвэл төлөвлөгөөний бүтэц, агуулга өөрчлөлт оруулсан тохиолдолд тус тус тодотгол хийнэ .

1.8. Төлөвлөгөөг дараах ерөнхий дарааллын дагуу боловсруулна. Жич: Хийгдэх ажлыг 15 хэсэгт хуваасан нь өдөр хоногийн тоо биш бөгөөд төлөвлөгөө боловсруулах нийт хугацааг 15 хэсэгт хувааж үзүүлсэн болно.

№	Хийгдэх ажил, үе шат	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	
1.	Ажлын хэсэг байгуулах																
2.	Мэдээлэл цуглуулах																
3.	Мэдээлэл эмхтгэх																
4.	Танилцуулга хэсэг боловсруулах																
5.	Эрсдэлийн үнэлгээ хийх																
6.	Цагийн байдал үүсгэх																
7.	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн чиглэлийг тодорхойлох (9.-ийн дараа ч байж болно)																
8.	Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлэх																
9.	Урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах																
10.	Гамшгийн үеийн хор уршгийг арилгах төлөвлөгөө																
11.	Гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох төлөвлөгөө																
12.	Төлөвлөгөөний хавсралт хэсгийг боловсруулах																
13.	ОНЗөвлөлд танилцуулах																
14.	Засаг даргаар батлуулах																
15.	ОНИТХ-д танилцуулах																
<b>Хариуцах байгууллага, албан тушаалтан (Нийслэл, Аймаг)</b>																	
Орон нутгийн Онцгой байдлын байгууллага		+														+	
Ажлын хэсэг			+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+			
Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл																	
Нийслэл, дүүрэг, аймгийн Засаг дарга		+															+
Дүүрэг, Сумын Засаг дарга																	+

## **Хоёр. Төлөвлөгөөний ерөнхий бүтэц**

2.1. Төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

-Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

-Хоёрдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт

-Гуравдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө

-Дөрөвдүгээр бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах төлөвлөгөө

-Тавдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн үед хойшлуулшгүй сэргээн босгох төлөвлөгөө

-Хавсралтууд

## **Гурав. Төлөвлөгөөний агуулга**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Энэ бүлэг орон нутгийн танилцуулга, төлөвлөгөөний зорилго, зарчим, удирдлага зохион байгуулалт гэсэн хэсгээс бүрдэнэ.

#### **1.1.Танилцуулга**

1.1.1. Тухайн орон нутгийн ерөнхий танилцуулга:

Энэ хэсэгт газар зүй, байгаль цаг уур, нийгэм эдийн засаг, хүн ам, засаг захиргааны нэгж, дэд бүтэц, барилга байгууламжийн талаарх танилцуулгыг бичнэ. Газар зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас жил бүр гаргадаг Монгол улсын статистикийн эмхэтгэлийн албан ёсны статистик тоо баримтыг үндэслэн хүснэгт, зурган болон бусад хэлбэрээр үзүүлнэ. Түүнчлэн, тухайн орон нутгийн Засаг даргын Тамгын газрын танилцуулга, веб хуудас, үйл ажиллагааны хөтөлбөр, тайлан мэдээг ашиглаж болно.

Газар зүй, байгаль цаг уур, нийгэм эдийн засаг, хүн ам, засаг захиргааны нэгж, дэд бүтэц, барилга байгууламжийн товч танилцуулга нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

А) Газар зүй, байгаль цаг уурын мэдээлэлд:

Тухайн орон нутгийн нутаг дэвсгэрийн хэмжээ, ямар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй хиллэдэг болох, далайн түвшнээс дээш хэдэн метрт оршдог, байгалийн ямар бүслүүрт багтдаг, Нийслэл Улаанбаатар хотоос хэдэн километрийн зайд оршдог, ямар уулс, гол мөрөн, нуур цөөрөм, булаг шанд байдаг, агаарын жилийн дундаж хэм, цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлт, хур тунадас, газрын гадаргын хагарал, хөрсний бүтэц, өмнө тохиолдож байсан гамшигт үзэгдэл, учирсан хохирол,

Б) Нийгэм эдийн засаг, хүн ам, засаг захиргааны нэгжийн мэдээлэлд:

Засаг захиргааны нэгжийн тоо, хоорондын зай, хүн амын тоо насны бүлэг, хүйсээр, өрхийн тоо төв суурин газар хөдөөгөөр, хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал,

ажилгүй иргэдийн тоо, шилжилт, хөдөлгөөн, нэг өрхийн сарын дундаж орлого, ДНБ эдийн засгийн салбараар, хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа, тээвэр, харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, худалдааны салбарын нийт борлуулалт, үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн, тухай аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин гэх мэт.

В) Дэд бүтэц, барилга байгууламж талаарх мэдээлэлд:

Тухайн орон нутгийн зам, инженерийн болон цахилгаан, дулааны шугам сүлжээ, барилга байгууламж, хувийн болон нийтийн орон сууц, сургууль цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын мэдээлэл (насжилт, хийц, бүтээц, давхарын тоо, төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдсон байдал гэх мэт)

1.1.2. Тухайн орон нутагт тохиолдсон газар хөдлөлтийн гамшгийн тухай мэдээлэл

Тухайн орон нутагт тохиолдож байсан газар хөдлөлтийн тохиолдол, учруулсан хохирол, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сургамжийн тухай тусгана. Тухайлбал, газар хөдлөлтийн чичирхийлэлтийн он сар өдөр, эпицентр, магнитуд, хүний амь нас эрсдсэн байдал, барилга байгууламжинд учирсан эвдрэл, эдийн засгийн хохирол зэргийг дурьдах; Одон орон геофизикийн хүрээлэнгээс тухайн орон нутгийн газар хөдлөлтийн идэвхитэй бүс, ерөнхий болон бичил мужлалын зураглал, хөрсний судалгааны ажлын үр дүнгийн талаар тусгах.

**1.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, баримтлах зарчим**

1.2.1. Төлөвлөгөө боловсруулах зорилго

Гамшигт тэсвэртэй хот, суурин газар, хүрээлэн буй орчныг цогцлоох, орон нутгийн гамшгаас хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах асуудлыг гол зорилгоо болгоно.

1.2.2. Зарчим, үндсэн чиглэл

Төлөвлөгөө боловсруулахад газар хөдлөлтийн гамшгийн болзошгүй цагийн байдал, хохирлын төсөөлөлд үндэслэсэн, амьдралд илүү нийцсэн, хэрэгжих үндэслэлтэй, газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох талуудын харилцан ажиллагаа, уялдааг хангасан, орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдсан байх зэрэг зарчмыг баримтлана.

Газар хөдлөлтийн гамшгаас хүний эрүүл мэнд, амь насыг хамгаалах нь хамгийн чухал бөгөөд үүний тулд бэлэн байдлыг хангах, сургалт, дадлага зохион байгуулах, иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах байгууллагуудын харилцан ажиллагааг хангах, дүрэм журам, стандартыг мөрдөх зэрэг бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна бүтцийн арга хэмжээг /байшин барилгыг хүчитгэх, илүү тэсвэртэй байхаар барьж байгуулах зэрэг/ илүүтэй авч хэрэгжүүлэх нь хамгийн их үр дүнтэй арга хэрэгсэл юм.



Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг бүрэн таслан зогсоох боломжгүй ч гамшгийн хохирлыг аль болох хэмжээнд бууруулж, учирсан хор уршгийг шуурхай арилгах, нөхөн сэргээх замаар “гамшгийн аюулыг бууруулах” үзэл баримтлалыг мөрдлөг болгох, гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангаж гамшигт нэрвэгдсэн ч хүний амь насны эрсдэл, эд хөрөнгийн эвдрэл гэмтэл аль болох бага байхын тулд газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг авч хэрэгжүүлэн тухай орон нутгийн нийгэм, эдийн засагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг аль болох бага хэмжээнд хязгаарлахыг үндсэн чиглэл болгоно.

Мөн, тухайн орон нутгийн төрийн болон нутгийн засаг захиргааны байгууллага, онцгой комисс, онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах албад, төр хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн байгууллага, сайн дурынхны хамтын ажиллагаа, үүрэг, оролцоог нарийн тодорхойлж газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл болгоно.

### 1.2.3. Төлөвлөгөөнд засвар оруулах


Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, гамшгаас хамгаалах тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт өөрчлөгдөх зэргээс шалтгаалан төлөвлөгөөний агуулга бодит нөхцөл байдалтай зөрчилдөж өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд агуулгыг нягталж засвар оруулна.

## 1.3. Орон нутгийн гамшгаас хамгаалах удирдлага, бүтэц зохион байгуулалт


### 1.3.1. Гамшгаас хамгаалах тогтолцоо

Орон нутгийн зөвлөл, онцгой комисс, онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэх үндсэн чиг үүргийг тусгах.

Тухайлбал, гамшгаас хамгаалах удирдлага, бүтэц зохион байгуулалтын бүдүүвчийг зургаар харуулж, холбогдох байгууллагуудын үндсэн чиг үүргийг бичих.



Зураг 1. Гамшгаас хамгаалах удирдлага, бүтэц зохион байгуулалт (Аймгийн жишээ)



Зураг 2. Гамшгаас хамгаалах удирдлага, бүтэц зохион байгуулалт (Сумын жишээ)

### 1.3.2. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн ерөнхий чиг үүрэг

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох талуудын ерөнхий чиг үүргийг товч дурдана.

1. Онцгой комисс
2. Гамшгаас хамгаалах алба
3. Онцгой байдлын байгууллага
4. Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги
5. Улаан загалмайн хороо
6. Сайн дурын бүлэг, хэсэг
7. Төрийн байгууллага, аж ахуйн нэгж
8. Зэвсэгт хүчний анги, нэгтгэл
9. Иргэд гэх мэт

### 1.4. Хамтын ажиллагааны санамж бичиг

Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага хооронд гамшгийн үед үүрэг, хариуцлага хүлээх санамж бичиг байгуулах нь зүйтэй. Санамж бичиг байгуулах тухай, санамж бичгийн зорилгын тухай дурьдах.

Санамж бичгийн зорилго нь төлөвлөгөөгөөр зохицуулах боломжгүй нэмэлт үйл ажиллагааг талууд харилцан тохиролцож зөвшилцсөний үндсэн дээр хамтран хэрэгжүүлэх, гарах зардлыг гүйцэтгэлээр нөхөн төлж барагдуулахад оршино.

Санамж бичгийг эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, ундны ус, хоол, хүнсний хангалт, түр хорогдох байр, шатах тослох материалын хангалт, хог хаягдал, бохир ус цэвэрлэх, тээврийн хангалт, зам, гүүрийн засвар, холбоо харилцааны хангалтын чиглэлээр төрийн бус байгууллага, нийгэмлэг, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулж болно.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 2.1. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй цагийн байдлын төсөөлөл ба хохирлын үнэлгээ

### 2.1.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ

Улаанбаатар хот орчимд өвлийн хүйтний улиралд М7.0-М8.0 –ийн газар хөдлөлт тохиолдоход барилга байгууламж нурах, осголт хөдлөлтөөс үүдэж хүний амь нас эрсдэх, бусад хохирол үүсэхээр цагийн байдлын төсөөллийг бий болгоно.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн онцгой байдлын газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)–аас хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл<sup>1</sup>-ийн хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлын төгсгөлийн тайлангийн “Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийх үйл явц ба түүний үр дүн” гэсэн 4 дүгээр бүлгийн судалгааны ажлыг үндэслэл болгоно.

Аймаг, сумын тухайд Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалаар баталсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх заавар” болон түүний хавсралт болох Экселийн программын дагуу гүйцэтгэх талаар тусгана. Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа (ерөнхий үнэлгээ) болон нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх бөгөөд хэрэв эрсдэлийн тойм судалгааны үр дүнгээр нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай бол тухайн аймаг, сумын Засаг даргын Тамгын газар мэргэжлийн байгууллагаар нарийвчилсан үнэлгээ хийлгэх талаар тусгана.

### 2.1.2. Үүсч болзошгүй хохирлын төсөөлөл, түүнийг бууруулах зорилго, зорилт

Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан өвлийн улиралд газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед хүн ам, барилга байгууламжид учирч болзошгүй эвдрэл, хохирлыг тооцож үүсч болзошгүй цагийн байдлын төсөөллийг гарган гамшгийн эрсдэл, хохирлын хэмжээг бууруулах чиглэлээр зорилго, зорилт дэвшүүлнэ.

Тухайлбал:

1. Газар хөдлөлтийн улмаас амь насаа алдагсдын тоог 70 хүртлэх хувиар бууруулах
2. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний барилгад учрах хохирлыг 60 хувиар бууруулах
3. Орон сууц болон бусад барилга байгууламжид учрах хохирлыг 40 хувиар бууруулах
4. Инженерийн шугам сүлжээнд учрах хохирлыг 50 хувиар бууруулах.

<sup>1</sup>Монгол улс Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх төсөл (хөгжлийн судалгааны хэлбэрт техникийн хамтын ажиллагаа) Төгсгөлийн тайлан 2-р бүлэг Үндсэн тайлан. УБ хот. 2013 он. х-1-1.

Хохирлын төсөөлөл ба гамшгийн эрсдэлийг бууруулах зорилго, зорилт (жишээ)

Хохирлын төрөл			Хохирлын хэмжээ	Нэгж	Гамшгийн эрсдэл, хохирлыг бууруулах зорилго, зорилт
Хүний хохирол	Нас барсан хүний тоо	Барилгажсан хэсэг	250	хүн	70 хүртэлх хувиар бууруулах
		Гэр хороолол	40	хүн	
	Гэмтэж бэртсэн хүний тоо	Барилгажсан хэсэг	320	хүн	50 хувиар бууруулах
		Гэр хороолол	25	хүн	
	Гэр оронгүй болсон хүний тоо	Барилгажсан хэсэг	300	хүн	30 хувиар бууруулах
		Гэр хороолол	35	хүн	
Барилгын хохирол	Нурсан, их хэмжээгээр эвдэрсэн	Барилгажсан хэсэг	20	ширхэг	60 хувиар бууруулах
		Гэр хороолол	10	ширхэг	
	Нурангийн хэмжээ		500	тонн	
Дэд бүтэц, ИШС	Зам	Нэвтрэх боломжгүй болсон	15	цэг	50 хувиар бууруулах
	Гүүр	A аргачлал	Гүүрийн нэр		
		B аргачлал	Гүүрийн нэр		
	Цахилгааны шон	Нурсан	150	ширхэг	
	Цахилгааны шугам	Хохирлын хувь	50	%	
	Газар доорх шугам	Хохирлын хувь	30	%	
	Цэвэр усны шугам	Эвдэрсэн	40	цэг	
	Бохир усны шугам	Хохирлын хувь	30	%	
Дулаанн шугам	Эвдэрсэн	20	цэг		

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон учирч болзошгүй хохирлыг бууруулах чиглэлээр дэвшүүлсэн зорилгыг хангахын тулд ямар, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар төлөвлөгөөнд тусгана.

Дэвшүүлсэн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлэх:

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа
<b>1. Бүтцийн бус арга хэмжээ</b>			
1.	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулах	Гамшгаас хамгаалах удирдлага, менежментийн чадавхыг бэхжүүлэх	
		Иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх	
		Гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, хөгжлийн бодлогод гамшгийн эрсдэлийг тооцож, уялдуулах	
		Мэдээ, мэдээллийг хүргэх тогтолцоог бүрдүүлэх	

		Гамгийн эрсдэлийн үнэлгээ хийх нөхцлийг бүрдүүлэх	
		Тэсвэржилтийг хангах, хүчитгэх арга хэмжээнд шаардагдах санхүү, зардлын тооцоог гаргах	
<b>2.Бүтцийн арга хэмжээ</b>			
2.	Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг сайжруулах	Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх	
		Шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх	
		Барилга, байшинг хүчитгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	
		Шинээр барих барилгыг газар хөдлөлтөд тэсвэртэй байхаар барих	
3.	Инженерийн шугам сүлжээний тэсвэржилтийг хангах	Эрсдэлийн үнэлгээ хийх	
		Тэсвэржилтийг хангах, хүчитгэх арга хэмжээнд шаардагдах санхүү, зардлын тооцоог гаргах	
		Шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	
		Барилга, байшинг хүчитгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	
4.	Орон сууцны барилга, байшингийн тэсвэржилтийг хангах	Эрсдэлийн үнэлгээ хийх	
		Тэсвэржилтийг хангах, хүчитгэх арга хэмжээнд шаардагдах санхүү, зардлын тооцоог гаргах	
		Шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	
		Барилга, байшинг хүчитгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	
		Шинээр барих барилгыг газар хөдлөлтөд тэсвэртэй байхаар барих	
5.	Удирдлагын байрны аюулгүй байдлыг хангах	Гамшгийн шуурхай удирдлагын байрыг сонгож, төхөөрөмжлөх	
		Шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	
		Гамшгийн шуурхай удирдлагын байрыг хүчитгэх	
		Хөтөлгөөнт удирдлагын байрыг төхөөрөмжлөх, бэлэн байдлыг хангах	
6.	Бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлэх	Хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах	
		Гал унтраах бэлэн байдлыг хангах, чадавхыг сайжруулах	
		Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, чадавхыг сайжруулах	
		Нүүлгэн шилжүүлэх байрны бэлэн байдлыг хангах	
		Гамшгийн нөөцийг бүрдүүлэх	
		Холбоо, зарлан мэдээллийн бэлэн байдлыг хангах, чадавхыг сайжруулах	
		Ариутгал, халдваргүйтгэлийн бэлэн байдлыг хангах, чадавхыг сайжруулах	
		Хог хаягдал зайлуулах бэлэн байдлыг хангах гэх мэт	
		Усан хангамжийн тогтолцоог бүрдүүлэх	

## 2.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт

### 2.2.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны зорилго

Гамшгийн аюулыг хүн амд сэрэмжүүлэх, гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгож гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд орших бөгөөд 2.1.2-т дэвшүүлсэн зорилгыг биелүүлэхэд чиглэгдэнэ.

### 2.2.2. Холбогдох талын чиг үүрэг

Нийслэл, Аймаг, Сумын Засаг дарга нь нутаг дэвсэрийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах бөгөөд тухайн орон нутгийн гамшигт тэсвэрлэх, даван туулах чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ дараах үндсэн зарчим баримталж ажиллана. Үүнд:

- Хүний амь насыг хамгаалах арга хэмжээг нэн тэргүүнд тавих;
- Төрийн ажил, үйлчилгээ, нийгмийн амьдралд ноцтой саатал учруулахгүйгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Иргэдийн эд хөрөнгө болон нийтийн эзэмшлийн барилга, байгууламжид гарч болзошгүй хохирлыг багасгах;
- Сэргээн засварлах, сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гамшгаас хамгаалах сайн дурынхан, иргэний нийгмийн байгууллагын оролцоо, тэдгээрийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхой дурдана. Тухайлбал:

#### 1. Гамшгаас хамгаалах албадын чиг үүрэг

<b>1.Эрүүл мэндийн алба: / Эрүүл мэндийн газар/</b>
1.Мэргэжлийн ангиудын бэлэн байдлыг хангах, нэрвэгдэгсдийг хүлээн авахад бэлтгэх 2.Газар хөдлөлтийн гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Онцгой байдлын газартай хэлэлцэж, үүрэг чиглэл авах 3.Гамшгийн нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах 4.Шаардлагатай үед хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах бэлтгэлийг хангах 5.Бусад арга хэмжээ
<b>2.Хүнсээр хангах алба: /Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Хүнс, Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар/</b>
1.Зарлан мэдээллийн дохио хүлээн авч хариу мэдэгдэх бэлэн байдлыг хангаж, албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх 2.Мэргэжлийн ангиудыг яаралтай бэлэн байдалд оруулах, нэрвэгдэгсдийг хүлээн авахад бэлтгэх 3.Газар хөдлөлтийн гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Онцгой байдлын газартай хэлэлцэж, үүрэг чиглэл авах 4.Гамшгийн нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах 5.Шаардлагатай үед хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах бэлтгэлийг хангах 6.Бусад арга хэмжээ
<b>3.Хэв журам сахиулах алба: /Нийслэлийн Цагдаагийн газар, Аймгийн Цагдаагийн хэлтэс /</b>

<p>1.Газар хөдлөлтийн гамшгийн тухай зарлан мэдээлэл хүлээн авч бие бүрэлдэхүүнийг бэлэн байдалд оруулах бэлтгэлийг хангах</p> <p>2. Нийслэл, Аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газрын шийдвэрээр дараагийн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах</p> <p>3. Аврах ажиллагаанд шаардлагатай хүн, машин техник хэрэгслийн дайчилгаа явуулах бэлтгэл, бэлэн байдлыг хангах</p>
<p><b>4.Холбоо зарлан мэдээллийн алба: /Нийслэлийн Мэдээлэл технологийн газар, Шуудан, Холбооны газар/</b></p> <p>1.Гамшгийн тухай зарлан мэдээлэл явуулах шийдвэрийг хүлээн авах бэлтгэлийг хангах</p> <p>2.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх</p> <p>3.Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцан ажиллагааны төлөвлөгөө боловсруулах</p> <p>4.Зарлан мэдээлэл явуулах техник хэрэгсэл, хүн хүчний бэлэн байдлыг хангах</p> <p>5.Алба, аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдэд сэрэмжлүүлэх зарлан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах бэлтгэлийг хангах</p> <p>6.Онцгой комисс, Онцгой байдлын газар, томилгоожсон албаны холбооны шуурхай ажиллагааны бэлэн байдлыг хангах</p>
<p><b>5.Мэргэжлийн хяналтын алба: /Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтэс /</b></p> <p>1.Газар хөдлөлтийн гамшгийн тухай зарлан мэдээлэл хүлээн авах бэлтгэлийг хангах, албаны төлөвлөгөөнд тодотгол хийх, гүйцэтгэх ажлын чиглэлээр хангагдах</p> <p>2.Баригдаж буй барилга байгууламж нь хууль тогтоомж, норм нормативын хэрэгжилтийг биелүүлж байгаад хяналт тавих</p> <p>3.Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудад ашиглагдаж байгаа цацрагийн үүсгүүр, химийн бодисын ашиглалт хадгалалтанд хяналт тавих</p> <p>4.Цахилгаан, дулааны шугам сүлжээний ашиглалтанд хяналт тавих</p>
<p><b>6.Эрчим хүчээр хангах алба: /"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК, Аймгийн цахилгаан түгээх сүлжээний ААН байгууллага/</b></p> <p>1.Газар хөдлөлтийн гамшгийн тухай зарлан мэдээлэл хүлээн авах бэлтгэлийг хангах</p> <p>2.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх</p> <p>3.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах</p> <p>4.Нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах</p> <p>5.Онцгой комисс, Онцгой байдлын газраас гүйцэтгэх ажлын үүрэг чиглэл авах бэлтгэлийг хангах</p>
<p><b>7.Замын хөдөлгөөн зохицуулах алба: /Нийслэлийн Замын цагдаагийн газар, Аймгийн Замын цагдаагийн алба/</b></p> <p>1.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх</p> <p>2.Бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангуулах</p> <p>3.Дайчилгаагаар гамшгийн голомтонд үүрэг гүйцэтгэх чадавхитай том оврын болон тусгай тоноглолтой тээврийн хэрэгслийн тооцоо судалгаа гаргах</p> <p>4.Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, тэмдэг тэмдэглэгээ, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах</p> <p>5.Замын цагдаагийн тусгай тоноглолтой автомашины бэлэн байдал, шатахуун тосолгооны материалын нөөцийг нэмэгдүүлэх</p> <p>6.Аймгийн авто замын маршрут, чиглэл, ачаалал зэргийг тооцож зурагт оруулах,</p> <p>7.Гамшгийн улмаас хаагдаж болзошгүй зам, гарцын судалгааг гаргаж зурагт оруулах</p>
<p><b>8.Мал эмнэлгийн алба: /Нийслэлийн Мал эмнэлгийн газар, Аймгийн Мал эмнэлгийн газар/</b></p> <p>1.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх</p> <p>2.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах</p> <p>3. Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн бэлэн байдал, чадавхийг дээшлүүлэх</p> <p>4.Төлөвлөгөөт вакцинжуулалтыг хуваарийн дагуу хийх</p> <p>5.Ариутгал халдваргүйтгэлийн бодис уусмалын нөөцийг нэмэгдүүлэх</p> <p>6.Мал, амьтдын судалгаанд тодотгол хийх</p>
<p><b>9.Барилга инженерийн алба : /НХБЕТГ, Аймгийн Барилга захиалагчийн алба /</b></p> <p>1.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх</p> <p>2.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах</p> <p>3. Газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал, тооцоог үндэслэн шинээр баригдах барилга байгууламжинд газар олголт хийх, хяналт тавих</p> <p>4.Барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг тогтоох</p> <p>5.Барилгыг паспортжуулах</p> <p>6.Барилгын мэдээллийн сан бүрдүүлэх</p> <p>7.Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт хийх</p>

<b>10.Тээврийн алба: /Авто замын газар, Тээврийн компани /</b>
1.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх 2.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах 3.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд, тэдгээрийн хүчин чадлыг тооцож, судалгаа гаргах 4.Дайчилгаагаар гамшгийн голомтонд үүрэг гүйцэтгэх чадавхитай том оврын болон тусгай тоноглолтой тээврийн хэрэгслийн тооцоо судалгаа гаргах, тэдгээртэй гэрээ байгуулах
<b>11.Дулаанаар хангах алба: /“ Улаанбаатар Дулааны сүлжээ” ХК, Аймгийн дулаан хангамжийн ААН байгууллага/</b>
1.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх 2.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах 3. Аймгийн төвийн дулааны шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангах 4.Нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах 5.Болзошгүй гамшгийн үед дулааны шугам, тоног төхөөрөмжийг хамгаалах арга ажиллагаанд ажиллагсадыг сургах
<b>12.Орон сууцны алба: /Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар/</b>
1.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх 2.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах 3.Орон сууцны хорооллын хэрэглээний цэвэр ус, бохир, цахилгаан, дулааны шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангах 4.Нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах 5.Болзошгүй гамшгийн үед хэрэглээний цэвэр ус, бохир, цахилгаан дулааны шугам сүлжээний тоног төхөөрөмжийг хамгаалах арга ажиллагаанд ажиллагсадыг сургах
<b>13.Усаар хангах алба : /Ус сувгийн газар/</b>
1.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх 2.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах 3.Улаанбаатар хотын цэвэр усны станц, худгуудын найдвартай ажиллагааг хангах 4.Цэвэр усны станц, худгуудын харуул хамгаалалтыг сайжруулах 5.Ус тээвэрлэгч автомашинуудын бэлэн байдлыг дээшлүүлж, сэлбэг хэрэгсэл, шатахуун тосолгооны материалын нөөцийг нэмэгдүүлэх 6.Болзошгүй гамшгийн үед тоног төхөөрөмжийг хамгаалах арга ажиллагаанд ажиллагсадыг сургах
<b>14.Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэх алба: /Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль хамгаалах газар/</b>
1.Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх 2.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах 3.Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагуудад ашиглагдаж байгаа цацрагийн үүсгүүр, химийн бодисын тоо хэмжээ, нөөц, зориулалт зэргийг тодорхой тусгасан нарийвчилсан судалгаа гаргах 4.Цацрагийн үүсгүүр, химийн бодисын хор аюулын лавлагааг бодис тус бүр дээр гаргах 5.Цацрагийн үүсгүүр, химийн бодистой харьцдаг ажилтан албан хаагчдад аюулгүй ажиллагааг хангах, өөрийгөө хамгаалах мэдлэг дадлага эзэмшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах 6.Цацрагийн үүсгүүр, химийн бодистой харьцдаг ажилтан албан хаагчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангуулах арга хэмжээг зохион байгуулах 7.Цацрагийн үүсгүүр, химийн онцгой хортой болон хортой бодис уусмал алдагдсан үед түүнийг саармагжуулах арга хэмжээг авах лавлагааг боловсруулах
<b>15. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах алба: /Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Нийслэлийн Боловсролын газар/</b>
1.Нийслэлийн Боловсролын газар, Аймгийн боловсролын хэлтсээс ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид, сурагч, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд дараахь сургалтыг явуулах: -Орон тооны бус штабын бүрэлдэхүүнд “Удирдах бүрэлдэхүүний сургалт” -Томилгоожсон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд “Мэргэжлийн ангийн сургалт” -Сурагч, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд гамшгийн боловсрол олгох сургалт 2. Аливаа гамшгаас өөрийгөө хамгаалах, бусдад туслах мэдлэг дадал олгох дадлага сургуулийг багш, ажилчид, сурагч, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд явуулах.

1. Гамшгаас хамгаалах албадын чиг үүрэг
2. Онцгой байдлын байгууллагын чиг үүрэг:



3. Улаан загалмайн хорооны чиг үүрэг:
4. Сайн дурын бүлэг, хэсгийн чиг үүрэг:
5. Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн чиг үүрэг:
6. Иргэдийн чиг үүрэг гэх мэт

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **3.1. Барилга байгууламж, дэд бүтэц болон инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн гамшигт тэсвэртэй байдлыг дээшлүүлэх**

Барилга, байгууламж, дэд бүтэц болон инженерийн шугам сүлжээ, удирдлагын байрны газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ, газар хөдлөлтийн гамшигт тэсвэртэй байдлыг дээшлүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх, хариуцах байгууллагын талаар энэ хэсэгт дурдана.

#### **“Гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт ба үлдэгдэл эрсдэл”**

Монгол Улсын хувьд гамшгийн өмнөх эрсдэлийг бууруулах урьдчилсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгө дутмаг, төсөвт тусгуулахад хүндрэлтэй байдаг тул урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ төдийлөн хэрэгждэггүй гэсэн асуудал байдаг. Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт нь гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох болон урт хугацааны сэргээн босголтод зарцуулагдах хөрөнгийн хэмжээтэй харьцуулахад ач холбогдлын хувьд илүү үр дүнтэй байдаг гэдгийг ойлгож, юуны түрүүнд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгуулах ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Мөн, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангах явцад эрсдэл бүхий барилга байгууламж болон дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд “үлдэгдэл эрсдэл” гэсэн асуудал тулгардаг. “Үлдэгдэл эрсдэл” гэдэг нь эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлсэн хэдий ч тодорхой хэмжээнд орхигдож үлдэх эрсдэлийг хэлэх бөгөөд уг үлдэгдэл эрсдэлийг бууруулахад хөрөнгө оруулалт хийх явдал нь нэн чухал гэдгийг ойлгох шаардлагатай. Үр дүнтэй хөрөнгө оруулалт хийхийн тулд бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг зохистойгоор хосолсон хувилбарыг тодорхой болгож үүсч болзошгүй эдийн засгийн хохирол ихтэй салбарт нэн тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн, хэрэгжүүлэхэд цаг хугацаа ихээр зарцуулдаг бүтцийн арга хэмжээний хэрэгжүүлэх шат дарааллыг тодорхой болгож төлөвлөгөөнд тусгана.

#### **3.1.1. Газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах.**

Газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах нь газар хөдлөлтийн эрсдэл, хүний амь нас, эдийн засгийн хохирлыг бууруулах ач холбогдолтой бөгөөд барилга байгууламжийн бүтээц хийцийг хүчитгэх замаар тэсвэржилтийг хангана.

Иймд барилгын норм, дүрмийг хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийх, хийц бүтээцийг хүчитгэх арга хэмжээг тусгах талаар дурьдана. Барилгын тухай хуулийн 25.2 дугаар зүйлд зааснаар газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах барилгын байгууламжийн зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт магадлалын ажлыг гүйцэтгэж бүтээц, хийцийн даацын бат бэхийг сайжруулах, хүчитгэх арга хэмжээ авах талаар тусгах.

Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн

тэсвэрлэлтийн үнэлгээний хялбарчилсан ба нарийвчилсан үнэлгээ хийх, тэдгээрийг хүчитгэх, шинэчлэн барихад доорхи барилгын дүрмийн дагуу гүйцэтгэх талаар дурдах.

#### **Барилгын дүрэм**

- 1) Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал (БД);
- 2) Угсармал том хавтгаалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал (БД); ;
- 3) Тоосгон өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал (БД);
- 4) “Авто зам, гүүр, инженер хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал” (БД).

#### **3.1.2. Удирдлагын байрны газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах**

Гамшгийн үед онцгой комиссын үйл ажиллагааг хэвийн явуулах, удирдлагаар хангах, шуурхай штаб, бүлэг хүч хэрэгслийн харилцан ажиллагаа, зохицуулалтыг хангаж ажиллахын тулд Удирдлагын байрны газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах шаардлагатай. Үүний зэрэгцээ, холбоо, техник, хэрэгслийн найдвартай ажиллагааг хангах үүднээс газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хэрхэн хангах талаар дурдах.

#### **3.1.3. Хувийн болон олон нийтийн барилга байгууламжийн тэсвэржилтийг хангах**

Хувийн болон олон нийтийн барилга байгууламж, орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг үйлчилгээний байгууллагын газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийж хүчитгэх арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх. Газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдвэрлэх, эрсдэл бүхий барилга, байгууламжийн тэсвэржилтийг хангах арга хэмжээг ямар үе шаттай, хэрхэн хийж гүйцэтгэх, хяналт тавих асуудлыг ямар байгууллага хэрхэн зохион байгуулах талаар дурьдах.

#### **3.1.4. Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах**

Цэвэр, бохир усны шугам хоолойн байгууламж, эрчим хүчний байгууламж, телефон утасны байгууламж, хөдөлгөөнт холбооны байгууламж, нийтийн тээвэр, төмөр замын аюулгүй байдал болон газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах арга хэмжээг ямар байгууллага хэрхэн зохион байгуулах талаар дурдах. Тухайлбал:

Барилга инженерийн алба, эрчим хүчний алба, дулаанаар хангах алба, усаар хангах алба, орон сууцны алба, холбоо мэдээллийн алба, мэргэжлийн хяналтын алба, зам тээврийн албад газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дулааны шугам сүлжээний засварын алба нь дулааны шугам сүлжээнд засвар үйлчилгээ хийж, газар хөдлөлтийн үед эвдрэл гэмтлийг засварлаж босгох ажил гүйцэтгэх бэлэн байдлыг хангах, цэвэр, бохир усны засварын алба нь цэвэр, бохир усны сүлжээнд засвар үйлчилгээ хийж, эвдрэл, гэмтлийг таслан зогсоох, сэргээн босгох ажил гүйцэтгэх болон усны бохирдолтод шинжилгээ хийх, усны эх ундаргыг хамгаалах, шинээр худаг ус гаргах, усыг тээвэрлэн түгээх ажлыг зохион байгуулах бэлтгэлийг хангах, цахилгааны шугам сүлжээний засварын алба нь эрчим хүчний шугам сүлжээ, цахилгаан станцын засвар үйлчилгээ хийж, ослыг аваарыг таслан зогсоох, хойшлуулшгүй сэргээн босгох ажил гүйцэтгэх бэлтгэлийг хангах, Уст цэг хамгаалах алба нь уст цэг, усны эх үүсвэрийг хордолт, халдварлалтаас хамгаалах, ариутгал хийх, усны

хайгуул хийх, уст цэг гаргах, ус түгээх бэлтгэлийг хангах, холбоо, зарлан мэдээллийн алба нь холбоо, мэдээллийн системийн найдвартай ажиллагааг хангах холбооны шугамын гэмтлийг шуурхай засварлах бэлтгэлийг хангах талаар тус тус тусгах.

3.1.5. Шуурхай тээвэрлэлт хийх автозамыг тогтоох, зам болон замын байгууламжийг сэргээн засварлах бэлтгэл ажлыг хангах

Зам, гүүрийн засварын алба нь зам гүүрийн байгууламжид засвар үйлчилгээг чанартай явуулж газар хөдлөлтийн үед зам гүүрт гарц гаргах, түр гүүр тавих, засвар хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг зохион байгуулах бэлтгэлийг хангах талаар тусгах.

Гамшгийн үед шуурхай тээвэрлэлт зохион байгуулам зам, маршрутыг урьдчилан тогтоох, хот суурин газрын план зурагт үзүүлэх.

3.1.6. Гал түймэрт нэрвэгдэх болзошгүй барилга байгууламж, хүний хохирлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

Барилга байгууламжийн гал түймэрт өртөмтгий байдлыг бууруулах ажлыг авч хэрэгжүүлэх, гал түймрээс хамгаалах зурвас болон ногоон байгууламжийг байгууллагын орчинд бий болгох, аж ахуйн нэгж, байгууллагын орчны гудамж талбайд болон зам дагуу зүлэг мод шинээр суулгах, нэмэгдүүлэх талаар дурдах.

## **3.2. Хүч хэрэгсэл**

3.2.1. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах

Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурынханы хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргаж, бэлэн байдлыг хангуулах, үзлэг шалгалт зохион байгуулах талаар дурдана.

Тухайлбал, “Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги” нь сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үүрэг гүйцэтгэх, “Тусгай зориулалтын мэргэжлийн анги” нь гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж, байгууллагын даргын шийдвэрээр байгуулагдаж, тухайн алба, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгийн үед үүрэг гүйцэтгэх мэргэжлийн чиг үүрэг, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогтой уялдан хүн, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, цацраг, химийн хорт болон аюултай бодисын хордолтыг аюулгүй болгох, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, хүүхэд хамгаалал, гал түймэр унтраах, нийгмийн хэв журам сахиулах, холбоо мэдээлэл, цахилгаан дулаанаар хангах, тээвэр, хоол хүнсээр үйлчлэх, нэрвэгдсэн дэд бүтцийн байгууламжийг хойшлуулшгүй сэргээн босгох чиглэлээр үүрэг гүйцэтгэхээр тус тус байгуулсныг аймаг, сумын гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал үзлэг явуулах замаар тодотгож томилгоожуулна.

Ерөнхий болон тусгай зориулалттай мэргэжлийн ангийг Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн ангийн дүрэм”-д заасан бүтэц, орон тооны дагуу байгуулж, тодотголыг хийнэ.

3.2.2. Орон нутгийн дотоод нөөц боломж, чадавх

Одоогийн орон нутгийн нөөц боломж, чадавхын тухай дурьдах, мөн цаашид бүрдүүлэх шаардлагатай арга хэмжээг тусгах. Тухайлбал, аймаг, сумын хүч хэрэгсэл,

шатахуун, түр цугларах олон хорогдох байр, хүний нэн тэргүүний амьдралын хэрэгцээг хангах ус, хүнс, эд материалын нөөц боломж, эмнэлгийн хүлээн авах байр, эм тариа, эмнэлгийн материал, цус цусан бүтээгдэхүүн, холбоо, зарлан мэдээллийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлт хийх техник, тоног төхөөрөмж, хог хаягдал зайлуулах, зам, гарц гаргах техник хэрэгсэл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурынхны бэлэн байдал, чадавх, орон нутгийн төсөв санхүү, гамшгаас хамгаалах арга хэмжээнд төлөвлөсөн зардал зэргийг бэлэн байдлын үзлэг, шалгуур үзүүлэлтийг үндэслэн тодорхойлж дутуу байгаа нөөцийг хаанаас хэрхэн бүрдүүлэх талаар тусгах

### **3.3. Холбоо, зарлан мэдээлэл**

#### **3.3.1. Холбоо, зарлан мэдээллийн бэлэн байдал**

Холбоо, зарлан мэдээллийн бэлэн байдал, сүлжээ, газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем, мэдээллийн санг хэрхэн бүрдүүлэх талаар дурьдах. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журмыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт үүссэн болон үүсэж болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн үед гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн байгууллагуудад зарлан мэдээллийг хэрхэн дамжуулах талаар дурьдана.

3.3.2. Холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангах

Улс, нутгийн захиргааны байгууллага, цахилгаан холбооны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд нь мэдээлэл харилцааны барилга байгууламжийн гамшигт тэсвэртэй байдлыг хангаж, цахилгаан тасрахад бэлэн байдлыг хангах, мэдээлэл харилцааны барилга байгууламжид учирч болзошгүй аюулыг сарниулах, харилцаа холбооны сувгийг олшруулах, холбооны болон телевизийн кабелийг газар доогуур явуулах ажлыг эрчимжүүлэх, радио холбоо ашигласан харилцаа холбооны нөөц бий болгох, тоон системд оруулах ажлыг эрчимжүүлэх гэх зэрэг гамшгаас хамгаалах арга хэмжээг боловсронгуй болгохын хажуугаар гамшгийн үеийн харилцаа холбооны технологи болон давтамжийг үр дүнтэйгээр ашиглах технологийг судалж, хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

#### **3.3.3. Холбоо, зарлан мэдээллийн чадавхыг бэхжүүлэх**

Холбоо мэдээллийн алба нь гамшгийн үеийн харилцаа холбооны зохион байгуулалтыг бүрдүүлэх, радио холбооны сүлжээг өргөтгөн бэхжүүлэх, Аймаг сумын онцгой комисс, онцгой байдлын газар хэлтэс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангиудын хоорондоо найдвартай холбоогоор хангах зэргээр сүлжээ хоорондын уялдаа холбоог хангах. Мөн, үүрэн телефон, цахилгаан холбооны шугамыг гамшгийн үед ашиглах үүднээс багтаамж, хүчин чадлыг нэмэгдүүлэх. Гамшгийн үед ашиглах цахилгаан үүсгэх тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангахын зэрэгцээ засвар үйлчилгээ явуулах, ажиллуулах горимыг сайтар эзэмших, мэргэжлийн мэдлэг болон технологийн дагуу газар хөдлөлтөд тэсвэртэй бөгөөд ус нэвтрэх аюул багатай бат бөх бөгөөд найдвартай газар (газар хөдлөлтийн гамшгийн үед чичирхийллийн тэсвэржилттэй болон салхи усны гамшгийн үед усанд автах аюул багатай газар) суурилуулах.

Холбоо мэдээллийн алба нь нутгийн захиргааны байгууллага, албаны харилцаа

холбооны тоног төхөөрөмж гамшигт нэрвэгдэх цагийн байдлыг тооцож үндсэн тоног төхөөрөмжийн байршлыг тараан зохион байгуулах, яаралтай засвар үйлчилгээний тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, харилцаа холбооны ачаалал нэмэгдсэн үеийн арга хэмжээг хэрэгжүүлэх зэргээр цахилгаан холбооны тоног төхөөрөмжийн аюулгүй бөгөөд найдвартай байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг тусгах.

#### 3.3.4. Газар хөдлөлтийн гамшгийн аюулын мэдээ, мэдээллийг хүргэх

Онцгой комисс, онцгой байдлын газар хэлтэс, гамшгаас хамгаалах холбоо мэдээллийн албыг түшиглэн гамшгийн мэдээ, мэдээллийг цуглуулах, гамшгийн цагийн байдлыг үнэлэх арга хэмжээ авна.

Гамшгийн орон зайн мэдээллийн систем (ГОЗМС) болон телевиз, радио, сошиал сүлжээ гэх зэрэг мэдээллийн хэрэгслийг ашиглан гамшгийн мэдээ, мэдээллийг орон нутгийн төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, албан хаагчид, иргэд, олон нийт, сайн дурынханд хүргэх, тэдний мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар дурьдана. Тухайлбал, ГОЗМС-ийг аймаг, нийслэл, улсын хэмжээнд болон Азид цахим мэдээллийн системээр дамжуулан олж авсан гамшгийн мэдээллийг гамшгаас хамгаалах төлөвлөлтэд ашиглана.

#### **Гамшгийн орон зайн мэдээллийн систем**

ГОЗМС-ийн мэдээллийн сангаас хэрэглэгч нь богино хугацаанд гамшгийн талаархи товч болон гол мэдээллийг олж авах, тухайн бүсэд тохиолдсон төрөл бүрийн байгалийн гамшгийн нөлөөллийн талаар суурь ойлголт өгөх, график, хүснэгтэд гамшгийн ангилал, шинж чанар, цаг хугацаа, орон зайн байршлыг харуулсан мэдээллийг боловсруулдаг.

### **3.4. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ**

#### 3.4.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоо

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар дурьдах Тухайлбал: нэгдсэн эмнэлэг, эмнэлэг, эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх, гэмтэж бэртсэн хүний тоо ихээр нэмэгдсэн тохиолдолд түргэн тусламжийн тээвэрлэлт саатах буюу бусад болзошгүй хүндрэл бэрхшээлийг тооцоолж, эмнэлгийн яаралтай тусламжид шаардлагатай эм бэлдмэл, эмнэлэгийн тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх талаар дурьдах. Мөн гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн бодит байдалд зохицсон гамшгийн үеийн түшиц эмнэлгийг сонгох зэрэг гамшгийн үеийн эмнэлэгийн түргэн тусламжийн тогтолцоог байгуулахад анхаарна. Гамшгийн үеийн түшиц эмнэлэгт тээврийн хэрэгслэл, хоол хүнс, ундны цэвэр ус, эм бэлдмэл, нөөц цахилгаан тэжээлийн түлш зэргийг нөөцөлж бэлэн байдлыг хангах талаар тусгана.

Эрүүл мэндийн албанаас бусад гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, улаан загалмайн нийгэмлэгийн харилцан ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, гамшгийн үед шуурхай томилон ажиллуулах гамшгийн үеийн эмнэлгийн тусламжийн баг, эмч, сувилагчид, эмнэлгийн анхны тусламжийн нөхөрлөлийг сургаж бэлтгэнэ.

Онцгой комисс болон нутгийн засаг захиргааны байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн бодит нөхцөл байдалд нийцүүлэн аймаг, сум дундын нөөц эмнэлэг рүү

гэмтэж бэртсэн хүмүүсийг зөөн тээвэрлэх боломжийг урьдчилан тооцох талаар тусгана.

### 3.4.2. Эм тариа, эмнэлгийн материал, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний хангамж

Эм тариа, эмнэлгийн материал, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний хангамжийн тогтолцоог хэрхэн бий болгох. Тухайлбал, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулах эм, эмийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг орон нутгийн хэмжээнд бүрдүүлэх болон газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод шаардлагатай эм, эмийн хэрэгслийн хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, газар хөдлөлтийн голомтод эмнэлгийн анхны болон эмчийн тусламж үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах эм, эмийн хэрэгслийн 24-72 цаг, 7 хоног, нэг сарын хэрэгцээг эм хангамжийн байгууллагуудад захиалга өгөх;

Эм, эмийн хэрэгсэл дутагдах бүс, нутаг дэвсгэрийг тодорхойлж тухайн хот суурин газар, орон нутаг дахь эмийн нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, эсвэл бусад хот, орон нутгаас татаж нийлүүлэх арга хэмжээ авах, газар хөдлөлтийн гамшгийн үед эм хангамжийн байгууллага, эмийн сангуудын бөөний болон жижиглэн худалдах үйчилгээг тодорхой хугацаагаар хязгаарлах талаар тусгах ; түр цугларах байр, түр хорогдох байр, түр орон сууцад эмнэлгийн анхны болон эмчийн тусламж үзүүлэх арга хэмжээнд шаардагдах эм, эмийн хэрэгслийн хэрэгцээг тооцож гаргах; газар хөдлөлтийн гамшгийн үед эрэн хайх, аврах ажиллагааг явуулах томилгоот шуурхай бүлэг, ерөнхий болон тусгай зориулалттай мэргэжлийн анги, бусад хүч хэрэгсэл, бие бүрэлдэхүүний эмнэлгийн хангалтын эм, эмийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах талаар тусгах;

### 3.4.3. Эрүүл ахуйн халдвар эсэргүүцэх арга хэмжээний зохион байгуулалт

Гоц халдварт өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн халдвар эсэргүүцэх арга хэмжээний зохион байгуулалтыг хэрхэн бий болгох талаар дурдах.

Тухайлбал, газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод гоц халдварт өвчин гарч тархахаас урьдчилан сэргийлж тандалт, судалгаа, ажиглалт, үнэлгээ хийх, бэлэн байдлыг хангах, халдварын эсрэг эм, оношлуур, багаж хэрэгсэл, вакцин, ариутгал, халдваргүйжүүлэлт бодис, хамгаалах хэрэгсэл, орны нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах талаар тусгах. Гоц халдварт өвчний үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, түргэн тусламжийн машин, эмчийн тоог нэмэгдүүлэх өвчинг тусгаарлан эмчлэх, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжийг бэлэн байлгах тусгах

## 3.5. Гамшгаас хамгаалах арга хэмжээ

### 3.5.1. Гал түймэртэй тэмцэх тогтолцоо

Гал түймэртэй тэмцэх тогтолцоо бүрдүүлэх, гал унтраах зориулалтын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, усны эх үүсвэр, хангамжийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар дурьдах. Тухайлбал, Гал унтраах ангийн болон сайн дурын бүлэг хэсгийг хэрхэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллах, гал түймрийн голомтод гал түймэр унтраах ажиллагааг хэрхэн шуурхай удирдлага зохион байгуулалтаар хангах, усны эх

үүсвэрүүдийг тодорхойлох, хүч хэрэгслийг хэрхэн хуваарилах, түймэр унтраах бие бүрэлдэхүүнийг хүргэх, сэлгэн байршуулах, нэмэлт ус зөөврийн автомашин, шаардлагатай техник, багаж хэрэгсэл, бусад хангалтыг хэрхэн бүрдүүлэх талаар тусгах.

### 3.5.2. Хог хаягдалыг цэвэрлэх арга хэмжээний зохион байгуулалт

Хог хаягдал, ялгадас цэвэрлэх арга хэмжээний зохион байгуулалтыг хангах талаар тусгах. Тухайлбал, Онцгой комисс нь гамшгийн улмаас бий болсон хог хаягдлын төрөл ба шинж чанарыг (шавхай, лаг, бохирдуулагч бодис гэх мэт) харгалзан хог хаягдлын нийт хэмжээг таамаглан тооцоолсоны үндсэн дээр урьдчилан боловсруулсан хог хаягдлын төлөвлөгөө боловсруулж хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, хаях, булах арга хэмжээ авах талаар тусгах. Эвдэрч, гэмтсэн байшинг буулгах ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгох, гамшгийн хог хаягдлыг зайлуулахдаа байгаль орчны бохирдлоос сэргийлэх, эрүүл ахуйн шаардлагыг хангах талаар тусгана.

### 3.5.3. Нөөц бүрдүүлэлт

Цэвэр ус, хоол хүнс, эм, эмийн хэрэгсэл, шатахуун, нэн шаардлагатай эд материалын нөөц бүрдүүлэлт, нөхөн хангалтыг сайжруулах чиглэлээр зохион байгуулах арга хэмжээний талаар тусгах. Тухайлбал, Онцгой байдлын газрын нөөцийн салбарт газар хөдлөлтийн гамшгийн үед хүнсний болон нийтийн хоолны үйлдвэр үйлчилгээ байгууллагуудын үйл ажиллагаа зогссон тохиолдолд хүнсний хангамжийн байгууллагуудын агуулахуудын ундны цэвэр ус, хуурай хоол, хүнсний нөөц, нэмэлт хангалт хийх боломжтой хугацааг тодорхойлж хангалт хийх, хөнөөлийн голомтод шаардлагатай ундны цэвэр ус, хуурай хоол хүнсний хангалт, тээвэрлэлтийн шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх талаар тусгах.

Түр цугларах талбай, түр хорогдох байр, түр орон сууцын ойролцоо байрлах хувийн хэвшлийн хүнсний хангамжийн байгууллага, борлуулагч хүнсний дэлгүүр, нийтийн хоол, түргэн хоолны сүлжээний компаниудын агуулахын байршил, хүнсний нөөцийн хэмжээ болон бусад шаардагдах мэдээллээр хангах, газар хөдлөлтийн гамшгийн үед хамтран ажиллах хувийн хэвшлийн хүнсний хангамжийн байгууллага, борлуулагч хүнсний дэлгүүр, нийтийн хоол, түргэн хоолны сүлжээний компаниудын жагсаалт гаргаж гэрээ, санамж бичиг байгуулах талаар тусгах.

### 3.5.4. Усан хангамжийн тогтолцоо

Усан хангамжийн тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар дурьдах. Тухайлбал: газар хөдлөлтийн үед цэвэр усны шугам сүлжээнд эвдрэл гарсны улмаас гэр орондоо ундны болон ахуйн хэрэглээний уснаас гачигдаж буй хүмүүсийн тоо, усны хэрэгцээний талаарх мэдээллийг Ус сувгийн удирдах газар, орон сууц, нийтийн аж ахуйн алба болон зөөврийн ус тээвэрлэх шуурхай бүлэгт гаргаж өгөх;

Хээрийн эмнэлэг болон эмчийн тусламж, эмнэлгээний яаралтай тусламжийн цэгүүдийн усны хэрэгцээг тогтоож шуурхай хангах арга хэмжээг төлөвлөж болон зөөврийн ус тээвэрлэх шуурхай бүлэг байгуулах арга хэмжээ авах;

Ундны болон ахуйн хэрэгцээний ус нөөцлөх цэгүүдийн байршлыг тогтоох, цэвэр

усны шугам сүлжээг сэргээн засварлаж дуустал дутагдаж буй усыг худаг, байгалийн ус (гол, горхи, тогтсон ус) цөөрмийн ус, ус нөөцлөх торх, галд тэсвэртэй ус нөөцлөх торхны усыг шүүж цэвэрлэн ариутгах замаар нөхөх арга хэмжээг шуурхай зохион байгуулах талаар тусгах, усны машин, ус шүрших машин, галын машиныг холбогдох байгууллагуудаас дайчилж газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн тухайлбал, түр хорогдох байр, түр орон сууцад шилжин ирэгсэд, орон сууцны болон гэр хорооллын хүн амд ус түгээх арга хэмжээг шуурхай зохион байгуулах талаар тусгах; м

Мөн газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн хүн амын өрхийн хэрэглээний усыг оршин суугчдын ойролцоох гүний худгийн усаар хангах арга хэмжээг зохион байгуулах, гамшигт нэрвэгдсэн хүн амд өрхийн хэрэгцээний усыг нөөцлөхөд ашиглагдах усны сав, хувин, канестр, ёмкость, торх түгээх ажлыг хувийн хэвшлийн болон сүлжээний дэлгүүрүүдтэй хамтран зохион байгуулах, цэвэр усны шугам хоолойн эвдрэл гэмтлийг шуурхай засварлаж хэвийн байдалд оруулахад шаардагдах хүн хүч, техник хэрэгсэл, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж, ариутгал, цэвэрлэгээний материалын захиалгыг аймгийн Онцгой комисст өгөх талаар тусгах.

### 3.5.5. Нүүлгэн шилжүүлэх, түр хорогдох байр

Засаг даргын захирамжаар нүүлгэн шилжүүлэх, түр хорогдох байр томилгоожуулах, түр хорогдох байрын бэлэн байдлыг хангах талаар тусгах.

Нүүлгэн шилжүүлэх, түр хорогдох байрыг бэлтгэх, байршлыг тогтоох ажлын зохион байгуулалтын талаар дурьдах.

Нүүлгэн шилжүүлэлтийн цугларах байр нь нүүн шилжих хүн амыг цугларуулах, бүртгэх, явах цуваа, цувраа зохион байгуулах, тээврийн хэрэгсэлд хүмүүсийг суулгах, аюулгүй газар руу явуулах үүрэгтэйгээр байгуулагдана.

Нүүн шилжиж ирэгсдийг байрлуулах газарт тавигдах үндсэн шаардлага:

- гамшгийн хүчин зүйлээс аюулгүй байдалд байлгах нөхцөлөөр хангах;
- хүмүүсийн амрах амьдралын эн тэргүүний хэрэгцээг хангах;
- эмнэлэг ариун цэвэр халдвар эсэргүүцэх шаардлагад тохирсон байх зэрэг болно.

Эдгээр шаардлагын дагуу сургууль, үйлдвэр, албан байгууллагад байрлах газрыг урьдчилан оноож өгөх бөгөөд шаардлагатай бол тэр газарт орон нутгийн хэд хэдэн суурин газрыг оногдуулж болно.

Нүүн шилжиж ирэгсдийг түр байрлуулахад ахуйн болон албан байгууллагын байр, клуб, амралт, сувилалын газар, жуулчны бааз мэтийг ашиглаж болно.

Хүмүүсийг байрлуулах байр сууц дутагдвал ердийн газар гэр барьж байгуулж болох бөгөөд үүний тулд урьдаас барих газар материалын боломжийг судлаж энэ ажлыг эхлэн гүйцэтгэх байгууллагыг тогтоох нь зүйтэй.

Зуны улиралд хүмүүсийг гэр асар майханд түр суулгаж болно. Нүүн шилжиж очих хүн амыг байрлуулах газар суулгах байр явах зам чиглэлийг тухайн нутагт байрлаж буй цэргийн хотхон анги байгууллагын удирдлагатай тохиролцсон байвал зохино.

## 3.6. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа

### 3.6.1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах дадлага сургууль

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль, таниулан сурталчлах үйл ажиллагааг ямар байгууллага хэрэгжүүлэх, хэрхэн зохион байгуулах талаар дурдана.



ГХТХ-ийн 13.2-т заасны дагуу холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцаж явуулах талаар дурдана.

- оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалтыг БСШУС-ын Сайдын А181 тоот тушаалаар баталсан “Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр”-ийн дагуу тухайн шатны боловсролын байгууллага;

- хуулийн этгээдийн ажилтны сургалтыг тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан.

Мөн төлөвлөгөөнд Гамшгаас хамгаалах иж бүрэн болон удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн (тусгай чиг үүргийн томилгоот бүлэг) ангийн сургалт бэлтгэлийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/331 тоот тушаалын хавсралт “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар”-ын дагуу зохион байгуулах талаар тусгах

3.6.2. Сурагч болон сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалт

Сургуулийн сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтыг “Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр”-т үндэслэн, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад, гамшиг, ослыг хохирол багатай даван туулах чадварыг бэхжүүлэх зорилгоор онцгой байдлын байгууллага, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид, бусад байгууллагууд, олон нийтийн оролцоотэй хэрэгжүүлэхээр төлөвлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны сурагч болон сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдүүдэд газар хөдлөлтийн гамшгийн үед бэлэн байдлыг хангах дадлага сургалтыг хэрхэн зохион байгуулах талаар дурьдах. “Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр”-ийн дагуу газар хөдлөлтийн аюулын үед бага боловсролын сургуулийн сурагчдын мэдвэл зохих агуулгаар сургалтыг төлөвлөж зохион байгуулна. Үүнд:

a. Газар хөдлөлтийг төсөөлөх, авах арга хэмжээний тухай бодох (унаж, нурж, гулсаж ирэхгүй газар хорогдох, ширээн доогуур орох, зарлан мэдээллийг сонсох, багшийн зааврыг дагах гэх мэт)

b. Газар хөдлөлт анги танхимаас гадуур /коридор, шатан дээр, бие засах газарт, биеийн тамирын талбай, номын санд гэх мэт / байх үед авах арга хэмжээний талаар эргэцүүлэн хэлэлцэх

c. Гэртээ байгаа эд зүйлс, тэдгээрийн байршил, гэрийн аюултай, аюулгүй газар (даацын хана гэх мэт), аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар эцэг эхтэйгээ ярилцах

d. Эцэг эхтэйгээ гэрийн ойролцоох газруудыг судлах (байшин барилга?нурах, гал түймэр гарах, дэлбэрэх, бусад аюултай газрууд, хорогдох байр, цугларах талбай, уулзах газар, явах замын талаар ярилцах, төлөвлөх)

e. Газар хөдлөлтийн үед баримтлах дэг журмыг мэдэх (10 алхам: төлөвлөх, аюулаа тодорхойлох гэх мэт)

f. Гамшгийн үеийн зарлан мэдээллийн дохиог ялган таних, дохио дуугарсан үед насанд хүрэгчдийн заавар, дүрмийн дагуу ажиллах

### 3.6.3. ААН байгууллага, иргэдийн гамшгаас хамгаалах боловсролын арга хэмжээ

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гамшгаас хамгаалах сайн дурынхан, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хэрхэн хангах, тэдгээрийн гүйцэтгэх чиг үүргийг дурдана.

Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухайд, иргэд, хуулийн этгээдэд чиглэсэн гамшгаас хамгаалах сургалт, сурталчлан таниулах үйл ажиллагааг тухайн төвийн сургалтын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүнд үндэслэн хэрэгжүүлэх талаар дурдах.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ХОР УРШГИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэ бүлэгт газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай удирдлага зохицуулалт, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

### **4.1. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай удирдлага зохицуулалт**

#### 4.1.1. Удирдлага зохион байгуулалт

Онцгой комисс, онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг дуудах бүдүүвч, шуурхай штаб байгуулах, хохирлыг үнэлэх, ГОЗМС-ийг ашиглан гамшгийн мэдээлэл, гамшгийн шуурхай удирдлагын мэдээллийг хүргэх зэрэг эхний ээлжинд авч хэрэгжүүлэх арга хэмжээг дурьдах.

Онцгой комиссын ажлын хэсэг, Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн газар хөдлөлтийн гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт, удирдах бүрэлдэхүүний авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дурдаж, голлох байгууллагуудын үүргийг дурдах.

#### 4.1.2. Онцгой комисс

Онцгой комиссын дарга тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдал зарлаж газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор онцгой комиссыг хуралдуулж онцгой комиссын гишүүд, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, албан байгууллага, дүүрэг, сум, багийн засаг дарга нарт холбогдох үүргийг өгөх.

Онцгой комиссоос газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж, удирдлага зохицуулалтаар хангах үүрэг бүхий салбар комисс, шуурхай бүлэг байгуулж ажиллана. Шуурхай бүлгийн дарга нь газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах удирдах бүрэлдэхүүн, аврах анги, салбар, мэргэжлийн албад, анги, бүлгийн нийт бие бүрэлдэхүүнд аврах, хор уршгийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг тодотгож, хариу арга хэмжээний үндсэн чиглэлийг боловсруулах, харилцан ажиллагааны зохицуулалтыг хангах талаар үүрэг өгөх.

Онцгой комиссын дарга нь газар хөдлөлтийн гамшгийн голомтод шуурхай бүлэг

чиглэл хариуцсан албадын мэргэжилтнүүдийг илгээж үүссэн цагийн байдлыг судалж мэдээлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээ авах.

Шуурхай бүлэг болон чиглэл хариуцсан албадын мэргэжилтнүүд газар хөдлөлтийн гамшгийн голомтод үүссэн цагийн байдал, хариу арга хэмжээний явц байдлын талаар онцгой комиссын хуралдаанд танилцуулж шийдвэр гаргуулах.

Шуурхай бүлэг газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагатай холбоо тогтоож, харилцан ажиллагааны зохицуулалт хийж онцгой комисс болон салбар комисс, шуурхай бүлгээс гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.

Шуурхай бүлэг, чиглэл хариуцсан албадын мэргэжилтнүүд газар хөдлөлтийн цагийн байдлын талаар дээд удирдлагад байнга мэдээлж гал түймэр унтраах, эрэн хайх, аврах, эмнэлгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангаж ажиллах.

Шуурхай бүлгийн дарга нь үүссэн цагийн байдал, газар хөдлөлтэд нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн удирдлагатай зөвшилцсөний үндсэн дээр төвөөс болон зэргэлдээ аймаг орон нутгаас, эсвэл ойролцоо байрлах Зэвсэгт хүчний болон тусгай чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллагуудын анги салбаруудаас нэмэлт хүч хэрэгслийн дэмжлэг авах талаар онцгой комисст илтгэх.

Мөн Онцгой комисс гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг гамшгийн голомтод томилж үүрэг гүйцэтгүүлэх, эрэн хайх, аврах, анхны тусламж үзүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гамшгийн цагийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар дээд шатны байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад илтгэх, тэднээс мэргэжлийн зөвлөгөө зааварчилгаа тусламж авах, гамшгийн голомтод хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын бүс тогтоож аврах үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог хангах, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа хүч хэрэгслийн харилцан ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хяналт тавих, голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний болон нэрвэгдэгсдэд үзүүлэх бүх төрлийн хангалтыг зохион байгуулах. Гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын хүч хэрэгслийг харилцан ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу үүрэг гүйцэтгүүлэх, шаардагдах хүн, хүч хэрэгслийг орон нутгаас дайчлан гаргах, тэдгээрийн хангалтын асуудлыг зохион байгуулах, хариу ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хүч хэрэгслийн уядаа холбоо, үйл ажиллагааг зохион байгуулах шуурхай штаб (хээрийн штаб)-ыг байгуулах, хэрэв шаардлагатай бол гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах талаар тусгах.

#### 4.1.3. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн чиг үүрэг

##### 1. Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг:

<b>1.Эрүүл мэндийн алба: / Эрүүл мэндийн газар/</b>
---

- |   |
|---|
| 1.Газар хөдлөлтийн талаар сэрэмжлүүлэг дохио мэдээлэл хүргэх                |
| 2.Газар хөдлөлт болсон бүсээс хүн амыг нүүлгэн шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх  |
| 3.Нэрвэгдэгсдийг нурангинаас гаргах, эрэн хайх, албадуудтай хамтран ажиллах |
| 4.Нэрвэгсэгсдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, эмнэлэгт хүргэх      |

<p>5.Хүн хүч, машин техник хэрэгслийг бэлтгэж шаардлагатай материалыг тухайн газарт хүргэх</p> <p>6.Эм тариа, ороох боох материал, цус, цус орлох бүтээгдэхүүнээр хангах</p> <p>7.Эд материалын дэмжлэг үзүүлэх 8.Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх</p> <p>9.Онцгой байдлын газраас нэмэлт хүн, хүч, техник хэрэгсэл хүсэх</p> <p>10.Амь үрэгдсэн хүмүүсийг ялган тусгаарлаж, тусгай газар хүргэх</p>
<p><b>2.Хүнсээр хангах алба: / Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Хүнс, Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар/</b></p> <p>1.Гамшгийн голомтонд ажиллаж байгаа хүн хүч, нэрвэгдсэн иргэдийг хүнсээр хангах арга хэмжээг зохион байгуулах</p> <p>2.Гамшигт нэрвэгдсэн ард иргэдэд хүнс, дулаан хувцасны туслаж дэмжлэг үзүүлэх хөдөлгөөн өрнүүлэх</p> <p>3.Олон улсын тусламжаар ирсэн болон ард иргэдээс хуримтлуулсан тусламжийн хүнсний бараа материалыг гамшигт нэрвэгдэгсдэд түгээх арга хэмжээг зохион байгуулах</p> <p>4.Тухайн цагийн байдалд уялдуулан бусад арга хэмжээг хэрэгжүүлэх</p>
<p><b>3.Хэв журам сахиулах алба: / Нийслэлийн Цагдаагийн газар, Аймгийн Цагдаагийн хэлтэс/</b></p> <p>1.Гамшгийн тухай зарлан мэдээлэл дамжуулах</p> <p>2.Гамшгийн голомтонд хэв журам сахиулах, аврах ажиллагааг явуулах</p> <p>3.Гамшигт нэрвэгдсэн ард иргэдийн өмч хөрөнгийг хамгаалалтанд авах</p> <p>4.Газар хөдлөлтөнд нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн хэмжээг тогтоох, байшин барилгын эвдрэл, хүн, эд хөрөнгийн хохирлыг тогтоож, аврах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх</p>
<p><b>4.Холбоо зарлан мэдээллийн алба: /Нийслэлийн Мэдээлэл технологийн газар, Шуудан, Холбооны газар /</b></p> <p>1.Гамшгийн үеийн зарлан мэдээллийг эрт зарлан мэдээлэх техник хэрэгслээр явуулах</p> <p>2.Орон нутгийн холбоо зарлан мэдээллийн албатай харилцан ажиллагааг зохион байгуулна.</p> <p>3.Нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчилж байгаа холбооны байгууламж, радио нэвтрүүлгийн станцуудыг бэлэн байдалд шилжүүлэн цагийн байдлыг тогтмол шуурхай мэдээлж ажиллах</p> <p>4.Цагийн байдлыг зөв үнэлж бодит мэдээллээр ард иргэдийг хангана.</p> <p>5.Тухайн үед цагийн байдалд тохируулан нэмж төлөвлөх</p>
<p><b>5.Мэргэжлийн хяналтын алба: /Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтэс/</b></p> <p>1.Газар хөдлөлтийн тухай мэдээ мэдээллийг дамжуулах</p> <p>2.Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдлын талаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, гамшгаас хамгаалах штаб, албадын үйл ажиллагааны уялдааг зохицуулах</p> <p>3.Хор уршгийг арилгах арга хэмжээний зардлыг тооцох, шийдвэр гаргуулах захиран зарцуулах, удирдлагын байр болон түр орогнох байр эдгээрийг цэвэр усаар хангах ажилд хяналт тавих</p> <p>4.Дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах</p> <p>5.Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах, нүүлгэн шилжүүлэх, цэвэр ус, байраар хангах ажилд хяналт тавих</p> <p>6.Газар хөдлөлтийн гамшгийн голомт руу хяналтын баг томилж аюул, хохирлыг үнэлэх</p>
<p><b>6.Эрчим хүчээр хангах алба: /"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК, Аймгийн цахилгаан түгээх сүлжээний ААН байгууллага/</b></p> <p>1.Улсын онц чухал объект, Онцгой комиссын удирдлагын байр, эрүүл мэндийн байгууллагуудыг эрчим хүчээр тасралтгүй хангах арга хэмжээ авах</p> <p>2.Газар хөдлөлтөнд өртсөн цахилгаан шугам сүлжээг хэсэгчлэн сэргээн засварлах арга хэмжээг авах</p> <p>3.Удирдлагын байр, холбоо мэдээллийн хэрэгслийг бэлэн байдалд оруулж жижүүрлэлт томилох, мэдээ мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээж авах, дамжуулах</p> <p>4.Барилгын нуранги зайлуулах, зам гарц гаргах, аврах ажил явуулахад дэмжлэг үзүүлэх</p>
<p><b>7.Замын хөдөлгөөн зохицуулах алба : /Нийслэлийн Замын цагдаагийн газар, Аймгийн Замын цагдаагийн алба/</b></p> <p>1.Гамшгийн голомтонд замын хөдөлгөөн зохицуулах</p> <p>2.Хяналтын бүлэг томилж авто замын эвдрэл гэмтэл, авто замын хаагдсан /нурангинд дарагдсан гэх мэт/ хэсгүүдэд үнэлгээ хийлгэх</p> <p>3.Авто замын эвдэрсэн болон хаагдсан хэсгүүдийг тооцож хөдөлгөөний урсгал чиглэлийг өөрчилж замын хөдөлгөөн зохицуулах арга хэмжээ авах</p> <p>4.Аврах ажиллагаанд шаардлагатай том оврын болон тусгай тоноглолтой тээврийн хэрэгслийг дайчлах</p> <p>5.Нэрвэгдэгсдийг аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</p>
<p><b>8.Мал эмнэлгийн алба: / Нийслэлийн Мал эмнэлгийн газар, Аймгийн Мал эмнэлгийн газар /</b></p> <p>1.Зарлан мэдээлэх дохиог хүлээн авч мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд хүргэх</p> <p>2.Малчин айл өрх болон малын судалгаанд тодотгол хийж, Онцгой комисс, Онцгой байдлын газраас өгсөн үүрэг</p>

чиглэлийн дагуу ажиллах
<b>9. Барилга инженерийн алба : / НХБЕТГ, Аймгийн Барилга захиалагчийн алба /</b>
1.Нүүлгэн шилжүүлэх байршлыг тогтоох 2.Барилгын эвдрэлийн зэрэглэлийг тогтоох 3.Аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
<b>10. Авто замын алба: /Авто замын газар/</b>
1.Нүүлгэн шилжүүлэлт хийх үед шаардагдах техник хэрэгсэл, хүн хүчээр хангах 2.Хорио цээрийн эргүүл, пост ажиллуулах 3.Шаардлагатай техникийн дайчилгаа явуулах 4.Постоор орж гарч байгаа тээврийн хэрэгсэлд хяналт тавих 5.Бусад байгууллагуудтай харилцан ажиллагааг зохион байгуулж хүн хүч, техник хэрэгслээр дэмжлэг үзүүлж ажиллах
<b>11.Тээврийн алба: / Авто замын газар, Тээврийн компани /</b>
1.Аврах ажиллагаанд шаардлагатай том оврын болон тусгай тоноглолтой тээврийн хэрэгслийг дайчлах 2.Гамшгийн улмаас орон гэргүй болсон иргэдийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах 3.Нэрвэгдэгсдийг аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
<b>12.Дулаанаар хангах алба: /“Улаанбаатар Дулааны сүлжээ” ХК, Аймгийн дулаан хангамжийн ААН байгууллага /</b>
1.Алдагдсан уур, дулааныг эх үүсвэр дээр нь хаах арга хэмжээ авах 2.Газар хөдлөлтийн гамшгийн улмаас дулааны шугам сүлжээний эвдрэл гэмтлийг тодорруулахаар хяналтын бүлэг томилж ажиллуулах 3.Гэмтлийг засварлах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэсэгчилсэн байдлаар дулаанаар хангах арга хэмжээ авах
<b>13.Орон сууцны алба: / Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар /</b>
1.Алдагдсан хэрэглээний цэвэр ус, бохир, уур дулааныг эх үүсвэр дээр нь хаах арга хэмжээ авах 2.Хэрэглээний цэвэр ус, бохир, цахилгаан, дулааны шугам сүлжээний эвдрэл гэмтлийг тогтоохоор хяналтын бүлгийг томилж ажиллуулах 3.Гэмтлийг засварлах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэсэгчилсэн байдлаар дулаан, цахилгаан, хэрэглээний цэвэр усаар хангах арга хэмжээ авах
<b>14.Усаар хангах алба : / Ус сувгийн газар /</b>
1.Алдагдсан хэрэглээний цэвэр усыг, эх үүсвэр дээр нь хаах арга хэмжээ авах 2.Хэрэглээний цэвэр усны станц, худаг, шугам сүлжээнд гарсан эвдрэл гэмтлийг тогтоохоор хяналтын бүлгийг томилж ажиллуулах 3.Гэмтлийг засварлах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэсэгчилсэн байдлаар хэрэглээний цэвэр усаар хангах арга хэмжээ авах
<b>15.Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэх алба:/Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль хамгаалах газар/</b>
1.Цацрагийн үүсгүүр, химийн онцгой хортой болон хортой бодис уусмал алдагдсан бүс нутгийг хамгаалалтанд авч хязгаарлалтын дэглэм тогтоох 2.Бодис уусмалын хордолт, агаар дахь тархалт, салхины чиглэлийг тогтоох арга хэмжээ авах 3.Саармагжуулах 4.Аврах ажиллагаанд оролцож байгаа албан хаагчдыг найдвартай нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах 5.Хордолтын бүсэд оршин сууц байгаа ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах
<b>16.Сурталчилгаа, мэдээллийн алба:/Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс /</b>
1.Гамшигт нэрвэгдсэн иргэдэд сурталчилгаа, мэдээлэл хийх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх 2.Эцэг эх, асран хамгаалагчаасаа тусгаарлагдсан хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх 3.Сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдүүдийг сурах нөхцлөөр хангах талаар бололцоотой арга хэмжээ авах

## 2. Мэргэжлийн ангийн чиг үүрэг

Аймаг, Нийслэл, сум дүүрэг, ААН байгууллагын мэргэжлийн ангийн гүйцэтгэх чиг үүргийг дурдана. Тухайлбал:

Эмнэлгийн яаралтай тусламжийн мэргэжлийн анги - эмнэлэг, биологийн халдвар судлалын шинжилгээ хийх, гамшгийн голомтод эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, эмчлэн сувилах, халдвар эсэргүүцэх эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээг хэрэгжүүлэх.

Хээрийн эмнэлэг-гамшгийн голомтод эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, олон улсын хөл хориот өвчний дэгдэлт гарсан тохиолдолд халдварт өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах.

Цус сэлбэх хөдөлгөөнт мэргэжлийн анги-нэрвэгдэгсдийн цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээг хангах, нөөц бүрдүүлэх, тээвэрлэх, хүргэх ажлыг зохион байгуулах.

Хөдөлгөөнт эмийн сан-эмнэлгийн яаралтай тусламжийн бүлгийн бүрэлдэхүүнд орж, нэрвэгдэгсдийг шаардлагатай эм, тариа, ороох, боох материалаар хангах.

Эмнэлэг, эрүүл ахуй, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэжлийн анги- нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж, иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги - онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын асуудлаар бусад бүлгүүдтэй хамтран ажиллах, хүүхдийн эрхийн хамгаалалт үүсгэх, хямралт байдлын үед хүүхдэд ээлтэй орон зайг байгуулах, хүүхэд хамгааллын бусад асуудлаар үйл ажиллагаа зохион байгуулах.

Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах мэргэжлийн анги - Онцгой байдлын үе дэх өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран оролцох.

Гал унтраах мэргэжлийн анги-гамшгийн голомтод үүссэн объектын болон ой хээрийн түймрээс хүний амь нас, эд хөрөнгө, байгалийн баялагийг авран хамгаалах, гал түймрийг унтраах.

Дулааны шугам сүлжээний засварын мэргэжлийн анги-дулааны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтэл, ослыг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажил гүйцэтгэх.

Цэвэр, бохир усны засварын мэргэжлийн анги-усны бохирдолтод шинжилгээ хийх, усны эх ундаргыг хамгаалах, шинээр худаг ус гаргах, усыг тээвэрлэн түгээх, цэвэр, бохир усны сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг таслан зогсоох, засвар үйлчилгээ хийх, сэргээн босгох ажил гүйцэтгэх.

Цахилгааны шугам сүлжээний засварын мэргэжлийн анги - цахилгаан эрчим хүч, цахилгаан станцад гарсан ослыг таслан зогсоох, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажил гүйцэтгэх.

Зам, гүүрийн засварын мэргэжлийн анги - аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын улмаас нурсан, эвдэрсэн зам гүүрт гарц гаргах, түр гүүр тавих, засвар хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг зохион байгуулах.

Инженер, тэсэлгээний ажлын мэргэжлийн анги-зам гарц гаргах, нуранги зайлуулах, дэд бүтцийн барилга, байгууламжийг хамгаалах, аврах ажиллагаа зохион

байгуулахад учирч буй саадыг арилгах зорилгоор шаардлагатай үед их, бага хэмжээний тэсэлгээний ажлыг зохих журмын дагуу аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэх.

Хэв журам сахиулах, харуул хамгаалалтын мэргэжлийн анги - гамшгийн голомтод хэв журам сахиулах, хүн амыг нүүлгэн шилжүүлэх үед аюулгүй байдлыг хамгаалах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хорио цээрийн дэглэм сахиулах, улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах.

Цацраг, химийн хяналтын мэргэжлийн анги-техникийн холбогдолтой ослын голомтод цацраг, химийн хяналт явуулах, үнэлэлт өгөх, цацрагийн түвшингийн хэмжилт хийх, цацраг, химийн ослын голомтод аврах, саармагжуулах ба идэвхгүйжүүлэх, ариутгал цэвэрлэгээ хийх.

Ургамал, газар тариалан хамгаалах мэргэжлийн анги-таримал ургамлын өвчин, хортон шавьжтай тэмцэх.

Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн хөдөлгөөнт мэргэжлийн анги-халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг хийж онош тогтоох, тусгаарлах, хязгаарлалт, хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал халдваргүйжүүлэлт хийх,

Санхүү, нийгмийн хамгааллын мэргэжлийн анги-гамшгийн дараах үеийн хөрөнгө санхүү, төрийн үнэт зүйлсийг хамгаалах, аюулгүй газарт байршуулах, байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх, иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх.

Хүнсний хангалтын мэргэжлийн анги-гамшгийн голомтод ажиллаж байгаа шуурхай бүлэг, аврагч, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, нэрвэгдэгсдийг хоол, хүнсээр хангах.

Нөөцийн материал, орон сууцны хангалтын мэргэжлийн анги-гамшгийн дараах үед иргэдэд нөөцөөс төрөл бүрийн хангалтыг түгээх, хоргодох байр, гэр болон майхан, түр орон сууцаар хангах асуудлыг зохион байгуулах.

Уст цэг хамгаалах мэргэжлийн анги-уст цэг, усны эх үүсвэрийг хордолт, халдварлалтаас хамгаалах, ариутгал хийх, усны хайгуул хийх, уст цэг гаргах, ус түгээх.

Цугларах байрны мэргэжлийн анги-гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлсэн иргэдийг нэгтгэн зохион байгуулалтад оруулж, иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээг хангах (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж үзүүлэх, аюулгүй байдлыг хангах) арга хэмжээг зохион байгуулах.

Шатахуун хангалтын мэргэжлийн анги-гамшгийн голомтод ажиллаж байгаа авто машин, бусад техник хэрэгслийг шатахуунаар цэнэглэх, шатах тослох материалаар хангах, нөөц бүрдүүлэх.

Тээврийн мэргэжлийн анги - гамшигт нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшгийн голомтоос хүн ам, эд хөрөнгө, үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, шуурхай бүлэгт тээврийн үйлчилгээ үзүүлэх.

Ариутгал, халдваргүйжүүлэлтийн мэргэжлийн анги -цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомтод байсан хүн, техник хэрэгсэлд цэвэрлэгээ ариутгал, халдваргүйжүүлэх.

Холбоо, зарлан мэдээллийн мэргэжлийн анги -гамшгийн голомтод Онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах албад, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай холбоогоор хангах, холбооны шугамд үүссэн гэмтлийг засварлах, сэргээх, холбоо, мэдээллийн системийн найдвартай ажиллагааг хангах.

Сурталчилгаа, мэдээллийн мэргэжлийн анги-гамшгийн үед иргэдэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах, гамшгийн нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр хангах.

Иргэний бүртгэл, мэдээллийн мэргэжлийн анги-хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг тоолох, нэрвэгдэгсдийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд лавлагаа гаргаж өгөх.

Сайн дурын мэргэжлийн анги -аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажилд оролцох багуудын ажилд дэмжлэг үзүүлэх.

Төмөр замын техникийн засварын мэргэжлийн анги-төмөр замын ослоос урьдчилан сэргийлэх, өюулт үзэгдэлтохиолдсон үед аврах ажиллагаа зохион байгуулах, галт тэрэгний хөдөлгөөнийг сэргээх, мэргэжлийн бусад ажлуудыг гүйцэтгэх.

Нисэх буудлын авран туслах мэргэжлийн анги- агаарын хөлөг осолдох, гал гарах үед унтраах, гамшгийн үед онгоцны буудлын орчим дэглэм тогтоох үүрэг гүйцэтгэх.

### 3. Сайн дурын хэсгийн чиг үүрэг

Сайн дурын хэсгийн бие бүрэлдэхүүн нь мэргэшсэн багуудын хүчээр аврах ажиллагааны төрлүүдэд дэмжлэг үзүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэхэд оролцох, иргэдийн ахуйн нөхцөлд туслах, хүмүүсийг эрэн хайх, төөрөлдсөн гэр бүлийн гишүүд нэг нэгнийгээ олоход нь туслах, нүүлгэн шилжүүлэлтийн хүлээн авах төвүүдэд ажиллах, мөнгөн санхүүгийн болон эд материалын тусламж үзүүлэх, иргэдэд мэдээлэл, сурталчилгаа хийх, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхэд хамгаалах асуудлыг хяналтандаа авах зэрэг үйл ажиллагаанд оролцуулах талаар тусгах

#### 4.1.4. Гамшгаас хамгаалах дайчилгааг зохион байгуулах

Гамшгаас хамгаалах дайчилгааг ямар хүч хэрэгслээр хэрхэн зохион байгуулах талаар дурьдах. Тухайлбал, Гамшгаас хамгаалах дайчилгааг Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гамшгийн үеийн дайчилгаа зохион байгуулах журам”ын дагуу зохион байгуулах, гамшгаас хамгаалах дайчилгааг хоёр үе шаттай явуулах, эхний ээлжинд онцгой байдлын газар, хэлтсийн үндсэн хүч хэрэгсэл болох аврах анги, гал унтраах анги, улсын нөөцийн салбарууд, цэргийн анги, байгууллагуудыг өргөтгөн зохион байгуулах, нөхөн хангалт хийх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, цэргийн штабын хүчээр цэргийн хоёрдугаар үүрэгтэн буюу цэргийн насны цэргийн алба хаагаагүй иргэд, гамшгаас хамгаалах дүйцүүлэн алба хаасан иргэдийг дайчлах талаар тусгана.



Хэрэв газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулахад дээр дурьдсан үндсэн хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд дайлчилгааны хоёрдугаар ээлжийг зохион байгуулж гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг өргөтгөн зохион байгуулах, нөхөн хангалт хийх зорилгоор сайн дурын бүлэг, хэсгийн хүн техникийг дайчилна.

#### 4.1.5. Гамшгийн үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах ажлыг зохион байгуулах

Цагийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах, хүн амд мэдээлэл хүргэх асуудлыг тусгах.

Гамшиг болох үед юуны өмнө эрт зарлан мэдээлэх дохио дамжуулах, зэрэг гамшгаас сэргийлэх шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх бөгөөд гамшиг болсны дараахи ерөнхий мэдээлэл болон газар зүй, орон зайн мэдээлэл, бусад харилцаа холбооны хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэдээллийн систем ашиглан гамшгийн хохирлын хэмжээг яаралтай тодорхойлж цуглуулсан мэдээллийг дээд байгууллагад дамжуулж, гамшгийн дараах эхний 72 цагийг хугацаанд хүний амь нас аврах, эмнэлгийн түргэн тусламж бусад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, түймэр унтраах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа явц байдал, бусад үйл ажиллагаанд шаардлагатай хүн ба материалын нөөцийн нэн тэргүүнд хуваарилах талаар мэдээлнэ.

Онцгой комисс нь гамшиг болсны дараа хохирлын тухай мэдээлэл цуглуулж цагийн байдлыг мэдэхийн тулд нисэх онгоцноос ажиглалт хийх, зураг авах, дүрсэн мэдээллийг ашиглах, Онцгой байдлын газар хэлтэс, цагдаагийн хэлтэс 101, 102, 103 дугаарт ирж буй дуудлагын мэдээллийг ашиглана.

Онцгой комисс нь хүний амь насны хохирлын байдал (сураггүй алга бологсдыг оруулаад), барилга байгууламжийн хохирол, түймэр, хөрсний нуралтын гамшгийн байдлын мэдээллийг цуглуулахын хамт сураггүй алга бологсдын тоо бүртгэлд үндэслэн эрэл хайгуул, аврах үйл ажиллагааг явуулж байгаа талаар дээд байгууллагад мэдээлж шаардлагатай дэмжлэг тусламж авах талаар тусгана.

Нутгийн захиргааны байгууллагаас өөрийн харьяаны зам, харилцаа холбоо, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны инженерийн дэд бүтцийн эвдрэл гэмтлийн байдлыг тодорхойлохын хамт тэдгээрийг сэргээн босгож буй нөхцөл байдлын талаар дээд байгууллагад мэдээлнэ. Харилцаа холбоо тасарсан тохиолдолд мэдээлэл холбооны хэрэгслийн эвдрэл, гэмтлийг сэргээн засварлаж даруй холбоо холбоо тогтоох ялангуяа, алс бөглүү орон нутгийн харилцаа холбооны хэрэгслийн сэргээхэд онцгой анхаарал тавина. Шаардлагатай бол гар утас, сансарын холбоо, хөдөлгөөнт холбоог ашиглаж холбоо тогтооно.

#### 4.1.6. Холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, орон нутгийн онцлогт нийцүүлэн холбоо, зарлан мэдээллийг хэрхэн хүлээн авах, дамжуулах талаар дурьдах.

Тухайлбал, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс нь ОБЕГ–ын дэргэдэх Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс газар хөдлөлтийн амжиж анхааруулах зарлан мэдээллийг богино хугацаанд хүлээн авч хүн амд гамшгийн аюулын

тухай мэдээллийг текст, шууд яриа болон дуут дохиоллын хэлбэрээр олон нийтэд хүргэнэ.

Мөн зарлан мэдээллийг сансрын холбоо, хэт богино долгионы радио холбооны хэрэгслээр дамжуулан өргөн нэвтрүүлгийн төхөөрөмжийг тохируулан дуун нэвтрүүлгийг радиогоор, текст болон дүрст мэдээллийг телевизээр автомат болон гар ажиллагаатайгаар дамжуулах орон нутгийн телевиз FM радиогийн өргөн нэвтрүүлэг ашиглаж дамжуулна. Мөн орон нутгийн үүрэн холбооны сүлжээг ашиглаж мэдээлэл дамжуулах талаар тусгана.

#### 4.1.6. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах

Цагийн байдалтай уялдуулан хүмүүнлэгийн тусламжийг хүсэх, хүлээн авах, байршуулах, хуваарилах асуудлыг тусгах. Тухайлбал,

Онцгой комиссоос газар хөдлөлтийн гамшгийн үед нэрвэгдэгсдэд наад захын хэрэгцээний амин чухал бараа материал хүрэлцэхгүй тохиолдолд гамшгаас хамгаалах тухай хуулийн хүмүүнлэгийн тусламж хүсэх тухай заалтыг үндэслэн дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг Аймгийн онцгой комиссоор дээд байгууллагад уламжилна.

Хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, байршуулах, хувиарлах, түгээх ажиллагааг онцгой байдлын газар, хэлтсийн улсын нөөцийн салбарын албан хаагчид, шуурхай штабтай хамтран хүмүүнлэгийн тусламжийн баг байгуулж зохион байгуулна. Хүмүүнлэгийн тусламжийг Улсын нөөцийн анги салбарын агуулахаас болон нэмэлт цэгээс нүүлгэн шилжүүлэх цугларах байр, түр хорогдох байр, түр орон сууцанд хүрэлцэн ирсэн нэрвэгдэгсдэд, гэр оронгүй болсон хүмүүс, цахилгаан дулаан тасарснаас гэр орондоо хоол ундаас хийж чадахгүй хүмүүст хувиарлах талаар тусгана.

Онцгой байдлын газар, хэлтсийн улсын нөөцийн салбарын албан хаагчид, шуурхай штабтай хамтран иргэд, ААНБ-аас ирүүлсэн хандивийн барааны жагсаалт болон явуулах хаягийг тодорхойлж энэ тухай хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан ард иргэдэд мэдээлнэ. Тэрчлэн гамшгийн бүсийн эрэлт нийлүүлэлтийн байдлыг харгалзан уг жагсаалтыг байнга шинэчилж байх.

Иргэд болон ААНБ нь хандивийн бараа хүлээлгэн өгөхдөө гамшгийн бүсийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийг хичээн, барааны нэрийг тодорхой бичих зэргээр хайрцагийг нь хараад л оновчтой шуурхай ялган тээвэрлэх боломжтой байх шаардлагыг хангасан байх талаар иргэдэд мэдээлэх, Онцгой комисс болон шуурхай штаб хандивын мөнгийг цуглуулж, хуваарилах арга хэмжээ авна.

Тэрчлэн хохирлын хэмжээ нь олон нутаг дэвсгэрийн нэгж дамнасан өргөн хүрээний гамшгийн үед онцгой комисс төрийн бус байгууллага, сайн дурынханы дэмжлэгтэйгээр хандивын мөнгийг шуурхай хүлээн авч тодорхой шалгуурын дагуу хуваарилах ажлыг зохион байгуулах талаар тусгана.

#### 4.1.8. Гал түймэртэй тэмцэх ажлыг зохион байгуулах.

Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар дурьдах. Тухайлбал, газар хөдлөлтийн гамшгийн хөнөөлийн голомтод гал түймэр унтраах ажиллагаа гал түймэр унтраах дүрмийн дагуу зохион байгуулах талаар тусгах.

Газар хөдлөлтийн гамшгийн хөнөөлийн голомтод гал түймэр унтраах удирдагч нь гал түймэр унтраахаар хүрэлцэн ирсэн аврах, гал унтраах анги, хэсгийн хүн хүч, техник зэвсэглэмж бусад хүч хэрэгсэлийг удирдлагаар хангаж ажиллах бөгөөд гал унтраах үйл ажиллагааг зохион байгуулах, бие бүрэлдэхүүний аюулгүй байдал, техникийн бүрэн байдлыг хариуцна.

Гал түймрийн цагийн байдал, гаргасан шийдвэр, авсан арга хэмжээ, гал унтраах хүн хүч, хэрэгслийн хүрэлцээ, нэмэгдэл дуудлагаар ирсэн хүн хүч, хэрэгсэл, гал унтраах бодис, усан хангамжийн талаар танилцуулах, гал түймрийн байдалд үнэлгээ өгсөний үндсэн дээр шуурхай штабыг зохион байгуулж, байрлах газрыг тогтоон өгөх, гал унтраахад шаардагдах нөөц хүн хүч, хэрэгслийг бүрдүүлж удаан хугацаагаар ажилласан хүмүүст амрах, дулаацах, хуурай хувцас солих боломжоор хангах, аюулгүйн ажиллагааг хариуцсан албан тушаалтанг томилж, шаардлагатай гэж үзвэл эмнэлгийн яаралтай тусламжийг зохион байгуулах, гал түймэр унтраах үйл ажиллагаанд дайчлан оролцуулсан албадын хамтын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, орон нутгийн төр захиргааны байгууллага, объектын инженер техникийн ажилтнуудтай байнга холбоотой байх, түймрийг унтрааж дууссаны дараа дахин нарийн хайгуул шалгалт хийж хүлээлгэн өгөх талаар тусгах.

#### 4.1.9. Эрэн хайх, аврах ажлыг зохион байгуулах

Эрэн хайх, аврах, яаралтай тусламж үзүүлэх ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар дурдах, Тухайлбал, газар хөдлөлтийн гамшгийн хөнөөлийн голомтод тандалт, ашиглалт явуулж мэдээлэл цуглуулж цагийн байдлыг үнэлэх, эрэн хайх, аврах, гал унтраах бүлгүүдийн хөдөлгөөн үйлдэх зам маршрут дахь барилгын нурангийг цэвэрлэж зайлуулах, зам гарц гаргах, барилга, байгууламжийн нурах аюултай хийцүүдийг нураах буюу түр бэхлэх, ус, хий, цахилгаан, дулааны шугам, сүлжээний аваар, ослыг олж илрүүлэн таслан зогсоох, гал түймэр унтраах, нэрвэгдэгсдийг эрж олох, аврах, тэдэнд эмнэлгийн анхны тусламж үзүүлж оройлцоох эмнэлэгт яаралтай хүргэх, гэр оронгүй болсон хүмүүсийг газар хөдлөлтийн голомтийн бүсээс нүүлгэн шилжүүлэх, газар орон, гудамж талбай, зам гарцын бохирдолтыг арилгах, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авах талаар тусгана.

Нэрвэгдэгсдийг хайж олохын тулд аврах бүлэг хэсэг нуранги дундуур таран явж нуранги, эвдэрч гэмтсэн барилга, барилгын суурь хөндий, гадна цонх, шатны хөндий, доод давхарын хана, булангийн дотор, гадна, талын зай, замын байгууламж, суваг шуудуу зэрэг хүмүүс байж болох бусад газрыг нарийвчлан үзэж шалгана. Мөн нуранги зайлуулах, бэхэлгээ материалыг бэлтгэх, нурангийн хийц бүтээцийг зайлуулах ажлыг дэс дараатай гүйцэтгэх зэргийг тусгана.

Нурангиас нэрвэгдэгсдийг гаргахын тулд аврах ажиллагааны бүсийг тогтоож, техник хэрэгслийг байрлуулах, нуранги дахь бүх цахилгаан, дулааны эх үүсвэрийг таслах, аврах ажлын талбайн гэрэлтүүлэг болон агааржуулах хэрэгслийг байрлуулах, суваг хоолойнуудыг гаргах, том төмөр хийцүүдийг бутлах, таслах, бэхэлгээ хийх ажлыг зохион байгуулах талаар дурьдах

#### 4.1.10. Ар тал, хангалтыг зохион байгуулах

Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа хүч хэрэгсэл, эд материал, хүнсний хангалтыг хэрхэн зохион байгуулах талаар тусгана. Тухайлбал, аврах анги, салбар, гамшгаас хамгаалах албадын бие бүрэлдэхүүнийг хоол хүнс, эм тариа, шатах тослох, материалын нөөц, тэдгээрийн зарцуулах хэмжээг хангамж, тооцооны нэгжид үндэслэн бүрдүүлэх, нөхөн хангалтыг дараахи үе шаттайгаар тээвэрлэж гүйцэтгэх талаар тусгах.

1-р үе шат

- Аврах, түргэн тусламж үзүүлэх үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оролцож буй хүмүүс, эм хэрэгсэл зэрэг хүний амь нас аврахтай холбоотой хүн хүч, бараа материал
- Гал түймэр унтраах, үерийн эсрэг арга хэмжээ зэрэг хохиролын хэмжээ тэлэхээс сэргийлсэн үйл ажиллагаад шаардлагатай хүн хүч, бараа материал
- Холбоо, мэдээллийн технологи, цахилгаан, ус, цэвэр бохир усны шугам сүлжээний аюулгүй байдал хариуцсан ажилтнууд, зэрэг анхан шатны шуурхай арга хэмжээний бараа материал
- Ар талын эмнэлгийн байгууламж руу тээвэрлэх шархдагсад
- Шуурхай тээвэрлэлтийн байгууламж, тээврийн баазын шуурхай сэргээн босголт, тээврийн зохицуулалтад шаардлагатай хүн хүч, бараа материал

## 2-үе шат

- Дээрхи 1-ийн үргэлжлэл
- Хүнс, унданы ус зэрэг амь нас сахин хамгаалахад шаардлагатай бараа материал
- Шархдагсад болон гамшигт өртөгсдийг гамшгийн бүсээс тээвэрлэх
- Тээврийн байгууламжийн шуурхай сэргээн босголтод шаардлагатай хүн хүч, бараа материал

## 3-р үе шат

- Дээрхи 2-ын үргэлжлэл
- Гамшгийн сэргээн босголтод шаардлагатай хүн хүч, бараа материал
- өдөр тутмын хэрэглээний бараа

## **4.2. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах**

### 4.2.1. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг төлөвлөх

Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын талаар дурдах (нүүлгэн шилжүүлэх бүсийн утга, үндэслэлийг нь дурдах) Тухайлбал, нутаг дэвсгэрийн нэгжийн засаг захиргааны байгууллага хүн амыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний бичмэл хэсэгт дараах өгөгдөхүүнийг багтаана:

- нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх дараалал;
- орон нутгийн болон аж ахуйн нэгж байгууллагын удирдлага хүн амд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн тухай зарлан мэдээлэл явуулах дараалал;
- нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд хамрагдах хүн амын тоо;
- нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд хамрагдах хүн амыг байрлуулах байршил;
- нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд хамрагдах хүн амыг нүүлгэн гаргах журам дараалал зам маршрут;
- нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд хамрагдах хүн амыг хамгаалах арга хэмжээний зохион байгуулалт;
- нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд хамрагдах хүн амыг хүлээн авч байрлуулах, тэдгээрийг тэргүүн ээлжинд шаардлагатай зүйлээр хангах арга хэмжээний зохион

байгуулалт.

#### 4.2.2. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

Гамшгийн голомтоос иргэдийг түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх бүс, хоргодох байранд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар тусгана. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг Засгийн газрын 2011 оны 340-р тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх журмын дагуу зохион байгуулна. Тухайлбал:

Хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг нүүлгэн шилжүүлэх комисс зохион байгуулна. Нүүлгэн шилжүүлэх комисст дараах бүлгүүдийг томилж ажиллуулна. Бүлгийг орон тооны бус гамшгаас хамгаалах албадын дарга нар удирдах бөгөөд нэг бүлэгт 5-7 хүн байна:

- тээврийн бүлэг;
- эмнэлэг, эрүүл ахуй, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг;
- хоол хүнсний хангалтын бүлэг;
- шатахуун, нефтийн бүтээгдэхүүний хангалтын бүлэг;
- нөөцийн материал, орон сууцны хангалтын бүлэг;
- хэв журам сахиулах, зохицуулах бүлэг;
- холбоо, мэдээлэл, лавлагааны бүлэг;
- иргэний бүртгэл, мэдээллийн бүлэг;
- банк, санхүү, нийгмийн хамгааллын бүлэг;
- байгууллагын эд материалын үнэт болон түүх, соёл, урлагийн үнэт зүйл хамгаалах бүлэг орно.

Нүүлгэн шилжүүлэлтийг удирдан зохион байгуулах Засаг дарга нь дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах тусгай бүлгүүдийн удирдлагыг томилж, бүлгийн гүйцэтгэх үүргийг тодотгож, нүүлгэх ажиллагааг эхлүүлэх;

- төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд гамшгаас хамгаалах дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэр гарсан тухай зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх;

- гамшгийн нөхцөл байдлыг үнэлж, шийдвэр гаргахдаа гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах, нүүлгэн шилжүүлэх боломж нөхцөл, гамшгийн голомтын бүс нутаг, цар хүрээ, тархалтын байдал, ажиллах мэргэжлийн анги, хүч хэрэгслийн тооцоо, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, цугларах байр, цаг хугацааг тодорхой зааж өгөх;

- гамшгийн нөхцөл байдал, хамарсан нутаг дэвсгэр, тархаж болзошгүй чиглэл, үүсэж болзошгүй үр дагавар, гамшиг болсон нутгийн заагийг тогтоосон тухайгаа хөрш зэргэлдээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нарт нэн даруй мэдээлэх;

- нүүлгэн шилжүүлэлтийн үеийн хангалтын (хоол хүнс, ус, шатахуун г.м) зардлыг тухайн орон нутгийн төсвөөс гаргах;

- шилжиж ирсэн иргэдийг жагсаалтын дагуу бүртгэн байршуулах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тогтоон өгөх, байршуулж, нүүлгэн шилжүүлэх явцад хүн ам, эд хөрөнгө, мал, амьтны тоо, бүртгэлийн талаар гарсан өөрчлөлтийн мэдээг Улсын Онцгой комисст мэдээлэх;

- иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээг хангах (ундны ус, хоол хүнс, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах) бүх төрлийн хангалтыг зохион байгуулах;

- хүн ам, эд хөрөнгийг тээвэрлэн шилжүүлэх үеийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, эмх замбараагүй байдал гаргуулахгүй байх арга хэмжээг авах;

- нүүлгэн шилжүүлэлтэд шаардагдах орон нутгийн төсвөөс давсан зардлыг Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх.

Газар хөдлөлтийн бүсээс хүн амыг нүүлгэн шилжүүлэх ажлыг дараахи байдлаар зохион байгуулна. Үүнд:

- нүүлгэн шилжүүлэлтийн байгууллагуудыг бэлэн байдалд оруулж тэдгээрийн ажлын журмыг тодотгох;


- нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдах явган болон тээврийн хэрэгслээр гаргах хүмүүсийн тоог тодотгож, тээврийн хэрэгслэлд суулгах байруудад хуваарилах, явган цуваанд ажиллах тоотуудыг тодотгон зам чиглэлийг тогтоож өгөх;

- нүүлгэн шилжүүлэлтийн зам чиглэлийг бэлтгэж, замын заалт, тэмдгүүдийг байрлуулж амрах байруудыг бэлтгэх;

- цугларах байр, суулгах, буулгах байруудыг дэлгэн байгуулахад бэлтгэх;

- зарлан мэдээлэл, холбооны системийн бэлэн байдлыг шалгах;

- хамгаалах байгууламжуудыг бэлэн байдалд оруулах зэрэг ажил багтана.



Зураг 4. Нүүлгэн шилжүүлэх комиссын зохион байгуулалтын бүдүүвч

Нүүлгэн шилжүүлэх иргэдийн нэрсийн жагсаалтыг гурван хувь үйлдэж нэг хувийг объект буюу орон сууц ашиглалтын байгууллагад, хоёр дахь хувийг нүүлгэн шилжүүлэлтийг эхлэх тушаал авмагц цугларах байранд (оперативийн бүлэгт) хүргүүлж иргэдийн нүүлгэж гаргасны дараа тухайн нүүлгэн шилжүүлэлтийн комисст шилжүүлнэ. Гурав дахь хувийг хүмүүсийг гаргаж эхэлмэгц нүүн шилжигсдийн байрлах газарт байгаа хүлээн авах ажлыг хариуцаж байгаа байгууллагад хүргүүлнэ.

**4.2.3. Нүүлгэн шилжүүлэх болон түр хоргодох байрны ар тал, хангалтыг зохион байгуулах**

Нүүлгэн шилжүүлэх болон түр хоргодох байран дахь хүнс, материалын хангалтыг хэрхэн зохион байгуулах талаар дурьдах. Тухайлбал, гамшигт өртөгсдийн амьдралын нөхцлийг хангахад шаардлагатай хүнс, унданы ус, шатахуун, хөнжил зэрэг чухал хэрэгцээт барааг худалдан авч, хадгалах, хэрэгцээг нь харгалзан нийлүүлэх, хуваарилахын тулд холбогдох байгууллагууд нь тухайн нөөцийн бараа, материалын нийлүүлэлтийн талаар хамтран ажиллах хүчин чармайлт гаргахын хамт доор дурьдсан чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулна.

Нүүлгэн шилжүүлэх байршил болон түр хоргодох байранд шаардлагатай барааны хэрэгцээ нь цаг хугааны явцад өөрчлөгдөгийг бодолцон барааг тухайн цаг үеийн хэрэгцээнд нь тохируулан худалдан авахад анхаарна. Мөн зуны улиралд сэнс, өвлийн улиралд халаагуур, түлш гэх мэт гамшгийн бүсийн бодит байдал болон анхаарал тавих шаардлагатай хүмүүсийн хэрэгцээ, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн хэрэгцээний ялгаа зэргийг харгалзан худалдан авалт хийнэ.

Түр хоргодох байрны ашиглалтад эмэгтэйчүүдийн оролцоог хадгалахын хамт эрэгтэй ба эмэгтэй хүний хэрэгцээний ялгааг эрэгтэй эмэгтэй хүний аль алиных нь байр сууринаас анхааран авч үзнэ. Ялангуяа эмэгтэйчүүдийн зориулалттай юм хатаах газар, хувцас солих, хүүхэд хөхүүлэх өрөө гаргах, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэгсэл, дотор хувцасыг эмэгтэйчүүдээр түгээлгэх, эргүүл хийх, гэмт хэргээс хамгаалах дохиоллын товчлуур тараах замаар түр хоргодох байрны аюулгүй байдлыг хангах зэрэг эмэгтэйчүүд хүүхэд гэр бүлийн хэрэгцээг харгалзан үзсэн ашглалтын үйл ажиллагаа явуулна. Мөн гэртээ хоргодож буй хүмүүс, түр орон сууцны хэлбэрээр олгосон хувийн түрээсний орон сууцанд орсон нүүлгэн шилжүүлсэн иргэдэд нэгэн адил бараа, эд зүйлээр хангана.

**4.2.4. Хэв журам сахиулах арга хэмжээг зохион байгуулах**

Гамшгийн голомт, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний үед болон шаардлагатай бусад газарт хэв журам сахиулах арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар тусгах. Тухайлбал, Нийгмийн хэв журам сахиулах алба нь гамшгийн бүс ба түүний ойр хавьд бие дааж эсвэл гэмт хэргээс сэргийлэх сайн дурын байгууллагатай хамтран эргүүл хийж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой мэдээлэл түгээж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг нэн дарай авах, Тэрчлэн гамшгийн бүсээр үл хязгаарлан гамшгийг далимдуулсан гэмт хэргийг шалгах, хохирлоос сэргийлэх арга хэмжээ авахын хамт гамшгийн улмаас олширсон кибер халдлагын тухай мэдээлэл цуглуулах, ард түмэнд үнэн зөв мэдээлэл өгөх зэргээр нийгмийн тогтворгүй байдлыг намжаах арга хэмжээ авах талаар тусгах.

**4.3. Гамшгийн үед нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга**

## **ХЭМЖЭЭ**

### **4.3.1. Нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ**

Голомтын бүсэд нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээг хэрхэн зохион байгуулах, Тухайлбал, газар хөдлөлтийн гамшгийн хөнөөлийн голомтод нэрвэгдэгсдийг олж, тэдгээрийн биеийн байдал, тоог тогтоож, аюулгүй газар зөөж тээвэрлэх, зам гарцыг сонгох, эмнэлгийн анхны тусламжийн ажлын багтаамжийг тооцох, эмнэлгийн анхны болон эмнэлгийн тусламж үзүүлэх эмнэлэг дэлгэх газар, нэрвэгдэгсдийг цуглуулах газрын сонгож, ангилан ялгах ажлыг зохион байгуулах талаар тусгах, гамшгийн бүс, ялангуяа түр хоргодох байранд амьдралын орчны огцом өөрчлөлтөөс гамшигт өртөгсдийн бие сэтгэлийн байдал муудахаас сэргийлэх, байнга эрүүл ахуйн таатай нөхцөлийг хангах арга хэмжээ авахын хамт гамшигт өртөгсдийн эрүүл мэндийн байдлыг сайтар тодруулж, шаардлагатай бол асрах, тусламж үзүүлэх цэг байгуулж, сэтгэл санааны тусламжийг багтаасан арга хэмжээ авах, аххаарал тавих шаардлагатай хүмүүсийн бие сэтгэлийн байдалд онцгой анхаарал тавьж, шаардлагатай бол асрамжийн газарт оруулах, асрах ажилтан томилох, тэргэнцэр олгох зэрэг арга хэмжээнд халамжийн байгууллага, сайн дурын байгууллагын дэмжлэг авч, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн нэгжийн засаг захиргааны байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн эмч сувилагчийн тойрох үзлэг зохион байгуулж, зөвлөгөө өгүүлэх, түр хоргодох байрны амьдралын орчиныг хангах үүднээс шаардлагатай бол түр жорлон болон нүхэн жорлон зэргийг даруй байгуулахын хамт гамшгийн бүсийн эрүүл ахуйн нөхцөлийг хангахын тулд цэвэрлэгээ хийх, бохир зайлуулах, ахуйн хог цуглуулан зайлуулах талаар шаардлагатай арга хэмжээ авах.

### **4.3.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг зохион байгуулах**

Эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн, ороох, боох материалын хангалтыг хэрхэн зохион байгуулах талаар дурьдах

Тухайлбал, тухайн орон нутгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн эмнэлгүүд болон эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгийн болон газар хөдлөлтийн голомтод эмнэлгийн анхны болон эмчийн тусламж үзүүлэхэд шаардагдах эм, эмийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүнийг 24-72 цагийн хугацаанд эм хангамжийн байгууллагууд болон бөөний болон жижиглэн худалдах эмийн сангуудаас нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулах бөгөөд хэрэв эм, эмийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн дутагдах тохиолдол төвөөс болон зэргэлдээ нутаг дэвсгэрийн нэгжээс татаж авах арга хэмжээ авах талаар тусгана. Түүнчлэн газар хөдлөлтийн гамшгийн үед эрэн хайх, аврах ажиллагааг явуулах томилгоот шуурхай бүлэг, ерөнхий болон тусгай зориулалттай мэргэжлийн анги, бусад хүч хэрэгсэл, бие бүрэлдэхүүний эмнэлгийн хангалтын эм, эмийн хэрэгслээр хэрхэн тасралтгүй хангах талаар тусгах;

### **4.3.3. Түр хоргодох байрны эмнэлгийн тусламж үйлчилгээ**

Нүүлгэн шилжүүлэх болон түр хоргодох байранд эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн зохион байгуулах талаар тусгах. Тухайлбал, нүүлгэн шилжүүлэлтийн эмнэлгийн



хангалтыг төлөвлөх, нүүлгэн шилжүүлэлтийн эмнэлгийн хангалтыг зохион байгуулахад эмнэлгийн байгууллага, мэргэжлийн ангиудыг бэлтгэх, нүүлгэн шилжүүлэлтийн цугларах байр, зам, чиглэл, суулгах, буулгах, дундын байр байрласан газарт эмнэлгийн анхны тусламж үзүүлэх.

#### **4.4. Ариун цэвэр, халдвар судлал, хог хаягдал, хүрээлэн буй орчны талаар авах арга хэмжээ**

##### **4.4.1. Эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх арга хэмжээ**

Гамшгийн голомтод болон нүүлгэн шилжүүлэх бүсэд эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тусгана. Тухайлбал, халдварт өвчин дэгдэж тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэрвэгдэгсдэд эмнэлгийн үзлэг хийх, илэрсэн өвчтөнүүдийг тусгаарлан эмчилэх, эмнэлгийн ариутгал хийх ажлыг зохион байгуулах, хоол хүнсний хангалт, усны эх үүсвэрийг хамгаалах, гамшгийн болон гамшгийн бүсийн гадна нэрвэгдэгсдийг цуглуулах, түр байрлуулахдаа эмнэлэг, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж ариутгасан зөөврийн хоол, хүнс, усны хангалтыг тоолцох, нэгд 2.5 м<sup>2</sup> байраар тооцох, байрны агаарын температур 18 хэмээс доошгүй 35-65 хувийн чийгшилтэй байх, ундны усыг хоногт нэг хүнд 10 литр байхаар тооцох, нүүлгэн шилжүүлэх бүсийн эргэн тойронд байнгын халдваргүйжүүлэлтийг хлорын шохой, хлорамины 3 хувийн уусмалаар усалгааны машин, авто цэвэрлэгээний тусгай зориулалтын машин, галын болон бусад техник ашиглаж эмнэлгийн болон нийтийн ахуйн үйлчилгээний албаны бие бүрэлдэхүүний хүчээр гүйцэтгэх талаар тусгана.

Мөн түр цугларах талбай, түр хорогдох байр, түр орон сууцад шаардагдах нийтийн бие засах газар, био жорлонгийн хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулж, орон сууц нийтийн аж ахуйн болон бохирын ус тээвэрлэх компаниудыг мэдээллээр хангах; Нүүн шилжигчдийг дамжин өнгөрүүлэх болон хүлээж авах цэгүүдэд шаардагдах нийтийн бие засах газар, био жорлонгийн хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулж бохирын ус тээвэрлэх компаниудыг мэдээллээр хангах.

##### **4.4.2. Хог хаягдал цэвэрлэх, зайлуулах арга хэмжээ**

Ахуйн болон барилгын хог хаягдал, ялгадас цэвэрлэх, зайлуулах арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар дурдах. Тухайлбал, Орон сууцны хороолол, гудамж талбайд бохир ус халихаас хотын нийтийн тээвэр үйлчилгээ, замын хөдөлгөөн, төр захиргааны болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд үүссэн саатлын талаарх мэдээллийг цуглуулах, орон сууц нийтийн аж ахуй, бохирын ус тээвэрлэх компаниудыг мэдээллээр хангах, хот суурин газрын доторх ахуйн болон барилгын хог хаягдал, бохир ус хальж ариун цэвэр, халдвар эсэргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай цэгүүдийн байршлыг тодорхойлох, гудамж талбайд хальсан бохир усыг зөөврийн насос, бохир ус соруулах машинаар соруулан авч ариутгал, цэвэрлэгээ, халдвар эсэргүүцэх арга хэмжээг зохион байгуулах, бохир усны шугам хоолойн эвдрэл гэмтлийг шуурхай засварлаж хэвийн байдалд оруулахад шаардагдах хүн хүч, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, цэвэрлэгээний материалаар хангах

талаар тусгах.

#### 4.4.3. Хүнсний эрүүл ахуйг хангах арга хэмжээ

Хүнсний хангалтын эрүүл ахуйг хангах, хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар дурдах Тухайлбал, Хүнс, хөдөө аж ахуйн албан нь гамшгийн хөнөөлийн голомтод болон нүүлгэн шилжүүлэх бүсэд нийлүүлж байгаа хоол хүнсний чанар, эрүүл ахуйд тавих, тандалт судалгаа хийх, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд чанар, эрүүл ахуйн баталгаанд урьдчилсан хяналтыг холбогдох хуульд заасны дагуу хийх, хоол хүнс бэлтгэх, боловсруулах, худалдаалах, хэрэглэх, хадгалах, тээвэрлэх үед эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм алдагдсахаас сэргийлэх, уураг, нүүрс усаар баялаг хүнсний бүтээгдэхүүн, мөн бүх төрлийн хоол, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, ус, орчноос сорьц авч мэргэжлийн хяналтын байгууллагын эрүүл мэнд, мал эмнэлэгийн болон бусад магадлан итгэмжлэгдсэн холбогдох лабораторид өгч шинжилгээг хийлгэж, дүгнэлт гаруулах, эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм алдагдаж халдварт өвчний тохиолдол, дэгдэлт гарсан үед лабораториудыг өвчний оношлогоо, халдварын эх сурвалжийг яаралтай тогтоох шаардлагаар 24 цагийн тасралтгүй ажиллагааны горимд шилжүүлэх талаар тусгах.

#### 4.4.4. Мал амьтныг хамгаалах арга хэмжээ

Мал амьтныг хамгаалах, мал эмнэлгийн арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар дурдах. Тухайлбал, алдагдсан мал амьтныг эрэн хайж цуглуулан эзэн олж өгөх, мал, амьтанд мал эмнэлгийн үзлэг хийж, бэртсэн мал амьтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг өвчин үүсгэгчийг устгах, халдвар авах замыг таслан зогсоох, эмчилэх боломжгүй малыг устгах, ариутгал цэвэрлэгээ, хорио цээр тогтоох байдлаар хэрэгжүүлнэ. Үхсэн малын сэг зэмийг шатааж, булшилах зэргийг тусгана.

#### 4.4.5. Амь насаа алдсан иргэдийг оршуулах арга хэмжээ

Амь насаа алдсан иргэдийн шарилыг таниулах, байршуулах талбай, оршуулах арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар тусгах. Тухайлбал, шүүх эмнэлэг, цагдаагийн газрын эмч нарын дэмжлэгээр цогцост үзлэг, задлан шинжилгээ хийх, хэн болохыг нь тогтоох арга хэмжээ авах, нас барагдагсдыг хөдөөлүүлэх арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгжийн засаг захиргааны байгууллагатай хамтран шуурхай зохион байгуулж, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах талаар тусгана.

### **ТАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ҮЕД ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ БОЛОН СЭРГЭЭН БОСГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэ бүлэг нь хүн амын нийгмийн асуудлыг нэн даруй шийдвэрлэх, сэргээн босгох арга хэмжээ гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

## **5.1 Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ.**

### **5.1.1. Хүн амын амьдралын зайлшгүй хэрэгцээг хангах арга хэмжээ**

Хүн амын наад захын хэрэгцээг хангах асуудлыг ямар хугацаанд хэрхэн шийдвэрлэх талаар тусгана. Хүн амын наад захын хэрэгцээг хангах асуудлыг ямар хугацаанд хэрхэн шийдвэрлэх талаар тусгана.

Онцгой комисс нь эхлээд хямралт нөхцөл байдлын эсрэг арга хэмжээ авсны дараа эрүүл ахуйн нөхцөл байдал болон нийгмийн хэв журмыг сахиулж, инженерийн шугам сүлжээг сэргээн босгож, гамшигт өртсөн хүмүүст мэдээлэл өгөх, хоёрдогч чичирхийлэлтээс урьдчлан сэргийлэх арга хэмжээ авна. Түүнчлэн сэргээн босгох арга хэмжээнд оролцох хүн хүч, бараа материалын тусламжийн саадгүй хүлээн авах арга хэмжээг зохион байгуулах, хүн амын наад захын хэрэгцээг хангахын тулд зам, харилцаа холбоо, цахилгаан, хий, цэвэр бохир усны инженерийн дэд бүтцийн эвдрэл гэмтлийн сэргээн босгох нэрвэгдэгсдэд ундны ус, хоол хүнс, дулаан хувцас, түр орогнох байраар хангах арга хэмжээг 24-48 цагийн дотор авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах талаар тусгана.

### **5.1.2. Гамшгийн хохирлыг тогтоох, хойшлуулшгүй сэргээн босгох ажлын зохион байгуулалт**

Гамшгийн хохирлыг тогтоох, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар дурьдана.

Онцгой комисс газар хөдлөлтийн тухай (чичирхийллийн хүч, голомт, магнитуд) болон хохирлын талаархи мэдээллийг цуглуулах, мэдээлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ. Тухайлбал, харилцаа холбооны мэдээллийн систем ашиглан ерөнхий цагийн байдлын мэдээлэл, газар зүйн болон орон зайн төрлийн бүрийн мэдээллийг цуглуулж, хохирлын үнэлгээ, дүн шинжилгээ хийж хохирлын хэмжээг яаралтай тодорхойлох арга хэмжээ авах талаар тусгах. Хэрэв хохирлын хэмжээ нь нутаг дэвсгэрийн нэгжийн дотоод нөөц боломжийн хүрээнд байна гэж үзвэл өөрийн гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн хүчээр зохион байгуулах арга хэмжээг авах, харин газар хөдлөлтийн гамшгийн хохирол нь тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн дотоод нөөц боломжоос давсан тохиолдолд тухайн бүсийн хэмжээний гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, улсын онцгой комиссын оролцоотойгоор сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулах талаар тусгана.

Засгийн газар болон яам, агентлагууд нь Онцгой комисст барилга байгууламжийг шуурхай сэргээн босгоход хүн, техникийн дэмжлэг үзүүлж бараа материалаар тасралтгүй хангах арга хэмжээ авах талаар тусгана.

## **ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАДЫН ЧИГ ҮҮРЭГ**

<b>1. Эрүүл мэндийн алба: / Эрүүл мэндийн газар/</b>
1. Учирсан гарз хохирлын улмаас сэтгэл зүйн дарамтад орсон болон гэмтсэн иргэдийн эмчилгээг үргэлжлүүлэн эмчлэх арга хэмжээ авах
2. Гарсан зардлын тооцоог гаргаж аймгийн Онцгой комисс болон Онцгой байдлын газарт хүргүүлэх
<b>2. Хүнсээр хангах алба: / Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс,</b>

<b>Хүнс, Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар /</b>
1.Нэмэлтээр татан авах хоол хүнс, цэвэр усны тооцоог гаргаж Онцгой комисст танилцуулах, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх, хүнсний хангалт хийх 2.Гарсан зардлын тооцоог гаргаж аймгийн Онцгой комисс болон Онцгой байдлын газарт хүргүүлэх
<b>3.Хэв журам сахиулах алба: / Нийслэлийн Цагдаагийн газар, Аймгийн Цагдаагийн хэлтэс /</b>
1.Газар хөдлөлтөнд нэрвэгдсэн хүмүүсийг түр орогнох байр руу зөөвөрлөх, 2.Орон гэргүй болсон иргэдийг түр байрлуулсан хотхонд хэв журам сахиулах 3.Цогцосыг зөөвөрлөн тусгай байрлалд хүргэх, таниулах арга хэмжээ авах 4.Сураггүй алга бологсдыг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах 5. Холбогдох тооцоо, судалгааг Онцгой комисст гаргаж өгөх
<b>4.Холбоо зарлан мэдээллийн алба: / Нийслэлийн Мэдээлэл технологийн газар, Шуудан, Холбооны газар /</b>
1.Гамшгийн улмаас эвдэрч гэмтсэн холбооны шугам, техник хэрэгслийг засварлах, хэвийн ажиллагаанд оруулах 2.Холбогдох зардлыг тооцоо судалгааг Онцгой комисст гаргаж өгөх
<b>5.Мэргэжлийн хяналтын алба: / Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтэс /</b>
1.Газар хөдлөлтийн улмаас нурсан барилга байгууламж, бохирдсон зам талбайн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих 2.Орон гэргүй болсон хүмүүсийг байрлуулах байр, орон сууцны аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах
<b>6.Эрчим хүчээр хангах алба: /"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК, Аймгийн цахилгаан түгээх сүлжээний ААН байгууллага/</b>
1.Газар хөдлөлтөнд өртсөн цахилгаан шугам сүлжээг бүрэн засварлаж дуусгах 2.Сэргээн босгох арга хэмжээнд зарцуулсан болон нэн шаардлагатай байгаа зардлын тооцоог Онцгой комисст гаргаж өгөх
<b>7.Замын хөдөлгөөн зохицуулах алба : / Нийслэлийн Замын цагдаагийн газар, Аймгийн Замын цагдаагийн алба /</b>
1.Авто замын эвдэрсэн хэсгүүдийг сэргээн засварлаж дуустал замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг зохицуулах 2.Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, тэмдэг тэмдэглэгээ, багаж хэрэгслийн хэвийн ажиллагааг мэргэжлийн байгууллагаар хангуулах арга хэмжээ авах 3.Хохирлын тооцоог Онцгой комисст гаргаж өгөх
<b>8.Мал эмнэлгийн алба: / Нийслэлийн Мал эмнэлгийн газар, Аймгийн Мал эмнэлгийн газар /</b>
1.Газар хөдлөлтийн үед нурангинд дарагдаж хорогдсон мал, амьтадын сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйтгэл хийх 2. Нийтийн эзэмшлийн бохирдсон зам талбайд ариутгал халдваргүйтгэл хийх 3.Хохирол, гарсан зардлын тооцоог Онцгой комисст гаргаж өгөх
<b>9. Барилга инженерийн алба : / НХБЕТГ, Аймгийн Барилга захиалагчийн алба /</b>
1.Орон гэргүй болсон иргэдийг түр орон байраар хангах ажлыг зохион байгуулах /сандвичэн барилга/ 2.Нэн тэргүүнд сэргээн босгох барилгын ангилал зэрэглэлийг тогтоох 3.Хохирлын тооцоо судалгааг Онцгой комисст гаргаж өгөх
<b>10. Авто замын алба: /Авто замын газар/</b>
1. Авто замд гарсан эвдрэлийг нэн даруй сэргээн босгох, хэвийн үйл ажиллагаанд оруулах 2. Хохирол, гарсан зардлын тооцоог Онцгой комисст гаргаж өгөх
<b>11.Тээврийн алба: / Авто замын газар, Тээврийн компани /</b>
1.Хохирол, гарсан зардлын тооцоог Онцгой комисст гаргаж өгөх
<b>12.Дулаанаар хангах алба: /"Улаанбаатар Дулааны сүлжээ" ХК, Аймгийн дулаан хангамжийн ААН байгууллага /</b>
1.Дулааны шугам сүлжээнд учирсан гэмтлийг засварлаж хэвийн ажиллагаанд оруулах 2.Хохирол, гарсан зардлын тооцоог Онцгой комисст гаргаж өгөх
<b>13.Орон сууцны алба: /Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар/</b>
1.Шугам сүлжээнд учирсан гэмтлийг засварлаж хэвийн ажиллагаанд оруулах 2.Хохирол, гарсан зардлын тооцоог Онцгой комисст гаргаж өгөх
<b>14.Усаар хангах алба : /Ус сувгийн газар/</b>
1.Гамшигт нэрвэгдэгсдийг хэрэглээний цэвэр усаар хангах арга хэмжээг зохион байгуулах 2.Учирсан гэмтлийг бүрэн засварлаж хэвийн ажиллагаанд оруулах 3.Хохирол, гарсан зардлын тооцоог Онцгой комисст гаргаж өгөх

## **5.2. Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээний үндсэн чиглэл**

Онцгой комисс нь нийтийн хэрэгцээний барилга, байгууламжийг сэргээн босгох үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны хөтөлбөр, гамшигт тэсвэртэй хот болгох зорилтын хүрээнд хойшлуулшгүй сэргээн босголтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх шийдвэр гаргах талаар тусгана. Газар хөдлөлтийн гамшгийн хойшлуулшгүй сэргээн босголтын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд, бэрхшээлтэй иргэд, өндөр настан онцлогийг харгалзан тэдгээрийн оролцоог дэмжинэ.

Засгийн газраас сэргээн босголтын арга хэмжээнд санхүү хөрөнгө оруулалтын дэмжлэгийг хэрхэн үзүүлэх талаар тусгана. Гамшигт өртөгсдийн амьдралыг дахин зохион байгуулах үүднээс орон байр гаргаж өгөх, амьжиргааны зардал олгох зэрэг арга хэмжээг авах механизм бий болгохын хамт ажил, амьдралыг сэргээн босгосноор амьжиргааны тогтвортой орлогыг баталгаажуулах.

Амьдралын хэвийн байдалд эргүүлэн оруулах бүх талыг дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд, юуны түрүүнд гамшгийн улмаас орон сууцны байшинд учирсан хохирлын хэмжээг судлах, тодорхойлолт олгох тогтолцоог байгуулж, хохирлын судалгааг хийж, иргэдэд гамшигт өртсөн тухай тодорхойлолтыг гаргаж өгөх. Мөн, гамшгийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсны тэтгэмж олгох, гамшгийн тусламжийн сангийн болон нийгмийн халамжийн сангийн зээл олгох арга хэмжээ авах, гамшгаас хамгаалах тухай хуулийг үндэслэн гамшигт өртөгсдэд мөнгөн тусламж үзүүлэх замаар тэдний амьдралыг сэргээн босгоход дэмжлэг үзүүлэх.

Гамшигт нэрвэгдэгсдийн санхүү, татварын ачааллыг бууруулах арга хэмжээний хүрээнд, татвартай холбоотой хугацаа сунгах, татвар төлөх хугацааг хойшлуулах буюу чөлөөлөх, эрүүл мэндийн даатгалын хураамж, эмчилгээний зардлыг багасгах зэрэг арга хэмжээ авах.

Гамшигт өртсөн иргэд хөл дээрээ босоход зориулсан дэмжлэг туслалцааны арга хэмжээний талаар гамшигт өртсөн иргэдэд өргөн хүрээнд сурталчилан таниулахын хамт аль болох цогц зөвлөлгөө өгөх цэг нээж ажиллуулах. Гамшигт өртөгсөд өөрийн хүчээр гэр орон барихад шаардлагатай хөрөнгийг зээл болон бусад санхүүгийн арга хэлбэрээр олгох, хэрвээ аль хэдийнэ зээл авсан бол тухайн зээлдэгчийн зээл буцаан төлөх хугацааг сунгах зэрэг арга хэмжээ авах.

Өөр аймаг, суманд түр шилжин амьдарч буй иргэдийн хувьд ч үндсэн захиргаа болон түр шилжин сууж буй орон нутгийн захиргаа нь хамтран шаардлагатай мэдээлэл олгож, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх.

Гамшигт өртсөн ЖДҮ-т тусламж, дэмжлэг үзүүлэх арга хэмжээний талаар гамшигт өртсөн иргэдэд өргөн хүрээнд сурталчилан таниулахын хамт зөвлөлгөө өгөх цонх нээж ажиллах, гамшигт өртсөн ЖДҮ-ийн бизнесийн үйл ажиллагааг сэргээн босгоход дэмжлэг үзүүлэх бөгөөд сэргээн босголтын зээл, эргэлтийн хөрөнгийн зээл, тоног төхөөрөмжийн зээл олгох, шаардлагатай бол гамшгийн дараах сэргээн босголтын зээл олгож бизнесийн хоршооллын үйл ажиллагааг сэргээн босгох санхүүжилт олгох, гамшигт өртсөн ХАА-н бизнес эрхлэгчидийн үйлдвэрлэлийн байгууламжийг сэргээн босгох, хэвийн үйл

ажиллагааг тогтворжуулахад зориулсан хөрөнгийг бага хүүтэй зээлээр олгох.

Орон нутгийн захиргаа нь гамшигт өртсөн сургуулийн барилгыг сэргээн босгох ажлыг гүйцэтгэхдээ сургуулийн барилгын гамшгаас хамгаалах чадварыг бэхжүүлж, тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдийн түр хоргодох газар, бааз бий болгохыг зорих, түр хичээлийн байр болон биеийн тамирын талбай гаргах, сургуулийн барилгыг шуурхай сэргээн босгох, хичээлд аюулгүй явах нөхцлийг бүрдүүлэх, өдрийн хоол өгөх, сурах бичиг, хичээлийн хэрэглэлээр хангах, сургалтын тэтгэмж олгох, гамшгийн улмаас амьдрал нь хүндэрсэн айлын нярай хүүхэд, бага насны хүүхэд, оюутан сурагчдыг сургуульд оруулах талын дэмжлэгээ нэмэгдүүлэхийн хамт тусгай дэмжлэгт сургуулийн хүүхдүүдийн урамшууллын мөнгийг дахин олгох зэрэг гамшгийн үеийн боловсролын үйл ажиллагаанд шаардлагатай арга хэмжээг авах талаар тусгах.

### **5.3. Хойшлуулшгүй сэргээн босгох ажлын ерөнхий шат дараалал**

5.3.1. Хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг эхлүүлэх тогтолцоог бий болгох (Газар хөдлөлт болсноос 14 хоногийн хугацаанд)

Энэ хугацаанд хот суурин газрын сэргээн босголтын эхний үеийн зохион байгуулалтыг бий болгох шаардлагатай бөгөөд хотын сэргээн босголтын ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна. Мөн, гамшигт өртсөн нийт нутаг дэвсгэр дээрх орон сууцын барилгын хохирлын нөхцөл байдлын ерөнхий судалгааг гаргана.

Тухайлбал:

- 1) Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босголтын баг байгуулах
- 2) Орон сууцын барилгын хохирлын хувь хэмжээг тогтооход чиглэсэн мэдээлэл цуглуулах
- 3) Орон сууцын барилгын нийтлэг хохирлын талаарх жагсаалт боловсруулах
- 4) Хохирол ихтэй нутаг дэвсгэр дэх хохирлын нөхцөл байдлыг газар дээр нь судлах гэх зэрэг арга хэмжээний талаар дурдах.

5.3.2. Сэргээн босгох ажлын үндсэн чиглэлийг тогтоох (14 дэх хоногоос 2 сарын хугацааны хооронд)

Онцгой комисс, холбогдох мэргэжлийн албадын ажлын хэсгүүдтэй хамтран газар хөдлөлтийн гамшгийн хохирлын үнэлгээнд үндэслэн сэргээн босгох ажлын үндсэн чиглэлийг дараахи байдлаар тодорхойлно. Үүнд:

Тухайн гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийг нэн даруй анхны хэвийн байдалд оруулахын тулд хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг төлөвлөж тодорхойлох.

Гамшигт илүү тэсвэртэй хот суурин газрыг бий болгох байгуулах зорилгоор тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд болон урт хугацааны зорилтын хүрээнд сэргээн босгох арга хэмжээг тодорхойлох.

5.3.3. Сэргээн босгох ажлын үндсэн төлөвлөгөө боловсруулах (2 сар~6сар)

Онцгой комисс нь хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, мэргэжлийн албад, аж ахуйн нэгж байгуулалттай хамтран гүйцэтгэх үйл

ажиллагааны нэгдсэн удирдлага, зохицуулалтыг хангаж ажиллах талаар тусгана.

Гамшгийн дараахи сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөөнд доорхи арга хэмжээнүүдийг тусгах хэрэгжүүлэх . Үүнд:

- Дэд бүтэц, зам, тээвэр, мэдээлэл, холбоо, харилцаа, инженерийн шугам сүлжээ, орон сууц нийтийн ахуй үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг сэргээх
- Засаг захиргаа, төрийн үйлчилгээ, нийгмийн халамжийн байгууллагуудын үйл ажиллагааг сэргээх,
- Эмнэлэг, сургууль, цэцэрлэг бусад нийгмийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг сэргээх
- Хүнс хөдөө аж ахуйн болон бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн байгууламжийг сэргээн босгох, хэвийн үйл ажиллагааг хангаж тогтворжуулах
- Жижиг дунд үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээж хэвийн ажиллагаанд шилжүүлэх
- Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг сэргээх

#### 5.3.4. Сэргээн босгох ажлын үндсэн төлөвлөгөөг батлах (6 сар~1 жил)

Газар хөдлөлтийн гамшгийн хохирлыг тухайн нутаг дэвсгэрийн дотоод нөөц боломж, чадавхиар сэргээн босгох боломжтой тохиолдолд сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг Онцгой комисс, тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн Иргэдийн хуралд өргөн барьж батлуулан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлнэ. Хэрэв гамшгийн хохирлыг тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн дотоод нөөц боломж, чадавхиар сэргээн босгох боломжгүй тохиолдолд сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг Улсын онцгой комисс баталж Засгийн газрын нөөц хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

#### 5.3.5. Сэргээн босгох ажлыг хөгжлийн бодлоготой уялдуулж хэрэгжүүлэх (1 жилээс хойш)

Сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг гамшгийн аюул дахин тохиолдохоос сэргийлэн, гамшигт тэсвэртэй хот бий болгох хүн амын аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд анхаарч хот байгуулалтын дахин төлөвлөлттэй уялдуулж хэрэгжүүлнэ. Оршин суугчдын амьдралыг нэн даруй хэвийн байдалд оруулах, гамшигт тэсвэртэй хотыг бий болгохын тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, эмэгтэйчүүдийн санал зөвлөмжийг тусгаж зөвшилцөн, газар зохион байгуулалт, хот байгуулалтын төслүүд хэрэгжүүлэх замаар оновчтой,эрүүл хотын дүр төрхийг бий болгож хотын үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авах талаар тусгана.

### **Дөрөв.Төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал**

Төлөвлөгөө боловсруулахад энэхүү зааврыг удирдлага болгон орон нутгийн онцлогт нийцүүлэн газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үеийн цагийн байдал, хохирлын төсөөллийг бий болгож, авч хэрэгжүүлэх арга хэмжээг аль болох бүрэн дүүрэн тодорхойлж, бүтээлч сэтгэлгээгээр хандах шаардлагатай.

Мөн шаардагдах мэдээ, мэдээллийг цуглуулж, бусад орны туршлагыг судлан

холбогдох байгууллагын мэргэжлийн хүмүүсийн оролцоог хангаж боловсруулах нь амьдралд илүү нийцсэн, хэрэгжих боломжтой төлөвлөгөө болоход ач холбогдолтой юм.

---oOo---



1-6 Санамж бичгийн төслүүд

1-6-1 Санамж бичиг боловсруулах гарын авлага

Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас  
хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл

Санамж бичиг боловсруулах гарын авлага

ОБЕГ

ЖАЙКА Мэргэжилтний баг

## Гарчиг

1.	Санамж бичгийн тодорхойлолт.....	1
2.	Санамж бичиг байгуулах төвшнүүд.....	1
3.	Уг гарын авлагын хүрээ.....	1
4.	Санамж бичиг байгуулах салбар.....	1
5.	Санамж бичиг байгуулах шат дараалал.....	2
6.	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны нөхцөл байдлыг тодорхой болгох.....	3
7.	Санамж бичгийн агуулгын талаар хэлэлцэх.....	7
8.	Санамж бичиг гаргах.....	24
9.	Санамж бичиг боловсруулах ажлын хэсэг.....	24
10.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгах.....	24
11.	Санамж бичиг боловсруулах гарын авлагыг шинэчлэх.....	24
12.	Санамж бичиг боловсруулах гарын авлагыг өөрчлөх.....	25
13.	Санамж бичиг боловсруулах гарын авлагыг хүчингүй болгох.....	25

## 1. Санамж бичгийн тодорхойлолт

Санамж бичиг нь 2017 оны 2 сарын 2 өдөр батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 зүйлд заасан Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахад үндэслэн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, ААН байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон тухайн арга хэмжээг саадгүй хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байгууллага хоорондын хамтын ажиллагааны тухай агуулгыг тусгасан баримт бичиг мөн юм.

## 2. Санамж бичиг байгуулах төвшнүүд

Санамж бичиг байгуулах байгууллагаас хамааран санамж бичгийг доорхи 10 төвшнөөр ангилж болно.

1. Хот – Хот  
(Улаанбаатар хот – Дархан хот, Дархан хот – Эрдэнэт хот, Эрдэнэт хот - Улаанбаатар хот)
2. Хот - Дүүрэг
3. Дүүрэг - Дүүрэг
4. Нийслэл - Аймаг
5. Аймаг – хөрш зэргэлдээ Аймаг
6. Дүүрэг - Аймаг
7. Сум – Дүүрэг (Төв аймгийн Эрдэнэ сум – Налайх дүүрэг гэх мэт)
8. Төрийн байгууллага – Төрийн байгууллага
9. Гамшгаас хамгаалах улсын алба – Гамшгаас хамгаалах улсын алба
10. ААН байгууллага – ААН байгууллага

※Уг ангиллыг ОБЕГ-аас тогтоосон болно.

## 3. Уг гарын авлагын хүрээ

Санамж бичгийн агуулга нь зөвхөн холбогдох хууль тогтоомж, дүрэм журам бус санамж бичиг байгуулах байгууллагын тогтолцоо, талууд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх тухай зүйл заалтыг харгалзан үзэж агуулгыг тогтоох шаардлагатай.

Уг гарын авлага нь санамж бичиг байгуулах 10 төвшин, төрийн байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллага, ААН байгууллагын хооронд санамж бичиг байгуулах шат дарааллыг тайлбарласан баримт бичиг юм. Санамж бичиг байгуулах бусад төвшнүүдийн тухайд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, байгууллагын тогтолцоо, талууд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх тухай агуулгыг харгалзан үзэж уг гарын авлагад нэмэлт хийх, өөрчлөлт оруулах буюу гарын авлага шинээр боловсруулах шаардлагатай.

## 4. Санамж бичиг байгуулах салбар

Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө (2013 оны 3 сар)-ний 4-ийн “Нийлүүлэлт,

зохицуулалт” дээрх ангилалд тулгуурлан санамж бичиг байгуулах байгууллагуудын жишээг доорхи хүснэгтээс үзүүлэв. .

**Хүснэгт 1. Санамж бичиг байгуулах салбар ба байгууллагын жишээ**

Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний нийлүүлэлт, зохицуулалтын салбар	Санамж бичиг байгуулах боломжтой байгууллагын жишээ
Харилцаа холбоо	Дэд бүтцийн салбарын байгууллага, худалдаа үйлчилгээ, хэвлэл мэдээллийн байгууллага, радио, телевиз
Эмнэлэг	Эрүүл мэндийн салбарын байгууллага, олон улсын байгууллага, МУЗН, эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдаа эрхэлдэг байгууллага
Орон сууц, хувцас хунар	Нийгмийн халамжийн байгууллага, байгаль орчны салбарын байгууллага, барилгын салбарын байгууллага, худалдаа үйлчилгээ, боловсролын байгууллага, хот тохижилт ба газар зохион байгуулалт
Хүнс	Нийгмийн халамжийн байгууллага, хүнс, хөдөө аж ахуйн салбарын байгууллага
Тээврийн хэрэгсэл	Зам тээврийн байгууллага, аялал жуулчлалын салбарын байгууллага, барилгын салбарын байгууллага, худалдаа үйлчилгээ, агаарын тээврийн байгууллага, төмөр зам
Хүч хэрэгсэл	Батлан хамгаалахын байгууллага, тусгай чиг үүргийн байгууллага, хил хамгаалах болон зэвсэгт хүчний байгууллага
Түлш, эрчим хүч	Эрчим хүч үйлдвэрлэлийн байгууллага, дэд бүтцийн салбарын байгууллага, аюултай хог хаягдлын тээвэрлэлт, хадгалалтын ажил эрхэлдэг ААН байгууллага
Ус, дулаан	Дулааны шугам сүлжээ, ус сувгийн байгууллага, дэд бүтцийн салбарын байгууллага
Мал эмнэлэг	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын байгууллага
Шатахуун, тослох материал	Аюултай хог хаягдлын тээвэрлэлт, хадгалалтын ажил эрхэлдэг ААН байгууллага

Уг гарын авлагад улсын нөөц гэх зэрэг улсын нууцтай холбоотой салбарыг авч үзэхгүй байх болно.

## 5. Санамж бичиг байгуулах шат дараалал

Санамж бичиг байгуулахад гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлага бүхий салбарын нөхцөл байдлыг тодорхой болгосны үндсэн дээр санамж бичгийн агуулгын талаар хэлэлцэж, санамж бичиг боловсруулна.

Мөн, өмнө нь байгуулсан санамж бичгийн тухайд, шинээр илэрхий болсон нөхцөл байдлыг тусгахын тулд цаг тухайд өөрчлөлт оруулж асуудлыг тодорхой болгох ба санамж бичгийн агуулгыг шинэчилж байх нь чухал.

## 6. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны нөхцөл байдлыг тодорхой болгох

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодит байдлыг тодорхой болгох аргачлалын жишээг доор тайлбарлав.

Уг аргачлал нь санамж бичиг байгуулах тухайн салбарын мэргэжилтэн ба гамшгаас хамгаалахын мэргэжилтэн нар хамтран санал бодлоо солилцох байдлаар тухайн салбарын талаарх мэдээллийг солилцох бөгөөд хуваалцахад чиглэгдсэн аргачлал юм.

### ( 1 ) Хүснэгт боловсруулах

- Авч үзэж буй салбарын үйл явцын байдлаас нь үзээд хамаарах байгууллагуудыг тодорхой болгох.
- Хүснэгтийн хэвтээ тэнхлэгт холбогдох байгууллагын нэрсийг оруулах.
- Холбогдох байгууллагын нэрсийг зүүнээс баруун тийш мэдээлэл болон үйл явцын дагуу оруулах.

Хэмжилтийн багаж хэрэгсэл	Мэдээлэл цуглуулах байгууллага	Гамшгаас хамгаалах байгууллага (ОБЕГ)	Холбогдох байгууллага	Мэдээлэл дамжуулах байгууллага	Орон нутгийн байгууллага	Иргэд

### Бүдүүвч 1. Хүснэгтийн жишээ (мэдээлэл харилцаа)

#### ( 2 ) Үйл ажиллагааны талаарх мэдээлэл оруулах

- Мэдээллийн төрлөөс хамааруулан өөр өөр өнгийн наалт ашиглана.


### Хүснэгт 2. Наалтын өнгө

Өнгө	Мэдээллийн төрөл
Цэнхэр	Мэдээлэл, үйл явц
Ягаан	Хууль тогтоомж, тогтолцоо
Шар	Зардал хариуцах зэрэг бусад агуулга

#### 1 ) Мэдээлэл, үйл явцын талаарх агуулга (цэнхэр)

Холбогдох байгууллагын нэр болон хариуцах газар хэлтсийн нэр бүхий наалтыг наах. Мэдээлэл болон үйл явцын холбоог тооцож сум зурсан наалтаар үйл явцын чиглэлийг зааж үйл явцын ерөнхий урсгал харагдаж байхаар хийх. Доорх хүснэгтэнд нэгэн зэрэг


олон сум байгаа учраас ялгаж салгахад хүндрэлтэй.



## Бүдүүвч 2. Мэдээлэл, үйл явцын урсгалыг харуулах

Мэдээлэл болон үйл явцын уялдаа холбоог тооцож мэдээлэл, үйл явцын урсгалыг ойлгомжтой болгохын тулд хүснэгтийн толгойг өөрчлөхийн зэрэгцээ наалтуудыг ч сольж наана.


Доорх бүдүүвч нь ОБЕГ-аас хэвтээ тэнхлэгийн дагуу чиглэсэн сумыг цэгцлэхийн тулд төрийн байгууллага, орон нутгийн онцгой байдлын газар хэлтэс, телевиз, радио тус бүрийн наалтын байршлыг доошлуулж, толгойн хэсгийн “Орон нутгийн байгууллага” ба “Мэдээлэл дамжуулах байгууллага”-ын байршлыг сольсноор сумуудын байршлыг ойлгомжтой болгосон.



### Бүдүүвч 3. Мэдээлэл, үйл явцын урсгалыг харуулах

2) Хууль тогтоомж, тогтолцооны талаарх агуулга (ягаан)


Хууль тогтоомж, тогтолцоо болон өмнө нь байгуулсан санамж бичигтэй холбоотой мэдээллийг наалтан дээр бичиж оруулан, байршуулах. Тухайн мэдээлэл илүү оновч зохистой байх үүднээс наалтын байршлыг өөрчилнө.



Бүдүүвч 4. Хууль тогтоомж, тогтолцоо, өмнө нь байгуулсан санамж бичгийн тухай мэдээллийг оруулах

3) Мэдээлэл дамжуулах үйл явцын урсгал

Мэдээлэл дамжуулах үйл явцыг сумаар зааж, ашиглагдаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгслийг наалтаар үзүүлнэ.



**Бүдүүвч 5. Мэдээлэл дамжуулах үйл явц, түүнд ашиглаж буй тоног төхөөрөмж ба багаж хэрэгсэл**

(3) Мэдээлэл эмхтгэх

Үйл ажиллагааны нөхцөл байдлын тухай мэдээлэл оруулсан наалтуудыг хангалттай байршуулсан гэж үзсэн үед ижил төстэй үйл ажиллагааны агуулгыг наалтан дээр оруулж мэдээлэл нэмэх замаар мэдээллийг эмхтгэж, харахад хялбар болгох.

(4) Мэдээллийг нягтлах

Тухайн салбарын мэргэжилтэнтэй мэдээлэл болон үйл явцын урсгалд тусгагдаагүй мэдээлэл байгаа эсэхийг нягталж шалгах.




## 7. Санамж бичгийн агуулгын талаар хэлэлцэх

### (1) Санамж бичгийн үйлчлэх хүрээний тухай судлах

Хүснэгт ашиглаж мэдээллийн урсгалыг тодорхой болгож гамшгийн үед болон хохирол үүсэх үед холбогдох байгууллага, мэдээлэл дамжуулах дэд бүтэц, тоног төхөөрөмжид гарч болзшгүй гэмтэл хохирлоос үүдсэн нөлөөллийг тооцож, аюултай байж болзошгүй хүрээг тодорхойлох.

Тухайлбал, үүрэн телефон үйлчилгээний ачаалал болон холбоо тасарснаас шалтгаалсан мэдээлэл дамжуулах хэрэгслийн ажиллагаа алдагдах, төрийн байгууллагын байрлах барилга байгууламж гэмтэж сүйдсэнээс хяналт удирдлага алдагдана гэсэг цагийн байдлыг тооцож авч үзэх шаардлагатай.



Бүдүүвч 6. Гамшгийн үед аюул үүсч болзошгүй хэсгүүдийг тодорхой болгох

( 2 ) Санамж бичгийн агуулгын тухай судлах

Боловсруулах санамж бичгийн үйлчлэх хүрээний тухайд доорх агуулгын дагуу авч үзэх.

**Хүснэгт 3. Санамж бичгийн агуулгыг тодорхойлох**

№	Тодорхойлох агуулга	Хоорондын хамаарал	Санамж бичгийн зүйл заалт
1	Санамж бичиг байгуулах нэг талын байгууллага, газар хэлтсийн нэр	→	Зорилго • Зорилго • Холбогдох хууль, журам, дүрэм • Санамж бичиг байгуулах талууд
2	Санамж бичиг байгуулах нөгөө талын байгууллага, газар хэлтсийн нэр		
3	Холбогдох хууль тогтоомж		
4	Хэрэгжүүлэх ажлын ерөнхий агуулга	→	Хамтран ажиллах чиглэл • Санамж бичгийн ерөнхий агуулга
5	Санамж бичиг байгуулахаас өмнө зөвшилцөх шаардлагатай байгууллага, газар хэлтсийн нэр	→	Тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргах • Хүсэлтийн агуулга
6	Ажил хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүсэх зардал, тухайн зардлыг түр хариуцах байгууллага, газар хэлтсийн нэр		
7	Ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл	→	Тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргах шат дараалал • Хүсэлтийн дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлэх шат дараалал
8	Ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа материал	→	Тусламж үзүүлэх хэлбэр болон аргачлал
9	Ажил хэрэгжилтийн нөхцөл байдал, үр дүнг хянах аргачлал	→	Тусламжийг хуваарилах
10	Санамж бичиг шинэчлэх шаардлагатай эсэх	→	Тайлагнах
11	Судлах шаардлагатай, тодорхойгүй асуудал	→	Хэлцэл хийх
			Хүчинтэй хугацаа

**Хүснэгт 4. Санамж бичгийн агуулгыг зохиох жишээ (ОБЕГ-ын барилга байгууламжийн харилцаа холбоо тасрах гэсэн цагийн байдал: 1)**

Гамшгийн зарлан мэдээлэл хүлээж авах

№	Агуулга	Тайлбар
1	Санамж бичиг байгуулах нэг талын байгууллага, газар хэлтсийн нэр	• ОБЕГ
2	Санамж бичиг байгуулах нөгөө талын байгууллага, газар хэлтсийн	• Одон орон геофизикийн хүрээлэн (ООГХ)

	нэр	
3	Холбогдох хууль тогтоомж	• ООГХ-ээс ОБЕГ-т газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулахтай холбоотой гамшгийн зарлан мэдээллийн дохио дамжуулах тухай ЗГ-ын тогтоолын хавсралт
4	Хэрэгжүүлэх ажлын ерөнхий агуулга	• ОБЕГ-ын барилга байгууламжийн харилцаа холбоо тасарсан үед ООГХ-ээс газар хөдлөлтийн гамшгийн сэрэмжлүүлэх мэдээллийг саадгүй шуурхай хүлээн авах.
5	Санамж бичиг байгуулахаас өмнө зөвшилцөх шаардлагатай байгууллага, газар хэлтсийн нэр	ООГХ-ийн газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах чиг үүрэг бүхий газар хэлтэс
6	Ажил хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүсэх зардал, тухайн зардлыг түр хариуцах байгууллага, газар хэлтсийн нэр	• Үүрэн телефон, автомашин ашигласны хөлс гэх зэрэг хүн хүчний зардал гарна. • Зардал хариуцах талаар авч үзэхгүй
7	Ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл	• ОБЕГ-ын барилга байгууламжийн харилцаа холбоо тасарсныг үнэлж тогтоох аргачлал • Мэдээлэл дамжуулах тодорхой аргачлал
8	Ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа материал	• Радио холбооны тоног төхөөрөмж (ОБЕГ-аас хангах)
9	Ажил хэрэгжилтийн нөхцөл байдал, үр дүнг хянах аргачлал	• ООГХ-ийн мэдээлэл дамжуулсан тухай хөтөлсөн тэмдэглэл • ОБЕГ-ын мэдээлэл хүлээн авсан тухай хөтөлсөн тэмдэглэл • Дээрх тэмдэглэлүүдийг нягталснаар газар хөдлөлтийн гамшгийн зарлан мэдээлэл дамжуулсан талаарх нөхцөл байдлыг тодорхой болгох
10	Санамж бичгийг шинэчлэх шаардлага буй эсэх	• Харилцаа холбооны аргачлалыг өөрчилсөн үед • Мэдээлэл дамжуулах аргачлал болон дамжуулах тоног төхөөрөмж өөрчлөгдсөн тохиолдолд
11	Судлах шаардлагатай асуудал, тодорхойгүй асуудал	• ООГХ-ийн мэдээлэл дамжуулах аргачлал

**Хүснэгт 5. Санамж бичгийн агуулгыг зохиох жишээ (ОБЕГ-ын барилга  
байгууламж харилцаа холбоо тасрах гэсэн цагийн байдал: 2)**

Гамшгийн зарлан мэдээллийг түгээх

№	Агуулга	Тайлбар
1	Санамж бичиг байгуулах нэг талын байгууллага, газар хэлтсийн нэр	• ОБЕГ
2	Санамж бичиг байгуулах нөгөө талын байгууллага, газар хэлтсийн нэр	• Телевиз, радио
3	Холбогдох хууль тогтоомж, тогтолцоо	• Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам (2011 оны ЗГ-ын 339 тогтоолын хавсралт) • Гамшгаас хамгаалах тухай хууль
4	Хэрэгжүүлэх ажлын ерөнхий агуулга	• Үүрэн телефоны холбоо тасарсан үед телевиз, радиогийн байгууллагатай холбогдох, мэдээлэл дамжуулахад зориулж радио холбоог ашиглах ба бэлэн байдлыг хангах
5	Санамж бичиг байгуулахаас өмнө зөвшилцөх шаардлагатай байгууллага, газар хэлтсийн нэр	• Телевиз, радио станц (Телевиз: МҮОНТ, UBS, MN25, ТВ5, ТВ9 зэрэг телевизүүдийн холбогдох газар хэлтэс) (Радио: МҮОНР-ийн газар хэлтэс)
6	Ажил хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүсэх зардал, тухайн зардлыг түр хариуцах байгууллага, газар хэлтсийн нэр	• Радио холбооны тоног төхөөрөмжийн зардал • Гарах зардлыг радио холбооны төхөөрөмж хүлээн авч байгаа байгууллага хариуцна (Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5-д заасны дагуу)
7	Ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл	• Ашиглах төхөөрөмжийн төрөл нэгдмэл байх
8	Ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа материал	• Радио холбооны төхөөрөмж
9	Ажил хэрэгжилтийн нөхцөл байдал, үр дүнг хянах аргачлал	• Төхөөрөмж нийлүүлэх ажлыг нягтлах

10	Санамж бичгийг шинэчлэх шаардлага буй эсэх	• Радио холбооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, холбогдох хууль тогтоомжинд өөрчлөлт орох
11	Судлах шаардлагатай асуудал, тодорхойгүй асуудал	байхгүй

**Хүснэгт 6. Санамж бичгийн агуулгыг эмхтгэх жишээ (үүрэн телефоны ачаалал нэмэгдэх, холбоо тасрах)**

№	Агуулга	Тайлбар
1	Санамж бичиг байгуулах нэг талын байгууллага, газар хэлтсийн нэр	• ОБЕГ
2	Санамж бичиг байгуулах нөгөө талын байгууллага, газар хэлтсийн нэр	• MobiCom • Skytel • Unitel • G-Mobile
3	Холбогдох хууль тогтоомж, тогтолцоо	• Гамшгаас хамгаалах тухай хууль • Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө (ЗГ-ын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралт)
4	Хэрэгжүүлэх ажлын ерөнхий агуулга	• Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах • Газар хөдлөлт болох үеийн мэдээлэл холбооны сүлжээний хэвийн байдлыг хангах • Гамшгийн үеийн шуурхай телефон холбоог ашиглах орчныг бүрдүүлэх
5	Санамж бичиг байгуулахаас өмнө зөвшилцөх шаардлагатай байгууллага, газар хэлтсийн нэр	• Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар • MobiCom • Skytel • Unitel • G-Mobile
6	Ажил хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүсэх зардал, тухайн зардлыг түр хариуцах байгууллага, газар хэлтсийн нэр	Тодорхойгүй
7	Ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл	• Харилцаа холбоог хязгаарлах, гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг бүрдүүлэх нөхцөл • Гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны шугамын тоо • Харилцаа холбоог хязгаарлах, гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг дуусгавар болгох нөхцөл
8	Ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай	Байхгүй

	бараа материал	
9	Ажил хэрэгжилтийн нөхцөл байдал, үр дүнг хянах аргачлал	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцаа холбоог хязгаарласан тухай тэмдэглэл</li> <li>• Гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээний тухай тэмдэглэл</li> </ul>
10	Санамж бичгийг шинэчлэх шаардлага буй эсэх	<ul style="list-style-type: none"> <li>• Үүрэн телефоны системийн шинэчлэл</li> </ul>
11	Судлах шаардлагатай асуудал, тодорхойгүй асуудал	<ul style="list-style-type: none"> <li>• Үүрэн телефоны оператор компанитай хэлэлцэж харилцаа холбоог хязгаарлах, гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг хэрэгжүүлэх боломжтой эсэх, үүнтэй холбоотой гарах зардлын тухай нягтлах.</li> <li>• Үүрэн телефоны үндсэн сүлжээг нөөцжүүлэх, орон нутаг дахь үйлчилгээний нөхцөл байдлын тухай оператор компаниас мэдээлэл авах.</li> <li>• Зардлын хуваарилалтын талаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хэлэлцэх шаардлагатай.</li> </ul>

### ( 3 ) Тодорхойгүй асуудлын талаарх судалгаа

“Судлах шаардлагатай асуудал, тодорхойгүй асуудал”-ын тухайд холбогдох судалгааг хэрэгжүүлж санамж бичиг байгуулахтай холбоотой тулгамдсан асуудлыг эмхтгэж, асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар санамж бичиг байгуулах байгууллага болон холбогдох байгууллагатай санал бодлоо солилцох.

### ( 4 ) Санамж бичгийн загвар агуулгын талаар санал солилцож зөвшилцөх

Санамж бичгийн загвар агуулгыг эмхтгэж, санамж бичиг байгуулах талуудыг оролцуулан санал солилцон санамж бичиг байгуулахтай холбоотой асуудлыг тодорхой болгож шийдлийг нь тусгасан төслийг боловсруулж, санамж бичгийн загвар агуулгыг шинэчлэн сайжруулах.

Доор санамж бичгийн ерөнхий бүтэц агуулгыг эмхтгэсэн жишээг үзүүлэв.

**Хүснэгт 7. Санамж бичгийн ерөнхий загвар бүтцийн агуулгыг эмхтгэсэн жишээ (ОБЕГ-ын барилга байгууламж харилцаа холбоогүй болох цагийн байдал: 1)**

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл хүлээн авах

Санамж бичгийн бүлэг	Агуулга
Зорилго • Зорилго • Үндэслэл болох хууль тогтоомж, дүрэм, журам • Санамж бичгийн талууд	• Газар хөдлөлт болох үед газар хөдлөлтийн мэдээллийг найдвартай дамжуулах зорилготой, • Одон орон геофизикийн хүрээлэнгээс ОБЕГ-т шилэн кабель ашиглан мэдээлэл дамжуулах харилцаа холбоо тасарсан үеийн бэлэн байдлыг хангах, • ООГХ-ээс ОБЕГ-т газар хөдлөлтийн гамшгийн аюулын тухай сэрэмжлүүлэх мэдээлэл дамжуулахтай холбоотой ЗГ-ын тогтоолын хавсралт"-д үндэслэн, • ООГХ-ээс ОБЕГ-т мэдээлэл дамжуулах талаар • Нэг талаас Одон орон, геофизикийн хүрээлэн, нөгөө талаас ОБЕГ хооронд санамж бичиг байгуулав.
Хамтын ажиллагааны чиглэл • Санамж бичгийн ерөнхий агуулга	• Одон орон геофизикийн хүрээлэнгээс ОБЕГ-т шилэн кабель ашиглан мэдээлэл дамжуулах харилцаа холбоо тасарсан үеийн бэлэн байдлыг хангаж, мэдээлэл дамжуулах аргачлалыг тодорхойлох.
Тусламж үзүүлэх тухай хүсэлт • Хүсэлтийн агуулга	• Шилэн кабель ашигласан харилцаа холбоо тасарсан үед мэдээлэл дамжуулах боломжтой харилцаа холбооны нөөц техник хэрэгсэл, дамжуулах мэдээллийн агуулгын тухай • Харилцаа холбооны нөөц техник хэрэгсэл ашиглах боломжгүй үед мэдээлэл дамжуулах бусад аргачлал ба дамжуулах мэдээллийн агуулгын тухай
Тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргах шат дараалал • Хүсэлтийн агуулгыг хэрэгжүүлэх шат дараалал	• Шилэн кабель ашигласан харилцаа холбоо тасарсан үед мэдээлэл дамжуулах боломжтой харилцаа холбооны нөөц техник хэрэгслийг ач холбогдлоор нь эрэмбэлэх • Харилцаа холбооны нөөц техник хэрэгсэл ашиглах боломжгүй үеийн мэдээлэл дамжуулах бусад аргачлал
Тусламжийн хэлбэр болон аргачлал	• Үүрэн телефоны үйлчилгээний хөлс, автомашины хөлс ба хүн хүчний зардал үүснэ. • Зардлыг ООГХ хариуцна (Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5-д зааснаар)
Тусламжийн хуваарилалт	байхгүй
Тайлан	• ООГХ-ийн мэдээлэл явуулсан тухай тэмдэглэл • ОБЕГ-ын мэдээлэл хүлээн авсан тухай тэмдэглэл • Дээрх тэмдэглэлүүд дээр үндэслэн газар хөдлөлтийн гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дамжуулах ажлын нөхцөл байдлыг нягтлах
Зөвшилцөх	• ОБЕГ болон ООГХ-ээс санал гарсан тохиолдолд тухай бүрд зөвшилцөж санал солилцох
Хүчин төгөлдөр байх хугацаа	• Санамж бичиг байгуулсан өдрөөс 1 жилийн хугацаатай байна • ОБЕГ болон ООГХ-ийн зүгээс зөвшилцөх тухай санал гараагүй тохиолдолд хүчин төгөлдөр байх хугацааг 1 жилээр сунгах



**Хүснэгт 8. Санамж бичгийн ерөнхий загвар бүтцийн агуулгыг эмхтгэсэн жишээ  
(ОБЕГ-ын барилга байгууламж харилцаа холбоогүй болох цагийн байдал: 2)**

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулан түгээх

Санамж бичгийн бүлэг	Агуулга
Зорилго • Зорилго • Үндэслэл болох хууль тогтоомж, дүрэм, журам • Санамж бичгийн талууд	<ul style="list-style-type: none"> <li>• Газар хөдлөлт болох үед гамшгийн зарлан мэдээллийг найдвартай дамжуулан түгээх зорилготой,</li> <li>• ОБЕГ-аас телевиз, радиогийн компанитай холбогдох интернет, үүрэн телефон ашигласан харилцаа холбоо тасарсан үеийн бэлэн байдлыг хангах,</li> <li>• Гамшгаас хамгаалах тухай хууль, ЗГ-ын 339 дүгээр тогтоолын хавсралт (Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам)-д үндэслэн,</li> <li>• ОБЕГ-аас телевиз, радиогийн компанид мэдээлэл дамжуулах тухай</li> <li>• ОБЕГ ба телевиз, радиогийн компани хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.</li> </ul>
Хамтын ажиллагааны чиглэл • Санамж бичгийн ерөнхий агуулга	<ul style="list-style-type: none"> <li>• ОБЕГ-аас телевиз, радиогийн компанитай холбогдох интернет, үүрэн телефон ашигласан харилцаа холбоо тасарсан үеийн бэлэн байдлыг хангаж, харилцаа холбоо тасарсан үеийн мэдээлэл дамжуулах аргачлалыг тодорхойлох</li> </ul>
Тусламж үзүүлэх тухай хүсэлт • Хүсэлтийн агуулга	<ul style="list-style-type: none"> <li>• Интернет, үүрэн телефон ашигласан харилцаа холбоо тасарсан үед мэдээлэл дамжуулах аргачлал ба дамжуулах агуулгын тухай</li> </ul>
Тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргах шат дараалал • Хүсэлтийн агуулгыг хэрэгжүүлэх шат дараалал	<ul style="list-style-type: none"> <li>• Интернет, үүрэн телефон ашигласан харилцаа холбоо тасарсан үеийн мэдээлэл дамжуулах аргачлал</li> </ul>
Тусламжийн хэлбэр болон аргачлал	<ul style="list-style-type: none"> <li>• Автомашин ашигласны хөлс, хүн хүчний зардал үүснэ.</li> <li>• Зардлыг тухайн компани хариуцна (Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5-д зааснаар)</li> </ul>
Тусламжийн хуваарилалт	байхгүй
Тайлан	<ul style="list-style-type: none"> <li>• ОБЕГ-ын мэдээлэл явуулсан тухай тэмдэглэл</li> <li>• Телевиз, радиогийн компанийн мэдээлэл хүлээн авсан тухай тэмдэглэл</li> <li>• Дээрх тэмдэглэлүүд дээр үндэслэн газар хөдлөлтийн гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дамжуулах ажлын нөхцөл байдлыг нягтлах</li> </ul>
Зөвшилцөх	<ul style="list-style-type: none"> <li>• ОБЕГ болон телевиз, радиогийн компаниас санал гарсан тохиолдолд тухай бүрд зөвшилцөж санал солилцох</li> </ul>
Хүчин төгөлдөр байх хугацаа	<ul style="list-style-type: none"> <li>• Санамж бичиг байгуулсан өдрөөс 1 жилийн хугацаатай байна</li> <li>• ОБЕГ болон телевиз, радиогийн компанийн зүгээс зөвшилцөх тухай санал гараагүй тохиолдолд хүчин төгөлдөр байх хугацааг 1 жилээр сунгах</li> </ul>

**Хүснэгт 9. Санамж бичгийн ерөнхий загвар бүтцийн агуулгыг эмхтгэсэн жишээ  
(үүрэн телефоны ачаалал нэмэгдэх, холбоо тасрах)**

Санамж бичгийн бүлэг	Агуулга
Зорилго • Зорилго • Үндэслэл болох хууль тогтоомж, дүрэм, журам • Санамж бичгийн талууд	<ul style="list-style-type: none"> <li>• Газар хөдлөлт болох үед мэдээлэл дамжуулах,</li> <li>• Телефон холбооны сүлжээний хэвийн байдлыг хангах, гамшгийн үеийн шуурхай телефон холбооны орчинг бүрдүүлэх зорилготой,</li> <li>• Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө (ЗГ-ын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралт)-д үндэслэн,</li> <li>• нэг талаас ОБЕГ болон нөгөө талаас үүрэн телефоны компани (Мобиком, Скайтел, Юнител, Жи-мобайл)-ийн хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.</li> </ul>
Хамтын ажиллагааны чиглэл • Санамж бичгийн ерөнхий агуулга	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцаа холбоог хязгаарлах, гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг хэрэгжүүлэх, гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны шугамын тоо, харилцаа холбоог хязгаарлах, гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг дуусгавар болгох нөхцлийг тодорхой заана.</li> </ul>
Тусламж үзүүлэх тухай хүсэлт • Хүсэлтийн агуулга	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцаа холбоог хязгаарлах тухай</li> <li>• Гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг хэрэгжүүлэх тухай</li> <li>• Гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны шугамын тооны тухай</li> </ul>
Тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргах шат дараалал • Хүсэлтийн агуулгыг хэрэгжүүлэх шат дараалал	<ul style="list-style-type: none"> <li>• Газар хөдлөлтийн гамшгийн үед үүрэн телефоны үйлчилгээний ачаалал нэмэгдэж, холбогдох боломжгүй болох тохиолдолд үүрэн телефоны оператор өөрөө шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ</li> <li>• Үүний тулд, газар хөдлөлтийн гамшгийн үед ОБЕГ-аас үүрэн телефоны операторт тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргахгүй.</li> </ul>
Тусламжийн хэлбэр болон аргачлал	<ul style="list-style-type: none"> <li>• Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5-д заасны дагуу үүрэн телефоны оператор компани хариуцна</li> </ul>
Тусламжийн хуваарилалт	байхгүй
Тайлан	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцаа холбоог хязгаарласан тухай тэмдэглэл</li> <li>• Гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээний тухай тэмдэглэл</li> </ul>
Зөвшилцөх	<ul style="list-style-type: none"> <li>• ОБЕГ болон үүрэн телефоны операторын зүгээс санал гарсан үед зөвшилцөх</li> <li>• Үүрэн телефоны операторын зүгээс санал гарсан тохиолдолд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраар дамжуулах</li> </ul>
Хүчин төгөлдөр байх хугацаа	<ul style="list-style-type: none"> <li>• Санамж бичиг байгуулсан өдрөөс 1 жилийн хугацаатай байна</li> <li>• ОБЕГ болон үүрэн телефоны операторын зүгээс зөвшилцөх тухай санал гараагүй тохиолдолд хүчин төгөлдөр байх хугацааг 1 жилээр сунгах</li> </ul>

## ( 5 ) Санамж бичгийн төсөл боловсруулах

Санамж бичгийн бүтэц агуулгын талаар тодорхой ярилцсаны үндсэн дээр санамж бичиг байгуулах байгууллага нь санамж бичгийн төслийг боловсруулна.

Доор санамж бичгийн жишээг үзүүлэв.

- 1) ОБЕГ-ын барилга байгууламж харилцаа холбоогүй болох үед бэлэн байдлыг хангах 1-р хувилбарын санамж бичгийн жишээ

Харилцаа холбоо тасарсан үед гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг найдвартай дамжуулах тухай Одон орон, геофизикийн хүрээлэн ба ОБЕГ-ын хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг

201..он...сар...өдөр

### 1 . Зорилго

Газар хөдлөлт болох үед гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг найдвартай дамжуулах болон Одон орон, геофизикийн хүрээлэнгээс ОБЕГ-тай шилэн кабель ашиглан мэдээлэл дамжуулах харилцаа холбоо тасарсан үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор, Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журамд үндэслэн, нэг талаас Одон орон, геофизикийн хүрээлэн (цаашид “ООГХ” гэнэ), нөгөө талаас Онцгой байдлын ерөнхий газар (цаашид “ОБЕГ” гэнэ) мэдээлэл дамжуулах аргачлалыг нөөцжүүлэх болон боловсронгуй болгохын тулд уг санамж бичгийг байгуулав.

### 2 . Хамтын ажиллагааны чиглэл

ООГХ-ээс ОБЕГ-тай шилэн кабель ашиглан мэдээлэл дамжуулах харилцаа холбоо тасарсан үеийн бэлэн байдлыг хангаж, харилцаа холбоо тасарсан үеийн мэдээлэл дамжуулах аргачлалыг тодорхойлно.

### 3 . Тусламж үзүүлэх тухай хүсэлт ※Уг заалтыг ООГХ-тэй зөвшилцөж тохирсны үндсэн дээр зааж тогтооно

Тусламж үзүүлэх тухай хүсэлтийн агуулга нь доор заасны дагуу байна.

• Шилэн кабель ашиглан мэдээлэл дамжуулах харилцаа холбоо тасарсан үеийн мэдээлэл дамжуулах боломжтой харилцаа холбооны нөөц техник хэрэгсэл болон мэдээлэл дамжуулах агуулгын тухай

Одоогийн байдлаар ашиглах боломжтой харилцаа холбооны нөөц техник хэрэгслийн тухайд гар утас, суурин телефон утас, радио холбоо байгаа бөгөөд эдгээрийг ач холбогдлоор нь үнэлж гар утас, суурин телефон утас, радио холбоо гэсэн дараалалтай

байна.

Ашиглах харилцаа холбооны техник хэрэгслийн тухайд ООГХ сонголт хийнэ. ООГХ ба ОБЕГ нь эдгээр харилцаа холбооны техник хэрэгслийг ашиглах боломжтой бэлэн байдлыг нь хангахын зэрэгцээ энэхүү харилцаа холбооны техник хэрэгслийг ашиглан сард 1 удаа ООГХ-ээс ОБЕГ луу холбоо барьж, тухайн техник хэрэгслүүдийн ашиглах боломжтой бэлэн байдлыг нягтлах.

• Харилцаа холбооны нөөц техник хэрэгслийг ашиглах боломжгүй байгаа тохиолдолд мэдээлэл дамжуулах аргачлал, дамжуулах мэдээллийн агуулгын тухай

Бүхий л харилцаа холбооны техник хэрэгслийг ашиглах боломжгүй байгаа тохиолдолд ООГХ-ийн албан хаагч гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн талаарх хэвлэсэн бичгийг ОБЕГ-т хүргэх.

#### 4 . Холбоо барих, мэдээлэл хүлээн авах

ОБЕГ нь холбоо барих, мэдээлэл хүлээн авах ажлыг хариуцаж буй газар, хэлтэс болон албан тушаалтны нэр, гар утасны дугаар, суурин телефон утасны дугаар, ашиглах радио холбооны хэрэглэгчийн нэр (ID) буюу ашиглаж буй сувгийн тухай ООГХ-ийн хариуцаж буй ажилтан, албан хаагчид мэдээлсэн байна.

ООГХ нь холбоо барих, мэдээлэл хүлээн авах ажлыг хариуцаж буй газар, хэлтэс болон албан тушаалтны нэр, гар утасны дугаар, суурин телефон утасны дугаар, ашиглах радио холбооны хэрэглэгчийн нэр (ID) буюу ашиглаж буй сувгийн тухай ОБЕГ-ын хариуцаж буй ажилтан, албан хаагчид мэдээлсэн байна.

#### 5 . Тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргах шат дараалал

Гамшгийн тухай зарлан мэдээлэл дамжуулах үед шилэн кабель ашиглан ОБЕГ-т мэдээлэл дамжуулах боломжгүй болсон тохиолдолд ООГХ-ийн хариуцагч ажилтан, албан хаагчийн зүгээс ОБЕГ-ын хариуцаж буй ажилтан, албан хаагч руу харилцаа холбооны нөөц техник хэрэгслийн ач холбогдлын эрэмбийн дагуу харилцаа холбооны техник хэрэгслийг ашиглан гамшгийн тухай зарлан мэдээллийн агуулгыг дамжуулна. Мэдээлэл дамжуулах боломжгүй тохиолдолд эрэмбийн дагуу дараах төрлийн харилцаа холбооны техник хэрэгслийг ашиглана.

Харилцаа холбооны нөөц техник хэрэгслээр гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дамжуулах боломжгүй тохиолдолд ООГХ-ийн хариуцаж буй ажилтан, албан хаагч нь гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг хэвлэж ОБЕГ-т хүргэн хариуцаж буй ажилтан, албан хаагчид хүлээлгэн өгнө.

## 6 . Тусламжийн хэлбэр болон аргачлал

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5-д заасны дагуу ООГХ хариуцна.

## 7 . Тайлан

ООГХ нь гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулсан техник хэрэгслийн төрөл, мэдээлэл дамжуулсан цаг, зарлан мэдээллийн агуулгын талаар тэмдэглэл хөтөлнө. ОБЕГ мэдээлэл хүлээн авсан харилцаа холбооны техник хэрэгсэл, мэдээлэл хүлээн авсан цаг, хүлээн авсан зарлан мэдээллийн агуулгын талаар тэмдэглэл хийнэ. ОБЕГ нь дээрх тэмдэглэлүүд дээр үндэслэн мэдээлэл дамжуулсан болон хүлээн авсан нөхцөл байдлыг нягтлах.

ООГХ-ийн тэмдэглэлийг ОБЕГ-аас хүсэлт гаргаснаас хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

## 8 . Зөвшилцөх

Санамж бичгийн агуулгын талаар санал байгаа тохиолдолд, ОБЕГ болон ООГХ-ийн зүгээс санал гарсан үед зөвшилцөх.

## 9 . Хүчин төгөлдөр байх хугацаа

Уг санамж бичиг нь 201X оны XX сарын XX өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Уг санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацаа нь санамж бичиг хүчин төгөлдөр болох өдрөөс 1 жилийн хугацаатай байх ба ОБЕГ болон үүрэн телефоны операторын талуудаас зөвшилцөх санал гараагүй тохиолдолд хүчин төгөлдөр байх хугацааг 1 жилээр сунгана.

2) ОБЕГ-ын барилга байгууламж харилцаа холбоогүй болох 2-р хувилбарын санамж бичгийн жишээ

Харилцаа холбоо тасарсан үеийн гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг найдвартай дамжуулах тухай ОБЕГ ба Телевиз, радиогийн компанийн хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг

201..он...сар...өдөр

#### 1 . Зорилго

Газар хөдлөлт болох үед гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг найдвартай дамжуулах болон ОБЕГ-аас Телевиз, радиогийн компанитай компанитай холбогдох интернет, үүрэн телефон ашигласан харилцаа холбоо тасарсан үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор, Гамшгаас хамгаалах тухай хууль, ЗГ-ын 339 дүгээр тогтоолын хавсралт (Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам)-д үндэслэн, нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар (цаашид “ОБЕГ” гэнэ), нөгөө талаас Телевиз, радиогийн компани, мэдээлэл дамжуулах аргачлалыг нөөцжүүлэх болон боловсронгуй болгохын тулд уг санамж бичгийг байгуулав.

#### 2 . Хамтын ажиллагааны чиглэл

ОБЕГ-аас Телевиз, радиогийн компанитай компанитай холбогдох интернет, үүрэн телефон ашигласан харилцаа холбоо тасарсан үеийн бэлэн байдлыг хангаж, харилцаа холбоо тасарсан үеийн мэдээлэл дамжуулах аргачлалыг тодорхойлно.

3 . Тусламж үзүүлэх тухай хүсэлт ※Уг заалтыг Телевиз, радиогийн компанитай зөвшилцөж тохирсны үндсэн дээр зааж тогтооно

Тусламж үзүүлэх тухай хүсэлтийн агуулга нь доор заасны дагуу байна.

• Интернет, үүрэн телефон ашигласан харилцаа холбоо тасарсан үеийн мэдээлэл дамжуулах аргачлал ба дамжуулах мэдээллийн агуулгын тухай

Бүхий л харилцаа холбооны техник хэрэгслийг ашиглах боломжгүй байгаа тохиолдолд ОБЕГ-ын албан хаагч гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн талаарх хэвлэсэн бичгийг ОБЕГ-т хүргэх.

#### 4 . Холбоо барих, мэдээлэл хүлээн авах

ОБЕГ нь холбоо барих, мэдээлэл хүлээн авах ажлыг хариуцаж буй газар, хэлтэс болон албан тушаалтны нэрийг Телевиз, радиогийн компанийн хариуцаж буй ажилтанд мэдээлсэн байна.

Телевиз, радиогийн компани нь хариуцаж буй газар, хэлтэс болон ажилтны нэрийг ОБЕГ-ын хариуцаж буй албан хаагчид мэдэгдсэн байна.

## 5. Тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргах шат дараалал

Газар хөдлөлтийн гамшгийн үед интернет, үүрэн телефон ашигласан харилцаа холбоо тасарснаас шалтгаалан Телевиз, радиогийн компанитай холбогдох боломжгүй болсон тохиолдолд ОБЕГ-ын хариуцаж буй ажилтан, албан хаагч нь гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг хэвлэж Телевиз, радиогийн компанийн хариуцаж буй ажилтан, албан хаагчид хүлээлгэн өгнө.

## 6. Тусламжийн хэлбэр болон аргачлал

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5-д заасны дагуу Телевиз, радиогийн компани хариуцна.

## 7. Тайлан

ОБЕГ нь гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг хүлээлгэн өгсөн цаг хугацаа, зарлан мэдээллийн агуулгыг тэмдэглэн авна. Телевиз, радиогийн компани нь мэдээлэл хүлээн авсан цаг хугацаа, хүлээн авсан зарлан мэдээллийн агуулгыг тэмдэглэн авна. ОБЕГ нь дээрх тэмдэглэлүүд дээр үндэслэн мэдээлэл дамжуулсан болон хүлээн авсан нөхцөл байдлыг нягтлах.

Телевиз, радиогийн компанийн тэмдэглэлийг ОБЕГ-аас хүсэлт гаргаснаас хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

## 8. Зөвшилцөх

Санамж бичгийн агуулгын талаар санал байгаа тохиолдолд, ОБЕГ болон Телевиз, радиогийн компанийн зүгээс санал гарсан үед зөвшилцөж санал солилцох.

## 9. Хүчин төгөлдөр байх хугацаа

Уг санамж бичиг нь 201X оны XX сарын XX өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Уг санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацаа нь санамж бичиг хүчин төгөлдөр болох өдрөөс 1 жилийн хугацаатай байх ба ОБЕГ болон Телевиз, радиогийн компанийн талуудаас зөвшилцөх санал гараагүй тохиолдолд хүчин төгөлдөр байх хугацааг 1 жилээр сунгана.

Жич: Телевиз, радиогийн компаниуд:

Телевиз: МҮОНТ, UBS, MN25, ТВ5, ТВ9 зэрэг телевизүүдийн холбогдох газар хэлтэс

Радио: МҮОНР-ийн газар хэлтэс

3) Үүрэн телефоны ачаалал нэмэгдэх, холбоо тасрах үеийн бэлэн байдлыг хангах тухай санамж бичгийн жишээ

## Үүрэн телефоны ачаалал нэмэгдэх, холбоо тасрахаас сэргийлэх тухай санамж бичиг

201X оны XX сарын XX өдөр

### 1. Зорилго

Газар хөдлөлтийн үед гамшгийн мэдээлэл дамжуулахад телефон холбооны сүлжээний хэвийн байдлыг хангах, гамшгийн үеийн шуурхай телефон холбооны орчинг бүрдүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө (ЗГ-ын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралт)-д үндэслэн нэг талаас ОБЕГ, нөгөө талаас үүрэн телефоны оператор хооронд үүрэн холбооны ачааллаас шалтгаалсан доголдлоос сэргийлэх тухай энэхүү санамж бичгийг байгуулав.

### 2. Хамтын ажиллагааны чиглэл

Гамшгийн үед үүрэн телефоны холбоо харилцааг хязгаарлах, тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг хэрэгжүүлэх, гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны шугамын тоо, холбоо харилцааг хязгаарлах, гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг дуусгавар болгох нөхцлийг тодорхой заана.

3. Тусламж үзүүлэх тухай хүсэлт ※Уг заалтыг үүрэн телефоны оператортай зөвшилцөж тохирсны үндсэн дээр зааж тогтооно

Тусламж үзүүлэх тухай хүсэлтийн агуулга нь доор заасны дагуу байна.

• Холбоо харилцааг хязгаарлах тухай

Үүрэн телефоны шугамын ачааллаас сэргийлэх зорилгоор гол сүлжээний нэг дор холбогдох тоо хэмжээг хязгаарлах.

Нэг дор холбогдох тоо хэмжээг хязгаарлах хувь хэмжээ нь гол сүлжээний нэг дор холбогдох хамгийн дээд хувь хэмжээний ...% байхаар тогтооно.

• Гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг хэрэгжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах холбогдох байгууллагын мэдээлэл дамжуулах зорилгоор гамшгийн үед тэргүүн ээлжинд телефон холбоо болон дата мэдээлэл дамжуулах орчин нөхцлийг бүрдүүлэх



· Гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны шугамын тооны тухай  
Телефон холбооны шугам нь GSMXXX шугам, GPRSXXX шугам, LTEXXX шугам байна.  
Дата мэдээллийн шугам нь GPRSXXX шугам, LTEXXX шугам байна.

#### 4 . Холбоо барих, мэдээлэл хүлээн авах

ОБЕГ нь холбоо барих, мэдээлэл хүлээн авах ажлыг хариуцаж буй газар, хэлтэс болон албан тушаалтны нэрийг үүрэн телефоны операторын хариуцаж буй ажилтанд мэдээлсэн байна.

Үүрэн телефоны оператор нь хариуцаж буй газар, хэлтэс болон ажилтны нэрийг ОБЕГ-ын хариуцаж буй албан хаагчид мэдэгдсэн байна.

#### 5 . Тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргах шат дараалал

Газар хөдлөлтийн гамшгийн үед үүрэн телефоны үйлчилгээний ачаалал нэмэгдэж, холбогдох боломжгүй болох тохиолдолд үүрэн телефоны оператор өөрөө шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ. Үүний тулд, газар хөдлөлтийн гамшгийн үед ОБЕГ-аас үүрэн телефоны операторт тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргахгүй.

#### 6 . Тусламжийн хэлбэр болон аргачлал

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5-д заасны дагуу үүрэн телефоны оператор компани хариуцна.

#### 7 . Тайлан

Үүрэн телефоны оператор нь холбоо харилцааг хязгаарласан тухай тэмдэглэл болон гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээний тухай тэмдэглэлийг тайлагнана. Үүнийг ОБЕГ-ын тайлан ирүүлэх хүсэлт гарснаас хойш 14 хоногийн дотор хүргүүлнэ.

#### 8 . Зөвшилцөх

Санамж бичгийн агуулгын талаар санал байгаа тохиолдолд, ОБЕГ болон үүрэн телефоны операторын зүгээс санал гарсан үед зөвшилцөх. ОБЕГ болон үүрэн телефоны операторын зүгээс санал гарсан тохиолдолд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраар дамжуулах.

#### 9 . Хүчин төгөлдөр байх хугацаа

Уг санамж бичиг нь 201X оны XX сарын XX өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Уг санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацаа нь санамж бичиг хүчин төгөлдөр

болох өдрөөс 1 жилийн хугацаатай байх ба ОБЕГ болон үүрэн телефоны операторын талуудаас зөвшилцөх санал гараагүй тохиолдолд хүчин төгөлдөр байх хугацааг 1 жилээр сунгана.

Жич: Үүрэн телефоны операторын компаниуд:

- 1 MobiCom
- 2 Skytel
- 3 Unitel
- 4 G-Mobile

#### ( 6 ) Санамж бичгийн төслийн талаар санал солилцох

Санамж бичгийн төслийн тухайд санамж бичиг байгуулах талуудыг оролцуулан санал солилцоно. Санамж бичгийн төслийн агуулгад асуудал байгаа тохиолдолд асуудал бүхий агуулга болон өөрчлөлт оруулах чиглэлийг тогтоон санамж бичгийн төслийг өөрчлөн засварлана.

#### 8 . Санамж бичиг эцэслэн гаргах

Санамж бичгийн агуулга тодорхой бөгөөд бүрэн боловсруулж дууссан үед санамж бичгийг эцэслэн гаргана. Санамж бичиг гаргах шат дараалал доорхын дагуу байна:

- ① ОБЕГ дотроо санал солилцох
- ② ОБЕГ-ын хуулийн зөвлөхөөр хянуулах
- ③ ОБЕГ-ын ГШУГ-ын даргаар батлуулах
- ④ Холбогдох байгууллагуудтай санал солилцох
- ⑤ ОБЕГ-ын даргаар батлуулах

#### 9 . Санамж бичиг боловсруулах ажлын хэсэг

Цаашид санамж бичгийг үргэлжлүүлэн боловсруулах, шинэчлэх зорилгоор санамж бичиг боловсруулах ажлыг хариуцах мэргэжилтэнг томилох. Санамж бичиг боловсруулах ажлыг хариуцах мэргэжилтэн нь санамж бичигт тусгагдах тухайн салбарын мэргэжилтэнг багтаасан ажлын хэсэг байгуулах.

#### 1 0 . Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгах

Боловсруулсан санамж бичгийн талаар Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгах.

#### 1 1 . Санамж бичиг боловсруулах гарын авлагыг шинэчлэх

Санамж бичиг байгуулах явцад тус гарын авлагыг шинэчлэх, нэмэлт оруулах

шаардлагатай тохиолдолд тухайн асуудалтай гэж үзэж байгаа агуулга, өөрчлөлт оруулах чиг баримжааг тодорхой болгосны үндсэн дээр засвар оруулах бөгөөд өөрчлөлт оруулсан буюу шинэчилсэн тухай тэмдэглэлд өөрчлөлт оруулсан өдөр, хувилбарын дугаар, өөрчлөлт оруулсан мэргэжилтэн зэргийн мэдээллийг оруулж үлдээнэ.

- 1) Нэмэлт, засвар оруулах агуулгын талаар санал солилцох
- 2) Нэмэлт болон засварыг тусгаж оруулах

## 1 2 . Санамж бичиг боловсруулах гарын авлагыг өөрчлөх

Хүчинтэй хугацаа нь дуусаагүй санамж бичгийг өөрчлөх тохиолдолд тухайн санамж бичигт өөрчлөлт болон засвар оруулах агуулгыг тодорхойлох шаардлагатай. Санамж бичигт өөрчлөлт, засвар оруулах агуулгын талаар ярилцсаны үндсэн дээр санамж бичигт өөрчлөлт, засвар оруулж, өмнөх санамж бичгийг хүчингүй болгож, өөрчлөлт болон засвар оруулсан санамж бичгийг шинээр гаргана. Өөрчлөлт оруулсан огноо, дугаар, өөрчлөлт оруулсан албан тушаалтан, мэргэжилтний нэр гэх зэрэг тэмдэглэлийг нэмж оруулна.

- 1) Санамж бичигт оруулсан өөрчлөлт, засварын агуулга болон санамж бичгийн төсөлд нэмж оруулах
- 2) Санамж бичгийн өмнөх хувилбарыг хүчингүй болгох
- 3) Өөрчлөлт болон засвар оруулсан санамж бичгийг гаргах

## 1 3 . Санамж бичиг боловсруулах гарын авлагыг хүчингүй болгох

Хүчинтэй хугацаа нь дуусаагүй санамж бичгийг хүчингүй болгох тохиолдолд тухайн санамж бичгийн асуудал бүхий агуулга болон санамж бичиг шаардлагагүй болсон шалтгааныг тодорхой болгох шаардлагатай. Дээрх асуудлын талаар ярилцсаны үндсэн дээр санамж бичгийг хүчингүй болгоно. Санамж бичгийг хүчингүй болгосон огноо, дугаар, өөрчлөлт оруулсан албан тушаалтан, мэргэжилтний нэр гэх зэрэг тэмдэглэлийг нэмж оруулна.

- 1) Санамж бичгийн төслийн агуулга болон хүчингүй болгох тухай шалтгааны талаар ярилцах
- 2) Санамж бичгийн өмнөх хувилбарыг хүчингүй болгох
- 3) Өөрчлөлт болон засвар оруулсан санамж бичгийг гаргах

# Хамтын ажиллагааны санамж бичиг боловсруулахад ашиглах материал

Санамж бичгээр зохицуулах салбар

Цагийн байдал.....	1
1. Харилцаа холбоо .....	1
(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ .....	1
(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл .....	1
(3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал .....	1
(4) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ.....	3
(5) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс.....	4
2. Түргэн тусламж, эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж .....	6
(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ .....	6
(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл .....	6
(3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал .....	6
(4) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ.....	7
(5) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс.....	8
3. Хүн хүч.....	10
(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ .....	10
(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл .....	10
(3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал .....	10
(4) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ.....	11
(5) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс.....	12
4. Зам тээвэр.....	12
(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ .....	12
(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл .....	12
(3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал .....	12
(4) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ.....	13
(5) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс.....	14
5. Боловсрол, дадлага сургууль.....	15
(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ .....	15
(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл .....	15
(3) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ.....	15
(4) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс.....	16
6. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа .....	17
(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ .....	17
(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл .....	17
(3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал .....	17

(4) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс .....	18
7. Гэртээ харихад хүндрэл гарсан иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа .....	19
(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ .....	19
(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл .....	19
(3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал .....	19
(4) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс .....	20

Цагийн байдал

	Цагийн байдал	1. Харилцаа холбоо	2. Түргэн тусламж, эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж	3. Хүн хүч	4. Зам тээвэр	5. Боловсрол, дадлага сургууль	6. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа	7. Гэртээ харихад хүндрэл гарсан иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа
Тайван цагт	Гамшгаас хамгаалах тухай ойлголт мэдлэгийг дээшлүүлэх					Сургууль, компани дээрх боловсрол	Сургууль, компани дээрх арга зүйн сургалт удирдлага	
	Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах	Мэдээллийн эх үүсвэрийг нэг болгох Харилцаа холбооны байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах Харилцаа холбооны шугамыг олшруулах Харилцаа холбооны хойшлуулшгүй сэргээн босголтын төлөвлөгөөний төсөл боловсруулах	Эмнэлгийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж бүхий барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах	Нутгийн захиргааны барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах Тусламж үзүүлэх ажилтан илгээх маршрутыг тогтоох Илгээх маршрутын бэлэн байдлыг хангах	Замын хөдөлгөөнийг нөхөн сэргээх төлөвлөгөөний төсөл боловсруулах Бараа материалын шуурхай тээвэрлэлтийн маршрутыг тогтоох, маршрутын нэвтрэх байдлыг хангах	Сургууль, компани дээрх дадлага сургууль	Сургууль, компани дээрх тусламж дэмжлэг	Гэртээ харихад хүндрэл гарсан иргэдэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулах
	Нөөц бүрдүүлэх		Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж					
Гамшгийн үед	Барилга нурах	Компанийн барилга нурах Харилцаа холбооны байгууламж гамшигт нэрвэгдэх Харилцаа холбоо тасрах	Эмнэлгийн барилга нурах Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Нутгийн захиргааны барилга байгууламж нурах Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл эвдэрч гэмтэх	Компанийн барилга нурах		Гал түймэртэй тэмцэх газрын барилга нурах Гал унтраах машин эвдэрч гэмтэх	
	Амь алдагсад гарах	Ажилтан, албан хаагч амь алдах	Эмнэлгийн ажилтан, албан хаагч амь алдах	Захиргааны ажилтан, албан хаагч амь алдах	Ажилтан, албан хаагч амь алдах		Гал түймэртэй тэмцэх газрын албан хаагч амь алдах	
	Замын хөдөлгөөн зогсох	Мэдээллийн материал цуглуулах хүндрэлтэй болох	Түргэн тусламжийн багийн хөдөлгөөнд хүндрэл үүсэх	Тусламж үзүүлэх ажилтны хөдөлгөөнд хүндрэл үүсэх	Тээврийн хэрэгсэл бүрэн зогсох Логистик бүрэн зогсох		Гал унтраах машины хөдөлгөөнд хүндрэл үүсэх	Өртөө, автобусны буудал гэх зэрэг газруудад гэртээ харихад хүндрэл гарсан иргэд олноороо саатах
	Гал түймэр гарах	Харилцаа холбооны дамжуулах дэд бүтцийн гэмтлээс үүдэж холбоо тасрах	Түргэн тусламжийн багийн үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Оршин суугчдыг бүрэн нүүлгэн шилжүүлэх	Тээврийн хэрэгслийн зорчих замыг өөрчлөх Логистикт эмх замбараагүй байдал үүсэх		Гал түймрийн нөхцөл байдлыг тогтооход хүндрэл үүсэх Үр дүнтэй гал унтраах үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй болох	Мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан гэртээ харихад хүндрэл гарсан иргэд төөрөх
	Тог тасрах	Харилцаа холбооны тоног төхөөрөмж ажиллагаагүй болох	Эмнэлгийн тоног төхөөрөмж ажиллагаагүй болох	Засаг захиргааны үйл ажиллагаа удааширч саатах	Автобус, төмөр замын хөдөлгөөх зогсох Бараа материалын хуваарилан нийлүүлэлт удаашрах, эсвэл зогсох		Тушаал, зааварчилгаа өгөхөд хүндрэл үүсэх	
	Харилцаа холбоо тасрах		Түргэн тусламжийн багтай холбоо барихад хүндрэлтэй болох	Засаг захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоо муудах Тусламж үзүүлэх ажилтантай холбоо барихад хүндрэл үүсэх	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөхцөл байдлыг тодорхой болгоход хүндрэл үүсэх Бараа материалын тээвэрлэлтийн нөхцөл байдлыг тодорхой болгоход хүндрэл үүсэх		Гал түймэртэй тэмцэх хүч хэрэгслийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулахад хүндрэл үүсэх	Мэдээлэлгүй болох
	Инженерийн шугам сүлжээ гэмтэх	Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх		Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Бухимдал үүсэх
	Дулаан хангамж зогсох (өвлийн улиралд)	Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх		Үйл ажиллагаанд хүндрэл үүсэх	Амьдрахад хүндрэл үүсэх
Нүүлгэн шилжүүлэгсэд	Мэдээлэл өгөх	Гэмтсэн иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, эмнэлэгт хүргэх	Түр хоргодох байрыг нээн ажиллуулах Түр хоргодох байрны удирдлага зохион байгуулалт Бараа материалын хангамжийг бататгах	Түр хоргодох байр руу шилжин байрших Түр хоргодох байранд бараа материал тээвэрлэн хүргэх		Түр хоргодох байранд гал гарч тархахаас сэргийлэн хамгаалах	Түр хоргодох байр руу нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах	

## 1. Харилцаа холбоо

### (1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ

Японы жишээ	Холбогдох байгууллага
<ul style="list-style-type: none"> <li>• Сэрэмжлүүлэх мэдээлэл хүлээн авах</li> <li>• Гамшиг, гамшгаас хамгаалах тухай мэдээллийг иргэдэд хүргэх</li> <li>• Гамшиг үүссэн үеийн харилцаа холбооны техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цаг уур, орчны шинжилгээний газар</li> <li>• Сонин, телевиз, радио гэх зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага</li> <li>• Суурин болон үүрэн телефон, интернэтийн компаниуд</li> </ul>

### (2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл

- Мэдээлэл цуглуулах, солилцох, дамжуулах
  - 1) Мэдээлэл цуглуулах
    - Мэдээлэл цуглуулах шат дарааллыг тодорхой болгох
    - Гамшигт нэрвэгдсэн үед ч мөн гүйцэтгэх боломжтой мэдээлэл цуглуулах ажил
  - 2) Мэдээлэл солилцох
    - Мэдээллийг хамтран ашиглах шат дарааллыг тодорхой болгох
    - Гамшгаас хамгаалах холбогдох байгууллага дотор мэдээллийг хамтран ашиглах
  - 3) Мэдээлэл дамжуулах
    - Иргэдэд чиглэсэн мэдээлэл дамжуулах шат дарааллыг тодорхой болгох
    - Мэдээлэл дамжуулах сувгийг олшруулах

### (3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал

Япон дахь мэдээллийн урсгалын жишээг доор үзүүлэв

	Мэдээлэл өгөх байгууллага	Гамшгаас хамгаалах штаб	Гамшгаас хамгаалах холбогдах байгууллага	Орон нутгийн засаг захиргаа, иргэд
	Мэдээлэл цуглуулах			
		Мэдээлэл солилцох		
	Мэдээлэл дамжуулах			
Гамшиг үүссэнээс хойш 1 цагийн хугацаанд	Газар хөдлөлтийн хэмжилт хийдэг байгууллага → Орон нутгийн засаг захиргаа →  Гал түймэртэй тэмцэх байгууллага → Газар зохион байгуулалтын байгууллага →  Инженерийн шугам сүлжээний	Газар хөдлөлтийн мэдээлэл Ажилтнууд цугларах тухай мэдээлэл Хохирлын талаарх мэдээлэл  Гал түймэр, хамрах хүрээний талаарх мэдээлэл Гол мөрөн, замын хохирол Замын хөдөлгөөн хаасан тухай мэдээлэл ИШС-ий хохирлын	Мэдээлэл солилцох	Ерөнхий мэдээлэл

	компаниуд → Зам тээврийн компаниуд →	талаарх мэдээлэл Зам тээврийн хэрэгслийн хохирлын талаарх мэдээлэл	Мэдээлэл солилцох	
Гамшиг үүссэнээс хойш 3 хоногийн дотор	Орон нутгийн засаг захиргаа →  Түргэн тусламж үзүүлдэг компаниуд →	Нүүлгэн шилжүүлэх тушаал гарсан тухай мэдээлэл Түр хоргодох байрны тухай тайлбар мэдээлэл Аврах ажлын талаарх мэдээлэл Тусламжийн бараа материалын талаарх мэдээлэл	Мэдээлэл солилцох	Ерөнхий мэдээлэл
Гамшиг үүссэнээс хойш 3 хоногийн дараа	Орон нутгийн засаг захиргаа →  Инженерийн шугам сүлжээний компаниуд → Зам тээврийн компаниуд → Эмнэлгийн байгууллага →	Түр хоргодох байрны үйл ажиллагааны нөхцөл байдал Түр хоргодох байрны бараа материалын талаарх мэдээлэл ИШС-ий хохирлын талаарх мэдээлэл Зам тээврийн хэрэгслийн хохирлын талаарх мэдээлэл Эмнэлгийн байгууллагын талаарх мэдээлэл	Мэдээлэл солилцох	Ерөнхий мэдээлэл

Мэдээлэл дамжуулах шат дарааллын тухай жишээг доор үзүүлэв





Дээрх мэдээлэл дамжуулах ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай харилцаа холбооны техник хэрэгслийг гамшгийн үед доорхи байдлаар ашиглах

Харилцаа холбооны техник хэрэгсэл		Агуулга	Санамж бичигтэй холбоотой агуулга
Төрийн байгууллагын мэдээлэл солилцох техник хэрэгсэл	Яам агентлагууд хоорондын WAN сүлжээ	Яам агентлаг бүр холбогдож гамшгийн үед харилцаа холбоогоор хангагдах	байхгүй
	Яам агентлагийн WAN сүлжээ	Яам агентлагын салбар байгууллагууд холбогдож гамшгийн үед харилцаа холбоогоор хангагдах	
	Цагдаа, Гал унтраах байгууллагын радио холбоо	Бүх улсын цагдаа, гал унтраах байгууллага холбогдож гамшгийн үед харилцаа холбоогоор хангагдах	
	Орон нутгийн засаг захиргааны WAN сүлжээ	Орон нутгийн засаг захиргаа холбогдож гамшгийн үед харилцаа холбоогоор хангагдах	
	Орон нутгийн засаг захиргааны радио холбоо	Хамрагдах бүс доторх харилцаа холбоо, олон нийтийн мэдээллийн байгууламжтай холбогдох Орон нутгийн засаг захиргаа гамшгийн үед харилцаа холбоогоор хангагдах	
Хувийн хэвшлийн үзүүлэх харилцаа холбооны үйлчилгээ	Суурин телефоны шугам	Ачаалал нэмэгдсэнээс үүдэж харилцаа холбоо тасрахаас сэргийлэх арга хэмжээ, гамшгийн үед харилцаа холбоогоор хангах ажлыг “Цахилгаан холбоо харилцааны үйл ажиллагааны хууль”-ийн дагуу хэрэгжүүлэх	Гамшгаас хамгаалах дадлага сургууль явуулах тухай санамж бичгийн жишээ байгаа
	Үүрэн телефоны шугам		
	Интернэт шугам		
	Агаарын WAN/LAN шугам		

( 4 ) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ

Бүлэг, зүйл		Тусгагдсан агуулга	Тайлбар
Харилцаа холбоо	Сонин, телевиз, радио	Зорилго	Хоккайдо муж – Хэвлэл мэдээллийн байгууллага (Мэдээлэл дамжуулах тухай (сонин) ба Мэдээлэл дамжуулах тухай (телевиз, радио)) <a href="http://www.pref.hokkaido.jg.jp/sm/ktk/28keikakusyusei/2805shiryuu/08-01.pdf">http://www.pref.hokkaido.jg.jp/sm/ktk/28keikakusyusei/2805shiryuu/08-01.pdf</a>
		Хэвлэл мэдээллийн байгууллагад хүсэлт гаргах	
		Хүсэлт гаргах шат дараалал	
		Мэдээлэл дамжуулах	
		Гамшгийн үед мэдээлэл өгөх	
		Холбоо харилцааны ажилтан илгээх	
		Хариуцаж ажиллах ажилтан	
		Санамж бичгийн үйлчлэх хүрээ	
		Санал солилцох, зөвшилцөх	
		Санамж бичиг байгуулах талууд	
		Хүчин төгөлдөр байх хугацаа	
		Санамж бичиг хадгалах	

Үүрэн телефон	Зорилго	Санамж бичиг байгуулах эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх нөхцөл, байгуулах талууд, зорилго зэргийг тодорхой заах	Аомори хот – Эн Ти Ти Докомо (Гамшгийн үеийн харилцаа холбооны төнөг төхөөрөмжийг нөхөн сэргээх ажлын харилцан туслалцах тухай санамж бичиг)  https://www.city.aomori.aomori.jp/kikikanri/anzen-kinkyu/bousai-syoubou/documents/shiryu1.pdf
	Гамшгийн үед мэдээлэл өгөх	Шаардлагатай мэдээллээр хангах (гамшигт нэрвэгдсэн байдлын талаарх мэдээлэл, замын хөдөлгөөний зохицуулалт гэх зэрэг) талаар тодорхой заах	
	Холбоо харилцааны ажилтан илгээх	Гамшгаас хамгаалах штаб руу ажилтан, албан хаагч илгээх талаар тодорхой заах	
	Харилцаа холбооны хойшлуулшгүй сэргээн босголт	Тоног төхөөрөмжийн хойшлуулшгүй сэргээн босголтын үр дүнд харилцаа холбооны нөхцөл байдлыг хэвийн болгох, харилцаа холбооны хөдөлгөөнт станц илгээх талаар тодорхой заах	
	Хойшлуулшгүй сэргээн босголтын ажилд тусламж үзүүлэх	Тоног төхөөрөмжийн хойшлуулшгүй сэргээн босголтын зэрэгцээ үүрэн телефоны оператор компаниас замын хойшлуулшгүй сэргээн босголтод дэмжлэг үзүүлэх талаар тодорхой заах	
	Хойшлуулшгүй сэргээн босголтын орчин нөхцлийг бүрдүүлэхэд тусламж үзүүлэх	Тоног төхөөрөмжийн хойшлуулшгүй сэргээн босголтод шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хадгалах газар, автомашины зогсоолоор хангахад төрийн байгууллагаас тусламж үзүүлэх талаар тодорхой заах	
	Хэвийн байдалд буцаан оруулах	Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хадгалах газар, автомашины зогсоолыг хэвийн байдалд буцаан оруулах тухай тодорхой заах	
	Хохирлын нөхөн төлбөр	Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хойшлуулшгүй сэргээн босголтын үед санаатайгаар гэмтэл учруулсан тохиолдолд нөхөн төлбөр ногдуулах талаар тодорхой заах	
	Гамшгаас хамгаалах дадлага сургуулийн ажилд дэмжлэг үзүүлэх	Гамшгаас хамгаалах дадлага сургуулийн үед үүрэн телефоны оператор компанийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл байршуулах талбай, автомашины зогсоолыг түр ашиглуулах талаар тодорхой заах	
	Хариуцаж ажиллах ажилтан	Санамж бичиг байгуулах байгууллагуудын хариуцаж ажиллах ажилтан, албан хаагчийн тухай тодорхой заах	
	Санамж бичгийн үйлчлэх хүрээ	Санамж бичиг хүчин төгөлдөр болох өдрийг тодорхой заах	
	Санал солилцох, зөвшилцөх	Маргаан гарсан тохиолдолд зөвшилцөх, санал солилцох аргачлалыг тодорхой заах	
	Санамж бичиг байгуулах талууд	Санамж бичиг байгуулах талуудын тухай тодорхой заах	
	Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах	
	Санамж бичиг хадгалах	Санамж бичгийг талууд өөр дээрээ хадгалах тухай тодорхой заах	

(5) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс

1) Мэдээлэл цуглуулах

- Мэдээлэл найдвартай цуглуулах > Мэдээлэл цуглуулах сувгийг олшруулах, мэдээлэл хангамж саатсан үед мэдээлэл цуглуулах тогтолцоонд холбогдох байгууллагуудтай хамтарч урьдчилан зохицуулалт хийх
- Хууль тогтоомжинд үндэслэн мэдээлэл өгөх байгууллагатай уялдаа холбоо сайжруулах талаар журамлах > Зохих баримт бичгийн төрлийг сонгож, түүнийг боловсруулах

2) Мэдээлэл солилцох

- Мэдээлэл найдвартай солилцох > Мэдээлэл солилцох техник хэрэгслийг төрөлжүүлэх, мэдээллийн хангамж саатсан үед мэдээлэл солилцох тогтолцоонд

холбогдох байгууллагуудтай хамтарч урьдчилан зохицуулалт хийх

- Хууль тогтоомжинд үндэслэн гамшгаас хамгаалах холбогдох байгууллагатай уялдаа холбоог сайжруулах талаар журамлах > Зохих баримт бичгийн төрлийг сонгож, түүнийг боловсруулах
- 3) Мэдээлэл дамжуулах
- Цуурхал дэгдэхээс урьдчилан сэргийлэн, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны зүй зохистой байдлыг хангах > Мэдээллийн эх үүсвэрийг нэг болгох, хэвлэлийн бага хурал зохион байгуулах
  - Мэдээлэл найдвартай дамжуулах > Мэдээлэл дамжуулах техник хэрэгслийг төрөлжүүлэх, мэдээллийн хангамж саатсан үед мэдээлэл дамжуулах тогтолцоог холбогдох байгууллагуудтай хамтарч урьдчилан бүрдүүлэх
  - Шаардлагатай мэдээлэл өгөх > Иргэдэд дэлгэрэнгүй нарийн мэдээллийг хүргэх
  - Хууль тогтоомжинд үндэслэн мэдээлэл дамжуулах талаар журамлах > Зохих баримт бичгийн төрлийг сонгож, түүнийг боловсруулах
- 4) Харилцаа холбооны техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах
- Харилцаа холбооны техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах > Телефон хэрэглээг хязгаарлах, дата харилцааг түлхүү ашиглах гэх зэрэг гамшгийн үед авах арга хэмжээ
  - Зөв зохистой мэдээлэл дамжуулах > Цаг хугацааны байдалтай нийцсэн мэдээлэл дамжуулах
  - Зохих хууль тогтоомжинд үндэслэн харилцаа холбооны компанитай уялдаа холбоог сайжруулах талаар журамлах > Зохих баримт бичгийн төрлийг сонгож, түүнийг боловсруулах
- 5) Хэвлэл мэдээллийн байгууллагатай уялдаа холбоог сайжруулах
- Цуурхал дэгдэхээс урьдчилан сэргийлэх > Мэдээллийн эх үүсвэрийг нэг болгох
  - Зөв зохистой мэдээлэл дамжуулах > Цаг хугацааны байдалтай нийцсэн мэдээлэл дамжуулах
  - Зохих хууль тогтоомжинд үндэслэн хэвлэл мэдээллийн байгууллагатай уялдаа холбоог сайжруулах талаар журамлах > Зохих баримт бичгийн төрлийг сонгож, түүнийг боловсруулах

## 2. Түргэн тусламж, эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж

### (1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ

Японы жишээ	Холбогдох байгууллага
<ul style="list-style-type: none"> <li>Гамшгийн үеийн эмнэлгийн тусламжийн үйл ажиллагаа</li> <li>Гамшгийн үеийн эм бэлдмэлийн нөөц</li> <li>Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эмнэлгийн байгууллага, анагаах ухааны боловсролын байгууллага</li> <li>Эм үйлдвэрлэгч компани, эмийн худалдааны компани, эмийн жижглэнгийн худалдааны компани</li> <li>Эмнэлгийн байгууллага, эм үйлдвэрлэгч компани, эм бэлдмэлийн ханган нийлүүлэлтийн компани, эмийн худалдааны компани</li> </ul>

### (2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл

#### 1) Түргэн тусламж


- Эмнэлгийн тусламж үзүүлэх байгууламжийг байгуулах
- Эмнэлгийн үйлчилгээний талаарх мэдээлэл цуглуулах
- Эмнэлгийн үйлчилгээний баг бүрдүүлэх, илгээх
- Хүнд гэмтэл авсан хүмүүсийг төв эмнэлэгт тээвэрлэн хүргэх, хөрш зэргэлдээ орон нутгийн эмнэлгийн байгууллагад хүргэх

#### 2) Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж

- Ханган нийлүүлэх тухай хүсэлт хүлээн авах нэгж байгуулах
- Хомсдол үүссэн үед ханган нийлүүлэх газрыг тогтоох

### (3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал

#### 1) Түргэн тусламж



(4) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ

Бүлэг, зүйл		Тусгагдсан агуулга	Тайлбар
2. Түргэн тусламж ба эмнэлгийн үйлчилгээ	Гамшгийн үеийн эмнэлгийн үйлчилгээ	Зорилго	Санамж бичигт байгуулах эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх нөхцөл, байгуулах талууд, зорилго зэргийг тодорхой заах
		Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх хугацаа (гамшиг үүссэнээс хойш 14 хоног)-г тодорхой заах
		Эмнэлгийн тусламжийн баг илгээх	Илгээх нөхцөл, хүсэлт гаргах аргачлал, эмнэлгийн тусламжийн тогтолцоо (эмнэлгийн тусламжийн баг бүрдүүлэх, илгээх)-г тодорхой заах
		Гамшгийн үеийн эмнэлгийн тусламжийн төлөвлөгөө боловсруулах болон хүлээлгэн өгөх	Эмнэлгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааны үед хүлээлгэн өгөх шаардлагатай баримт бичиг (эмнэлгийн тусламж үзүүлэх төлөвлөгөө боловсруулах, хүлээлгэн өгөх)-ийн тухай тодорхой заах
		Эмнэлгийн тусламжийн багийн албан үүрэг	Тухайн эмнэлгийн тусламж үзүүлэх багийн гүйцэтгэх боломжтой эмнэлгийн үйлчилгээ, үйл ажиллагааны үндсэн хэлбэр, ажлын агуулга (эмнэлгийн үйлчилгээ, эх барих, шарил г.м.)-ын талаар тодорхой заах
		Гамшгийн үеийн мэдээлэл өгөх	Эмнэлгийн тусламж үзүүлэх багийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг өгөх (гамшигт нэрвэгдсэн тухай мэдээлэл, замын хөдөлгөөний зохицуулалт г.м.) талаар тодорхой заах
		Эмнэлгийн тусламж үзүүлэх багт өгөх тушаал г.м.	Тушаал өгөх албан тушаалтны тухай тодорхой заах
		Эм бэлдмэлийн нөхөн хангалт	Эмнэлгийн тусламж үзүүлэх багийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа материалаар хангах (эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж г.м.) тухай тодорхой заах
		Хүлээн авах эмнэлгийг сонгох	Гэмтэгсэд болон өвчтөн хүлээн авах эмнэлгийг сонгох албан тушаалтны талаар тодорхой заах
		Эмнэлгийн үйлчилгээний хөлс	Эмнэлгийн тусламж үзүүлэх баг гамшигт нэрвэгдэгсдээс авах эмнэлгийн үйлчилгээний хөлс (үнэ төлбөргүй байх)-ийн талаар тодорхой заах
		Зардлыг хариуцах	Санамж бичигт дурдсан ажлыг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлыг хариуцах талын тухай тодорхой заах
		Хариуцах зардлын ангилал болон хэмжээ	Хариуцах зардлыг ангилж, тухайн хүрээг тодорхой заах
		Зардлыг нэхэмжлэх хэлбэр	Зардлыг нэхэмжлэх хэлбэр болон аргачлалын талаар тодорхой заах
		Зөвшилцөх	Зардлын хүрэнээс гадуур үүссэн зардлыг хэрхэх талаар зөвшилцөх тухай тодорхой заах
		Хот, тосгон болон бүс нутгийн эмч нарын нийгэмлэгтэй уялдаа холбоотой ажиллах	Хот, тосгоны хэрэгжүүлэх эмнэлгийн үйл ажиллагаатай уялдаа холбоог хангах, зохицуулалтын талаар хариуцаж ажиллах ажилтны тухай тодорхой заах
Нарийвчилсан заалтууд	Нарийвчилсан заалтуудыг оруулснаар санамж бичгийн агуулгыг нарийвчлан тогтоох тухай тодорхой заах		
Санамж бичигт байгуулах талууд	Санамж бичигт байгуулах талуудыг тодорхой заах		

Хоккайдо муж – Эмнэлгийн байгууллага (Эмнэлгийн үйлчилгээ, эх барих, шарилын зохицуулалт (газарт оршуулах болон шарил түр хадгалах үйлчилгээнээс бусад), гамшгийн үеийн эмнэлгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааны тухай санамж бичиг, Гамшгийн үеийн шүдний эмчилгээ үзүүлэх үйл ажиллагааны тухай санамж бичиг, Гамшгийн үеийн эмнэлгийн зориулалтаар ашиглах хийн хангамжийн тухай санамж бичиг, зэрэг)

<http://www.pref.hokkaido.lg.jp/sm/ktk/28keikakusyuuisei/2805shiryuu/08-031.pdf>

Гамшгийн үед эм бэлдмэлийн нөөцөөр хангах ажил	Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах	<p>Хоккайдо муж – Эм бэлдмэлийн компани (Гамшгийн үед эм бэлдмэлийн нөөцөөр хангах ажил)</p> <p><a href="http://www.pref.hokkaido.lg.jp/sm/ktk/28keikakusyuusei/2805shiryuu/08-031.pdf">http://www.pref.hokkaido.lg.jp/sm/ktk/28keikakusyuusei/2805shiryuu/08-031.pdf</a></p> <p>※Энэхүү ажил нь Ажил гүйцэтгэх гэрээгээр зохицуулагдаж байна</p>
	Санамж бичиг хадгалах	Санамж бичгийг талууд өөр дээрээ хадгалах тухай тодорхой заах	
	Зорилго	Санамж бичиг байгуулах эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх нөхцөл, байгуулах талууд, зорилго зэргийг тодорхой заах	
	Эм бэлдмэлийн нөөцийн ханган нийлүүлэлт	Ханган нийлүүлэлтийн ажлын ерөнхий агуулгын талаар тодорхой заах	
	Ханган нийлүүлэлтийн ажлын төсөв	Ханган нийлүүлэлтийн ажлын төсөв (гэрээний баталгааны мөнгө г.м.)-ийн талаар тодорхой заах	
	Эрх үүрэг шилжүүлэх	Ханган нийлүүлэлтийн ажлыг бусдад шилжүүлэхийг хориглох тухай тодорхой заах	
	Ханган нийлүүлэлтийн ажлыг бусдаар гүйцэтгүүлэх	Ханган нийлүүлэлтийн ажлыг бусдаар гүйцэтгүүлэхийг хориглох тухай тодорхой заах	
	Холбоо барих хариуцлагатай этгээд	Санамж бичиг байгуулах 2 талын байгууллагын хариуцаж буй ажилтны талаар тодорхой заах	
	Өөрчлөх тухай санал гаргах	Ханган нийлүүлэлтийн ажил гүйцэтгэж байгаа компанид зөрчлийг арилгуулах талаар санал оруулах эрхийн тухай тодорхой заах	
	Тайлагнах үүрэг	Осол гэх зэргийн талаар тайлагнах үүргийн тухай тодорхой заах	
	Ажлын агуулгыг өөрчлөх	Ажлын агуулгын өөрчлөлтийн талаар мэдэгдэх, өөрчлөлт хийснээс шалтгаалсан хохирлын нөхөн төлбөрийн тухай тодорхой заах	
	Судалгаа	Ажлын явцын талаар судалгаа явуулах тухай тодорхой заах	
	Үр дүнгийн тайлан	Ажлын үр дүнгийн тухай тайланг хүлээлгэн өгөх үүргийн талаар тодорхой заах	
	Ажлын төлбөрийн нэхэмжлэл болон төлбөр гүйцэтгэх	Төлбөр хийх хугацаа, төлбөр гүйцэтгэх газрын тухай тодорхой заах	
	Хугацаандаа багтаан төлбөр гүйцэтгээгүй тохиолдолд	Төлбөрийг хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд тооцох алданги, торгуулийн тухай тодорхой заах	
	Гэрээг цуцлах эрх	Ажил гүйцэтгэхэд хүндрэлтэй болсон тохиолдолд гэрээг өөрчлөх, цуцлах нөхцлийн тухай тодорхой заах	
	Хохирлын нөхөн төлбөр	Ажил гүйцэтгэх явцад мужид хохирол учруулсан тохиолдолд үүсэх нөхөн төлбөрийн тухай тодорхой заах	
Нууц хадгалах	Нууц хадгалах үүргийн тухай тодорхой заах		
Шүүхээр шийдвэрлүүлэх	Гэрээг хэрэгжүүлэх явцад асуудал гарсан тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэх тухай тодорхой заах		
Нарийвчилсан заалтууд	Нарийвчилсан заалтуудыг оруулснаар санамж бичгийн агуулгыг нарийвчлан тогтоох тухай тодорхой заах		
Санамж бичиг байгуулах талууд	Санамж бичиг байгуулах талуудыг тодорхой заах		
Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах		
Санамж бичиг хадгалах	Санамж бичгийг талууд өөр дээрээ хадгалах тухай тодорхой заах		

( 5 ) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс

- Гэмтэл бэртэл авсан хүмүүс олноор гарах>Тэргүүн ээлжинд эмчилгээ хийлгэх хүмүүсийг газар дээр нь сонгох
- Замын түгжрэл үүсэх>Замын хяналт удирдлага хариуцаж буй газар хэлтсийн мэдээллийг хүргэх
- Краш синдром буюу удаан хугацаанд хавчуулагдан дарагдсаны хам шинжийн үед тусламж үзүүлэх>Тусламж үзүүлэх нэгж байгуулах
- PTSD буюу сэтгэл зүйн гэмтлийн дараах хямралын үед тусламж үзүүлэх >Тусламж үзүүлэх нэгж байгуулах
- Эм бэлдмэл болон эмнэлгийн багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх ажлыг захиалгаар гүйцэтгүүлэх>Ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шаардлагатай

### 3. Хүн хүч

(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ

Японы жишээ	Холбогдох байгууллага
<ul style="list-style-type: none"> <li>Хүн хүчний бэлэн байдлыг хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллага (гамшгаас хамгаалах нутаг дэвсгэрийн мэдээлэл дамжуулах ажилтан &gt;Орон нутгийн засаг захиргаа)</li> </ul>

(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл

- Том хэмжээний гамшгийн үед ажиллах ажилтан, албан хаагч дутагдах
- Гал түймэртэй тэмцэх хүч хэрэгсэл болон эмнэлгийн үйлчилгээний ажилтан дутагдах
- Өөрийгөө хамгаалах хүчнийг гамшгийн үед татан оролцуулах тухай хүсэлт хүлээн авах нэгж байгуулах

(3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал





(4) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ

Бүлэг, зүйл		Тусгагдсан агуулга	Тайлбар
3. Бараа материал ба хүн хүч	Хүн хүчний бэлэн байдлыг хангах	Зорилго	Санамж бичиг байгуулах эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх нөхцөл, байгуулах талууд, зорилго зэргийг тодорхой заах
		Муж дамнасан харилцан туслалцаа	Бүс нутгийн харилцан туслалцах үйл ажиллагааны хүрээ
		Харилцан туслалцах үйл ажиллагааны агуулга	Иргэдийг нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд үзүүлэх тусламж, хойшлуулшгүй сэргээн босголт г.м.
		Тушаал өгөх	Шийдвэр гаргах албан тушаалтан, тушаал өгөх тогтолцоог тодорхой заах
		Тусламж авах тухай хүсэлт гаргах	Тусламж авах тухай хүсэлт гаргах аргачлалыг тодорхой заах
		Хүсэлтийн бүлэг, заалт	Хүч хэрэгсэл, байгууламж ба ажлын төрөл, мэргэжил ба мэргэжилтний тоо, тусламж үзүүлэх бүс нутаг ба хүрэх зам, тусламж үзүүлэх хугацаа, бусад
		Зардлыг хариуцах	Гамшигт нэрвэгдсэн орон нутгийн засаг захиргаа зардлыг хариуцах, нэхэмжлэх аргачлал
		Нарийвчилсан заалтууд	Нарийвчилсан заалтуудыг оруулах тухай тодорхой заах
		Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах
		Гамшгийн үеийн эм бэлдмэл, тоног төхөөрөмжийн хангамжийн тухай санамж бичиг	Зорилго
Хүсэлтийн агуулга	Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийн тухай хүсэлтийн агуулгын ерөнхий тайлбар		
Хүсэлт гаргах шат дараалал	Шалтгаан, хүсэлт гаргах аргачлал, агуулга, бусад зүйлийг тодорхой заах		
Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийг хэрэгжүүлэх	Хангамжийн ажилд боломжийн хирээр дэмжлэг үзүүлэх тухай тодорхой заах		
Гамшгийн үеийн мэдээлэл	Муж нь гамшигт нэрвэгдсэн талаарх мэдээлэл болон замын хөдөлгөөний зохицуулалтын талаарх мэдээллийг хүргэх тухай тодорхой заах		
Эм бэлдмэл, тоног төхөөрөмж хүлээлгэн өгөх	Хүлээлгэн өгөх газар, тоо ширхэгийг нягтлах аргачлал, тээвэрлэгчийн талаар тодорхой заах		
Эм бэлдмэл, тоног төхөөрөмжийн үнэ	Нийлүүлэх үнэ (гамшгийн өмнөх зохистой үнэ)-ийг тодорхой заах		
Төлбөр	Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн үнийн төлбөрийг гүйцэтгэх этгээдийн талаар тодорхой заах		
Гамшгийн нөхөн төлбөр	Эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийн ажилтан амь алдсан үеийн нөхөн төлбөрийн талаар тодорхой заах		
Холбоо барих хариуцлагатай этгээд	Санамж бичиг байгуулах байгууллагуудын хариуцаж ажиллах ажилтан, албан хаагчийн тухай тодорхой заах		
Санамж бичгийн үйлчлэх хүрээ	Санамж бичиг хүчин төгөлдөр болох өдрийг тодорхой заах		
Санал солилцох, зөвшилцөх	Маргаан гарсан тохиолдолд зөвшилцөх, санал солилцох аргачлалыг тодорхой заах		
Санамж бичиг байгуулах талууд	Санамж бичиг байгуулах талуудын тухай тодорхой заах		
Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах		
Санамж бичиг хадгалах	Санамж бичгийг талууд өөр дээрээ хадгалах тухай тодорхой заах		
		<p>Хоккайдо муж – Эм бэлдмэл, тоног төхөөрөмжийн компани (Гамшгийн үеийн эм бэлдмэлийн хангамжийн тухай санамж бичиг, Гамшгийн үеийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийн тухай санамж бичиг)</p> <p><a href="http://www.pref.hokkaido.lg.jp/sm/ktk/28keikakusyusei/2805shiryu/08-31.pdf">http://www.pref.hokkaido.lg.jp/sm/ktk/28keikakusyusei/2805shiryu/08-31.pdf</a></p>	

(5) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс

- Хир хэмжээний тусламж шаардлагатай байгааг тодорхой болгох > Шаардлагатай техник хэрэгсэл, бараа материалын төрөл зүйл, ашиглуулах байгууламж, гүйцэтгэх ажлын төрөл, агуулга
- Хүн хүчний ямар тусламж шаардлагатай байгааг тодорхой болгох > Мэргэжил, боловсон хүчин

#### 4. Зам тээвэр

(1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ

Японы жишээ	Холбогдох байгууллага
<ul style="list-style-type: none"> <li>• Бараа материалын тээвэрлэлт</li> <li>• Тусламжийн бараа материалын удирдлага зохион байгуулалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тээвэр эрхлэгч ААН байгууллага, Ачаа тээврийн нийгэмлэг</li> <li>• Хүргэлт тээврийн компани</li> </ul>

(2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл

1) Замын хөдөлгөөн

- Шуурхай тээвэрлэлтийн замыг тогтоох
- Зам, гүүр, тог тасарснаас шалтгаалан гэрлэн дохио ажиллагаагүй болох, цас ихээр унах, замын гадаргууд гөлөөн үүсэх зэргээс шалтгаалсан эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлж замын хөдөлгөөнийг зохицуулах
- Хүнд өвчтөн, эм бэлдмэл болон бараа материалын шуурхай тээвэрлэлт хийх замын бэлэн байдлыг хангах

2) Тээвэр

- Бараа материал төвлөрүүлэх бараа материалын баазыг байгуулах
- Бараа материалын бааз дээрх бараа материалын ангилан хуваарилалт
- Гамшигт нэрвэгдсэн газруудад тээвэрлэлт хийх автомашин, хүн хүчний бэлэн байдлыг хангах

(3) Япон дахь үйл ажиллагааны шат дараалал

1) Замын хөдөлгөөн

Ангилал	Онцлог	Хамрагдах зам
Шуурхай тээвэрлэлтийн 1-р зам	Өргөн газар нутгийг хамарсан тээвэрлэлт хийх зам	Хурдны, улсын болон аймгийн чанартай замууд
Шуурхай тээвэрлэлтийн 2-р зам	Хотын болон дүүргийн захиргаа, түр хоргодох байр гэх зэрэг гамшгаас хамгаалах онц чухал байгууламжийг холбосон зам	Хот доторх төв замууд

2) Тээвэр



Гамшгийн үе шат	Хэрэгжүүлэх арга хэмжээний зорилго	Голлох арга хэмжээ
<b>Гамшиг үүсэх</b> ↓ <b>24 цаг</b> ↓ <b>7 хоног</b>	<ul style="list-style-type: none"> <li>Гэмтэгсэд ба өвчтөн, эм бэлдмэл, нөөцийн барааг тээвэрлэх</li> <li>Хүнс, ундны ус, ахуйн анхдагч хэрэглэгдэхүүн тээвэрлэх</li> <li>Хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцох хүч хэрэгслийг тээвэрлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Яаралтай тээврийн хэрэгслийг бүртгэх</li> <li>Нисдэг тэргийн зогсоол байгуулах</li> <li>Тээврийн компанид тусламж хүсэх</li> <li>Бараа материалын түгээлтийн түшиц бааз байгуулах</li> <li>Шуурхай тээврийн зам маршрутыг тогтоох</li> <li>Тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах</li> <li>Тээвэрлэх бараа материал, хүч хэрэгсэлд уялдуулсан тээврийн төлөвлөгөө боловсруулах</li> </ul>

(4) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ

Бүлэг, зүйл		Тусгагдсан агуулга	Тайлбар	
4. Зам тээвэр	Бараа материалын тээвэрлэлт	Зорилго	Токушима муж ба Амазон ямато хүргэлт тээвэр (Гамшиг үүссэн үеийн бараа материалын тээвэрлэлтийн тухай санамж бичиг) <a href="http://anshin.pref.tokushima.jp/docs/2015070700024/files/HPshiryouto.pdf">http://anshin.pref.tokushima.jp/docs/2015070700024/files/HPshiryouto.pdf</a>  Ойта хот (Гамшигийн үеийн Автотээврийн харилцан туслалцах тухай санамж бичиг)  <a href="http://www.city.oita.jp/www/contents/1309324635384/files/yusoukyoutei.pdf">http://www.city.oita.jp/www/contents/1309324635384/files/yusoukyoutei.pdf</a>	
		Хүсэлтийн агуулга		Санамж бичиг байгуулах эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх нөхцөл, байгуулах талууд, зорилго зэргийг тодорхой заах
		Хүсэлт гаргах шат дараалал		Тээвэрлэлтийн тухай хүсэлтийн агуулга
		Тээвэрлэлт хийх		Шалтгаан, хүсэлт гаргах аргачлал, агуулга, бусад агуулга
		Шуурхай нэвтрэх үнэмлэх олгох		ААН нь агуулахад ангилан ачилт хийж бараа материалын тээвэрлэлтийг гүйцэтгэх
		Мэдээлэл өгөх		Засаг захиргаанаас ААН-ийн тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэлд шуурхай нэвтрэх үнэмлэх олгох
		Тээвэрлэлтийн төлөвлөгөө боловсруулах, хүлээлгэн өгөх		Засаг захиргаанаас ААН-д гамшигийн талаарх мэдээлэл, замын хөдөлгөөний зохицуулалтын талаарх мэдээллийг өгөх
		Эм бэлдмэл, техник хэрэгслийн үнэ		Тээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотойгоор засаг захиргаанд хүлээлгэн өгөх шаардлагатай баримт бичиг
		Төлбөр төлөлт		Нийлүүлэх үнэ (гамшгийн өмнөх үеийн зохистой үнэ)
		Гамшгийн нөхөн төлбөр		Тээвэрлэлттэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх талын тухай тодорхой дурдах
		Холбоо барих хариуцлагатай этгээд		Тээвэрлэлтийн үед хариуцаж байгаа ажилтан амь алдсан үеийн нөхөн төлбөрийн талаар тодорхой заах
		Санамж бичгийн үйлчлэх хүрээ		Санамж бичиг байгуулах байгууллагуудын хариуцаж ажиллах ажилтан, албан хаагчийн тухай тодорхой заах
		Санал солилцох, зөвшилцөх		Санамж бичиг хүчин төгөлдөр болох өдрийг тодорхой заах
		Санамж бичиг байгуулах талууд		Маргаан гарсан тохиолдолд зөвшилцөх аргачлалыг тодорхой заах
Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичиг байгуулах талуудын тухай тодорхой заах			
Санамж бичиг хадгалах	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах			
		Санамж бичгийг талууд өөр дээрээ хадгалах тухай тодорхой заах		

( 5 ) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс

1) Зам

- Шуурхай тээвэрлэлт хийх замыг тогтоох > Олон нийтийн байгууламж, эмнэлгийн байгууламж, нийгмийн халамжийн байгууламж, түр хоргодох байр зэрэгт хүрэх замын хөдөлгөөнийг хангах, тусламжийн бараа материалын тээвэрлэлт хийх замын бэлэн байдлыг хангах
- Шуурхай тээвэрлэлтийн замын хөдөлгөөнийг хангах > Тэргүүн ээлжинд хойшлуулшгүй сэргээн босголтыг гүйцэтгэж, шуурхай хөдөлгөөнт автомашинаас бусад автомашины хөдөлгөөнийг хязгаарлах

2) Тээвэр

- Шуурхай тээвэрлэлтийн замаар зорчих автомашиныг тодорхой заах > Хөдөлгөөнд оролцож буй шуурхай тээвэрлэлтийн автомашиныг ялган таних аргачлал, таних тэмдэг олгох аргачлал



- Тээвэрлэлтийн төлөвлөгөөний төсөл боловсруулах > Шаардлагатай бараа материалын тээвэрлэлт хийх боломжтой төлөвлөгөөний төсөл боловсруулах
- Шуурхай тээвэрлэлтийн замын удирдлага зохицуулалт > Шуурхай тээвэрлэлтийн автомашинаас бусад тээврийн хэрэгсэл шуурхай тээвэрлэлтийн замаар зорчихыг хориглох аргачлал

## 5. Боловсрол, дадлага сургууль

### (1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ

Японы жишээ	Холбогдох байгууллага
<ul style="list-style-type: none"><li>Гамшгаас хамгаалах дадлага сургууль зохион байгуулах</li><li>Гамшгаас хамгаалах боловсролыг хэрэгжүүлэх</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Орон нутгийн засаг захиргаа, гудамж хорооны хамтын холбоо, боловсролын байгууллага</li><li>Хувийн сургууль, улсын болон мужийн сургууль (олон нийтийн сургууль нь гамшгаас хамгаалах асуудал хариуцаж буй орон нутгийн засаг захиргаатай нягт холбоотой учраас санамж бичиггүй)</li></ul>

### (2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл

#### 1) Гамшгаас хамгаалах боловсрол

- Иргэн бүрийн гамшгаас хамгаалах мэдлэг, ухамсрыг сайжруулах
- Гэр бүл, орон нутгийн гамшгаас хамгаалах чадварыг дээшлүүлэх
- Танилцуулах материал, товхимол зэргээр таниулан сурталчлах ажлыг хэрэгжүүлэх
- ААН байгууллагад “Бизнесийн тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулах талаар таниулан сурталчлах ажлыг хэрэгжүүлэх

※Японд тайван үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хот, тосгон голлон хэрэгжүүлдэг ба бага, дунд сургууль нь хот, тосгоны харьяалалд байдаг учраас сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын тухайд санамж бичгээр авч үздэггүй ба орон нутгийн засаг захиргааны уялдаа холбооны хүрээнд хэрэгжүүлдэг.

#### 2) Гамшгаас хамгаалах дадлага сургууль


- Сургууль, иргэд, ААН байгууллагад чиглэгдсэн гамшгаас хамгаалах дадлага сургууль зохион байгуулах

(3) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ

Бүлэг, зүйл		Тусгагдсан агуулга	Тайлбар
5. Боловсрол, дадлага сургууль	Боловсрол, дадлага сургууль	Зорилго	Санамж бичиг байгуулах эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх нөхцөл, байгуулах талууд, зорилго зэргийг тодорхой заах
		Хүсэлтийн агуулга	Гамшгийн үед барилга байгууламжийг ашиглуулах, бараа материалын харилцан туслалцаа, багш албан хаагч, оюутнуудын сайн дурын бүлгийг илгээх, гамшгаас хамгаалах дадлага сургууль, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг
		Хүсэлт гаргах шат дараалал	Шалтгаан, хүсэлт гаргах аргачлал, агуулга, бусад агуулга
		Холбоо барих хариуцлагатай этгээд	Засаг захиргаа ба дээд сургуулийн хариуцаж ажиллах ажилтан, албан хаагчийн тухай тодорхой заах
		Санал солилцох, зөвшилцөх	Маргаан гарсан тохиолдолд зөвшилцөх аргачлалыг тодорхой заах
		Санамж бичиг байгуулах талууд	Санамж бичиг байгуулах талуудын тухай тодорхой заах
		Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах
		Санамж бичиг хадгалах	Санамж бичгийг талууд өөр дээрээ хадгалах тухай тодорхой заах
			Цүүр хот ба Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль (Гамшгийн үеийн харилцан туслалцаа тухай санамж бичиг)  <a href="http://www.city.tsuru.yamanashi.jp/div/gyousei/pdf/bousai/kennkoukagakud aigakukyouteisho.pdf">http://www.city.tsuru.yamanashi.jp/div/gyousei/pdf/bousai/kennkoukagakud aigakukyouteisho.pdf</a>

(4) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс

- 1) Гамшгаас хамгаалах боловсрол
  - Санамж бичгээр зохицуулах үйл ажиллагаа > ААН, ашгийн бус байгууллага зэргийн “Бизнесийн тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулах ажлыг эрчимжүүлэх, нөөц бүрдүүлэх. Нүүлгэн шлжүүлэх ажлын гарын авлага боловсруулах, түгээх.
- 2) Гамшгаас хамгаалах дадлага сургууль
  - Дадлага сургуульд хамрагдах байгууллага > Сургууль, иргэд, ААН байгууллага
  - Дадлага сургууль зохион байгуулах чиглэл > Байгууллагын уялдаа холбоог хангах, тасралтгүй хэрэгжүүлэх



## 6. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа

### (1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ

Японы жишээ	Холбогдох байгууллага
<ul style="list-style-type: none"><li>• Гал унтраах үйл ажиллагаа</li><li>• Гал түймэртэй тэмцэх төлөвлөгөө боловсруулах</li><li>• Гал гарах эрсдэлийг бууруулах</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Орон нутгийн гал түймэртэй тэмцэх эвлэл, гал түмэртэй тэмцэх бүлэг</li><li>• Орон нутгийн засаг захиргаа (гал түймэр хүрээгээ тэлэхээс сэргийлэн хамгаалсан хот байгуулалт)</li><li>• Ахуйн газ болон цахилгааны компаниуд</li></ul>

### (2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл

- Гал гарсан тухай мэдээллийг цуглуулахад зориулсан аргачлалыг эмхтгэх
  - Гал унтраах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тэргүүн ээлжинд гал унтраах ажлыг явуулах байгууламжийг тогтоох
    - 1) Тэргүүн ээлжинд гал унтраах ажил явуулах орон нутаг: хүний амь нас эрсдэх, гал түймэр хүрээгээ тэлэх эрсдэл ихтэй орон нутгийг тодорхой болгох
    - 2) Онц чухал объект: олон нийтийн байгууламж, эмнэлгийн байгууламж, нийгмийн халамжийн байгууламж, сургууль зэрэг
    - 3) Түр цугларах талбай болон нүүлгэн шилжүүлэх маршрутын галын аюулгүй байдлыг хангах
    - 4) Хот дотор гарсан галыг тэргүүн ээлжинд унтраах: аюултай бодис ашигладаг байгууламж болон том хэмжээний үйлдвэрийн газар гал гарсан үед гудамж, хороолол руу хүрээгээ тэлсэн гал түймрийг тэргүүн ээлжинд унтраах
    - 5) Гал унтраах боломжтой орон нутагт тэргүүн ээлжинд гал унтраах: дээрх нөхцлүүдийг харгалзан үзэж гал унтраах боломж нь илүү байгаа орон нутгийг тэргүүн ээлжинд авч үзэх
  - Усны шугам хоолойн гэмтлийн үеийн бэлэн байдлыг хангах үүднээс гал унтраах үйл ажиллагаанд ашиглаж болох гол мөрөн, усан сан, барилга байгууламжийн ус хуримтлуулах сав гэх зэрэгтэй холбоотой суурь мэдээллийг цуглуулах
  - Гал унтраах тусламж авах хүсэлт гаргах шалгуур нөхцлийг тогтоох
- ※Японы тайван үеийн гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг голлох этгээд нь хот, тосгон, эсвэл тухайн хот тосгоны орон нутаг байдаг ба гал түймэртэй тэмцэх байгууллага нь хот тосгоны харьяалагддаг учраас санамж бичгээр зохицуулдаггүй ба орон нутгийн засаг захиргааны уялдаа холбооны хүрээнд хэрэгжүүлдэг.

### (3) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ

- Японд гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг хариуцдаг байгууллагатай

байгуулсан санамж бичиг байдаггүй боловч үйлдвэрийн газрууд бие даасан гал унтраах ангитай байдаг учраас тэдгээртэй байгуулсан санамж бичгийг жишээ болгон доор үзүүлэв.

Бүлэг, зүйл		Тусгагдсан агуулга	Тайлбар
6. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа	Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа	Зорилго	Санамж бичиг байгуулах эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх нөхцөл, байгуулах талууд, зорилго зэргийг тодорхой заах
		Хүсэлтийн агуулга	Гал унтраах, аврах зэрэг гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд учруулж болзошгүй саадыг арилгах, аюулын эх үүсвэр болох бодисыг устгах, гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах талаарх зөвлөгөө өгөх зэрэг
		Хүсэлт гаргах шат дараалал	Гал түймэр гарсан газар, үйл ажиллагааны агуулга, шаардагдах хүч хэрэгсэл, гал унтраасан байршил, хариуцаж байгаа ажилтан алба хаагч, зэрэг
		Холбоо барих хариуцлагатай этгээд	Онцгой үеийн холбоо барих тогтолцооны талаарх мэдээллийг хүлээлгэн өгөх
		Ажил тайлагнах	Гал унтраах үйл ажиллагаа дууссаны дараах үйл ажиллагааны агуулгын талаар тайлагнахын зэрэгцээ тэмдэглэлийг эмхтгэж хүлээлгэн өгөх
		Ослын тухай мэдээг тайлагнах	Гал унтраах ажлын үед гарсан ослын тухай тайлагнах
		Санал солилцох, зөвшилцөх	Маргаан гарсан тохиолдолд зөвшилцөх аргачлалыг тодорхой заах
		Төлбөр	Гал унтраах ажилтай холбоотой төлбөр гүйцэтгэх этгээдийн тухай тодорхой заах
		Гамшгийн нөхөн төлбөр	Гал унтраах ажлын үед ажилтан алба хаагч амь алдсан тохиолдолд үүсэх нөхөн төлбөрийн талаар тодорхой заах
		Тайван үеийн тусламж дэмжлэг	Гал унтраах дадлага сургуульд ашиглагдах байгууламжаар хангах, дадлага сургууль, сургалтад оролцох, материалаар хангах, зэрэг
		Санамж бичиг байгуулах талууд	Санамж бичиг байгуулах талуудын тухай тодорхой заах
		Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах
Санамж бичиг хадгалах	Санамж бичгийг талууд өөр дээрээ хадгалах тухай тодорхой заах		

Гамшгийн үеийн гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааны харилцан туслалцах тухай санамж бичиг  
<https://www.city.chiba.jp/somu/kikikanri/documents/2-11-59kaitaigyo-syobokuyot ei.pdf>

(4) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс

- Төлөвлөгөө бүхий гал унтраах үйл ажиллагааг хэрэгжүүлэх > Тэргүүн ээлжинд гал унтраах газруудыг тодорхой болгох
- Газар хөдлөлт үүссэн үед ашиглах боломжтой усны эх үүсвэрийн талаар эмхтгэх > Гамшигт нэрвэгдсэн үеийн гал унтраах үйл ажиллагааг хэрэгжүүлэх



## 7. Гэртээ харихад хүндрэл гарсан иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа

### (1) Японы гамшгаас хамгаалах санамж бичгийн жишээ

Японы жишээ	Холбогдох байгууллага
<ul style="list-style-type: none"><li>• Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний саадгүй байдлыг хангах</li><li>• Түр цугларах талбайн бэлэн байдлыг хангах</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Төмөр зам, автобус, такси үйлчилгээний компаниуд</li><li>• Том хэмжээний дэлгүүр, ШТС, нийгмийн халамжийн байгууламж</li></ul>

### (2) Японы гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан чиглэл

- Гэртээ харихад хүндрэл гарсан иргэд олноороо төвлөрөх өртөөний ойр орчим, том хэмжээний үйлчилгээний байгууламж зэрэгт эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлж албан газрууд болон сургуулиудад ажилтан албан хаагч, оюутан сурагчдыг түр байлцуулж нэгэн зэрэг гэртээ харихаас үүсч болзошгүй эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх
- Гэртээ харихад хүндрэл гарсан иргэдийг хүргэх ажлыг муж дамнасан өргөн цар хүрээнд зохицуулан хэрэгжүүлэх
- Улс, орон нутгийн засаг захиргаа, төмөр зам болон харилцаа холбооны компани, хувийн хэвшлийн байгууллага зэргээс гаргасан зааварт үндэслэн “Токио хотын гэртээ харихад хүндрэл гарсан иргэдэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулах  
<http://www.metro.tokyo.jp/INET/KEIKAKU/2012/11/DATA/70mbd101.pdf>
- Гэртээ харихад хүндрэл гарсан иргэдэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх тухайд Токио хотоос журам гаргах
- Нийслэлийн байгууламжуудыг түр цугларах зорилгоор ашиглах байгууламж болгож гэртээ харихад нь тусламж үзүүлэх зорилготой гамшгийн үеийн гэртээ харихад туслах өртөөг зохион байгуулах

(3) Японы санамж бичигт тусгах бүлэг, заалтуудын жишээ

Бүлэг, зүйл		Тусгагдсан агуулга	Тайлбар
7. Гэртээ харихад хүндрэл гарсан иргэд	Гэртээ харихад туслах өртөө	Зорилго	Санамж бичиг байгуулах эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх нөхцөл, байгуулах талууд, зорилго зэргийг тодорхой заах
		Хүсэлтийн агуулга	Гэртээ харихад туслах өртөө байгуулах зэрэг
		Холбоо барих хариуцлагатай этгээд	Онцгой үеийн холбоо барих тогтолцооны талаарх мэдээллийг хүлээлгэн өгөх
		Холбоо барих хариуцлагатай этгээд	Засаг захиргаа ба дээд сургуулийн хариуцаж ажиллах ажилтан, албан хаагчийн тухай тодорхой заах
		Санал солилцох, зөвшилцөх	Маргаан гарсан тохиолдолд зөвшилцөх аргачлалыг тодорхой заах
		Ослын тухай мэдээг тайлагнах	Гал унтраах ажлын үед гарсан ослын тухай тайлагнах
		Санамж бичиг байгуулах талууд	Санамж бичиг байгуулах талуудын тухай тодорхой заах
		Хүчин төгөлдөр байх хугацаа	Санамж бичгийн хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой заах
		Санамж бичиг хадгалах	Санамж бичгийг талууд өөр дээрээ хадгалах тухай тодорхой заах
			<p>Гэртээ харихад хүндрэл гарсан иргэдэд туслах зорилгоор 24 цагийн сүлжээ дэлгүүрүүдийн хэрэглээний ус, ариун цэврийн өрөөгөөр хангах тухай санамж бичиг</p> <p><a href="http://www.pref.hokkaido.lg.jp/sm/ktk/28keikakusyusei/2805shiryuu/08-08.pdf">http://www.pref.hokkaido.lg.jp/sm/ktk/28keikakusyusei/2805shiryuu/08-08.pdf</a></p>

(4) Санамж бичиг боловсруулахад анхаарах зүйлс

- Хүйтний улиралд гэртээ харихад гарах хүндрэл > Албан газар болон сургуулиудад ажилтан албан хаагч болон оюутнуудыг түр хүлээлгэх явдлыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн шатахуунгүй болохоос сэргийлэх арга хэмжээ авах
- Гэртээ харихад нь дэмжлэг үзүүлэх > Харилцаа холбоо, төмөр замын компаниуд, ШТС, дэлгүүрүүдийн харилцан туслалцах зохион байгуулалтыг ханган бүрдүүлэх

## **1-6-2 САНАМЖ БИЧГИЙН ТӨСЛҮҮД**

### **1. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ БОЛОН ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХООРОНД БАЙГУУЛАХ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

#### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт дурьдсанчлан Засгийн газар, төрийн байгууллагууд, холбогдох салбар, талууд үндэсний онцлог, засаглалын тогтолцоондоо тохируулан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хүлээх үүрэг, хариуцлагаа тодорхойлох шаардлагатай байна гэснийг хүлээн зөвшөөрч,

Гамшгаас хамгаалах Хүнс, хөдөө аж ахуйн улсын алба нь гамшгийн хөнөөлийн голомтод бүсэд нэрвэгдэгсдэд тухайлбал, түр хорогдох байр болон түр орон сууцанд шилжин ирсэн хүмүүст хүнсний яаралтай тусламж үзүүлэхэд шаардагдах ундны цэвэр ус, хоол, хүнсээр хангахад чухал үүрэг хүлээдэг гэдгийг ухамсарлан,

Гамшгаас хамгаалах Хүнс, хөдөө аж ахуйн улсын албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн үеийн хүнсний нөөцийн хадгалалт, хуваарилалт, тээвэрлэлтийг зохион байгуулахад нутгийн захиргааны байгууллагуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч,

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогод дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх гэснийг ойлгон,

Аймаг, орон нутгийн Засаг даргын Тамгын газар нь хувийн хэвшлийн хүнсний үйлдвэр, нийтийн хоолны үйлчилгээ, хангамжийн болон импортлогч байгууллагууд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд гамшгийн үед нэрвэгдэгсдэд хүнсний яаралтай тусламжийг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж зохицуулах үүрэгтэйгээр оролцохоо илэрхийлж энэхүү санамж бичиг дээр харилцан тохиролцов.

#### **ХОЁР. ЗОРИЛГО**

Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг /Цаашид “Санамж бичиг” гэх/-ийн зорилго нь улсын хэмжээнд үүссэн гамшгийн голомтын бүсийн нэрвэгдэгсдэд шаардагдах хүнсний хангамжийн нөөцийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх байгууллагуудын хамтын үйл ажиллагааны чиглэл, талуудын хүлээх хариуцлага үүргийг тодорхойлоход оршино.

## ГУРАВ. ХАМРАХ ЦАР ХҮРЭЭ

Ган, зуд, газар хөдлөлт, хээрийн түймэр, хүйтэн хүчтэй салхи, шуурга, мөндөр, малын гоц халдварт өвчин зэрэг хөдөө аж ахуйн салбарт тохиолддог гамшигт үзэгдлүүдийн хүрээг хамарна.

## ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь дараахь хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Аймаг, нийслэлийн хүнсний үйлдвэр, худалдааны төв, хүнсний агуулахын судалгаа, аймаг, нийслэлийн жишсэн хүн амын жилийн, улирлын, сарын, 10 хоногийн, 3 хоногийн хүнсний хэрэгцээг тайван цагт тооцоолон гаргасан байх
- ✓ Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар тухайн орон нутгийн хүнсний үйлдвэр, худалдааны төв, хүнсний агуулахыг эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан гамшгийн үеийн хүнсний нөөцийг бэлэн байлгах эрх зүйн чадамжаар хангах
- ✓ Газар хөдлөлтийн гамшгийн үед төмөр зам, автозам, нисэх онгоцны буудлыг сэргээн засварлаж дуустал хугацаанд стратегийн хүнсний улирлын нөөцөөр хомсдох аймаг, нийслэл, сум, дүүргийг тодорхойлж тухайн хот суурин газар, орон нутаг дахь хүнсний хангамжийн нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, эсвэл бусад аймаг, орон нутгаас татаж нийлүүлэх арга хэмжээ авах
- ✓ Газар хөдлөлтийн гамшгийн үед түр хорогдох байр болон түр орон сууцын байршилд оролцоо орших хүнсний үйлдвэр, хангамжийн болон импортлогч байгууллагын агуулахаас газар хөдлөлтийн гамшгийн үед хоол, хүнс болон бусад нэн шаардлагатай бараа материалыг шуурхай нийлүүлэх, харилцан ажиллагааны болон тээвэрлэлтийн гэрээг хийж гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөнд тусгах.

4.2. Онцгой байдлын ерөнхий газар нь дараахь хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Гэр орондоо хоол хүнс бэлтгэх боломжгүй болсон иргэд, хүнсний худалдаа, зах зээлийн хангамж тасалдсанаас хоол хүнсээ базаах боломжгүй иргэд, гэртээ харихад хүндрэл үүссэн иргэдийн түр хоргодох байраар хангах, тэдний байршил болон гамшгаас хамгаалах арга хэмжээнд оролцож байгаа иргэдийн талаархи мэдээллийг хүнсний хангамжийн байгууллагууд болон тэдгээрийн нөөцийн агуулах, тээврийн компаниудад өгөх;
- ✓ Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны үйлчилгээ, хангамжийн болон импортлогч байгууллагуудын нөөцийн агуулахуудаас түр хоргодох байруудад, бусад шаардлагатай газруудад хоол хүнс, нэн шаардлагатай бараа материал тээвэрлэхэд өөрийн хүчин чадлаас давсан үед автомашины захиалгыг автотээврийн компаниуд болон Зэвсэгт хүчний анги салбаруудад өгөх;
- ✓ Гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд оролцох хүч хэрэгслийн бие бүрэлдэхүүний хүнсний хангалт, ундны цэвэр ус, хуурай хоол хүнсний жагсаалтыг гаргаж захиалга өгөх;

#### 4.3. Хоёр талын хамтын ажиллагаа

- ✓ Ган, зуд, газар хөдлөлт, хээрийн түймэр, хүйтэн хүчтэй салхи, шуурга, мөндөр, малын гоц халдварт өвчин зэрэг гамшгийн үед Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах, үнэлгээ, дүгнэлт, санал гаргах
- ✓ Гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд оролцох хүч хэрэгслийн бие бүрэлдэхүүн болон нэрвэгдэгсдийг хоол хүнсээр хангах болон хүнс бараа материал тээвэрлэхэд гарсан зардал, бусад нөхөн олгоход шаардагдах хөрөнгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлэх

#### **ТАВ. БУСАД ЗҮЙЛ**

Талууд харилцан зөвшилсөний үндсэн дээр Санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай харилцан мэдэгдэнэ.

Санамж бичиг нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба 2025 он хүртэл хугацаатайгаар байгуулав.

Санамж бичгийг 2018 оны ... дүгээр сарын ... ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

...oOo...

## **2. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ БА МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНД БАЙГУУЛСАН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

### *ТАНИЛЦУУЛГА*

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас дэлхий нийтэд тохиолдох гамшгийн аюул, түүнээс учрах хохирол нэмэгдэж, улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргаанд сөрөг нөлөөтэй байна.

Иймд, Япон улсын Сендай хотод 2015 онд зохион байгуулагдсан Гамшгийн эрсдлийг бууруулах Дэлхийн III бага хурлаас НҮБ-ын 187 улс “Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030” баримт бичгийг баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн 3.4.2-т гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх,

2018 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлаас баталж гаргасан “Улаанбаатарын тунхаглал” баримт бичигт “... Гамшгийн эрсдэлийг бууруулахад үндэсний болон орон нутгийн платформд худалдааны танхим, бизнесийн байгууллагуудын оролцоог дэмжих” гэснийг тус тус мөрдлөг болгон ажиллах бодлогын шаардлага тавигдаж байна.

Манай улсын дотоод нөхцөл байдлын хувьд 1990-ээд оноос эхлэн төрийн өмчит эм хангамжийн салбарууд хувийн хэвшилд шилжсэнээр болзошгүй гамшгийн үед хувийн хэвшлийн байгууллагуудад урьдчилан санамж бичгийг хүргүүлэн бэлэн байдлыг хангуулах шаардлагыг бий болгож байна.

Түүнчлэн Монгол улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх нь төсөл”-ийг 2017-2019 онд хэрэгжүүлж байна.

Энэхүү төслийн багаас болзошгүй гамшгийн үед нөөцийн бэлэн байдлыг хангахад онцгой объектуудтай санамж бичиг байгуулан ажилладаг Япон улсад амжилттай хэрэгжиж үр дүн гарсан туршлагыг зөвлөмж болгосон байна.

Энэхүү төслөөс “Гамшгийн үед санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах нь” сэдэвт сургалт, семинарыг ЭМЯ, ОБЕГ болон ЖАЙКА хамтран 2018 оны 04 сард зохон байгуулж санамж бичгийн төслийг боловсруулж, хэлэлцүүлж, цаашид батлуулж, хэрэгжүүлэхийг харилцан зөвшөөрсөн болно.

2017 оны байдлаар манай улсад 563 эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллага, 40 эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, 1967 эмийн сан үйл ажиллагаа явуулж байгаагаас Монгол эм импекс концерн ХХК нь 21 аймагт, Монос трейд ХХК 20 аймагт, Ази фарма ХХК 10 аймагт салбартай Эм ханган нийлүүлэх үйл ажиллагааг

гүйцэтгэж байгаа манай улсын томоохон Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагууд болж байна.

Тиймээс энэхүү санамж бичгийг дээрхи 3 байгууллагатай байгуулж, ажиллах, бэлэн байдлыг хангуулахаар төслийг боловсруулав.

**Зөвшөөрсөн:**

Э.Содномжамц  
М.Баттүвшин

ЭМЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Эмнэлгийн тусламжийн газрын дарга

М.Ганзориг

ЭМЯ-ны хуулийн хэлтсийн даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

**Боловсруулсан:**

С.Алтанбагана

ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газрын  
мэргэжилтэн

Б.Мандахгэрэл

ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын  
газрын дарга

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**  
**БА**  
**МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГА**  
**ХООРОНД БАЙГУУЛСАН**  
**ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн хэрэгжилт, Эрүүл мэндийн улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор нэг талаас Эрүүл Мэндийн Яам нөгөө талаас хувийн хэвшлийн эм хангамжийн байгууллагууд хамтран энэхүү санамж бичгийг үйлдэв.

**Нэг. Зорилго**

Болзошгүй гамшгийн эрсдлийн үед амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, нөөцийн санг бүрдүүлэх,

**Хоёр. Эрүүл мэндийн яамны хүлээх үүрэг.**

2.1 Гамшгийн хөнөөлийн голомтод шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх;

2.2 Энэхүү төлөвлөгөөнд заасан эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг эм хангамжийн байгууллагуудад өгөх;

2.3 Гамшгийн үед хувийн хэвшлийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн байгууллага, эмийн сангуудаас гарсан зардлын нөхөн төлөх тооцоог Улсын онцгой комисс, улсын нөөцийн газартай урьдчилан байгуулах;

**Гурав. Эм хангамжийн байгууллагын хүлээх үүрэг.**

3.1 Гамшгийн үед Эрүүл мэндийн яамны захиалгад үндэслэн гамшгийн хөнөөлийн голомтод шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх;

3.2 Болзошгүй гамшгийн үед дутагдаж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, нэмж захиалах, нөөцийг бүрдүүлэх, хэрэгцээт газарт нийлүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

3.3 Зарцуулсан эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоог гаргаж, баримтаар баталгаажуулан Эрүүл мэндийн яаманд ирүүлэх;



## **Дөрөв. Бусад зүйл**

4.1. Талууд гамшгийн үед хувийн хэвшлийн эм, эмийн хэрэгслийн хангамжийн байгууллага, эмийн сангуудаас гарсан зардлын тооцоог хийж Улсын онцгой комисс, улсын нөөцийн газарт хүргүүлнэ.

4.2. Талууд харилцан зөвшилсөний үндсэн дээр энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болно.

4.3. Энэхүү Харилцан Ойлголцлын Санамж Бичгийн хэрэгжилтийг хангахын тулд талууд энэхүү санамж бичгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах хүнийг томилж бичгээр мэдэгдэнэ.

4.4 Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд харилцан ойлголцлын санамж бичгийг аль нэг байгууллага нь нөгөө байгууллагадаа 6 сараас доошгүй хугацааны өмнө бичгээр өгч мэдэгдэл хийснээр цуцална.

4.5 Санамж бичгийг 2018 оны 11 дүгээр сарын\_\_\_ ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

### **ХОЁР БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН:**

Огноо: 2018 оны 11 дүгээр сар—ны өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ: ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

---

Л.БЯМБАСҮРЭН

Д.ЦЭРЭНБАТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭД САЙД

“МОНОС ТРЕЙД” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**  
**БА**  
**МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГА**  
**ХООРОНД БАЙГУУЛСАН**  
**ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Нэг талаас Эрүүл мэндийн яам нөгөө талаас хувийн хэвшлийн эм хангамжийн байгууллагууд нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн хэрэгжилтийг хангахад үндэслэн энэхүү санамж бичгийг үйлдэв.

**Нэг. Зорилго**

Болзошгүй гамшгийн эрсдлийн үед амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, нөөцийн санг бүрдүүлэх,

**Хоёр. Эрүүл мэндийн яамны хүлээх үүрэг.**

2.1 Гамшгийн хөнөөлийн голомтод шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх;

2.2 Энэхүү төлөвлөгөөнд заасан эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг эм хангамжийн байгууллагуудад өгөх;

2.3 Гамшгийн үед хувийн хэвшлийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн байгууллага, эмийн сангуудаас гарсан зардлын нөхөн төлөх тооцоог Улсын онцгой комисс, улсын нөөцийн газартай урьдчилан байгуулах;

**Гурав. Эм хангамжийн байгууллагын хүлээх үүрэг.**

3.1 Гамшгийн үед Эрүүл мэндийн яамны захиалгад үндэслэн гамшгийн хөнөөлийн голомтод шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх;

3.2 Болзошгүй гамшгийн үед дутагдаж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, нэмж захиалах, нөөцийг бүрдүүлэх, хэрэгцээт газарт нийлүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

3.3 Зарцуулсан эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоог гаргаж, баримтаар баталгаажуулан Эрүүл мэндийн яаманд ирүүлэх;

## **Дөрөв. Бусад зүйл**

4.1. Талууд гамшгийн үед хувийн хэвшлийн эм, эмийн хэрэгслийн хангамжийн байгууллага, эмийн сангуудаас гарсан зардлын тооцоог хийж Улсын онцгой комисс, улсын нөөцийн газарт хүргүүлнэ.

4.2. Талууд харилцан зөвшилсөний үндсэн дээр энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болно.

4.3. Энэхүү Харилцан Ойлголцлын Санамж Бичгийн хэрэгжилтийг хангахын тулд талууд энэхүү санамж бичгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах хүнийг томилж бичгээр мэдэгдэнэ.

4.4 Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд харилцан ойлголцлын санамж бичгийг аль нэг байгууллага нь нөгөө байгууллагадаа 6 сараас доошгүй хугацааны өмнө бичгээр өгч мэдэгдэл хийснээр цуцална.

4.5 Санамж бичгийг 2018 оны 11 дүгээр сарын\_\_\_ ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

### **ХОЁР БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН:**

Огноо: 2018 оны 11 дүгээр сар—ны өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ: ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

---

Л.БЯМБАСҮРЭН

Б.БОЛОРМАА

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭД САЙД

“МОНГОЛ ЭМ ИМПЕКС КОНЦЕРН”  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**  
**БА**  
**МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГА**  
**ХООРОНД БАЙГУУЛСАН**  
**ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Нэг талаас Эрүүл мэндийн яам нөгөө талаас хувийн хэвшлийн эм хангамжийн байгууллагууд нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн хэрэгжилтийг хангахад үндэслэн энэхүү санамж бичгийг үйлдэв.

**Нэг. Зорилго**

Болзошгүй гамшгийн эрсдлийн үед амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, нөөцийн санг бүрдүүлэх,

**Хоёр. Эрүүл мэндийн яамны хүлээх үүрэг.**

2.1 Гамшгийн хөнөөлийн голомтод шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх;

2.2 Энэхүү төлөвлөгөөнд заасан эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг эм хангамжийн байгууллагуудад өгөх;

2.3 Гамшгийн үед хувийн хэвшлийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн байгууллага, эмийн сангуудаас гарсан зардлын нөхөн төлөх тооцоог Улсын онцгой комисс, улсын нөөцийн газартай урьдчилан байгуулах;

**Гурав. Эм хангамжийн байгууллагын хүлээх үүрэг.**

3.1 Гамшгийн үед Эрүүл мэндийн яамны захиалгад үндэслэн гамшгийн хөнөөлийн голомтод шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх;

3.2 Болзошгүй гамшгийн үед дутагдаж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, нэмж захиалах, нөөцийг бүрдүүлэх, хэрэгцээт газарт нийлүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

3.3 Зарцуулсан эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоог гаргаж, баримтаар баталгаажуулан Эрүүл мэндийн яаманд ирүүлэх;

## **Дөрөв. Бусад зүйл**

4.1. Талууд гамшгийн үед хувийн хэвшлийн эм, эмийн хэрэгслийн хангамжийн байгууллага, эмийн сангуудаас гарсан зардлын тооцоог хийж Улсын онцгой комисс, улсын нөөцийн газарт хүргүүлнэ.

4.2. Талууд харилцан зөвшилсөний үндсэн дээр энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болно.

4.3. Энэхүү Харилцан Ойлголцлын Санамж Бичгийн хэрэгжилтийг хангахын тулд талууд энэхүү санамж бичгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах хүнийг томилж бичгээр мэдэгдэнэ.

4.4 Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд харилцан ойлголцлын санамж бичгийг аль нэг байгууллага нь нөгөө байгууллагадаа 6 сараас доошгүй хугацааны өмнө бичгээр өгч мэдэгдэл хийснээр цуцална.

4.5 Санамж бичгийг 2018 оны 11 дүгээр сарын\_\_\_ ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

### **ХОЁР БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН:**

Огноо: 2018 оны 11 дүгээр сар—ны өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ: ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

---

Л.БЯМБАСҮРЭН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭД САЙД

Г.БАЯРЖАРГАЛ

“АЗИ ФАРМА” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ,  
БА  
МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА  
ХООРОНД БАЙГУУЛСАН  
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧГИЙН ХАВСРАЛТ**

Гамшгийн хөнөөлийн голомтод шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт

<i>Д/Д</i>	<i>Эм, эмнэлгийн хэрэгслийн нэр</i>	<i>Тун хэмжээ</i>	<i>Эмийн хэлбэр</i>	<i>Хэмжих нэгж</i>
1.	Аминокапроны хүчил	400мг/мл-100мл, 400мг/мл-10мл	тарилгын уусмал	фл туншил
2.	Маннитол	100мл, 200мл, 400мл	тарилгын шингэн	фл
3.	Метамизол	500мг/мл-2мл	тарилгын уусмал	туншил
4.	Диазепам	5мг/мл-2мл	тарилгын уусмал	туншил
5.	Рингер лактатын уусмал	250мл, 500мл	тарилгын шингэн	фл
6.	Дибазол	10, 20, 50мг/мл- 1мл-5мл	тарилгын уусмал	туншил
7.	Дифенгидрамин	10мг/мл-1мл	тарилгын уусмал	туншил
8.	Марль	120см*1000м	эмнэлгийн хэрэгсэл	ширхэг
9.	Хөвөн	50гр	эмнэлгийн хэрэгсэл	ширхэг
10.	Шингэн сэлбэх систем	Нэг удаагийн хэрэгсэл	эмнэлгийн хэрэгсэл	ширхэг
11.	Бусад	Гамшгийн нөхцөл байдалтай уялдан гарах шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл		Тухайн үед захиалсан тоогоор

### **3-1. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН АЛБА БОЛОН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

#### **Нэг. Ерөнхий зүйл**

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт төрийн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох, бизнесийн үйл ажиллагаандаа гамшгийн эрсдэлийг тооцдог байх шаардлагатай байна гэснийг хүлээн зөвшөөрч,

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогод дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх гэснийг ойлгон,

Газар хөдлөлтийг гамшгийн үед Гамшгаас хамгаалах Барилга хот байгуулалтын улсын алба нь гамшгийн хөнөөлийн голомтод барилга байгууламжийн хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг саадгүй явуулахын тулд барилгын материалын хангамжийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг хүлээдэг гэдгийг ухамсарлан,

Гамшгаас хамгаалах Барилга хот байгуулалтын улсын албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн нөөц, чадавхийг бэхжүүлэхэд барилгын материал үйлдвэрлэх хувийн хэвшлийн байгууллагуудын чухал үүрэгтэй томоохон хүч хэрэгсэл болохыг хүлээн зөвшөөрч,

Хувийн хэвшлийн барилгын материал үйлдвэрлэгч, борлуулагч болон импортлогч байгууллагууд газар хөдлөлтийн гамшгийн үед нэн тэргүүнд шаардагдах барилгын материалыг нийлүүлэх, тээвэрлэж хүргэх чиглэлээр нийгмийн хариуцлагаа хүлээхээ илэрхийлж энэхүү санамж бичиг дээр харилцан тохиролцов.

#### **Хоёр. Зорилго**

Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг /Цаашид “Санамж бичиг” гэх/-ийн зорилго нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үүссэн газар хөдлөлтийн голомтын бүсэд хойшлуулшгүй сэргээн засварлах, босгох арга хэмжээг хэрэгжүүлэх шаардагдах барилгын материалын хангамжийн нөөцийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх байгууллагуудын хамтын үйл ажиллагааны чиглэл, талуудын хүлээх хариуцлага үүргийг тодорхойлоход оршино.

#### **Гурав. Барилга хот байгуулалтын улсын албаны хүлээх үүрэг**

3.1. Газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд шаардагдах барилгын материалын төрөл, хэрэгцээний талаар мэдээлэл цуглуулж нэгтгэн барилгын материал үйлдвэрлэгч, борлуулагч болон импортлогч байгууллагуудад захиалга өгөх;

3.2. Түр хорогдох байр, түр орон сууцыг барих газар, талбайд барилгын материалыг тээвэрлэж хүргэх газрын товлож нэгтгэн барилгын материал үйлдвэрлэгч, борлуулагч болон импортлогч байгууллагуудыг мэдээллээр хангах;

3.2. Газар хөдлөлтийн гамшгийн үед хувийн хэвшлийн барилгын материалын үйлдвэрүүдээс гарсан зардлын нөхөн төлөх гэрээг урьдчилан байгуулах;

### **Дөрөв. Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны хүлээх үүрэг**

4.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед барилгын материалын агуулахуудын нөөц, хангалт хийх боломжтой хугацааг тодорхойлж БХБУА-д мэдээлэх;

4.2. Газар хөдлөлтийн гамшгийн дараа Автозамын газар, Төмөр замын газруудаас эвдэрсэн авто зам болон төмөр замыг сэргээн засварлаж дуустал хугацаанд барилгын материалаар хомсдох бүс нутгийг тодорхойлж тухайн бүс нутаг дахь нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, эсвэл бусад бүс нутгаас автотээвэр болон төмөр замаар барилгын материал тээвэрлэх арга хэмжээ авах ;

4.3. Газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод барилга, байгууламжийг сэргээн босгох арга хэмжээнд шаардлагатай барилгын материалын хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх ;

4.4. БХБУА болон Зам тээврийн улсын албатай зөвшилцсөний үндсэн дээр барилгын материал үйлдвэрлэгч, борлуулагч болон импортлогч байгууллагуудын агуулахаас барилгын материал шуурхай тээвэрлэх хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах.

### **Тав. Бусад зүйл**

5.1.Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр Санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай талууд харилцан мэдэгдэнэ.

5.2. Санамж бичиг нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба 2017 оны дүгээр сарын ны өдөр хүртэл хугацаатайгаар байгуулав. Уг санамж бичигт тусгагдсан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дуустал хүчин төгөлдөр байна.

5.3.Санамж бичгийг 2017 оны дүгээр сарын ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.



## **3-2. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН АЛБА БОЛОН МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН ХОЛБООНЫ ХООРОНД БАЙГУУЛАХ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт төрийн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох, бизнесийн үйл ажиллагаандаа гамшгийн эрсдэлийг тооцдог байх шаардлагатай байна гэснийг хүлээн зөвшөөрч,

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогод дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх гэснийг ойлгон,

Газар хөдлөлтийг гамшгийн үед Гамшгаас хамгаалах Барилга хот байгуулалтын улсын алба нь гамшгийн хөнөөлийн голомтод барилгын нурангийг зайлуулах, барилга байгууламжийн эвдрэл гэмтлийг тодорхойлж үнэлэх, сэргээн засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд чухал үүрэг хүлээдэг гэдгийг ухамсарлан,

Гамшгаас хамгаалах Барилга хот байгуулалтын улсын албаны гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, инженер техникийн ажилчдын сургалт бэлтгэл, хүний нөөцийн нөхөн хангалт хийхэд Монголын барилгачдын нэгдсэн холбоо болон барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагуудын чухал үүрэгтэй томоохон хүч хэрэгсэл болохыг хүлээн зөвшөөрч,

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагууд газар хөдлөлтийн гамшгийн үед нэн тэргүүнд шаардагдах барилгын инженер техникийн ажилчдаар хангах чиглэлээр нийгмийн хариуцлагаа хүлээхээ илэрхийлж энэхүү санамж бичиг дээр харилцан тохиролцов.

### **Хоёр. Зорилго**

Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг /Цаашид “Санамж бичиг” гэх/-ийн зорилго нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үүссэн газар хөдлөлтийн голомтын бүсэд хойшлуулшгүй сэргээн засварлах, босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах барилгын инженер техникийн ажилтнуудыг дайчлах, барилгын салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх байгууллагуудын хамтын үйл ажиллагааны чиглэл, талуудын хүлээх хариуцлага үүргийг тодорхойлоход оршино.

### **Гурав. Барилга хот байгуулалтын улсын албаны хүлээх үүрэг**

3.1. Газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд шаардагдах барилгын инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн төрөл, хэрэгцээний талаар мэдээлэл цуглуулж нэгтгэн Монголын

барилгачдын нэгдсэн холбоо болон барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагуудад захиалга өгөх;

3.2. Гамшгийн хөнөөлийн голомтод барилгын нурангийг зайлуулах, барилга байгууламжийн эвдрэл гэмтлийг тодорхойлж үнэлэх, сэргээн засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох барилга угсралтын ажлыг гүйцэтгэх болон түр орон сууц барих газрыг товлож Монголын барилгачдын нэгдсэн холбоо болон барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагуудыг мэдээллээр хангах;

3.2. Газар хөдлөлтийн гамшгийн үед хувийн хэвшлийн байгууллагуудын барилгын инженер техникийн ажилтнуудын ажилласан хугацааны цалин хөлс бусад холбогдох зардлыг нөхөн төлөх гэрээг урьдчилан байгуулах;

### **Дөрөв. Монголын барилгачдын нэгдсэн холбооны хүлээх үүрэг**

4.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед нэн тэргүүн ээлжинд шаардагдах барилгын инженер техникийн ажилтнуудыг дайчлах боломжтой хугацааг тодорхойлж БХБУА-д мэдээлэх;

4.2. Газар хөдлөлтийн гамшгийн дараа барилгын инженер техникийн ажилтнуудаар хомсдох аймаг орон нутгийг тодорхойлж тухайн аймаг орон нутаг дахь барилгын салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, эсвэл бусад аймаг орон нутгаас дайчлах арга хэмжээ авах ;

4.3. Газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод барилга, байгууламжийг сэргээн босгох арга хэмжээнд шаардлагатай барилгын инженер техникийн ажилтнуудаар хангалт хийх шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ;

### **Тав. Бусад зүйл**

5.1.Талууд харилцан зөвшилсөний үндсэн дээр Санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай талууд харилцан мэдэгдэнэ.

5.2. Санамж бичиг нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл гурван жилийн хугацаатайгаар байгуулав. Уг санамж бичигт тусгагдсан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дуустал хүчин төгөлдөр байна.

5.3.Санамж бичгийг 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

#### **4. ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БА УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ХООРОНД БАЙГУУЛСАН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛОЛЫН САНАМЖ БИЧИГ**

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогод дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх гэснийг ойлгон,

Онцгой байдлыг ерөнхий газар болон Ус сувгийн удирдах газрын хамтын ажиллагаа нь газар хөдлөлтийн гамшгийн үед хот суурин газрыг цэвэр усаар тасралтгүй хангаж зохицуулах, цэвэр усны шугам хоолойн эвдрэл гэмтлийг шуурхай засварлаж хэвийн байдалд оруулахад чухал ач холбогдолтой гэдгийг ухамсарлан,

Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар нөгөө талаас Ус сувгийн удирдах газар нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн хэрэгжилтийг хангахад үндэслэн энэхүү санамж бичгийг үйлдэв.

#### **Хоёр. Зорилго**

Газар хөдлөлтийн гамшгийн үед хот суурин газрын цэвэр усны хангамжийг тасралтгүй зохицуулах, цэвэр усны шугам хоолойн эвдрэл гэмтлийг шуурхай засварлаж хэвийн байдалд оруулахад талуудын хүлээх үүргийг тодорхойлох

#### **Гурав. ОБЕГ –ын хүлээх үүрэг**

3.1. Газар хөдлөлтийн үед цэвэр усны шугам сүлжээнд эвдрэл гарсны улмаас гэр орондоо ундны болон ахуйн хэрэглээний уснаас гачигдаж буй хүмүүсийн тоо, усны хэрэгцээний талаарх мэдээллийг Ус сувгийн удирдах газарт болон зөөврийн ус тээвэрлэх шуурхай бүлэгт гаргаж өгөх;

3.2. Түр хорогдох байр, түр орон сууцанд шилжин ирсэн хүмүүсийн ундны болон ахуйн хэрэглээний усны хэрэгцээний талаархи мэдээллийг Ус сувгийн удирдах газарт болон зөөврийн ус тээвэрлэх шуурхай бүлэгт гаргаж өгөх;

3.3. Газар хөдлөлтийн үед ажлын байранд дээрээ гацаж гэртээ харих боломжгүй болсон хүмүүсийн судалгаа гаргаж тэдний цэвэр усны хэрэгцээг гаргаж Ус сувгийн удирдах газарт өгөх;

3.4. Хээрийн эмнэлэг болон эмчийн тусламж, эмнэлгийн яаралтай тусламжийн цэгүүдийн усны хэрэгцээг тогтоож шуурхай хангах захиалгыг Ус сувгийн удирдах газарт болон зөөврийн ус тээвэрлэх шуурхай бүлэгт өгөх;

3.5. Ундны болон ахуйн хэрэгцээний ус нөөцлөх цэгүүдийн байршлыг Ус сувгийн удирдах газарт болон зөөврийн ус тээвэрлэх шуурхай бүлэгт гаргаж өгөх;

#### Дөрөв. Ус сувгийн удирдах газрын үүрэг

4.1 Цэвэр усны шугам сүлжээг сэргээн засварлаж дуустал дутагдаж буй усыг худаг, байгалийн ус (гол, горхи, тогтсон ус) цөөрмийн ус, ус нөөцлөх торх, галд тэсвэртэй ус нөөцлөх торхны усыг шүүж цэвэрлэн ариутгах замаар нөхөх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

4.2. Усны машиныг дайчилж газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн тухайлбал, түр хорогдох байр, түр орон сууцад шилжин ирэгсэд, орон сууцны болон гэр хорооллын хүн амд ус түгээх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

4.3. Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн хүн амын өрхийн хэрэглээний усыг оршин суугчдын ойролцоох гүний худгийн болон гадаргын усаар хангах арга хэмжээг зохион байгуулах;

4.4. Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн хүн амд өрхийн хэрэгцээний усыг нөөцлөхөд ашиглагдах усны сав, хувин, канестр, ёмкость, торхны хэрэгцээ тооцоог гаргаж ОБЕГ болон холбогдох засаг захиргааны нэгжид захиалга өгч бэлдүүлэх ажлыг хамтран зохион байгуулах.

4.5. Цэвэр усны шугам хоолойн эвдрэл гэмтлийг шуурхай засварлаж хэвийн байдалд оруулахад шаардагдах хүн хүч, техник хэрэгсэл, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж, ариутгал, цэвэрлэгээний материалын захиалгыг Улсын болон аймаг, нийслэл, дүүргийн Онцгой комисст хүсэлт гаргах.

#### Тав. Бусад зүйл

5.1. Талууд харилцан зөвшилсөний үндсэн дээр энэхүү харилцан ойголцлолын санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болно.

5.2. Энэхүү Харилцан ойголцлолын санамж бичгийн хэрэгжилтийг хангахын тулд талууд энэхүү санамж бичгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах албан тушаалтанг томилж бичгээр мэдэгдэнэ.

5.3 Энэхүү харилцан ойголцлолын санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд харицлан ойголцлолын санамж бичгийг аль нэг байгууллага нь нөгөө байгууллагадаа 6 сараас доошгүй хугацааны өмнө бичгээр өгч мэдэгдэл хийснээр цуцална.

5.4 Санам бичгийг 2018 оны 11дүгээр сарын \_\_өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

ХОЁР БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН:

Огноо: 2018 оны11 дүгээр сарын өдөр

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ :

ХОШУУЧ ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

ДАРГА

Ц. ТӨРХҮҮ

## **5. ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХООРОНД БАЙГУУЛАХ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
ДЭД САЙД

ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Л.ХАЛТАР

Т.БАДРАЛ

### **ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХООРОНД БАЙГУУЛАХ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), нөгөө талаас Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ) /цаашид Талууд гэх/ нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө”-г үндэслэн энэхүү Санамж бичгийг үйлдэв.

#### **Нэг. Зорилго**

1.1. Энэхүү санамж бичгийн зорилго нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үүссэн газар хөдлөлтийн голомтын бүсэд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг саадгүй явуулахын тулд замын хөдөлгөөний болон тээвэрлэлтийн саадгүй байдлыг хангахад оршино.

#### **Нэг. ОБЕГ –ын үүрэг**

2.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед нэн тэргүүн ээлжинд үүрэг гүйцэтгэх хүч хэрэгсэл, галын болон эмнэлгийн тусламжийн машин техник, хүнд механизм, техник хэрэгслийн жагсаалтыг Зам, тээврийн хөгжлийн яаманд гаргаж өгөх;

2.2. Газар хөдлөлтийн голомтоос нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудыг тараан байрлуулахад дайчлагдах нийтийн тээврийн хэрэгслийн тоог тооцож гаргаж Зам, тээврийн хөгжлийн яамыг мэдээллээр хангах;

2.3. Замын хөдөлгөөний удирдлагын төвийн тусламжтайгаар газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод нийтийн зорчигч болон ачаа тээврийн замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах эсвэл зогсоох, тээврийн хэрэгслийн чиглэлийг өөрчлөх арга хэмжээг шуурхай авах;

2.4. Улсын болон орон нутгийн нөөцийн агуулахуудын байршлын талаарх мэдээллээр Зам, тээврийн хөгжлийн яамыг хангах;

2.5. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бараа материалын тээвэрлэлтийг саадгүй нэвтрүүлэх болон дамжин өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

### **Гурав. Зам, тээврийн хөгжлийн яамны хүлээх үүрэг**

- 3.1. Автозам болон төмөр зам, иргэний нисэхийн байгууламжийн бүрэн бүтэн байдал, гарсан эвдрэл, сааталд шуурхай үзлэг шалгалт хийж, хохирлын нөхцөл байдлын талаар ОБЕГ-т мэдээлэх;
- 3.2. Автозам болон төмөр зам, иргэний нисэхийн байгууламжид гарсан эвдрэл, нурангийг зайлуулж арилгах, барилга угсралт болон засварын ажлыг шуурхай гүйцэтгэж зорчигч болон ачаа тээврийн үйл ажиллагааг хэвийн байдалд оруулах төлөвлөгөөг гаргаж ОБЕГ –т мэдээлэх;
- 3.3. Газар хөдлөлтийн хөнөөлийн голомтоос нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх тээврийн хэрэгслийн аюулгүй хөдөлгөөн үйлдэх зам маршрутын чиглэлийг Тээврийн цагдаагийн албатай хамтран тогтоож ОБЕГ –т мэдэгдэх
- 3.4. Газар хөдлөлтийн гамшгийн эрэн хайх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд дайчлагдах томилгоот автотээврийн хэрэгсэл болон хүнд механизм, нисэх онгоцыг тогтоосон хугацаанд хурдан шуурхай гаргах;
- 3.5. Автозам, төмөр зам, иргэний нисэхийн аль нэг нь газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод ачаа тээвэрлэлт гүйцэтгэх боломжгүй тохиолдолд бие биенээ орлон тээвэрлэх боломж хувилбаруудыг ОБЕГ –т мэдэгдэх;
- 3.6. Газар хөдлөлтийн гамшгийн үед хамтран ажиллах хувийн хэвшлийн нийтийн тээврийн болон ачаа тээврийн компаниуд, холбоодын нэрсийн жагсаалтыг ОБЕГ –т гаргаж өгөх.

### **Дөрөв. Бусад зүйл**

- 4.1. Зам, тээврийн хөгжлийн яамнаас гамшиг тохиолдсон үед зам тээврийн салбарын тогтвортой байдлыг хангах талаар авсан арга хэмжээний тухай ОБЕГ-т тайлагнана.
- 4.2. Талууд харилцан зөвшилсөний үндсэн дээр Санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай Зам, тээврийн хөгжлийн яаманд мэдэгдэнэ.
- 4.3. Санамж бичиг нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба аль нэг талаас санал гараагүй тохиолдолд уг Санамж бичиг нь хүчин төгөлдөр байна.
- 4.4. Санамж бичгийг 2019 оны ... дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
ЯАМ**

**ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

## **6. ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН АШИГ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ХООРОНД БАЙГУУЛАХ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ  
ГЕНЕРАЛ

Т.БАДРАЛ

АШИГ МАЛТМАЛ, ГАЗРЫН  
ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА

Х.ХЭРЛЭН

ОНЦГ  
ОЙ  
БАЙД  
ЛЫН

ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН  
АШИГ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ХООРОНД БАЙГУУЛАХ  
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт дурьдсанчлан Засгийн газар, төрийн байгууллагууд, холбогдох салбар, талууд үндэсний онцлог, засаглалын тогтолцоондоо тохируулан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хүлээх үүрэг, хариуцлагаа тодорхойлох шаардлагатай байна гэснийг хүлээн зөвшөөрч,

Ашигт малтмал газрын тосны газар нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үүссэн газар хөдлөлтийн голомтын бүсэд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг саадгүй явуулахын тулд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг хүлээнэ гэдгийг ухамсарлан,

Ашигт малтмал газрын тосны газрын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн үеийн газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн асуудлыг зохион байгуулахад УБТЗ ХНН, газрын тосны бүтээгдэхүүн импортлогч томоохон компаниуд, нутгийн захиргааны байгууллагуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч,

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогод дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх гэснийг ойлгон,

Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч томоохон компаниуд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд гамшгийн үед газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн



тогтвортой байдлыг хангахад Ашигт малтмал газрын тосны газар болон Онцгой байдлын ерөнхий газарт дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээр оролцохоо илэрхийлж энэхүү санамж бичиг дээр харилцан тохиролцов.

## **ХОЁР. ЗОРИЛГО**

Энэхүү санамж бичгийн зорилго нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үүссэн газар хөдлөлтийн голомтын бүсэд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг саадгүй явуулахын тулд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх байгууллагуудын хамтын үйл ажиллагааны чиглэл, талуудын хүлээх хариуцлага үүргийг тодорхойлоход оршино.

## **ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА**

**Талууд доорхи асуудлуудыг харилцан тохиролцоно. Үүнд:**

3.1. Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас газар хөдлөлтийн голомтын бүсэд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тооцож гаргах;

3.2. Газар хөдлөлтийн голомтоос нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудыг тараан байрлуулахад дайчлагдах нийтийн тээврийн шатахууны хэрэгцээг тооцож гаргах;

3.3. Газар хөдлөлтийн гамшгийн үед газрын тосны салбарын тогтвортой ажиллагааг хангах замаар газрын тосны бүтээгдэхүүний үнэ хөөрөгдөх, зохиомол хомсдол үүсгэхгүй байх;

3.4. Газар хөдлөлтийн гамшгийн үед шатахуун түгээх суурин болон зөөврийн станцуудын хэрэглэгчдэд бөөний болон жижиглэн худалдах үйчилгээг тодорхой хугацаагаар хязгаарлах замаар улсын нэн чухал объект, харилцаа холбоо, эрчим хүч болон стратегийн зориулалттайгаас бусад үйлдвэр, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг улсын болон орон нутгийн хэмжээнд бүрдүүлэх;

3.5. Газар хөдлөлтийн гамшгийн үед эрэн хайх, аврах ажиллагааг явуулах томилгоот шуурхай бүлэг, ерөнхий болон тусгай зориулалттай мэргэжлийн анги, бусад хүч хэрэгслийн машин техник, хүнд механизм, галын болон эмнэлгийн тусламжийн машин, техник хэрэгслийг эхний ээлжинд дараалал харгалзахгүй газрын тосны бүтээгдэхүүнээр хангах ;

3.6. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн зохицуулалт, уялдаа холбоог хангах төлөвлөгөөг холбогдох талуудыг оролцуулан хамтран боловсруулах,

3.7. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хоёрдогч хөнөөл болох газрын тосны бүтээгдэхүүний хадгалах сав тоног төхөөрөмж, шатахуун түгээх станцанд гарч болзошгүй гал түймэр, дэлбэрэлтээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хамтран төлөвлөж хэрэгжүүлэх;

3.8. Газар хөдлөлтийн гамшгийн үед газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг зохицуулахтай холбогдон гарсан зардлыг нөхөн төлөх асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэх;

### **ДӨРӨВ. Онцгой байдлын ерөнхий газрын хүлээх үүрэг**

4.1. Ашигт малтмал, газрын тосны газрыг газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон хохирлын үнэлгээ, газрын тосны салбарт үүсч болзошгүй цагийн байдлын талаархи мэдээллээр хангах;

4.2. Ашигт малтмал, газрын тосны газарт газар хөдлөлтийн хөнөөлийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд газрын тосны бүтээгдэхүүнээр хангах хүч хэрэгслийн жагсаалтыг гаргаж өгөх;

4.3. Ашигт малтмал, газрын тосны газарт газар хөдлөлтийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 24-72 цаг, 7 хоног, нэг сарын шатахууны хэрэгцээг тодорхойлж, хангамжийг зохион байгуулах хүсэлт гаргах;

### **ТАВ. Ашигт малтмал газрын тосны газрын хүлээх үүрэг**

5.1. Газар хөдлөлтийн гамшгийн тохиолдсон бүс нутагт шаардлагатай газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн газрын тосны бүтээгдэхүүн импортлогч болон хангамжийн байгууллагуудын нөөц, хангалт хийх боломжит хугацааг тодорхойлж Онцгой байдлын ерөнхий газрыг мэдээллээр хангах;

5.2. Газар хөдлөлтийн гамшгийн үед газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тасалдаж болзошгүй бүс нутгийг тодорхойлж, тухайн бүс нутаг дахь нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, эсвэл бусад бүс нутгаас төмөр зам болон автоцистернээр газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хангамжийг зохицуулах арга хэмжээг зохион байгуулах;

## **ЗУРГАА. Бусад зүйл**

6.1. Ашигт малтмал газрын тосны газраас газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах талаар авсан арга хэмжээний тухай тэмдэглэлийг Онцгой байдлын ерөнхий газарт (14 хоногийн дотор) хүргүүлж тайлагнана.

6.2. Санамж бичиг нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр Санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд тухайн Санамж бичигт ямар нэгэн өөрчлөлт ороогүй тохиолдолд санамж бичгийг 1 жилээр сунгагдсанд тооцно.

6.3. Санамж бичгийг 2018 оны ... дүгээр сарын .... ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР

АШИГ МАЛТМАЛ, ГАЗРЫН  
ТОСНЫ ГАЗАР

## **7. Мэдээлэл харилцааны санамж бичиг**

### **ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ**

Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), нөгөө талаас Үүрэн телефоны оператор компани /цаашид Талууд гэх/ нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө” -г үндэслэн энэхүү Санамж бичгийг үйлдэв.

#### **Нэг. Зорилго**

1.1. Энэхүү санамж бичгийн зорилго нь газар хөдлөлтийн үед гамшгийн мэдээлэл дамжуулахад телефон холбооны сүлжээний хэвийн ажиллагаа, бэлэн байдал, шуурхай үйлчилгээг хангах, үүрэн холбооны ачааллаас шалтгаалсан доголдлоос сэргийлэхэд оршино.

#### **Хоёр. Талууд доорхи асуудлуудыг харилцан тохиролцоно. Үүнд:**

2.1. Гамшгийн үед үүрэн телефоны холбоо харилцааг хязгаарлах, тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээг хэрэгжүүлэх, дуусгавар болгох, шугамын тоо, холбоо харилцааг хязгаарлах нөхцлийг тодорхой заана;

2.2. Тусламж үзүүлэх тухай хүсэлтийг үүрэн телефоны оператортай зөвшилцөж тохирсны үндсэн дээр зааж тогтооно;

2.3. Газар хөдлөлтийн гамшгийн үед үүрэн телефоны үйлчилгээний ачаалал нэмэгдэж, холбогдох боломжгүй болох тохиолдолд үүрэн телефоны оператор өөрөө шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд ОБЕГ-аас үүрэн телефоны операторт тусламж үзүүлэх тухай хүсэлт гаргахгүй.

#### **Гурав. Үүрэн телефоны компани хүлээх үүрэг**

3.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5-д заасны дагуу үүрэн телефоны оператор компани нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулах;

3.1. Үүрэн телефоны шугамын ачааллаас сэргийлэх зорилгоор гол сүлжээний нэг дор холбогдох тоо хэмжээг хязгаарлах;

3.2. Нэг дор холбогдох тоо хэмжээг хязгаарлах хувь хэмжээ нь гол сүлжээний нэг дор холбогдох хамгийн дээд хувь хэмжээний ...% байхаар тогтоох.

3.3. Гамшгаас хамгаалах холбогдох байгууллагын мэдээлэл дамжуулах зорилгоор гамшгийн үед тэргүүн ээлжинд телефон холбоо болон дата мэдээлэл дамжуулах орчин нөхцлийг бүрдүүлэх;

#### **Дөрөв. ОБЕГ –ын хүлээх үүрэг**

4.1. Холбоо барих, мэдээлэл хүлээн авах ажлыг хариуцаж буй газар, хэлтэс болон албан тушаалтны нэрийг үүрэн телефоны операторын хариуцаж буй ажилтанд мэдээлсэн байна.

## **Тав. Бусад зүйл**

5.1. Үүрэн телефоны оператор нь холбоо харилцааг хязгаарласан тухай болон гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон холбооны үйлчилгээний тухай тэмдэглэлийг ОБЕГ-т 14 хоногийн дотор хүргүүлж тайлагнана.

5.2. Талууд харилцан зөвшилсөний үндсэн дээр Санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар мэдэгдэнэ.

5.3. Санамж бичиг нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба 2017 оны дүгээр сарын ны өдөр хүртэл хугацаатайгаар байгуулав. Уг санамж бичигт тусгагдсан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дуустал хүчин төгөлдөр байна.

5.4. Санамж бичгийг 2017 оны дүгээр сарын ны өдөр Улаанбаатар хотноо хоёр хувь үйлдэв.

Гарын үзэг

## **8. ТҮР ХОРГОДОХ БАЙРЫН ТУХАЙ НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ ХӨГЖЛИЙН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

НИЙСЛЭЛИЙН  
БОЛОВСРОЛЫН  
ГАЗРЫН ДАРГА,

Ж.ГАНТУЛГА

НИЙСЛЭЛИЙН ХОТ  
БАЙГУУЛАЛТ ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА,

Б.УУГАНБАЯР

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ  
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

**Төсөл**

### **НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ ХӨГЖЛИЙН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Нэг талаас Нийслэлийн Онцгой байдлын газар (НОБГ), нөгөө талаас Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар (НХБХГ), Нийслэлийн Боловсролын газар (НБГ) /цаашид Талууд гэх/ нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө”-г үндэслэн энэхүү Санамж бичгийг үйлдэв.

#### **Нэг. Зорилго**

1.1. Энэхүү санамж бичгийн зорилго нь газар хөдлөлтийн нэрвэгдэгсэд болон гэр оронгүй болсон хүмүүст яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээний хүрээнд сургуулийн барилгыг түр хоргодох байраар ашиглах ажлыг шуурхай зохион байгуулахад оршино.

#### **Хоёр. Талууд доорхи асуудлуудыг харилцан тохиролцоно. Үүнд:**

2.1. Түр хоргодох байрны үйл ажиллагааг саадгүй зохион байгуулж явуулах зорилгоор Түр хорогдох байрны үйл ажиллагаа хариуцсан хамтарсан түр комисс байгуулна. Тус комиссын бүрэлдэхүүн нь нийслэлийн Онцгой байдлын газар болон дүүргүүдийн Онцгой байдлын хэлтэс, Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газрын түр хорогдох байр хариуцсан албан хаагч болон түр хорогдох байр болгон ашиглах сургуулийн барилга байгууламжийг хариуцах Нийслэлийн боловсролын газар болон түр хорогдох байрыг өмчлөгч хуулийн этгээд, түр хорогдох байр байрлаж буй дүүрэг хорооны иргэдийн төлөөллөөс бүрдсэн байна.

2.2. Түр хоргодох байрыг нээх болон бусад удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудлыг Түр хоргодох байрны үйл ажиллагаа хариуцсан комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.3. Түр хоргодох байрны үйл ажиллагаа хариуцсан комиссоос түр хоргодох байрыг нээх, үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотой дадлага сургууль явуулахад НОБГ болон дүүргүүдийн онцгой байдлын хэлтэс, Нийслэлийн засаг даргын тамгын газраас мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлнэ.

**Гурав. Нийслэлийн Онцгой байдлын газрын хүлээх үүрэг**

3.1. Гамшигт нэрвэгдсэн газрын цагийн байдлыг үнэлэх, гэр оронгүй болсон иргэдийн талаар мэдээлэл цуглуулах;

3.2. Гамшигт нэрвэгдэж гэр оронгүй болсон иргэдэд түр хоргодох байр болон түр цугларах талбай болгож ашиглах боломжтой газруудыг тухайн хуулийн этгээд, дүүрэг, хороонд мэдээлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.3. Онцгой байдлын байгууллага нь гамшгийн үед аврах ажиллагаа явуулах салбар, нэгжийг Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар болон Нийслэлийн боловсролын газарт урьдчилан танилцуулж, түр хоргодох байрны удирдлага, зохион байгуулалтын ажилд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх;

3.4. Нийслэлийн Онцгой байдлын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь түр хоргодох байрны удирдлага, зохион байгуулалтыг хариуцах Салбар, нэгжийн бүрэлдэхүүнийг Онцгой байдлын ерөнхий газар болон Нийслэл хот байгуулалтын газар, Нийслэлийн боловсролын газруудад урьдчилан мэдэгдэнэ.

**Дөрөв. Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газрын хүлээх үүрэг**

4.1. Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар нь гамшгийн үед түр орон байрны жагсаалтыг гаргах, тодотгол хийж хүртээмжийг нэмгэдүүлэх, холбогдох байгууллагуудад мэдээлэх, дэмжлэг үзүүлэх,

4.2. Түр орон байрны барилгын хийц, бүтээцэд судалгаа хийх, паспортжуулах, хамтран ажиллах.

**Тав. Нийслэлийн боловсролын газрын үүрэг**

5.1. Нийслэлийн Боловсролын газраас сургуулийн барилга байгууламжийг түр хоргодох байраар нээж ажиллуулах боломжтой сургууль, цэцэрлэгийн судалгаа, мэдээллийг гаргах,

5.2. Нийслэлийн боловсролын газраас Гамшгийн үед сургуулийн барилга байгууламжийг түр хоргодох байраар нээх, хаах үед Нийслэлийн Онцгой байдлын газар болон харьяа дүүргийн Онцгой байдлын хэлтэст мэдэгдэх,

5.3. Түр хоргодох байрыг чөлөөлүүлэх шаардлага гарсан тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тухай бүр мэдэгдэх, .

5.4. Сургуулийн түр хоргодох байрны засвар үйлчилгээтэй холбоотой зардлын тооцоо судалгааг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах, түр хоргодох байрны нөхцөл байдлын талаар жилд 1 удаа Засаг даргын Тамгын газарт тайлагнах,

### **Зургаа. Бусад зүйл**

6.1. Түр хорогдох байрны үйл ажиллагаа хариуцсан хамтарсан түр комисс нь үйл ажиллагаа, гүйцэтгэсэн ажлын талаархи тайланг нийслэлийн Онцгой байдлын газарт болон нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

6.2.Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр Санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай талууд харилцан мэдэгдэнэ.

6.3. Уг санамж бичигтэй холбоотой маргаантай асуудал үүссэн тохиолдолд талууд зөвшилцөлийн зарчимаар асуудлыг шийдвэрлэнэ.

6.4. Санамж бичиг нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх бөгөөд 20.....оны ..... дүгээр сарын .....-ны өдөр хүртэл хугацаатайгаар байгуулав. Уг санамж бичгийн хүчинтэй хугацаа дуусах хүртэл талуудаас санал ирүүлээгүй тохиолдолд сунгагдсанд тооцно.

6.5. Хуулийн этгээдийн эзэмшлийн байгууламжуудыг түр хоргодох байраар ашиглах боломжгүй болсон тохиолдолд уг санамж бичгийг талууд цуцалж болно.

6.6. Санамж бичгийг 20.....оны ..... дүгээр сарын .....-ны өдөр Улаанбаатар хотноо 3 хувь үйлдэв.

---o0o---



## **9. БОХИР ЗАЙЛУУЛАХ ТУХАЙ НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР, УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

НИЙСЛЭЛИЙН ХОТ  
ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ДАРГА,  
Б.БЯМБАДОРЖ

УС СУВГИЙН УДИРДАХ  
ГАЗРЫН ДАРГА,  
Ц.ТӨРХҮҮ

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА  
Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

### **НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР, УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллага, академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох, үйл ажиллагаандаа гамшгийн эрсдэлийг тооцдог байх шаардлагатай байна гэснийг хүлээн зөвшөөрч,

1.2. Төрөөс баримтлах бодлогод дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт салбар дундын оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх гэснийг ойлгон,

1.3. Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн хот тохижилтын газар, Ус сувгийн удирдах газар нь гамшгийн үед хот, суурин газрын хэрэглээнээс гарсан бохир усны шугам сүлжээг сэргээн засварлах, ариутгал, цэвэрлэгээ болон гамшигт нэрвэгдсэн хүн амд орон сууц, нийтийн ахуйн үйлчилгээг тасралтгүй зохион байгуулахад чухал үүрэг хүлээдэг гэдгийг ухамсарлан, газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах чиглэлээр хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхээ илэрхийлж энэхүү санамж бичигт харилцан тохиролцов.

#### **Хоёр. Зорилго**

2.1. Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг /Цаашид “Санамж бичиг” гэх/-ийн зорилго нь газар хөдлөлтийн гамшгийн үед хот суурин газрын хэрэглээнээс гарсан бохир усны шугам сүлжээг сэргээн засварлах, ариутгал, цэвэрлэгээ болон гамшигт нэрвэгдсэн хүн амд орон сууц, нийтийн ахуй үйлчилгээг тасралтгүй зохион байгуулахад талуудын хамтын үйл ажиллагааны чиглэл, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

#### **Талуудын хүлээх үүрэг**

##### **Гурав. Нийслэлийн Онцгой байдлын газар**

3.1. Нийслэлийн Онцгой байдлын газар нь: Газар хөдлөлтийн гамшгийн үед нийслэлийн хэмжээнд түр цугларах аюулгүй талбай, түр хорогдох байранд шаардагдах нийтийн бие засах газар, зөөврийн 00 болон бохирын шугам эвдэрсэн, бохир ус хальсан талаарх мэдээллийг цуглуулах;

3.2. Нүүн шилжсэн иргэдийн дамжин өнгөрүүлэх болон хүлээж авах цэгүүдэд шаардагдах нийтийн бие засах газар, зөөврийн 00-ын хэрэгцээний талаарх мэдээллийг Нийслэлийн Хот тохижилтын газарт мэдэгдэж хамтран ажиллах;

3.3. Орон сууцны хороолол, гудамж талбайд бохир ус халиснаас үүдэлтэй Төр захиргааны болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага, айл өрх, иргэдийн үйл ажиллагаа, Нийтийн тээврийн үйлчилгээ, замын хөдөлгөөнд үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулж Ус сувгийн удирдах газрыг мэдээллээр хангаж хамтран ажиллах;

#### **Дөрөв. Нийслэлийн Хот тохижилтын газар**

4.1. Нийслэлийн Хот тохижилтын газар нь: Нийслэлийн Онцгой байдлын газрын мэдээлэлд үндэслэн түр цугларах талбай, түр хорогдох байранд нүүн шилжсэн иргэдийг хүлээж авсан цэгүүдэд шаардагдах зөөврийн 00-ыг байрлуулах;

4.2. Байрлуулсан зөөврийн 00-ын байршил, тоо, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Онцгой байдлын газарт мэдээлэх;

4.3. Байрлуулсан зөөврийн 00-ын цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт болон татаж авах, зөөвөрлөх асуудлыг хариуцах;

4.5. Цаашид шаардагдах зөөврийн 00-ын нөөц бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

#### **Тав. Ус сувгийн удирдах газар**

5.1. Ус сувгийн удирдах газар нь: Нийслэлийн Онцгой байдлын газрын мэдээлэлд үндэслэн орон сууцны хороолол, гудамж талбайд хальсан бохир усыг соруулах, сэргээн засварлах, ариутгал, халдваргүйтгэлтэй холбоотой арга хэмжээг зохион байгуулах;

5.2. Бохир усны шугам, хоолойн эвдрэл гэмтлийг шуурхай засварлаж хэвийн байдалд оруулахад шаардагдах хүн хүч, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг томилгоожуулах;

5.3. Бохирын хоолойн эвдрэл гэмтлийг засварлахад шаардагдах техник, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх;

#### **Зургаа. Бусад зүйл**

6.1. Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр Санамж бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай харилцан мэдэгдэнэ;

6.2. Санамж бичиг нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба 2019 оны ..... дугаар сарын.....-ний өдөр хүртэлх хугацаагаар байгуулав.

6.3. Уг санамж бичигт тусгагдсан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дуусах хүртэл талуудаас санал ирүүлээгүй тохиолдолд сунгагдсанд тооцно.

6.4. Санамж бичгийг 2019 оны ..... дугаар сарын .....-ний өдөр Улаанбаатар хотод гурван хувь үйлдэв.

---о0о--

## **Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам**

### **Нэг: Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү журмын зорилго нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын цагийн байдлыг системд зураглах, гамшгийн орон зайн мэдээллийг боловсруулах, мэдээллийн санг бүрдүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүнг ашиглах, нийтийн хүртээл болгох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гамшгийн код, орон зайн мэдээллийн сангийн загвар, бүтэц нь энэ журмын бүрэлдэхүүн хэсэг байна.

### **Хоёр: Нэр томъёоны тайлбар**

- 2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.  
Үүнд:
  - 2.1.1. “Өгөгдөл” гэж тоо буюу тэмдэгтийн цогц бөгөөд тодорхой утга агуулгатай, дүрсэлж болох мэдээллийг;
  - 2.1.2. “Орон зайн өгөгдөл” гэж газрын гадаргын дээрх, доорх ус агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, аюулт үзэгдлийн шинж чанар, хэмжээ, далайц байрлалыг тодорхойлж буй өгөгдлийг;
  - 2.1.3. “Орон зайн бус өгөгдөл” гэж орон зайн өгөгдөл агуулаагүй статистик тоон болон текст өгөгдлийг;
  - 2.1.4. “Гамшгийн орон зайн мэдээллийн систем” гэж гамшгийн орон зайн мэдээллийн санд хэрэглэгчийн эрхээр хандах, орон зайн болон орон зайн бус өгөгдлүүдийг шинээр үүсгэх, ашиглах, шинэчлэх, засварлах зориулалт бүхий системийг;
  - 2.1.5. “Гамшгийн орон зайн мэдээллийн сан” гэж тогтмол шинэчлэгддэг орон зайн болон орон зайн бус өгөгдлүүдийн бүрдлийг.

**Гурав: Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, түүнд тавигдах шаардлага**

- 3.1. Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн өгөгдлийг дараах байдлаар ангилна. Үүнд:
  - 3.1.1. Орон зайн мэдээллийн сангийн суурь өгөгдөл (засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, нийгэм, эдийн засаг, хот, суурин газрын хөгжлийн төлөвлөлт, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, кадастрын мэдээлэл, хот суурин газар, барилга байгууламж, гудамж талбай, бүх төрлийн зам, шугам, сүлжээ, геологи, уул уурхай, гидрологи, ойн сан бүхий газар, агаар, сансрын зураг, бусад суурь зургууд);
  - 3.1.2. Орон зайн мэдээллийн сангийн сэдэвчилсэн өгөгдөл (геологийн, биологийн, байгалийн гаралтай аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаатай холбоотой осол зэрэг).
- 3.2. Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн бүрдүүлэгчийг “үндсэн” болон “дэд” гэж ангилна.
  - 3.2.1. Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн “үндсэн бүрдүүлэгч” нь Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн онцгой байдлын анги, салбар байна;
  - 3.2.2. Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн “дэд бүрдүүлэгч” нь энэ журмын 4.2.1-д заасны дагуу Онцгой байдлын байгууллагатай мэдээ, мэдээллийг гэрээний хүрээнд харилцан солилцож, хамтран ажиллаж буй байгууллагууд байна.
- 3.3. Гамшгийн орон зайн мэдээллийн санд дараах шаардлага тавигдана. Үүнд:
  - 3.3.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын мэдээллийг тухайн цаг хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэд оруулсан байх;
  - 3.3.2. Мэдээллийг баталсан загварын дагуу Гамшгийн орон зайн мэдээллийн санд (2 дугаар хавсралт) оруулах, шинэчлэх, засварлах;
  - 3.3.3. Зураглал боловсруулахад Онцгой байдлын албаны болон бусад мэргэжлийн байгууллагын томъёолсон тэмдгийг ашиглах;

3.3.4. Гамшгийн орон зайн мэдээллийн системд оруулж буй орон зайн мэдээлэл, боловсруулалтын ажилд олон улсын геодезийн “WGS-84” солбицлыг, өндрийн сүлжээнд Балтийн тэнгисийн тогтолцоог, том, дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын “UTM” тусгагийг хэрэглэсэн байна.

**Дөрөв: Гамшгийн орон зайн мэдээллийн системийн удирдлагын зохион байгуулалт**

- 4.1. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв чиглүүлж, мэдээллийг бүртгэх, засварлах, боловсруулах асуудлыг Орон зайн мэдээлэл, технологийн тасаг хариуцна.
- 4.2. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 4.2.1. Гамшгийн орон зайн мэдээллийн санг хөгжүүлэх, бүрдүүлэх, харилцан ашиглах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;
  - 4.2.2. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үндсэн, дэд бүрдүүлэгч болон энэ журмын 5.4-т заасан бусад хэрэглэгчийн хандалтын эрхийг баталгаажуулах;
  - 4.2.3. Гамшгийн орон зайн мэдээллийн системийг хөгжүүлэх, хадгалах, нөөцлөх, нууцлахад шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамж, ашиглалт, үйлчилгээнд шаардагдах зардлын тооцоог танилцуулах;
  - 4.2.4. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагаа, ашиглалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргах;
- 4.3. Орон зайн мэдээлэл, технологийн тасаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 4.3.1. Орон зайн суурь бүхий гамшгийн сэдэвчилсэн өгөгдөл, гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийн бүрдүүлэлтэд хяналт тавих, баталгаажуулах, шаардлагатай мэдээллийг засварлах;
  - 4.3.2. Орон зайн мэдээллийн системийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай техник хэрэгсэл, программ хангамжийн системийг сайжруулах, өргөжүүлэх санал гаргах;

- 4.3.3. Гамшгийн орон зайн мэдээллийн системд оруулсан мэдээллийг хянах, баталгаажуулах;
- 4.3.4. Орон зайн суурь өгөгдөл, мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, шинэчлэх;
- 4.3.5. Орон зайн суурь өгөгдөл бүхий гамшгийн түүхчилсэн мэдээллийг бүрдүүлэх, шинэчлэх;
- 4.3.6. Нийгэм, эдийн засгийн статистик мэдээллийг бүрдүүлэн гамшгийн орон зайн мэдээллийн системд оруулах;
- 4.3.7. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл бүрийн мэдээ, зураглалаар удирдлагыг хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;
- 4.3.8. Нууцлал бүхий мэдээллийг оруулах, бүрдүүлэх, хадгалах;
- 4.3.9. Хэрэглэгчийн хандалтын эрх үүсгэх, хязгаарлах, энгийн хэрэглэгчийн хандалтын эрхийн ангилалд зөвшөөрөгдөх мэдээллийг тохируулах;
- 4.3.10. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн нөөцлөлт, нууцлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 4.3.11. Онцгой байдлын байгууллагын ашиглаж буй бусад систем, өгөгдлийн сантай уялдуулах;
- 4.3.12. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангах;

**Тав: Гамшгийн орон зайн мэдээллийн системийн ашиглалт**

- 5.1. Гамшгийн орон зайн мэдээллийн системийг дараах зорилгоор ашиглана.  
Үүнд:
  - 5.1.1. Болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээлэл, нийгэм эдийн засгийн суурь статистик мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, эрсдэлийн үнэлгээний зураглал болон бусад төлөвлөлтөд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх, мэдээлэл солилцох;
  - 5.1.2. Улсын алба, аймаг, нийслэл, сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, бэлэн байдлыг хангах зориулалт бүхий бусад төлөвлөлтийг зураглах;

- 5.1.3. тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын шуурхай хариу арга хэмжээний зураглал боловсруулах, цаашид гарч болзошгүй аюулыг тооцоолох, шуурхай шийдвэр гаргах, үр дүнг танилцуулах;
  - 5.1.4. Гамшиг, аюулт үзэгдэл, осолд нэрвэгдсэн бүс, төв орон нутгийн сэргээн босгох үйл ажиллагааны зураглал боловсруулах, мэдээлэл солилцох;
  - 5.1.5. Гамшгаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажилд ашиглах.
- 5.2. Энэ журмын 4.2.1-т зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт гамшгийн орон зайн мэдээллийн системийн нээлттэй мэдээллийг зохих зөвшөөрлийн дагуу ашиглана.
- 5.3. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн ашиглалтад дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:
- 5.3.1. Гамшгийн төрөл бүрийн сэдэвчилсэн зураглалыг боловсруулахдаа зөвхөн гамшгийн орон зайн мэдээллийн сангийн суурь өгөгдлийг ашигласан байх;
  - 5.3.2. Мэдээллийн сангийн загварын дагуу зураглаж, гамшиг, аюулт үзэгдэл, ослыг бүртгэсэн байх;
  - 5.3.3. Орон зайн өгөгдөл болон гамшгийн статистикийн мэдээллийг гамшгийн нэгдсэн кодчиллын дагуу бүртгэсэн байх;
  - 5.3.4. Гамшгийн орон зайн мэдээллийг хоёрдогч бүтээгдэхүүнд авч ашиглахдаа эх сурвалжийг заавал дурдсан байх.
- 5.4. Гамшгийн орон зайн мэдээллийн систем нь дараах хандалтын эрхтэй байна. Үүнд:
- 5.4.1. Системийн админ эрх;
  - 5.4.2. Систем дэх мэдээллийн сангийн админ;
  - 5.4.3. Засварлах эрх /зөвшөөрөгдсөн мэдээлэл оруулах, засварлах/;
  - 5.4.4. Хэрэглэгчийн эрх /зөвшөөрөгдсөн мэдээлэл харах, танилцах/;
  - 5.4.5. Олон нийтийн хандалтын эрх /зөвшөөрөгдсөн мэдээлэлтэй танилцах, ашиглах/.

### **Зургаа: Гамшгийн орон зайн мэдээллийн системийн хэрэглэгчийн чиг үүрэг**

- 6.1. Бүсийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 6.1.1. Улсын хэмжээний орон зайн суурь өгөгдөл бүхий гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын, сэдэвчилсэн мэдээлэлтэй танилцах, ашиглах;
  - 6.1.2. Боломжит, шаардлагатай орон зайн мэдээ, мэдээллийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас шаардах.
  - 6.1.3. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын, сэдэвчилсэн мэдээллийн бүрдүүлэлтэд хяналт тавих, зохицуулалт, удирдлагаар хангах;
- 6.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 6.2.1. Гамшгийн орон зайн мэдээллийн системд хэрэглэгчийн эрхээр нэвтрэх, суурь болон сэдэвчилсэн өгөгдлийг ашиглах.
  - 6.2.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээ, зураглалыг тухайн цаг хугацаанд оруулах, засварлах, шинэчлэх;
  - 6.2.3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэдээ, зураглалыг оруулах, засварлах, шинэчлэх;
  - 6.2.4. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл, судалгаа, зураглалыг оруулах, засварлах, шинэчлэх.
- 6.3. Гэрээт байгууллагын эрх үүрэг нь энэ журмын 3.2.2-т заасны дагуу зохицуулагдана.

### **Долоо: Гамшгийн орон зайн мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах**

- 7.1. Гамшгийн орон зайн мэдээллийн сан нь үндсэн болон нөөц сервер, нөөцлөлтийн программ хангамжтай байна;
- 7.2. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн нөөц хувилбарын систем нь үндсэн системтэйгээ адил түвшний хүчин чадалтай сервер байна;
- 7.3. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн нөөц хувилбарыг системээс систем рүү гэсэн зарчмаар нөөцлөн хадгална;



- 7.4. Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн нөөцлөлтийн ажиллагааг долоо хоног бүрийн Лхагва гарагийн 04:00 цагт хийх ба нөөцлөлт хэвийн хийгдэж буй эсэхийг 14 хоног тутам шалгаж тэмдэглэл хөтөлнө;
- 7.5. Гамшгийн орон зайн мэдээллийн системийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдөр бүрэн нөөцөлж хадгална;
- 7.6. Гамшгийн орон зайн мэдээллийн системийн нөөцлөлтийг зориулалтын хадгалах төхөөрөмжид хадгална;
- 7.7. Мэдээллийн сангийн нууцлал бүхий мэдээллийг зохих хууль тогтоомжийн дагуу хүлээн авах, мэдээллийн санд оруулах, ашиглах, дамжуулах ажиллагааг хэрэгжүүлнэ;
- 7.8. Бусад байгууллагатай мэдээлэл харилцан солилцох, системд хандах эрхийг олгох, холболт болон сүлжээний нууцлалтай холбоотой асуудлыг гэрээгээр зохицуулна.

#### **Найм: Хориглох**

- 8.1. Санаатай болон санамсаргүйгээр гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагаанд саад учруулах аливаа үйлдлийг хориглоно.
- 8.2. Гамшгийн орон зайн системийн мэдээ, мэдээллийг арилжааны зорилгоор ашиглах, ашиглуулахыг хориглоно.

#### **Ес: Хариуцлага**

- 9.1. Энэхүү журмыг зөрчсөн алба хаагч, ажилтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **ГАМШГИЙН ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН КОДЧИЛОЛ**

### **1 Зорилго**

“Гамшгийн орон зайн мэдээллийн сан” (ГОЗМС)-гийн ашиглалтыг хялбаршуулах, системтэйгээр ашиглахын тулд шинээр гамшгийн код боловсруулж ашиглах, бусад улсын хэмжээний, салбарын, байгууллагын мэдээллийн сангуудтай уялдуулан холбох түлхүүр болж хэрэглэгдэх юм.

#### **1.1 Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн суурь давхаргын кодчиллол**

ГОЗМС-ийн суурь мэдээлэл нь салбар бүрд нийтлэг ашиглагддаг засаг захиргааны, зам шугам сүлжээний, барилга байгууламжийн гэх мэт цэг, шулуун, полигоноор дүрслэгдсэн орон зайн биет мэдээллүүдийг хэлнэ. Орон зайн суурь өгөгдлүүдийн бүрдэл, хяналт, стандартыг улсын хэмжээнд “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” хариуцан хөгжүүлж, улсын хэмжээнд орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэхээр зорин ажиллаж байгаа бөгөөд “Гамшгийн орон зайн мэдээллийн сан” нь түүний нэг бүрдэл буюу нэгээхэн хэсэг нь болж хөгжих юм. Иймд гамшгийн орон зайн мэдээллийн сангийн суурь давхаргууд мөн түүний кодчиллол нь “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар”-т хийгдсэн байдаг тул шууд авч ашиглахаар энэхүү хавсралтад тусгав.

#### **1.2 Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн сэдэвчилсэн давхаргын код буюу гамшгийн кодчиллол**

Монгол Улсын хэмжээнд тохиолддог гамшиг, осол, аюулт үзэгдлийг гарал үүсэл, төрлөөр ангилж кодчилон ГОЗМС-д хэрэглэх нь хэрэглээг хялбарчлах, урт нэршил ашиглахгүйгээр бичих, нэршлийн алдаа гарахгүй байх, цаг хэмнэх мөн бусад мэдээллийн сангуудыг уялдуулахад хэрэглэгдэх юм.

Онцгой байдлын байгууллага нь анх удаа гамшгийн орон зайн мэдээллийн дэд бүтцийг системтэйгээр байгуулж, ашиглахаар зорьж байгаагийн нэг алхам нь өөрийн салбарын кодчиллыг боловсруулж ашиглах явдал юм. Гамшгийн кодчиллыг боловсруулахдаа гамшгийг гарал үүслээр нь 1) гал түймрийн, 2)

геологийн 3)байгалийн, 4)биологийн, 5)хүний буруутай үйл ажиллагаанаас гэж 4 үндсэн төрөлд ангилан цаашид байршил, тохиолдлын дугаар зэргээр дэд ангилалд хуваан кодчилсон юм.


Жишээ нь FF гэсэн кодчиллол байвал эхний F нь (Fire) буюу гал түймрийн гаралтай гамшиг байна гэж ойлгох бөгөөд дараах F нь forest буюу ойд тохиолдсон гэж үзэж ойн түймэр гэж авч үзэх юм. Хэрэв NZ гэсэн байвал N буюу байгалийн (natural) гаралтай Z гэснийг зуд гэж ойлгох юм. Тиймээс ойн түймэр гэж бичихийн оронд FF гэж бичих, зудыг NZ гэх зэргээр бичиж цаашид дангаар нь эсвэл нэртэй нь давхар авч ашиглах юм.

### 1.3 Суурь давхаргын кодчиллол, гамшгийн кодчиллыг ашиглах нь

Монгол Улсын хэмжээнд тохиолддог гамшиг, осол аюулт үзэгдлийг бүртгэхдээ аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор буюу нутаг дэвсгэрийн хил хязгаар болох засаг захиргааны нэгжийн хилийн цэсийг ашиглан эртнээс бүртгэж ирсэн байдаг бол орон зайн мэдээллийн систем ашигласнаар тухайн гамшиг ослыг голомтын түвшинд тэмдэглэн зураглаж, үүссэн нөхцөл байдлыг мэдээлэх боломж бүрдэж байгаа юм. Тиймээс тухайн гамшиг, осол тохиолдсон газрын ерөнхий байршлыг тодорхойлохдоо орон зайн мэдээллийн суурь давхаргын кодчиллыг ашиглах нь хялбар бөгөөд тухайн гамшиг осол нь ямар төрлийн, тохиолдсон цаг хугацаа, нарийвчилсан байршил зэргийг гамшгийн кодчиллол ашиглан хялбархан таньж унших боломжтой юм.

Жишээ болгож суурь давхаргын кодчиллол (байршлын) мөн гамшгийн кодчиллын нийлмэлийг авч үзье.

Хүснэгт 1-3: Байршлын болон гамшгийн кодчиллол



Дээрх кодчиллыг ашигласнаар бичвэр хялбарших, бичвэрийн алдаа багасах, цаг хугацаа хэмнэх, газрын зурагт дүн шинжилгээ хийх өргөн боломж бүрдэх юм. Дээрх кодчиллыг гамшгийн орон зайн мэдээллийн давхаргуудад хэрхэн ашиглах талаар журмын 2 дугаар хавсралтад дэлгэрэнгүй тайлбарлав.

## 2 Гамшгийн кодчилол

Гамшгийн орон зайн мэдээллийн системийг дотоод, гадаадын гамшгийн мэдээллийн системтэй холбох, харилцан мэдээллийг солилцох зорилгоор дараах кодуудыг ашиглана.

№	Гарал үүслийн нэр	Гарал үүслийн код	Төрлийн нэр		Төрлийн код	Он, сар, өдөр	Тохиолдлын тоо		
			Англи	Монгол					
	Гал түймэр (Fire)	F	1	Object fire	Объектын гал түймэр	O	20180924	01	
			2	Forest fire	Ойн түймэр	F			
			3	Steppe fire	Хээрийн түймэр	S			
1	Байгалийн гаралтай гамшиг (Natural hazard)	N	1	Drought	Ган	D			
			2	Dzud	Зуд	Z			
			3	Flood	Үер	F			
			4	Hail	Мөндөр	H			
			5	Snow fall	Цасан нуранги	S			
			6	Strong wind and storm	Хүчтэй салхи, шуурга	W			
			7	Thunder	Аянга	T			
2	Геологийн гаралтай (Geological hazard)	G	1	Earthquake	Газар хөдлөлт	E			
			2	Landslide	Хөрсний гулсалт	L			
3	Биологийн гаралтай гамшиг (Biological hazard)	B	<b>Animal disease</b>						
			1	Anthrax	Боом	M1			
			2	Blackleg	Дуут хавдар	C3			
			3	Bovine Ephemeral Fever	Үхрийн хорт салст халуурал	C2			
			4	Sheep POX, Goat Pox	Хонь, ямааны цэцэг өвчин	S1			
			5	Classical swine fever/ Hog cholera	Гахайн мялзан	P3			
			6	Enterotoxemia	Дотрын халдварт хордлого	D1			
			7	Equine influenza	Адууны ханиад	E1			
			8	Food and Mouth Disease	Шүлхий	A1			
			9	Glanders	Адууны ям	G1			
10	Rabies	Мал, амьтны галзуу	A2						

			11	High Pathogenic Avian Influenza	Шувууны томуу	<b>A3</b>			
			12	Newcastle disease	Тахианы ньюкасл өвчин	<b>N1</b>			
			13	Peste des Petits Ruminants	Бог малын мялзан	<b>C1</b>			
			14	Porcine Reproductive and Respiratory Syndrome	Гахайн үржил амьсгалын замын хам шинж	<b>P2</b>			
			<b>Human disease</b>						
			15	Brucellosis	Бруцеллёз	<b>S2</b>			
			16	Hand, food and mouth disease	Гар, хөл, амны өвчин	<b>H2</b>			
			17	Plague	Тарваган тахал	<b>P1</b>			
			18	H1N1 influenza	H1N1 томуу	<b>H1</b>			
			19	Tyberculosis	Сүрьеэ	<b>T1</b>			
<b>3</b>	<b>Хүний буруутай үйл ажиллагаа тай холбоотой осол (Human related disaster)</b>	<b>H</b>	1	Chemical	Химийн бодис	<b>C</b>			
			2	Explosive	Тэсэрч дэлбэрэх	<b>E</b>			
			3	Industrial accidents	Үйлдвэрлэлийн осол	<b>I</b>			
			4	Radiation	Цацрагийн бодис	<b>R</b>			
			5	Road and transportation accident	Зам, тээврийн хэрэгслийн осол	<b>T</b>			
			6	Search and rescue	Эрэн хайх, аврах ажиллагаа	<b>S</b>			

### 3 Суурь давхаргын буюу байршлын кодчилол

Гамшгийн орон зайн мэдээллийн системийг бусад мэдээллийн системийн суурь мэдээллийн баазуудыг холбоход дараах кодуудыг ашиглана.

№	Аймгийн, хотын нэр	Аймаг хотын код	Сум, дүүргийн нэр	Сум, дүүргийн код
1	Архангай аймаг	65000	Батцэнгэл	65100
			Булган	65120
			Жаргалант	65200
			Ихтамир	65170
			Өгийнуур	65020
			Өлзийт	65030
			Өндөр-Улаан	65210
			Тариат	65230
			Төвшрүүлэх	65070
			Хайрхан	65060
			Хангай	65250
			Хашаат	65010
			Хотонт	65040
			Цахир	65270
			Цэнхэр	65080
			Цэцэрлэг	65190
			Чулуут	65220
Эрдэнэбулган	65130			
Эрдэнэмандал	65150			
2	Баян-Өлгий аймаг	83000	Алтай	83150
			Алтанцөгц	83040
			Баяннуур	83030
			Бугат	83050
			Булган	83010
			Буянт	83140
			Дэлүүн	83060
			Ногооннуур	83100
			Өлгий	83120
			Сагсай	83160
			Толбо	83080
			Улаанхус	83170
			Цэнгэл	83190
3	Баянхонгор аймаг	64000	Баацагаан	64150
			Баянбулаг	64260
			Баянговь	64130
			Баянлиг	64010
			Баян-Овоо	64080
			Баян-Өндөр	64250
			Баянхонгор	64090
			Баянцагаан	64210
			Богд	64050
			Бөмбөгөр	64170
			Бууцагаан	64220
			Галуут	64110
			Гурванбулаг	64230
			Жаргалант	64180
			Жинст	64070
			Заг	64200
			Өлзийт	64030
Хүрээмарал	64240			

			Шинэжинст	64190
			Эрдэнэцогт	64020
4	Булган аймаг	63000	Баян-Агт	63180
			Баяннуур	63010
			Бугат	63090
			Булган	63080
			Бүрэгхангай	63050
			Гурванбулаг	63120
			Дашинчилэн	63060
			Могод	63150
			Орхон	63040
			Рашаант	63070
			Сайхан	63160
			Сэлэнгэ	63020
			Тэшиг	63100
			Хангал	63030
			Хишиг-Өндөр	63110
			Хутаг-Өндөр	63140
5	Говь-Алтай аймаг	82000	Алтай	82130
			Баян-Уул	82150
			Бигэр	82040
			Бугат	82200
			Дарви	82190
			Дэлгэр	82010
			Есөнбулаг	82080
			Жаргалант	82110
			Тайшир	82070
			Тонхил	82210
			Төгрөг	82170
			Халиун	82100
			Хөхморьт	82180
			Цогт	82050
			Цээл	82120
			Чандмань	82020
Шарга	82140			
Эрдэнэ	82030			
6	Говьсүмбэр аймаг	42000	Баянтал	42030
			Сүмбэр	42010
			Шивээговь	42020
7	Дархан-Уул аймаг	45000	Дархан	45150
			Орхон	45030
			Хонгор	45020
			Шарын гол	45010
8	Дорноговь аймаг	44000	Айраг	44120
			Алтанширээ	44070
			Даланжаргалан	44130
			Дэлгэрэх	44040
			Замын-Үүд	44010
			Иххэт	44090
			Мандал	44140
			Өргөн	44030
			Сайншанд	44100
			Сайхандулаан	44110
			Улаанбадрах	44050
			Хатанбулаг	44080
Хөвсгөл	44060			
Эрдэнэ	44020			



9	Дорнод аймаг	21000	Баяндун	21120
			Баянтүмэн	21050
			Баян-Уул	21160
			Булган	21090
			Гурванзагал	21080
			Дашбалбар	21100
			Матад	21020
			Сэргэлэн	21110
			Халх гол	21010
			Хөлөнбуйр	21150
			Хэрлэн	21060
			Цагаан-Овоо	21130
			Чойбалсан	21040
			Чулуунхороот	21030
10	Дундговь аймаг	48000	Адаацаг	48140
			Баянжаргалан	48020
			Говь-Угтаал	48070
			Гурвансайхан	48060
			Дэлгэрхангай	48170
			Дэлгэрцогт	48110
			Дэрэн	48080
			Луус	48120
			Өлзийт	48040
			Өндөршил	48010
			Сайнцагаан	48090
			Сайхан-Овоо	48180
			Хулд	48130
			Цагаандэлгэр	48030
Эрдэнэдалай	48150			
11	Завхан аймаг	81000	Алдархаан	81190
			Асгат	81170
			Баянтэс	81160
			Баянхайрхан	81180
			Дөрвөлжин	81280
			Завханмандал	81270
			Идэр	81060
			Их-Уул	81010
			Нөмрөг	81110
			Отгон	81070
			Сантмаргац	81260
			Сонгино	81230
			Тосонцэнгэл	81030
			Түдэвтэй	81210
			Тэлмэн	81050
			Тэс	81250
			Улиастай	81090
			Ургамал	81290
			Цагаанхайрхан	81120
			Цагаанчулуут	81150
Цэцэн-Уул	81220			
Шилүүстэй	81140			
Эрдэнэхайрхан	81240			
Яруу	81130			
11	Орхон аймаг	61000	Баян-Өндөр	61020
			Жаргалант	61010
12	Өвөрхангай аймаг	62000	Арвайхээр	62160
			Баруунбаян-Улаан	62270
			Бат-Өлзий	62210

			Баянгол	62060
			Баян-Өндөр	62010
			Богд	62190
			Бүрд	62020
			Гучин-Ус	62180
			Есөнзүйл	62030
			Зүүнбаян-Улаан	62120
			Нарийнтээл	62260
			Өлзийт	62050
			Сант	62040
			Тарагт	62140
			Төгрөг	62080
			Уянга	62220
			Хайрхандулаан	62240
			Хархорин	62090
			Хужирт	62110
13	<b>Өмнөговь аймаг</b>	<b>46000</b>	Баяндалай	46120
			Баян-Овоо	46030
			Булган	46110
			Гурвантэс	46150
			Даланзадгад	46080
			Мандал-Овоо	46090
			Манлай	46020
			Ноён	46140
			Номгон	46050
			Сэврэй	46130
			Ханбогд	46010
			Ханхонгор	46070
			Хүрмэн	46100
			Цогт-Овоо	46060
			Цогтцэций	46040
14	<b>Сүхбаатар аймаг</b>	<b>22000</b>	Асгат	22050
			Баруун-Урт	22070
			Баяндэлгэр	22110
			Дарьганга	22040
			Мөнххаан	22140
			Наран	22060
			Онгон	22090
			Сүхбаатар	22030
			Түвшинширээ	22160
			Түмэнцогт	22150
			Уулбаян	22130
			Халзан	22100
			Эрдэнэцагаан	22010
15	<b>Сэлэнгэ аймаг</b>	<b>43000</b>	Алтанбулаг	43040
			Баруунбүрэн	43170
			Баянгол	43060
			Ерөө	43010
			Жавхлант	43050
			Зүүнбүрэн	43090
			Мандал	43030
			Орхон	43140
			Орхонтуул	43160
			Сайхан	43130
			Сант	43150
			Сүхбаатар	43080
			Түшиг	43100
			Хушаат	43120

			Хүдэр	43020
			Цагааннуур	43110
			Шаамар	43070
16	Төв аймаг	41000	Алтанбулаг	41130
			Аргалант	41180
			Архуст	41060
			Батсүмбэр	41120
			Баян	41070
			Баяндэлгэр	41030
			Баянжаргалан	41020
			Баян-Өнжүүл	41140
			Баянхангай	41210
			Баянцагаан	41080
			Баянцогт	41170
			Баянчандмань	41160
			Борнуур	41150
			Бүрэн	41260
			Дэлгэрхаан	41280
			Жаргалант	41200
			Заамар	41270
			Зуунмод	41100
			Лүн	41240
			Мөнгөнморьт	41010
			Өндөрширээт	41250
			Сүмбэр	41190
			Сэргэлэн	41090
			Угтаалцайдам	41220
			Цээл	41230
			Эрдэнэ	41040
			Эрдэнэсант	41290
			17	Увс аймаг
Бөхмөрөн	85220			
Давст	85120			
Завхан	85100			
Зүүнговь	85040			
Зүүнхангай	85010			
Малчин	85090			
Наранбулаг	85110			
Өлгий	85150			
Өмнөговь	85210			
Өндөрхангай	85030			
Сагил	85190			
Тариалан	85130			
Түргэн	85200			
Тэс	85060			
Улаангом	85160			
Ховд	85230			
Хяргас	85080			
Цагаанхайрхан	85050			
18	Улаанбаатар	11000	Багануур	12000
			Багахангай	12300
			Баянгол	16000
			Баянзүрх	13000
			Налайх	12600
			Сонгино хайрхан	18000
			Сүхбаатар	14000
			Хан-Уул	17000
Чингэлтэй	15000			

19	Ховд аймаг	84000	Алтай	84080
			Булган	84210
			Буянт	84090
			Дарви	84010
			Дөргөн	84020
			Дуут	84200
			Жаргалант	84140
			Зэрэг	84060
			Манхан	84110
			Мөнххайрхан	84190
			Мөст	84070
			Мянгад	84100
			Үенч	84130
			Ховд	84170
			Цэцэг	84050
			Чандмань	84030
			20	Хөвсгөл аймаг
Алаг-Эрдэнэ	67140			
Арбулаг	67200			
Баянзүрх	67290			
Бүрэнтогтох	67220			
Галт	67190			
Жаргалант	67250			
Их-Уул	67050			
Мөрөн	67120			
Рашаант	67060			
Рэнчинлхүмбэ	67170			
Тариалан	67010			
Тосонцэнгэл	67110			
Төмөрбулаг	67160			
Түнэл	67090			
Улаан-Уул	67270			
Ханх	67070			
Цагааннуур	67260			
Цагаан-Уул	67300			
Цагаан-Үүр	67040			
Цэцэрлэг	67320			
Чандмань-Өндөр	67080			
Шинэ-Идэр	67240			
Эрдэнэбулган	67030			
21	Хэнтий аймаг	23000	Батноров	23040
			Батширээт	23160
			Баян-Адарга	23070
			Баянмөнх	23170
			Баян-Овоо	23010
			Баянхутаг	23060
			Биндэр	23100
			Бор-Өндөр	23220
			Галшир	23080
			Дадал	23030
			Дархан	23180
			Дэлгэрхаан	23200
			Жаргалтхаан	23190
			Мөрөн	23130
			Норовлин	23020
			Өмнөдэлгэр	23140
Хэрлэн	23110			
Цэнхэрмандал	23210			

## **ГАМШГИЙН ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЗАГВАР**

### **1 Танилцуулга**

Гамшгийн орон зайн мэдээллийн системийг үр ашигтай, системтэйгээр ашиглах, өгөгдлийн санд гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээ, мэдээллүүдийг хэрхэн оруулж, бүртгэх талаар энэхүү хавсралтад дэлгэрэнгүй тайлбарлан тусгав. Энэхүү өгөгдлийн сангийн загвар нь хэрэглэгчидэд мэдээллүүдийг системтэйгээр удирдан зохион байгуулах, тогтсон фонт, хэл, нэршил, кодчиллол, томъёолсон тэмдэг ашиглаж хялбар байдлаар гамшиг, ослын нөхцөл байдлын зураглал боловсруулах, үр дүнг шуурхай тайлагнах, тайлан мэдээ, шийдвэр гаргалтанд тусгах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журмын 5.4-д заасан хэрэглэгч интернэт болон дотоод сүлжээ холбогдсон аль ч төхөөрөмжийг ашиглан гамшгийн нөхцөл байдлыг хаанаас ч шууд бүртгэх, зураглах боломж бүрдэхээс гадна төв, орон нутгийн анги, салбарууд дотооддоо болон бусад төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай нэгдсэн загвараар мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломжтой болно.

Мөн гамшгийн орон зайн мэдээллийн систем нь удирдлага, мэргэжилтэн хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, шуурхай ажиллах, шийдвэр гаргах үйл явцыг дэмжих зорилготой систем юм.

### **2 Давхарга болон газрын зургийн нэршилд тавигдах шаардлага**

Гамшгийн орон зайн мэдээллийн систем нь олон хэлний эхийг ашиглаж бичих боломжтойгоор хөгжүүлсэн тул хэрэглэгчид системийг ашиглахдаа зөвхөн Монгол хэлийг ашиглана. Хэрэв Латин, кирилл зэрэг холимог үсэг ашиглах байдлаар газрын зураг, давхаргын нэр мөн хүснэгтэн мэдээллийг бичиж өгөх нь зохимжгүй тул энэхүү бүлэг нь уг систем дээр хэрхэн нэг аргачлалаар бичихийг тайлбарлалаа.

#### **2.1 Давхаргын нэр үүсгэхэд тавигдах шаардлага**

Гамшгийн орон зайн мэдээллийн системд хэрэглэгч өөрийн нэр, нууц үг ашиглан нэвтэрч орсны дараа давхаргын жагсаалт /layer list/ гэх сонголт бүхий талбар харагдах бөгөөд давхаргууд нь групп дотор мөн хавтас тодор хуваарилагдан байршсан байна. Уг давхарга тус бүрийн нэр нь Монгол хэлээр бичигдсэн байх бөгөөд хэрэглэгчид шинээр давхарга мэдээллийн нэр үүсгэх аргачлалыг хүснэгт 2-1-т үзүүлэв.

### 2.1.1 Суурь давхарга:

Хүснэгт 2-1:

Давхарга мэдээллийн нэрийг бичих формат					
Хавтасны нэр дурын 4 үгнээс ихгүйгээр бичигдэнэ.					
	(Байршлын мэдээлэл)	(Биетийн нэр 1)	(Биетийн нэр 2)	(Он)	
# Орон	20	20	10	10	
Жишээ 1	Улаанбаатар	хотын	барилга	_2019	✓
Жишээ 2	Багийн	хил		_2019	✓
Жишээ 3	Туул	гол		_2019	✓
<b>Буруу</b>	<b>Gol</b>	<b>hil</b>	<b>barilga</b>		✗

### 2.1.2 Сэдэвчилсэн давхарга:

Хүснэгт 2-2:

Давхарга мэдээллийн нэрийг бичих формат					
	(Байршлын мэдээлэл)	(Гамшиг, ослын мэдээлэл)	(Гамшгийн мэдээлэл 2)	Огноо (он, сараар)	
# Орон	20	20	20	10	
Жишээ 1	Хээрийн	Гал түймэр		_2019	✓
Жишээ 2	Объектын	Гал түймэр		_2019	✓
Жишээ 3	Ойн	Гал түймэр		_2019	✓
Жишээ 4		Шүлхий		_1901	✓
Жишээ 5		Эрэн хайх аврах ажиллагаа		_1902	✓
<b>Буруу</b>	<b>Ой, хээрийн</b>	<b>Гал түймэр</b>		<b>_201901</b>	✗

## 2.2 Хэрэглэгчийн нэр, нууц үг үүсгэхэд тавигдах шаардлага

Шинэ хэрэглэгч үүсгэхдээ доорх аргачлалыг мөрдөнө. Төв, орон нутгийн анги, салбар тус бүр журмын 5.4.1, 5.4.2-д заасан хэрэглэгч давтагдашгүй нэвтрэх эрх, нууц үг үүсгэнэ.

Бусад хэрэглэгчид гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журмын 5.4.3, 5.4.4, 5.4.5-д заасан хэрэглэгч тус бүр нэг нэвтрэх нэр, нууц үг ашиглан системд нэвтэрнэ. Хүснэгт 2-2-т үзүүлсэн стандарт загварын дагуу шинэ хэрэглэгч үүсгэнэ.

ГОЗМС-д шинэ хэрэглэгч үүсгэхэд тавигдах формат

Login ID (Дурын нэвтрэх ID)	Хэрэглэгчийн нэр (нэгж эсвэл байгууллагын нэр)	Нууц үг (8 оронтой тоо ашиглана)	Хэрэглэгчийн эрх(сонголтоор)
AR01	Архангай аймаг	*****	<ul style="list-style-type: none"> <li>• Admin/Администратор</li> <li>• Editor/засварлагч</li> <li>• User/харах эрх</li> <li>• Ямар нэгэн нэвтрэх эрхгүй боловч нийтэд зориулсан мэдээлэлтэй танилцана.</li> </ul>
BAU02	Баян-Өлгий аймаг	*****	
EMDC	НОБГ	*****	
DRAD	ОБЕГ, Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар	*****	

2.3 Групп болон хавтас үүсгэхэд тавигдах шаардлага:


2.3.1 Группийн нэр үүсгэхэд тавигдах шаардлага:

Шинээр групп үүсгэхэд хавтаснаас ялгаж харагдуулахын тулд группийн нэрийн ард заавал (\_групп) гэж бичнэ. Групп үүсгэхэд тавигдах бичвэрийн шаардлага нь хавтас үүсгэхтэй үндсэндээ ижил байна.

Группийн нэр бичих формат

	Дурын 4 үгнээс ихгүйгээр бичнэ.				
	1-үе	2- үе	3- үе	4- үе	
Жишээ 1	Зүүн	бүс		_групп	✓
Жишээ 2	Суурь	мэдээлэл		_групп	✓

ГОЗМС-н группын жагсаалт /Layer list/



### 2.3.2 Хавтас түүний нэр үүсгэхэд тавигдах шаардлага

ГОЗМС-д шинээр зорилтот групп эсвэл хавтас /folder/ үүсгэхэд тэдгээр нь давхаргын жагсаалт /Layer list/ хэсэгт үүсч харагдах байдал нь төстэй байдаг тул хавтасыг зөвхөн групп дотор үүсгэж (зураг 2-3) хүснэгт 2-3-т үзүүлсэн аргачлалыг дагаж мөрдөнө үү.


Хүснэгт 2-4:

Хавтасны нэр бичих формат

Хавтасны нэр дурын 4 үгнээс ихгүйгээр бичигдэнэ.					
	1-үе	2-үе	3-үе	4-үе	
Жишээ 1	Суурь	мэдээлэл		2017	✓
Жишээ 2	Зуд				✓

Зураг 2-4:

ГОЗМС-н давхаргын жагсаалт /Layer list/



### 2.4 Газрын зургийн нэр, түүнд тавигдах шаардлага

ГОЗМС-д үүсгэсэн газрын зураг нь энэ системийн хувьд эцсийн бүтээгдэхүүн байх ба ойлгоход хялбар, тодорхой, нийтлэг загвартай байх нь чухал юм. Иймд газрын зургийн нэршлээр дамжуулан тухайн тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын байршил, агуулга, илэрхийлэгдсэн биетийн төрөл, огноо зэргийг хэрэглэгчид төвөггүй ойлгож, аливаа мэдээллийг хайж олоход хялбар байх нь чухал. Үүнийг хүснэгт 2-6-д газрын зургийн нэр бичих аргачлалыг үзүүлэв.



## Газрын зургийн нэр бичих формат

	Байршил (Засаг захиргааны нэгж)	/Гамшгийн төрөл /	/Бусад /	Огноо (Он, сараар )	
Жишээ 1	Монгол Улсын	Газар хөдлөлийн	зураг	_2019	
Жишээ 2	Улаанбаатар хотын	Гал түймрийн бүртгэл, объектын гал түймрийн	нөхцөл байдлын зураглал	_1901	
Жишээ 2	Архангай аймгийн	Зудын	Зураг (хагас жилийн байдлаар)	_1902	

### 3 Суурь болон сэдэвчилсэн давхаргад агуулга нэмэх, шинээр багана үүсгэх, текст мэдээлэл нэмэх, засварлахад тавигдах шаардлага

#### 3.1 Давхарга мэдээлэлд шинээр багана нэмэх:

Орон зайн суурь болон сэдэвчилсэн давхаргууд нь өөрийн гэсэн текст мэдээлэл бүхий хэд хэдэн багана бүхий хүснэгтэн мэдээллийг агуулж байдаг. Уг баганын header буюу толгой гарчгийг бичиж өгөхдөө хүснэгт 3-1-т үзүүлсэн аргачлалаар, аль болох богино бичвэрээр нийт тэмдэгтийн уртыг 50-аас ихгүйгээр үүсгэнэ.

Хүснэгт 3-1:

Хүснэгтийн баганын толгойг бичих формат

	Баганын толгой (50 тэмдэгтээс ихгүй)	
Жишээ 1	Голомтын бүс	✓
Жишээ 2	Бүс	✓
Жишээ 2	Хамгаалалтын бүс	✓

Зураг 3-1:

Баганын нэрийг форматын дагуу бичиж өгсөн жишээ

Голомтын_бүс	бүс	Хамгаалалтын_бүс
10	10	

#### 3.2 Багана дотор текст мэдээлэл бичих, түүнд тавигдах шаардлага

Өмнөх үзүүлсний дагуу ГОЗМС-д шинээр давхарга үүсгэж нэр өгсний дараа тухайн үүсгэгдсэн давхаргын мэдээллийн агуулгыг тохируулж хүснэгтэн талбарыг үүсгэсний дараа хэрэглэгчдээр дамжин тухайн давхарга бүхий мэдээлэл нь цаашид шинэчлэгдэн засварлагдана. Нэг баганын харгалзах мөрт 100 тэмдэгтээс ихгүй текст мэдээлэл бичиж болох бөгөөд аргачлалыг хүснэгт 3-2-т жишээ болгож бичиж оруулсныг зураг 3-2-т тус тус үзүүлэв. Нийтлэг хэрэглэгдэх суурь болон сэдэвчилсэн давхарга тус бүрийн агуулгыг 2 дугаар хавсралтаас дэлгэрэнгүй харна уу.

Хүснэгт 3-2:

Баганад текст бичих формат

Баганын толгой	Голомтын_бүс	
Мөр 1	Төв аймаг баян сум (100 тэмдэгтээс ихгүй)	✓
Мөр 2	Төв аймгийн Сэргэлэн сумаас зүүн хойд зүгт 2км-т (100 тэмдэгтээс ихгүй)	✓

## Баганад дээрх форматын дагуу бичиж оруулсан жишээ

Голомтын_бүс	бүс	Хамгаалалтын_бүс
10	10	
Төв аймгийн зуун мод хотоос зүүн хойд зүгт 2км		

#### 4 Орон зайн мэдээллийн сангийн загварт нийтлэг хэрэглэгдэх томьёолол

Доорх нийтлэг хэрэглэгдэх томьёолол нь учирсан болон болзошгүй гамшиг ослын тохиолдолд өртөж буй хүн, мал, амьтаны нийт тоог орон зайн мэдээллийн санд оруулах, нэгтгэх, статистикийн болон орон зайн дүн шинжилгээ хийх, нэгдсэн тайлан мэдээлэл гаргахад дөхөм болох юм.

Хүснэгт 4-1:

Гал түймэр, байгалийн, геологийн гамшиг, хүний буруутай үйл ажиллагааны улмаас гарсан ослын тохиолдолд өртсөн хүний нийт тоо

Өртсөн хүний нийт тоо							
1	2	3	4	5	6	7	8
Нас барсан	Бэртэж гэмтсэн	түлэгдсэн	эмчлүүлсэн	Аварсан	Тусламж үзүүлсэн	Сураггүй болсон	Эсэн мэнд ирсэн

Өртсөн хүний нийт тоо гэдэгт дээрх 8 үзүүлэлтийн нийлбэр гэж авч үзэх бөгөөд тухайн гамшиг, ослын төрөл, онцлогийг харгалзан үзэж зарим үзүүлэлтийг нь сонгон авч ашиглахгүй байж болно. Мөн шаардлагатай тохиолдолд зарим үзүүлэлтийг нас, хүйсээр ангилан дэлгэрүүлж тусгана.

Хүснэгт 4-2:

Биологийн гаралтай малын гоц халдварт өвчинд өртсөн мал/амьтаны нийт тоог дараах байдлаар авч үзнэ

Голомтын бүсэд байгаа мал/амьтны тоо	Өртсөн малын нийт тоо/ Өвчилсэн мал		
1	1	3	4
	Эмчилсэн	Хорогдсон	Устгасан малын тоо

Өртсөн нийт мал/амьтаны нийт тоо нь өвчилсэн мал, амьтаныхаа тоотой адил байна. Иймээс өртсөн малын нийт тоо нь дээрх 3 үзүүлэлтийн нийлбэр гэж авч үзэх бөгөөд голомтод байгаа мал амьтаны тоог тусад нь тооцож бүртгэнэ. Тухайн гамшгийн төрөл, онцлогийг харгалзан үзэж зарим үзүүлэлтийг авч ашиглахгүй байж болно. Мөн шаардлагатай тохиолдолд зарим үзүүлэлтийг нас, хүйсээр ангилан дэлгэрүүлж тусгана.

Хүснэгт 4-3:

Биологийн гаралтай хүний гоц халдварт өвчинд өртсөн хүний нийт тоог дараах байдлаар авч үзнэ

Өртсөн хүний нийт тоо/ Өвчилсэн хүн	
1	2
Эмчилсэн	Нас барсан

Өртсөн нийт хүний нийт тоо нь өвчилсэн хүнийхээ тоотой адил байна. Иймээс өртсөн хүний нийт тоо нь дээрх 2 үзүүлэлтийн нийлбэр гэж авч үзнэ.

Дээрх нийтлэг томъёололд ашиглагдаж буй үзүүлэлтүүдээр үр дүнг хүснэгтэн байдлаар жишээ болгон хүснэгт 4-4, 4-5, 4-6-т тус тус үзүүлэв.

Хүснэгт 4-4:

Гал түймэр, байгалийн, геологийн гамшиг, хүний буруутай үйл ажиллагааны улмаас гарсан ослын тохиолдолд өртсөн хүний нийт тоог нэгтгэсэн үр дүн /жишээгээр/

Гамшиг/ослын төрөл	Өртсөн нийт хүний тоо	Үзүүлэлтүүд							
		Нас барсан	Бэртэж гэмтсэн, ,	түлэгдсэн	Эмчилсэн	Аварсан	Тусламж үзүүлсэн	Сураггүй болсон	Эсэн мэнд олдсон
Объектын гал түймэр	80	10	4	60		5			
Үер	20	2	5	3			10		
Газар чичирхийлэл	10						10		
Эрэн хайх, аврах	60	2	10	5			20	10	13

## Хүснэгт 4-5:

Биологийн гаралтай гамшгийн мэдээлэлд өртсөн мал, амьтаны нийт тоог нэгтэгсэн үр дүн /жишээгээр/

Гамшиг/ослын төрөл	Өртсөн мал/амьтны нийт тоо	Үзүүлэлтүүд		
		Эмчилсэн	Хорогдсон	Устгасан малын тоо
<b>Малын гоц халдварт өвчин</b>				
Шүлхий	80	50	10	20
Боом	20	5	5	10

## Хүснэгт 4-6:

Биологийн гаралтай хүний гоц халдварт өвчинд өртсөн хүний нийт тоог нэгтэгсэн үр дүн /жишээгээр/

Гамшиг/ослын төрөл	Өртсөн хүний нийт тоо/өвчилсэн	Үзүүлэлтүүд	
		Эмчилсэн	Нас барсан
<b>Хүний гоц халдварт өвчин</b>			
H1N1 томуу	80	70	10
Гар, хөл, амны өвчин	20	19	1

5 Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн суурь давхаргуудын загвар (статик)

Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн суурь давхаргууд нь байршилгүй илэрхийлсэн кодчилол ашиглаж тухайн жилүүдэд тохиолдсон гамшиг, осол, аюулт үзэгдлийн түүхэн мэдээллийг хураангуйлан агуулахаас гадна хүн ам, нийгэм, эдийн засгийн суурь мэдээллүүдийг агуулж, гамшгийн зураглал үйлдэх, төлөвлөгөө боловсруулахад ашиглагдана. Суурь давхаргуудад шинэчлэл хийгдэх хугацаа харьцангуй удаан тул жилд нэгээс багагүй удаа онцгой байдлын төв байгууллага шинэчилнэ.

1. Аймгийн хил\_2019

Орон зайн код	Нийгэм, эдийн засгийн мэдээлэл										Гамшгийн мэдээлэл														
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25
Аймгийн код	Хүн амын тоо	0-5 нас	6-17 нас	18-33 нас	36-64 нас	65-авс нас	Эрэгтэй	Эмэгтэй	Өрхийн тоо	Өрхийн сарын дундаж орлого	Ажил эрхлэлтийн түвшин	Ядуурлын түвшин	Объектын түүхийн тоо	Ойн түүхийн тоо	Хэзэрийн гал түүхийн тоо	Аянга тохиолдлын тоо	Газар хөдлөлт тохиолдлын тоо	Гангийн тохиолдлын тоо	Зуд тохиолдсон /Гөргөөр/	Мөндөр тохиолдлын тоо	Үер тохиолдлын тоо	Хүчтэй салхи, шуурганы тохиолдлын тоо	Цасан нуралт тохиолдлын тоо	Хөрсний гүлсалт тохиолдлын тоо	Шүлжийн тохиолдлын тоо
21000													10	1	1	1	10	1	Цагаан-зуд						

Үргэлжлэл

Гамшгийн мэдээлэл																
26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42
Мал, амьтны галзуулийн тохиолдлын тоо	Шувууны тохиолдлын тоо	Бол мөлхөн мөлхөн тохиолдлын тоо	Ухрийн код салст халуур тохиолдлын тоо	Дуг хавдрын тохиолдлын тоо	Дотрын халдварт хордлого	Адууны ханиадны тохиолдлын тоо	Адууны ям тохиолдлын тоо	ННП томиу тохиолдлын тоо	Гар, хөл, амны өвчин тохиолдлын тоо	Боом тохиолдлын тоо	Тажиааны нжвэл өвчин тохиолдлын тоо	Тарваган тахал тохиолдлын тоо	Гахайн үржил амьсгалын замын хам шинж	Гахайн илгээн тохиолдлын тоо	Хочь, ямааны цацраг өвчин тохиолдлын тоо	Бруцеллез тохиолдлын тоо

Үргэлжлэл

Гамшгийн мэдээлэл		
43	44	45
Сурьса тохиолдлын тоо	Тасарч дэлбэрэх тохиолдлын тоо	Хийний бодис тохиолдлын тоо
	Цацрагийн бодис тохиолдлын тоо	Үйлдвэрлэлийн осол тохиолдлын тоо
		Эрэн хайх, аврах ажиллагаа тохиолдлын тоо

- Сумын хил\_2019
- Дүүргийн хил\_2019
- Хорооны хил\_2019
- Багийн хил\_2019 гэх мэт давхаргуудыг үүсгэж тухайн жилт тохиолдсон бүх гамшиг, осол, аюулт үзэгдлийн тохиолдлын тоог дээрх загварт үзүүлсэнээр үүсгэж оруулна.

6 Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн сэдэвчилсэн давхаргуудын загвар (динамик)

Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн сэдэвчилсэн давхаргууд нь гамшгийн кодчилол ашиглахаас гадна гамшиг, осол, аюулт үзэгдлийн төрөл, байршил, хамрах хүрээ, өртсөн, бэртсэн хүн, эд зүйлс, ажилласан хүн хүч, техник зэрэг гамшгийн тухайн тохиолдлын чухал үзүүлэлтүүдийг сонгон авч бүртгэх, зураглах, дүн шинжилгээ хийх, төлөвлөгөө боловсруулахад чиглэгдсэн цэг, шулуун, полигоноор дүрслэгдэх орон зайн биет давхаргууд юм. Сэдэвчилсэн давхаргууд нь шинэчлэл харьцангуй ихтэй бөгөөд гамшиг, осол, аюулт үзэгдэл тохиолдсон тухай бүрд онцгой байдлын төв байгууллага, салбар нэгж шинэчилнэ.

6.1 Гал түймэрийн тохиолдол бүртгэх загвар

1. Объектын гал түймэр\_2019

Орон зайн болон гамшгийн код										Гамшгийн мэдээлэл													
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24
Аймгийн нэр	Сумын нэр	Бөлийн нэр	Гамшгийн код	Он	Сар	өдөр	Тохиолдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Шалтгаан	Өртсөн хүний нийт тоо	Нас барсан	Нас барсан /том хүн/	Нас барсан /хүүхэд/	Нас барсан (эр)	Нас барсан /эм/	Нас барсан (Хөгжлийн бэрхшээлтэй)	Түлэгдэж гэмтсэн	Түлэгдэж гэмтсэн /том хүн/	Түлэгдэж гэмтсэн /хүүхэд/	Түлэгдэж гэмтсэн (эр)	Түлэгдэж гэмтсэн /эм/	Түлэгдэж гэмтсэн (Хөгжлийн бэрхшээлтэй)
			FO	2018	08	10	01	102.751	48.733	Цахилгаанаас	10	3	1	2	2	1	2	2	1	2	1	8	1

Үргэлжлэл

Гамшгийн мэдээлэл													
25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38
Аварсан	Аварсан /том хүн/	Аварсан /хүүхэд/	Аварсан (эр)	Аварсан /эм/	Аварсан (Хөгжлийн бэрхшээлтэй)	Тусламж үзүүлсэн	Тусламж үзүүлсэн /том хүн/	Тусламж үзүүлсэн /хүүхэд/	Тусламж үзүүлсэн (эр)	Тусламж үзүүлсэн /эм/	Өртсөн эд зүйлс	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник
												30	30

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол “**Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)**” томъёогоор хөрвүүлж оруулна уу.

Заавар: 11 дүгээр баганыг бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Цахилгаанаас
- Санамсар болгоомжгүй байдлаас
- Шалтгаан тогтоогдоогүй
- Бусад

2. Ой, хээрийн гал түймэр\_2019

Орон зайн болон гамшгийн код										Гамшгийн мэдээлэл												
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	Он	Сар	өдөр	Тохиролдлын дугаар	Толомтын Уртраг	Толомтын Өргөрөг	Шалтгаан	Шатсан талбай /Га/	Үргэлжилсэн хугацаа /хоног/	Өртсөн хүний нийт тоо	Өртсөн гэмтсэн хүний нийт тоо	Түлэгдэж гэмтсэн хүний нийт тоо	Нас барсан хүний нийт тоо	Аварсан хүний тоо	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник	Хил хамгаалах албаас ажилласан хүн	
		FS	2018	08	10				Бусад													

Үргэлжлэл

Гамшгийн мэдээлэл									
23	24	25	26	27					
Хил хамгаалах албаас ажилласан техник	Зэвсэгт хүчнээс ажилласан хүн	Зэвсэгт хүчнээс ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник					

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол “**Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)**” томъёогоор хөрвүүлж оруулна уу.

Заавар: 10 дугаар баганыг бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Хүний үйл ажиллагаанаас
- Байгалийн үзэгдлээс
- Шалтгаан тогтоогдоогүй
- Бусад

## 6.2 Байгалийн гаралтай аюулт үзэгдэл бүртгэх загвар

### 1. Аянга\_2019

Орон зайн болон гамшгийн код		Гамшгийн мэдээлэл															
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохиролдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Өртсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Гэмтэж, бэртсэн хүний тоо	Аварсан хүний тоо	Өртсөн эд зүйлс	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник
		NF	2018	08	10	01											

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

**“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)”** томъёогоор хөрвүүлж оруулна уу.

### 2. Ган\_2019

Орон зайн болон гамшгийн код										Гамшгийн мэдээлэл				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохиролдлын дугаар	Үрэвжилсэн хугацаа	Өртсөн ерхийн тоо	Өртсөн хүний нийт тоо	Өртсөн малын нийт тоо	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник
		ND	2018	08	10									

### 3. Зуд\_2019

Орон зайн болон гамшгийн код										Гамшгийн мэдээлэл										
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Зудын төрөл	Үргэлжилсэн хугацаа /сараар/	Өртсөн ерхийн тоо	Өртсөн хүний нийт тоо	Өртсөн малын нийт тоо	Хоргодсон малын тоо	Хоргодсон үхэр	Хоргодсон хонь	Хоргодсон ямаа	Хоргодсон адуу	Хоргодсон тэмээ	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник
		NZ	2018	08	10															

Заавар: 7 дугаар баганыг бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Цагаан зуд
- Цагаанаар зудархуу
- Харын зуд
- Бусад

### 4. Мөндөр\_2019

Орон зайн болон гамшгийн код										Гамшгийн мэдээлэл							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохиролдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Өртсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Гэмтэж, бэртсэн хүний тоо	Аварсан хүний тоо	Өртсөн эд зүйлс	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник
		NF	2018	08	10												



5. Үер\_2019

Орон зайн болон гамшгийн код									
1	2	3	4	5	6	7	8	9	10
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохиролдлын дугаар	Үерийн төрөл /цагаар/	Үргэлжилсэн хугацаа /цагаар/	Өртсөн өрхийн нийт тоо
		NF	2018	08	10				

Үргэлжлэл

Гамшгийн мэдээлэл									
20	21	22	23	24	25	26	27		
Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник	Хил хамгаалах албаас ажилласан хүн	Хил хамгаалах албаас ажилласан техник	Зэвсэгт хүчнээс ажилласан хүн	Зэвсэгт хүчнээс ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник		

Заавар: 8 дугаар баганыг бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Усны үер
- Уруйн үер
- Шар усны үер
- Бусад

6. Хүчтэй, салхи шуурга\_2019

Орон зайн болон гамшгийн код									
1	2	3	4	5	6	7	8	9	10
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохиролдлын дугаар	Салхины хурд	Үргэлжилсэн хугацаа /цагаар/	Өртсөн өрхийн нийт тоо
		NW	2018	08	10				

Үргэлжлэл

Гамшгийн мэдээлэл									
21	22	23	24	25	26				
Хил хамгаалах албаас ажилласан хүн	Хил хамгаалах албаас ажилласан техник	Зэвсэгт хүчнээс ажилласан хүн	Зэвсэгт хүчнээс ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник				

7. Цасан нуранги\_2019

Орон зайн болон гамшгийн код									
1	2	3	4	5	6	7	8	9	10
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохиролдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Өртсөн хүний нийт тоо
		NN	2018	08	10				

Үргэлжлэл

Гамшгийн мэдээлэл									
19	20	21	22	23	24				
Хил хамгаалах албаас ажилласан хүн	Хил хамгаалах албаас ажилласан техник	Зэвсэгт хүчнээс ажилласан хүн	Зэвсэгт хүчнээс ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник				

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол “Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)” томъёогоор хөрвүүлж оруулна уу.

6.3 Геологийн гаралтай аюулт үзэгдэл бүртгэх загвар

1. Газар хөдлөлт\_2019

		Орон зайн болон гамшгийн код																			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохiolдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Мангитут	Цаг, минут	Өртсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Гэмтэж, бэртсэн хүний тоо	Аварсан хүний тоо	Урьдчилан сэргийлсэн хүний тоо	Өртсөн эд зүйлс	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник	
		GE	2018	08	10	2															

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)” томъёогоор хөрвүүлж оруулна уу.

2. Хөрсний гулсалт\_2019

		Орон зайн болон гамшгийн код																		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохiolдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Өртсөн ерхийн тоо	Өртсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Гэмтэж, бэртсэн хүний тоо	Аварсан хүний тоо	Нийт хоргодсон малын тоо	Өртсөн эд зүйлс	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник	
		GL	2018	08	10															

Үргэлжлэл

		Гамшгийн мэдээлэл			
21	22	23	24	25	26
Хил хамгаалах албаас ажилласан хүн	Хил хамгаалах албаас ажилласан техник	Звэсэгт хүчнээс ажилласан хүн	Звэсэгт хүчнээс ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)” томъёогоор хөрвүүлж оруулна уу.

6.4 Биологийн гаралтай өвчлөлийг бүртгэх загвар

1. Мал амьтаны гоц халдварт өвчний тохиолдол бүртгэх загвар

		Орон зайн болон гамшгийн код																						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохiolдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Өртсөн ерхийн тоо	Өртсөн хүний нийт тоо	Голомтын бусад байгаа малын тоо	Өртсөн мал, амьтаны нийт тоо (өвчлсөн)	Эмчилсэн малын тоо	Хоргодсон малын тоо	Устгасан малын тоо	Вакцин жуулсан мал, амьтны тоо	ОБА-наас ажилласан сан хүн	ОБА-наас ажилласан сан хүн	Мал эмнэлэг эс ажилласан сан хүн	Мал эмнэлэг эс ажилласан сан хүн	Мэргэжлийн хяналтаас ажилласан техник	Мэргэжлийн хяналтаас ажилласан сан хүн	Орон нутгаас ажилласан сан хүн	Орон нутгаас ажилласан техник
		BA1	2018	08	10																			

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)” томъёогоор хөрвүүлж оруулна уу.

- Шүлхий\_2019
- Мал, амьтны галзуу\_2019
- Шувууны томуу\_2019
- Бог малын мялзан\_2019

- Үхрийн хорт салст халуурал\_2019
- Дуут хавдар\_2019
- Дотрын халдварт хордлого\_2019
- Адууны ханиад\_2019
- Адууны ям\_2019
- Боом\_2019
- Тахианы ньюкасл өвчин\_2019
- Гахайн үржил амьсгалын замын хам шинж\_2019
- Гахайн мялзан\_2019
- Хонь, ямааны цэцэг\_2019 гэх мэт давхаргуудын мэдээллийг дээрх загвараар бүртгэнэ. (Шувуу, гахай, тахиа, мал зэрэгт тохиолддог өвчнүүд учир хүснэгтэн загвар үүсгэхдээ анхаарна уу)

## 2. Хүний гоц халдварт өвчний тохиолдол бүртгэх загвар

		Гамшгийн мэдээлэл																				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохимолдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Өртсөн өрхийн тоо	Өртсөн нийт тоо/өвчилсөн тоо	Эмчлүүлсэн хүний тоо	Нас барсан хүний тоо	Вакцинуулсан хүний тоо	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Эрүүл мэндийн байгууллага ас ажилласан хүн	Эрүүл мэндийн байгууллага ас ажилласан техник	Мэргэжлийн хяналтаас ажилласан хүн	Мэргэжлийн хяналтаас ажилласан техник	Орон нутгаас ажилласан сан хүн	Орон нутгаас ажилласан техник	
		BA1	2018	08	10																	

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол
- **“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)”** томъёогоор хөрвүүлж оруулна уу.
- Бруцеллээ\_2019
- Гар, хөл, амны өвчин\_2019
- Тарваган тахал\_2019
- Н1N1 томуу\_2019
- Сүрьеэ\_2019 зэрэг давхаргуудын мэдээллийг дээрх загвараар бүртгэнэ.

## 6.5 Хүний үйл ажиллагаатай холбоотой осол бүртгэх загвар

### 1. Тэсэрч дэлбэрэх\_2019

		Ослын мэдээлэл																			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохимолдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Төрөл	Өртсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Түлэгдэж, гэмтсэн хүний тоо	Аварсан хүний тоо	Өртсөн эд зүйлс	ОБА-наас ажилласан ан хүн	ОБА-наас ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник	
		HE	2018	08	10																

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол
- **“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)”** томъёогоор хөрвүүлж оруулна уу.

Заавар: 10 дүгээр баганыг /төрөл/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Ахуйн шингэрүүлсэн хийн осол
- Пиротехникийн хэрэгслийн осол
- Сум, галт хэрэгслийн осол
- Тэсрэх бодисын осол
- Тэсэлгээний хэрэгслийн осол
- Бусад

## 2. Химийн осол\_2019

		Ослын мэдээлэл																					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Төхмөлдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Төрөл	Алдагдсан бодис	Алдагдсан бодисын хэмжээ	Өрсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Түлэгдэж, гэмтсэн хүний тоо	Аварсан хүний тоо	Өрсөн эд зүйлс	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник	Орон нутаас ажилласан хүн	Орон нутаас ажилласан техник	
		НС		2018	08	10																	

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

“**Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)**” томъёогоор хөрвүүлж оруулна уу.

Заавар: 10 дүгээр баганыг/төрөл/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Аммиакын осол
- Аюултай хог хаягдлын осол
- Мөнгөн усны осол
- Нефтийн бүтээгдэхүүний химийн осол
- Хүнцлийн осол
- Хорт хийн осол
- Хүчлийн осол
- Цианидын осол
- Удаан задардаг органик бохирдуулагч бодисын осол
- Шүлтийн осол
- Бусад

## 3. Цацрагийн осол\_2019

		Ослын мэдээлэл																				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21		
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохиолдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Төрөл	Өрсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Түлэгдэж, гэмтсэн хүний тоо	Аварсан хүний тоо	Саармажуулах үйл ажиллагаа	Саярмажуулах үйл ажиллагаа	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник	Орон нутаас ажилласан хүн	Орон нутаас ажилласан техник	
		HR		2018	08	10																

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

**“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)”** томъёогоор хөрвүүлж оруулна уу.

Заавар: 10 дугаар баганыг/ослын төрөл/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Цацрагийн үүсгүүр алдагдах, гээгдэх, олдох,
- Тээвэрлэлттэй холбоотой цацрагийн осол
- Гал түймрийн үед цацраг идэвхт бодис алдагдах
- Лаборатори дахь цацрагийн осол
- Бусад

Заавар: 14 дүгээр баганыг/Саармагжуулах үйл ажиллагаа/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Саармагжуулсан
- Саармагжуулаагүй

#### 4. Зам, тээврийн хэрэгслийн осол\_2019

Орон зайн болон гамшгийн код										Ослын мэдээлэл											
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохимолдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Төрөл	Автомашин арлын дугаар	Өртсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Гэмтэж, бэртсэн хүний тоо	Аварсан хүний тоо	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник	
		НГ		2018	08	10															

• Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

**“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)”** томъёогоор хөрвүүлж оруулна уу.

Заавар: 10 дугаар баганыг/төрөл/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Автозамын осол
- Төмөр замын осол
- Нисэх онгоцны осол, сүйрэл
- Усан замын тээврийн осол
- Бусад

#### 5. Үйлдвэрлэлийн осол\_2019

Орон зайн болон гамшгийн код										Ослын мэдээлэл											
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохимолдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Төрөл	Өртсөн хүний нийт тоо	Нас барсан хүний тоо	Түлэгдэж, гэмтсэн хүний тоо	Аварсан хүний тоо	Өртсөн эд зүйлс	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан техник	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник	
		НГ		2018	08	10															

• Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг, өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

**“Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)”** томъёогоор хөрвүүлж оруулна уу.

Заавар: 10 дугаар баганыг /төрөл/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Бичил уурхай, нурангийн осол
- Дадл уурхайн осол
- Ил уурхайн осол
- Бусад

6. Эрэн хайх, аврах ажиллагаа\_2019

		Орон зайн болон гамшгийн код																			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
Аймгийн нэр	Сумын нэр	Гамшгийн код	он	сар	өдөр	Тохиролдлын дугаар	Уртраг	Өргөрөг	Төрөл	Өрсөн хүний нийт тоо	Нас барсан (Хөгжлийн бэрхшээлтэй)	Нас барсан (Хөгжлийн бэрхшээлтэй)	Олдоогүй буюу сураггүй болсон	Сураггүй болсон (Хөгжлийн бэрхшээлтэй)	Эсэн мэнд ирсэн	Эсэн мэнд ирсэн (Хөгжлийн бэрхшээлтэй)	Аварсан хүний тоо	Аварсан (Хөгжлийн бэрхшээлтэй)	Үргэлжилс эн хугацаа (холоор)	ОБА-наас ажилласан хүн	ОБА-наас ажилласан техник
		HS		2018	08	10				10											

Үргэлжлэл

23	24	25	26	27	28	29	30
Хил хамгаалах албаас ажилласан хүн	Хил хамгаалах албаас ажилласан хүн	Зөвсэгт хүчнээс ажилласан хүн	Зөвсэгт хүчнээс ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Цагдаагийн байгууллагаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан хүн	Орон нутгаас ажилласан техник

- Уртраг , өргөрөг оруулахдаа decimal, degree –ээр оруулах ёстой. Хэрвээ уртраг , өргөрөг нь Latitude/Longitude (градус, минут, секунд) хэлбэрээр бол

“*Decimal Degrees = градус + (минут/60) + (секунд/3600)*” томъёогоор хөрвүүлж оруулна уу.

Заавар: 10 дугаар баганыг /Төрөл/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Төөрсөн, сураггүй болсон
- Усны осол
- Ус, цас, шаварт саатсан
- Цогцос гаргах
- Амиа хорлолт /аврах/
- Бусад

6.6 Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг бүртгэх загвар

6.6.1 Аж ахуй нэгж/салбар, онц чухал объектын түвшинд хийсэн эрсдэлийн үнэлгээний үр дүнг нэгтгэх загвар

Орон зайн мэдээлэл	Статистик мэдээлэл (Барилгын жишээ)								Эрсдэлийн үнэлгээний мэдээлэл										
	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	
Барилга байгууламж	Барилгын хаяг	Барилгын бүтээц	Барилгын хийцийн төрөл	Барилгын насжилт /Жил/	Зориулалт	Давхар-ын тоо	Баглааж /ерх/	Үнэлгээний төрөл	Үнэлгээ хийсэн хугулийн эгзэгд ...ХХХ	Үнэлгээ хийгүүлсэн огноо	Үнэлгээний тодотгол хийсэн огноо	Гамшиг аюулт үзэгдэл, ослын ангилал	Үнэлгээ хийгүүлсэн гамшигийн төрөл	Гамшгийн эрсдэлийн түвшин	Аюулын магадлал	Өртөх байдал Эмзэг байдал	Чадавх	Зөвлөмж	
36	Төмөр бетон		30	Орон сууц	5	50	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	2018.10.25	2017.10.01	2018.10.25	2018.10.25	Объектын гал түмнэг	Дунд	Бага	их	Дунд	.....		

Удирдамж:

- Дээрх дугаар бүхий багануудыг бөглөж бичихдээ гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг үндэслэнэ.
- Багана тус бүрт бичихдээ доор заасан зааврын дагуу бичнэ. Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг бичиж оруулахад мөн адил аргачлал хэрэглэгдэнэ.
- 2-6 багана буюу хөх цэнхэр бүхий хэсгийн мэдээлэл нь тухайн эрсдэлийн үнэлгээ хийж буй салбар, объектын төрлөөс хамаарч өөрчлөгдөнө.
- 9-19 багана буюу шар дэвсгэр бүхий мэдээллүүд нь салбар, объектын төрөл зэргээс үл хамааран ижил байна.

Хүснэгтэнд бичих заавар:

3 дугаар баганыг /барилгын бүтээц төрөл/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгоно уу.

- Төмөр бетон
- Ган
- Модон
- Тоосто
- Блок
- Шавар

4 дүгээр баганыг /барилгын хийцийн төрөл/ бөглөж бичихдээ доорх сонголтуудаас сонгоно уу.

- Карказ
- Угсармал хавтгайлжин
- Бүрэн цутгамал
- Өрөгт
- Сэндвич

9 дүгээр баганын /Үнэлгээний төрөл/ мэдээллийг доорх 2 сонголтоос сонгож бичнэ үү.

- Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа
- Гамшгийн эрсдэлийн үнэлгээ

10. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн болон ажлын хэсгийн нэрийг бичнэ.

11. Үнэлгээ хийлгэсэн огноо бичнэ.

12. Үнэлгээний тодотгол хийсэн огноо бичнэ.

13. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын ангилалыг доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

- Гал түймэр
- Байгалийн гаралтай аюулт үзэгдэл
- Геологийн гаралтай аюулт үзэгдэл
- Биологийн гаралтай өвчин
- Хүний буруутай үйл ажиллагааны осол

14. Үнэлгээ хийлтгэсэн гамшгийн төрлийг доорх сонголтуудаас сонгож бичнэ үү.

**Гал түймэр:**

- Объектын гал түймэр
- Ойн, хээрийн түймэр
- Ган
- Зуд
- Үер
- Мөндөр
- Цасан нуранги
- Хүчтэй салхи, шуурга

**Биологийн гаралтай гамшиг:**

- Боом
- Дуут хавдар
- Үхрийн хорт салст халуурал
- Хонь, ямааны цэцэг өвчин
- Гахайн мялзан
- Дотрын халдварт хордлого
- Адууны ханиад
- Шүлхий
- Адууны ям
- Мал, амьтны галзуу

**Хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой осол:**

- Химийн осол
- Тэсэрч дэлбэрэх
- Үйлдвэрлэлийн осол
- Цацрагийн осол
- Зам, тээврийн хэрэгслийн осол
- Шувууны томуу
- Тахианы ньюкасл өвчин
- Бог малын мялзан
- Гахайн үржил амьсгалын замын хам шинж
- Бруцеллёз
- Гар, хөл, амны өвчин
- Тарваган тахал
- H1N1 томуу
- Сурьез

**Геологийн гаралтай гамшиг:**

- Газар хөдлөлт
- Хөрсний гулсалт

15-18. дугаар баганын мэдээллийг гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг үндэслэн доорх сонголтуудаас сонгож бичнэ. Газрын зурагт дүрслэн үзүүлэхдээ эрсдэл "Их" улаан, "Дунд" шар, "Бага" ногоон өнгөөр тус тус дүрслэнэ.

- Багана 15: Их, Дунд, Бага
- Багана 16: Их, Дунд, Бага
- Багана 17: Их, Дунд, Бага
- Багана 18: Их, Дунд, Бага

19. Илэрсэн эрсдэлийг бууруулах зөвлөмж бичнэ.

6.6.2 Засаг захиргаа нэгж, нутаг дэвсгэрийн түвшинд хийсэн эрсдэлийн үнэлгээний үр дүнг нэгтгэх загвар (Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо)

Орон зайн мэдээлэл	Эрсдэлийн үнэлгээний мэдээлэл											
	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Засаг захиргааны нэгж	Үнэлгээ хийсэн хуулийн эгзвэлд	Үнэлгээ хийгдсэн огноо	Үнэлгээ хийгдсэн огноо	Үнэлгээ тодотгол хийсэн огноо	Үнэлгээний тодотгол хийсэн огноо	Гамшиг асуулт үзвэл, ослын ангилал	Үнэлгээ хийгдүүлсэн гамшгийн төрөл	Гамшгийн эрсдэлийн түвшин	Аюулын магадлал	Өртөх байдал Эмзэг байдал	Чадавх	Зөвлөмж
	..ХХХ	2017.10.01	2018.10.15	2018.10.15			Зуд	Дунд	Бага	их	дунд	.....




## 6.7 Бусад

Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн хүснэгтэн загварт тусгагдаагүй бусад давхарга, мэдээллүүдийг мэдээллийн санд шинээр үүсгэх, оруулахдаа заавал "тайлбар" гэсэн багана үүсгэсэн байх шаардлагатай. Нэмэлтээр шинж чанар, ангилал, төрөл, тоо зэрэг бусад мэдээллийг дэлгэрэнгүй тусгах шаардлагатай бол мөн багана нэмж мэдээлэл оруулах боломжтой. Шинээр үүсгэсэн давхаргын нэр ойлгомжгүй, тайлбар мэдээлэлгүй давхарга үүсгэх, оруулахгүй байхыг анхаарна уу.

Бусад давхарга мэдээллийн агуулгад тавигдах нийтлэг шаардлага:

Заавал үүсгэнэ	Шаардлагатай тохиолдолд үүсгэнэ		
Тайлбар	Шинж	Чанар	Төрөл
			Тоо
			Бусад



**ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОН ХАМТРАН  
АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 2018/28  
21...

Улаанбаатар хот

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Нэг талаас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /цаашид "ГЗБГЗЗГ" гэх/-ыг төлөөлж, тус газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, нөгөө талаас Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "ОБЕГ" гэх/-ыг төлөөлж тус газрын Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн дарга, хурандаа Д.Баярбаатар /хамтад нь "Талууд" гэх/ нар доорх нөхцлийг харилцан тохиролцож, хамтран ажиллахаар энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээ нь хавсралт 1, 2-д дурдагдсан орон зайн мэдээ, гамшгийн мэдээ, мэдээллийг харилцан солилцох, ашиглахад үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээнд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1 "Орон зайн мэдээлэлд зориулсан сервис" /Web feature service/ гэж тухайлсан орон зайн мэдээллийг авч ашиглах боломж бүхий динамик цахим өгөгдлийн үйлчилгээг;

1.2.2 "Орон зайн мэдээлэлд зориулсан зурган сервис" /Web map service/ гэж тухайлсан орон зайн мэдээллийг харах боломж бүхий динамик цахим зургийн үйлчилгээг;

1.2.3 "Орон зайн мэдээлэлд зориулсан тэгш өнцөгт хуваагдал бүхий зурган сервис" /Web map tile service/ гэж тухайлсан орон зайн мэдээллийг харах боломж бүхий статик цахим үйлчилгээг хэлнэ.

1.3. Энэхүү гэрээний 1, 2 дугаар хавсралтаар баталсан "Харилцан солилцох мэдээллийн жагсаалт" нь гэрээний салшгүй хэсэг байна.

## **ХОЁР. ГЗБГЗЗГ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1. Гэрээний 1.3-д заасан мэдээллийн жагсаалтын дагуу орон зайн мэдээ, мэдээллээр ОБЕГ-ыг үнэ төлбөргүй хангана.

2.2. Геодези, байр зүйн ажлын заавар, журам, норм дүрмийн талаар ОБЕГ-ыг мэргэжлийн зааварчилгаа, удирдамжаар хангана.

2.3. Монгол Улсын Засгийн газар болон ГЗБГЗЗГ-аас гаргасан солбицол, өндрийн тогтолцоо, тусгаг, солбицлын эрин, геоидын өндрийн загвар болон байрлал, өндрийн үндэслэлийн цэгүүдийн солбицол, өндөр бүхий өгөгдлүүдийг Олон улсын стандарт шаардлагад нийцсэн солбицол, өндрийн тогтолцоонд шилжүүлэх аргачлал, зөвлөмжөөр хангана.

2.4. Гэрээний 1.2.1, 1.2.2, 1.2.3-т тодорхойлсон сервисүүдийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай ажиллагааг хариуцан ажиллана.

2.5. Орон зайн болон текст өгөгдөл бүхий мэдээллийг ОБЕГ-т тухайн орон зайн мэдээлэлд зориулсан сервис ашиглан дамжуулна.

2.6. Төрийн болон албаны нууцад хамаарах орон зайн болон текст өгөгдөл бүхий мэдээ, мэдээллийг төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий ОБЕГ-ын хэрэглэгчид тухайн орон зайн мэдээлэлд зориулсан сервис ашиглан дамжуулна.

2.7. Нууцын болон татаж авах боломжтой веб үйлчилгээнүүдийг байгууллагын “Орон зайн өгөгдлийн дэд бүтэц”-ийн журамд заасан эрх, үүрэгтэй ашиглуулна.

2.8. ОБЕГ-ын гамшгийн орон зайн мэдээлэл солилцох *IE-Comi map* системд хандах хэрэглэгчийн эрхээр дамжуулан гамшгийн орон зайн мэдээллийг авч ашиглана.

## **ГУРАВ. ОБЕГ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. ГЗБГЗЗГ-тай төрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээллийг солилцох, тухайн мэдээллийн санг эрхлэх мэргэжилтнийг төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнаар томилгоожуулан ажиллуулах.

3.2. ГЗБГЗЗГ-ын эрх бүхий албан тушаалтанд гамшгийн орон зайн мэдээлэл солилцох *IE-Comi map* системд хандах хэрэглэгчийн эрхийг олгон гамшгийн орон зайн мэдээллийг саадгүй солилцох боломжийг олгох.

3.3. ГЗБГЗЗГ-аас үзүүлж буй сервисүүдийн шугам, сувгаас мэдээлэл алдагдах, гадагш урсахаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлэх.

3.4. ГЗБГЗЗГ-ын үзүүлж буй сервисүүдийн өгөгдөл, мэдээллүүдийг бусдад дамжуулахгүй байх, зөвхөн өөрийн албан хэрэгцээндээ ашиглах.



## **ДӨРӨВ. ХАМТРАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

4.1. Талууд мэдээлэл солилцоходоо цахим мэдээлэл солилцох системийг ашиглана.

4.2. Цахимаар мэдээлэл солилцох боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд биечлэн болон бусад мэдээллийн сувгаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.

4.3. Талууд харилцан солилцож буй мэдээлэл, цахим системд нэвтрэх нэр, түлхүүр үг, сервис хаягийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэг хүлээнэ.

4.4. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг ашиглах, солилцоходоо холбогдох хууль, журмыг баримтална.

### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА**

5.1. Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

5.2. Гэрээг талуудын аль нэг нь цуцлах болон дуусгавар болгох санал тавиагүй тохиолдолд гэрээний хугацааг цаашид дахин нэг жилээр сунгагдсанд тооцно.

### **ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

6.1. Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш давагдашгүй нөхцөл байдлын улмаас болон гуравдагч этгээдийн хууль зөрчсөн санаатай эсхүл санамсаргүй байдлаар үйлдсэн үйлдлийн улмаас Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй бөгөөд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй.

6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн нөхцөл байдлын талаар Талууд ажлын 5 хоногийн дотор харилцан мэдэгдэж, цаашдын үйл ажиллагааг хамтран шийдвэрлэнэ.

### **ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

7.1. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Маргааныг зөвшилцлөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

### **НАЙМ. БУСАД ЗҮЙЛ**

8.1. Төрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн этгээдэд Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлтийг харилцан тохиролцсоны үндсэн дээр оруулах эрхтэй ба санал хүлээн авсан тал ажлын 14 хоногийн дотор өөрийн

саналын хариуг мэдэгдэнэ. Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд гэрээний нэмэлтийг акт үйлдэн баталгаажуулна.

8.3. Талууд гэрээний биелэлтийг Хагас жилд 1 удаа дүгнэж тайлагнана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ГЗБГЗЗГ-ЫН ЗАХИРГАА, УДИРДЛАГА,  
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
ДАРГА

Р.ГАНХУЯГ

ОБЕГ-ЫН ГАМШГИЙН ШУУРХАЙ  
УДИРДЛАГА, ЗАРЛАН  
МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН ДАРГА,  
ХУРАНДАА

Д.БАЯРБААТАР

ГЗБГЗЗГ-ЫН ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЭЛ,  
ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.БАЯРЖАРГАЛ

~~ОБЕГ-ЫН ХОЛБОО, ЗАРЛАН~~  
~~МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА-~~  
~~ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР, ДЭД~~  
~~ХУРАНДАА~~

Л.ЭНХБОЛД

ГЗБГЗЗГ-ЫН АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН  
ТӨВИЙН ДАРГА

Н.АДИЛБИШ<sub>2</sub>

ГЗБГЗЗГ-ЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

С.ЭНХТУЯА

ГЗБГЗЗГ болон ОБЕГ-ын 2018 оны 2018/28/21  
 дугаар "Орон зайн мэдээлэл солилцох,  
 хамтран ажиллах гэрээ"-ний Нэгдүгээр  
 хавсралт

ГЗБГЗЗГ-ын солилцох орон зайн мэдээллийн жагсаалт

Д/д	Үндсэн ангилал	№	Мэдээллийн төрөл	Агуулга	Талбайн хэмжээ	Биетийн төрөл	Цахим үйлчилгээний төрөл
1	Геодези зураг зүйн мэдээллийн сан	1	Хаягийн мэдээллийн сан	1:1 000-ны масштабын хаягийн зураг	Улсын хэмжээнд	полигон, цэгэн шугаман текстэн	WMS
		2		1:100 000-ны масштабын хаягийн зураг	Улсын хэмжээнд	полигон, цэгэн шугаман текстэн	WMS, WMTS
		3	Агаар, сансрын зураг	Spot5, Landsat8, ZY-3 хиймэл дагуулын өгөгдөл	Улсын хэмжээнд	Image	WMS, WMTS
2	Газар зохион байгуулалтын мэдээллийн сан	4	Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн	Аймаг, Нийслэл, Сум, Дүүрэг, Багийн хилийн цэс	Улсын хэмжээнд	полигон, текстэн, цэгэн	WFS
		5	Газрын нэгдмэл сангийн мэдээллийн сан	Хөдөө аж ахуйн газар	Улсын хэмжээнд	Полигон, Цэгэн Шугаман	WMS, WFS
		6		Хот, тосгон, бусад суурины газар	Улсын хэмжээнд	Полигон, Цэгэн Шугаман	WMS, WFS
		7		Зам, шугам сүлжээний газар	Улсын хэмжээнд	Шугаман	WMS, WFS
8	Ойн сан бүхийн газар	Улсын хэмжээнд	Полигон	WMS, WFS			



		9		Усны сан бүхий газар	Улсын хэмжээнд	Полигон, Шугаман	WMS, WFS
		10		Тусгай хэрэгцээний газар	Улсын хэмжээнд	Полигон	WMS, WFS
3	Инженер, хайгуул мониторингийн мэдээллийн сан	11	Инженер геологи, хүрээлэн буй орчны мэдээллийн сан	Ой	Улсын хэмжээнд	Полигон	WMTS, WMS
		12		Ашигт малтмал	Улсын хэмжээнд	Полигон	WFS, WMS
		13		Гидрологи	Улсын хэмжээнд	Полигон, шугаман	WFS, WMS, WMTS
		14		Ургамлын бүрхэвч	Улсын хэмжээнд	Полигон, шугаман	WFS, WMTS, WMS
		15		Шинэ тектоник, газар чичирхийлэл	Улсын хэмжээнд	Полигон, шугаман	WFS, WMS, WMTS
		16		Цэвдэг	Улсын хэмжээнд	Полигон, шугаман	WFS, WMS, WMTS
		17		Газар хөдлөлтийн мужлалын мэдээллийн сан	Улсын хэмжээнд	Полигон, шугаман, цэгэн	WFS, WMS, WMTS

ГЗБГЗЗГ болон ОБЕГ-ын 2018 оны 2018/28/21  
 дугаар "Орон зайн мэдээлэл солилцон  
 хамтран ажиллах гэрээ"-ний Хоёрдугаар  
 хавсралт

Онцгой байдлын ерөнхий газар  
 Солилцох гамшгийн мэдээллийн жагсаалт

Үндсэн ангилал	Д/д	Агуулга	Бүртгэх давтамж	Формат	Байршил
<b>Аюулт үзэгдэл, осол</b>					
1. Байгалын гамшиг	1	Салхи шуурга	Өдөр тутам, тухай бүрт	Текст	Монгол Улсын хэмжээнд
	2	Аянга		Текст	
	3	Үер		Текст	
	4	Зуд		Текст	
	5	Ган		Текст	
	6	Газар хөдлөл		Текст	
	7	Усны осол		Текст	
2. Хүн, малын өвчин	1	Хүний халдварт		Текст	
	2	Мал, амьтаны галзуу		Текст	
	3	Боом		Текст	
	4	Шүлхий		Текст	
	5	Цэцэг		Текст	
	6	Цусан халдвар		Текст	
	7	Мялзан		Текст	
	8	Үхрийн хорт салст	Текст		
	9	Адууны яам	Текст		
3. Физик, химийн гаралтай осол	1	Тэсэрч дэлбэрэх	Текст		
	2	Уурхайн осол	Текст		
	3	Цацраг идэвхит	Текст		
	4	Хими	Текст		
4. Аврах үйл ажиллагаа	1	Эрэн хайх аврах	Текст		
<b>Гал түймэр</b>					
	1	Объектын гал түймэр		Текст	



5.Гал түймэр	2	Ой, хээрийн гал түймэр	Сараар, тухай бүрт	Текст
<b>Гамшгийн эрсдлийн үнэлгээ</b>				
6.Эрсдэл	1	Гамшгийн төрөл тус бүрийн эрсдлийн үнэлгээ	Тухай бүрт	Текст
<b>Сэдэвчилсэн давхарга, мэдээллүүд</b>				
7.Сэдэвчилсэн мэдээлэл	1	Гамшгийн холбогдол бүхий сэдэвчилсэн давхарга мэдээллүүд	Тухай бүрт	Shp

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА ХОШУУЧ  
ГЕНЕРАЛ  
Т.БАДРАЛ

БАТЛАВ.  
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ  
АРХИТЕКТОР БӨГӨӨД  
НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,  
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ц.ТУЛГА

ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОЖ ХАМТРАН  
АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2019 оны 03 сарын 04 дөр

Дугаар . . . . .

Улаанбаатар хот

04/2019/03

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Нэг талаас Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар /цаашид "НХТЕТГ" гэх/, нөгөө талаас Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "ОБЕГ" гэх/, нар /хамтад нь "Талууд" гэх/ доорх нөхцөлийг харилцан тохиролцож, хамтран ажиллахаар энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээ нь 1, 2 дугаар хавсралтанд дурдсан орон зайн мэдээ, гамшгийн мэдээ, мэдээллийг харилцан солилцох, ашиглахад үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээнд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1 "Вектор, хүснэгтэн мэдээллийн цахим хуудасны үйлчилгээ" /Web feature service-WFS/ гэж тухайлсан орон зайн мэдээллийг авч ашиглах боломж бүхий вектор, хүснэгтэн мэдээллийг өөрчилж болох цахим өгөгдлийн үйлчилгээг;

1.2.2 "Зураг, хүснэгтэн мэдээллийн цахим хуудасны үйлчилгээ" /Web map service-WMS/ гэж тухайлсан орон зайн мэдээллийг харах боломж бүхий зураг харах, хүснэгтэн мэдээллийг өөрчилж болох цахим зургийн үйлчилгээг;

1.2.3 "Тэгш өнцөгт хуваагдал бүхий зурган цахим хуудасны үйлчилгээ" /Web map tile service-WMTS/ гэж тухайлсан орон зайн мэдээллийг харах боломж бүхий өгөгдлийг өөрчилж болохгүй цахим үйлчилгээг хэлнэ.

1.3. Энэхүү гэрээний 1, 2 дугаар хавсралтаар баталсан "Харилцан солилцох мэдээллийн жагсаалт" нь гэрээний салшгүй хэсэг байна.

## **ХОЁР. НХТЕТГ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1. НХТЕТГ нь Хот байгуулалтын мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэх, баяжуулах, ОБЕГ-тай хамтран ажиллах мэргэжилтнийг томилон ажиллуулна.

2.2. ОБЕГ-ын эрх бүхий албан тушаалтанд Хот байгуулалтын мэдээллийн санд хандах хэрэглэгчийн эрхийг олгон, орон зайн мэдээллийг саадгүй солилцох боломжийг олгох.

2.3. Гэрээний 1.3-д заасан мэдээллийн жагсаалтын дагуу орон зайн мэдээллээр ОБЕГ-ыг хангана.

2.4. Гэрээний 1.2.1, 1.2.2, 1.2.3-т заасан үйлчилгээнүүдийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай ажиллагааг хариуцан ажиллана.

2.5. Төрийн болон албаны нууцад хамаарах орон зайн мэдээллийг төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий ОБЕГ-ын хэрэглэгчид тухайн орон зайн мэдээлэлд зориулсан үйлчилгээг ашиглан дамжуулна.

2.6. ОБЕГ-ын гамшгийн орон зайн мэдээлэл солилцох систем *IE-Comi map*-д хандах хэрэглэгчийн эрхээр дамжуулан гамшгийн орон зайн мэдээллийг авч ашиглана.

## **ГУРАВ. ОБЕГ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. ОБЕГ нь Хот байгуулалтын мэдээллийн сангийн мэдээлэлд хандах, мэдээлэл солилцох, НХТЕТГ-тай хамтран ажиллах мэргэжилтнийг томилон ажиллуулна.

3.2. НХТЕТГ-ын эрх бүхий албан тушаалтанд гамшгийн орон зайн мэдээлэл солилцох систем *IE-Comi map*-д хандах хэрэглэгчийн эрхийг олгон гамшгийн орон зайн мэдээллийг саадгүй солилцох боломжийг олгох.

3.3. Гэрээний 1.3-д заасан мэдээллийн жагсаалтын дагуу орон зайн мэдээллээр НХТЕТГ-ыг хангана.

3.4. Гэрээний 1.2.1, 1.2.2, 1.2.3-т заасан үйлчилгээнүүдийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай ажиллагааг хариуцан ажиллана.

3.5. Гамшгийн орон зайн мэдээллийг НХТЕТГ-т тухайн орон зайн мэдээлэлд зориулсан үйлчилгээг ашиглан дамжуулна.

3.6. НХТЕТГ-аас үзүүлж буй үйлчилгээнүүдийн зураг, мэдээлэл алдагдах, гадагш урсахаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлэх.

3.7. НХТЕТГ-ын үзүүлж буй үйлчилгээнүүдийн зураг, мэдээллүүдийг бусдад дамжуулахгүй байх, зөвхөн өөрийн албан хэрэгцээндээ ашиглах.

3.8. НХТЕТГ-ын Хот байгуулалтын мэдээллийн сангийн мэдээллийг хүлээн авч мэдээллийн санг баяжуулах, холболт хийхэд гарах зардлыг хариуцах.

#### **ДӨРӨВ. ХАМТРАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

4.1. Талууд мэдээлэл солилцохдоо цахим мэдээлэл солилцох системийг ашиглана.

4.2. Цахимаар мэдээлэл солилцох боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд биечлэн болон бусад мэдээллийн сувгаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.

4.3. Талууд харилцан солилцож буй мэдээлэл, цахим системд нэвтрэх нэр, түлхүүр үг, үйлчилгээний IP хаягийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэг хүлээнэ.

4.4. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг ашиглах, солилцохдоо холбогдох, хууль журмыг баримтална.

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА**

5.1. Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс 1 (нэг) жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

5.2. Гэрээний хугацаа дуусгавар болгох санал тавиагүй тохиолдолд гэрээний хугацааг цаашид дахин 1 (нэг) жилээр сунгагдсанд тооцно.

#### **ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

6.1. Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш давагдашгүй нөхцөл байдлын улмаас болон гуравдагч этгээдийн хууль зөрчсөн санаатай эсхүл санамсаргүй байдлаар үйлдсэн үйлдлийн улмаас Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй бөгөөд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй.

6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн нөхцөл байдлын талаар Талууд ажлын 5 хоногийн дотор харилцан мэдэгдэж, цаашдын үйл ажиллагааг хамтран шийдвэрлэнэ.

#### **ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

7.1. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Маргааныг зөвшилцлөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ


8.1. Төрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн этгээдэд Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлтийг харилцан тохиролцсоны үндсэн дээр оруулах эрхтэй ба санал хүлээн авсан тал ажлын 14 хоногийн дотор өөрийн саналын хариуг мэдэгдэнэ. Талууд энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

8.3. Талууд гэрээний биелэлтийг жилд 1 (нэг) удаа дүгнэж тайлагнана.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,  
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА



Ш.УРТНАСАН

ХОТ БАЙГУУЛАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА




А.АМАРСАНАА

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН



Я.БОЛОР

ОБЕГ-ЫН ГАМШГИЙН ШУУРХАЙ  
УДИРДЛАГА, ЗАРЛАН  
МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН ДАРГА,  
ХУРАНДАА



Д.БАЯРБААТАР

ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЭЛ,  
ТЕХНОЛОГИЙН ТАСГИЙН ДАРГА,  
ХОШУУЧ



Д.СОДНОМРАГЧАА

ОБЕГ болон НХТЕТГ-ын 2019 оны .....  
дугаар “Орон зайн мэдээлэл солилцож  
хамтран ажиллах гэрээ”-ний Нэгдүгээр  
хавсралт

Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар  
Хот байгуулалтын мэдээллийн сангийн солилцох мэдээллийн жагсаалт

Д/д	Үндсэн ангилал	№	Мэдээллийн төрөл	Агуулга	Хамрах нутаг дэвсгэр	Биетийн төрөл	Цахим үйлчилгээний төрөл
1	Барилга, байгууламж	1		Барилгын бүтээц, хийц, багтаамж, зориулалт, насжилт, газар хөдлөлийн паспортжуулалтын үр дүн	УБ хот	полигон, хүснэгтэн	WFS
2	Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, /2030 он/	1	Архитектур орон зайн, төлөвлөлтүүд	Бүс тус бүрээр	УБ хот	полигон, хүснэгтэн	WMS, WMTS
		2	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	Байршил, нэр			
		3	Дахин төлөвлөлт	Төрөл, байршил, нэр холбогдох мэдээлэл			
3	Инженерийн дэд бүтэц, түүний хамгаалалтын бүс	1	Халуун усны төвлөрсөн шугам, магистрал	Магистралын нэр, эзэлхүүн, насжилт, хийцийн төрөл	УБ хот	полигон, хүснэгтэн	WFS
		2	Цэвэр усны төвлөрсөн шугам, магистрал				
		3	Төвлөрсөн ариутгах татуургын шугам				
		4	Хамгаалалтын бүсүүдийн хил хязгаар				
4	Байгаль, хүрээлэн буй орчин	1	Хөрс		УБ хот	полигон, хүснэгтэн, цэгэн	WFS
		2	Гол, ус				
		3	Ургамал				
		4	Ой	Ойн сан			
		5	Газар хөдлөлийн хагарал	2013 он			
		6	Газар хөдлөлийн бичил мужлал	Мужлал, баллаар			
		7	Хөрсний оргил хурдатгал	баллаар			
5	Хамгаалалтын бүс	1	Голын хамгаалалт,	Мужлалын нэр, ангилал	УБ хот	полигон, хүснэгтэн	WFS

		2	Усны эх үүсвэрийн хамгаалалт				
		3	Нисэх, буух зурвас түүний хамгаалат				
		4	Хогын цэг, түүний хамгаалалтын бүс				
		5	Цахилаан, өндөр хүчдэлийн хамгаалалтын бүс				
6	Нийгэм, эдийн засаг	1	Дүүрэг	Хүн, ам, өрхийн мэдээлэл, зарим гол мэдээллүүд	УБ хот	полигон, хүснэгтэн	WFS
		2	Хороо	Хорооны дугаар, Хүн, ам, өрхийн мэдээлэл, зарим гол мэдээллүүд			
7	Авто зам	1	Төв зам, хорооллын туслах зам	Зам, гудамж талбайн нэршил	УБ хот	Полигон	WFS
9	Байршил, хаягын бүсчлэл	1	Zip code		УБ хот	Полигон	WFS



ОБЕГ болон НХТЕТГ-ын 2019 оны .....  
дугаар “Орон зайн мэдээлэл солилцож  
хамтран ажиллах гэрээ”-ний Хоёрдугаар  
хавсралт

Онцгой байдлын ерөнхий газар  
Гамшгийн мэдээллийн сангийн солилцох мэдээллийн жагсаалт

Д/д	Үндсэн ангилал	№	Мэдээллийн төрөл	Агуулга	Хамрах нутаг дэвсгэр	Биетийн төрөл	Цахим үйлчилгээний төрөл
1	Байгалийн гамшиг	1	Аюулт үзэгдэл, осол	Барилгын бүтээц, хийц, багтаамж, зориулалт, насжилт, газар хөдлөлийн паспортжуулалтын үр дүн	УБ хот	полигон, хүснэгтэн, цэгэн	WFS
		2		Аянга			
		3		Үер			
		4		Зуд			
		5		Ган			
		6		Газар хөдлөл			
		7		Усны осол			
2	Хүн малын өвчин	1	Хүний халдварт	Мал, амьтаны галзуу	УБ хот	полигон, хүснэгтэн, цэгэн	WFS
		2		Боом			
		3		Шүлхий			
		4		Цэцэг			
		5		Цусан халдвар			
		6		Мялзан			
		7		Үхрийн хорт салст			
		8		Адууны яам			
		9		Тэсэрч дэлбэрэх			
3	Физик, химийн гаралтай осол	1	Уурхайн осол	Цацраг идэвхит	УБ хот	полигон, хүснэгтэн, цэгэн	WFS
		2		Хими			
		3					
		4					
4	Аврах үйл ажиллагаа	1	Эрэн хайх аврах	УБ хот	полигон, хүснэгтэн, цэгэн	WFS	
5	Гал түймэр	1	Гал түймэр	Объектын гал түймэр	УБ хот	полигон, хүснэгтэн, цэгэн	WFS
		2		Ой, хээрийн гал түймэр			
6	Эрсдэл	1	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Гамшгийн төрөл тус бүрийн эрсдлийн үнэлгээ	УБ хот	полигон, хүснэгтэн, цэгэн	WFS
7	Сэдэвчилсэн мэдээлэл	1	Сэдэвчилсэн давхарга, мэдээллүүд	Гамшгийн холбогдол бүхий сэдэвчилсэн давхарга мэдээллүүд	УБ хот	полигон, хүснэгтэн, цэгэн	WFS